



БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН МЕНЕЖМЕНТИЙН ХҮРЭЭ

УЛААНБААТАР ХОТЫН ТОГТВОРТОЙ АВТОЗАМ,
ТЭЭВЭР ТӨСӨЛ (УБТАТ-Р174007)

ГАРЧИГ

1. Удиртгал	6
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл ба үндэслэл	6
1.2. Төслийн зорилго	7
1.3. Хэрэгжилтийн бүтэц зохион байгуулалт	10
1.4. БОНМХ-ний зорилго, цар хүрээ ба арга зүй	11
2. Бодлого, эрх зүйн орчин	12
2.1. Дэлхийн банкны Байгаль Орчин, Нийгмийн Хүрээ	12
2.2. Дэлхийн банкны байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны удирдамж	14
2.3. Монгол Улсын бодлого ба журам	14
2.4. Хууль зүйн дүн шинжилгээ	18
2.4.1. Монгол орны байгаль орчны нөлөөлөх байдлын журмуудыг Дэлхийн Банкны бодлогуудтай харьцуулсан байдал	18
2.4.2. Нийгмийн бодлого, зохицуулалт	21
3. Байгаль орчин ба нийгмийн суурь судалгаа	22
3.1. Байгаль орчны суурь судалгаа	22
3.1.1. Газар зүй	22
3.1.2. Уур амьсгал	23
3.1.3. Агаарын чанар	23
3.1.4. Усан орчин ба Түүл гол	24
3.1.5. Ургамалан нөмрөг	25
3.1.6. Хог хаягдлын менежмент	26
3.2. Нийгмийн суурь үзүүлэлт	26
3.2.1. Хүн ам, хот зохион байгуулалт	26
3.2.2. Хотын хөгжил ба гэр хороолол	27
3.2.3. Төрийн үйлчилгээний хүрээмж	28
3.2.4. Тээврийн үйлчилгээ	29
3.2.5. Коридоруудын өнөөгийн нөхцөл байдал	31
3.2.6. Замын аюулгүй байдлын асуудлууд	31
3.2.7. Эмзэг байдал ба жендэрийн асуудал	34
3.2.8. Жендэрт суурилсан хүчирхийлэл	37
3.2.9. Ковид 19 цар тахал	38
4. Байгаль орчин, нийгмийн судалгаа, эрсдлийн үнэлгээ	38
4.1. Байгаль орчин, нийгмийн судалгаа, эрсдлийн үнэлгээ	38
4.2. Хамаарахгүй үйл ажиллагааны жагсаалт	45
5. Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөл, тэдгээрийг бууруулах арга хэмжээ	47
5.1. Байгаль орчинд үүсэх үр ашиг	47
5.2. Нийгэмд үүсэх үр ашиг	47
5.3. Байгаль орчинд үзүүлэх нөлөө болон бууруулах арга хэмжээ	48
5.4. Нийгмийн нөлөө болон бууруулах арга хэмжээ	52

6. Дэд төслийн байгаль орчин болон нийгмийн удирдлага, зохицуулалтын журам	60
6.1. БОН-ийн тандалт/шинжилгээ	61
6.2. Хяналт ба ангилал	65
6.3. Хяналт, баталгаажуулалт	66
6.4. Хэрэгжүүлэлт ба хяналт	66
6.5. Эцсийн гүйцэтгэл ба хянах ажиллагаа	67
6.6. Талуудын оролцоо	67
7. Талуудын оролцоо, өргөдөл гомдлыг барагдуулах	68
7.1. Мэдээллийн ил тод байдал	68
7.2. Оролцогч талуудын хамтын ажиллагаа	68
7.3. Өргөдөл, гомдол барагдуулах механизм	73
8. Институцийн зохион байгуулалт, чадавх бэхжүүлэх	77
8.1. Институцийн зохион байгуулалт, байгаль орчин, нийгмийн менежментийн хүрээний хэрэгжилт	77
8.2. Байгаль орчин, нийгмийн менежментийн чадавх бэхжүүлэх төлөвлөгөө	79
ХАВСРАЛТ 1. Нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээ	82
ХАВСРАЛТ 2. Хөдөлмөрийн харилцааг зохицуулах журам	108
ХАВСРАЛТ 3. Талуудын оролцоог хангах төлөвлөгөө	125
ХАВСРАЛТ 4. Дэд төслийн Байгаль орчин, нийгмийн тандалт, эрсдлийн үнэлгээ	145
ХАВСРАЛТ 5. Дэд төслийн байгаль орчин нийгмийн менежментийн төлөвлөгөө (Дэд-төслийн БОНМТ)	149
ХАВСРАЛТ 6. Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын удирдамж (БОНМТ)	159
ХАВСРАЛТ 7: Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө боловсруулах болон түр зохицуулалтын ерөнхий удирдамж	165
ХАВСРАЛТ 8: Жишиг Сахилгын дүрэм	178

Зургийн жагсаалт

Зураг 1. I-р төрлийн ажлын хүрээний коридорууд	10
Зураг 2. Монгол улсын БОННУ-ний зарчим	16
Зураг 3. Улаанбаатарын PM2.5 / PM10 (мкг / м)-ын жилийн дундаж агууламж, 2011-2015 он.....	24
Зураг 4. Зам тээврийн ослоос үүдэлтэй эндэгдэл	34
Зураг 5. Төслийн үйл ажиллагаанд баримтлах Байгаль орчин, нийгмийн менежментийн журам	61
Зураг 6. Төслийн санал болгож буй өргөдөл, гомдол барагдуулах механизм	75
Зураг 7. Төслийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх менежмент нь НЗДТГ-ын ухаалаг GRM системтэй уялдсан байдал	76
Зураг 8 Эргэн харах аргачлал болон талуудын оролцоог хангах жишээ.....	132
Зураг 9. Төслийн санал болгож буй өргөдөл, гомдол барагдуулах механизм	140
Зураг 10. Төслийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх менежмент нь НЗДТГ-ын ухаалаг GRM системтэй уялдсан байдал	141
Зураг 11. Явган хүний хажуугийн замыг хаах төлөвлөгөөний жишээ, Лондон хот.....	173
Зураг 12. Түр зохицуулалтын тоног хэрэгсэл, замын төлөвлөгөө	174
Зураг 13. Түр зохицуулалтын жишээ, Их Британи, Эдинбург хот	175
Зураг 14. Замын хаах, чиглэл өөрчилсөн жишээ	175
Зураг 15. Ачааны машины чиглэлийн жишээ	176

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 УБТАТ төслийн бүрэлдэхүүн хэсэг, төсөв болон үйл ажиллагаа	7
Хүснэгт 2. Улаанбаатар - Жилийн 12 сарын агаарын дундаж температур	23
Хүснэгт 3. Улаанбаатар хотын дүүргүүд, гэр хороолол, орон сууцны төрөл 2019.....	26
Хүснэгт 4. Монгол Улсын аюулгүй байдлын индикаторууд.....	32
Хүснэгт 5. ТТ-нд зориулж хийсэн БОН-ийн эрсдэлийн дүн шинжилгээ	39
Хүснэгт 6. Олон нийтийн хэлэлцүүлгийн тэмдэглэлийн маягт	68
Хүснэгт 7 Оролцогч талуудын үүрэг хариуцлага	69
Хүснэгт 8. Төсөл хэрэгжүүлж эхлэх үед зохион байгуулах Урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай сургалт	81
Хүснэгт 9. Монгол улсын хууль, Дэлхийн банкны албадан нүүлгэн шилжүүлэлтийн журмын харьцуулалт	85
Хүснэгт 10. Хөдөлмөртэй холбоотой гомдол барагдуулах зохицуулгын механизм	124
Хүснэгт 11 Оролцогч талууд	129

Товчилсон үгийн жагсаалт

АХБ	Азийн Хөгжлийн Банк
ТЗХУ	Талбайн Замын Хөдөлгөөний Удирлага
ТЗУ	Тусгай Замын Автобус
БОБУАХАБХ	Болзошгүй, Онцгой Байдлын Үед Авах Хариу Арга Хэмжээний Бүрэлдэхүүн Хэсэг
ЖСД	Жишиг Сахилгын Дүрэм
БОЭМАА	Байгаль Орчин, Эрүүл Мэнд, Аюулгүй Ажиллагаа
БОМТ	Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө
БОН	Байгаль Орчин, Нийгэм
БОНХ	Байгаль Орчин, Нийгмийн Хүрээ
БОННУ	Байгаль Орчин, Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээ
БОНМХ	Байгаль Орчин, Нийгмийн Менежментийн Хүрээ
БОНХТ	Байгаль Орчин, Нийгмийн Хариуцлагын Төлөвлөгөө
БОНМТ	Байгаль Орчин, Нийгмийн Менежментийн Төлөвлөгөө
БОНХХ	Байгаль Орчин, Нийгмийн Хяналтын Хураангуй
БОНС	Байгаль Орчин, Нийгмийн Стандарт
ГШХО	Гадаадын Шууд Хөрөнгө Оруулалт
GBV	Жендерт Суурилсан Хүчирхийлэл
ХХ	Хүлэмжийн Хий
СОУСТ	Салбарын Олон Улсын Сайн Туршлага
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
ГБМ	Гомдол Барагдуулах Механизм
ГБҮ	Гомдол Барагдуулах Үйлчилгээ
ХА	Хэрэгжүүлэгч Агентлага
ОУСК	Олон Улсын Санхүүгийн Корпораци
УТС	Ухаалаг Тээврийн Систем
ХХЗЖ	Хөдөлмөрийн Харилцааг Зохицуулах Журам
ЗТХЯ	Зам, Тээвэр Хөгжлийн Яам
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
ХШҮ	Хяналт, Шинжилгээ Үнэлгээ
ЭСТҮ	Эрэлтэд Суурилсан Тээврийн Үйлчилгээ
СЯ	Сангийн Яам
ЦУОШГ	Цаг Уур, Орчны Шинжилгээний Газар
МБТХ	Моторт Бус Тээврийн Хэрэгсэл
ТҮББ	Төслийн Үнэлгээний Баримт Бичиг
ТУА	Төслийн Удирдлагын Алба
ТҮАГА	Төслийн Үйл Ажиллагааны Гарын Авлага
ТХЗ	Төслийн Хөгжлийн Зорилго
ХТТХААС	Хөгжлийн Төлөөх Төслийн Худалдан Авах Ажиллагааны Стратеги
ТУХ	Төслийн Удирдах Хороо
НТҮГ	Нийтийн Тээврийн Үйлчилгээний Газар
НАЗХГ	Нийслэлийн Авто Замын Хөгжлийн Газар
РРФ	Нүүлгэн Шилжүүлэлтийн Бодлогын Хүрээ
БМХ	Бэлгийн Мөлжлөг Болон Хүчирхийлэл
ТОХТ	Талуудын Оролцоог Хангах Төлөвлөгөө
ЖДҮ	Жижиг Дунд Үйлдвэрлэл

ТА	Техникийн Туслалцаа
ЗЗБХМТ	Зам, Замын Байгууламжийн Хөрөнгийн Менежментийн Төлөвлөгөө
ЗХУТ	Замын Хөдөлгөөний Удирдлагын Төв
ЗЗБХОТ	Зам, Замын Байгууламжийн Хөрөнгө Оруулалтын Төлөвлөгөө
ЗХТЗИГ	Замын Хөдөлгөөний Төлөвлөлт, Зохицуулалт, Инженерчлэлийн Газар
УБТАТ	Улаанбаатар Хотын Тогтвортой Автозам Тээвэр Төсөл
ДБГ	Дэлхийн Банк Групп
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага

1. Удиртгал

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл ба үндэслэл

1. Улсын нийт хүн амын 47 хувь нь амьдардаг Монгол улсын нийслэл Улаанбаатар хот 2001 онд 700 мянган хүн амтай байсан бол 2019 онд 1.4 сая хүн амтай болж, 87 хувиар нэмэгдсэн байхад энэ хугацаанд улсын нийт хүн ам 32 хувиар нэмэгдсэн байна.

2. Улаанбаатар хот нь нийтийн тээврийн үйлчилгээ тааруу, моторт бус тээврийн хэрэгсэл (МБТХ)-д зориулсан дэд бүтэц туйлын дутагдалтай, явган алхах болон нийтийн тээврээр зорчих бололцоо хязгаарлагдмал байдгаас улбаалан хувийн машинаар зорчихыг илүүд үзэж байна. Газар ашиглалт болон тээврийн хэрэгслийн зохистой төлөвлөлтгүйгээр хурдацтай өсөж буй хотын бүтээн байгуулалт нь Улаанбаатар хотын одоогийн 1100 км урттай гудамж замын сүлжээг улам тархай байдалтай болгож байна. Гудамж замын сүлжээний зориулалтын ангилал тодорхой бус байгаа явдал нь гудамж замын хөдөлгөөнийг эмх цэгцгүй болгож байна. Гудамжны замууд нь эрс тэс уур амьсгалд тэсвэргүй байгаа явдал нь байнга зам хаагдах, тээврийн хэрэгслийн урсгалыг удаашруулах, бөглөрлийг үүсгэх нөхцлүүдийг бүрдүүлж байна.

3. Монгол улсад болж буй зам тээврийн ослын 87 хувь нь Улаанбаатарт болдог (Тээврийн цагдаагийн алба, 2019). Зам тээврийн дэд бүтцийг сайжруулах талаар авах арга хэмжээ маш хангалтгүй байна. Ослын талаарх мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, замын аюулгүй байдлын нөлөөллийн үнэлгээ, аудит болон замын сүлжээний аюулгүй байдлын менежментийн загварыг боловсруулах, зорилтот арга хэмжээг авч хэрэгжүүлэх тал дээр техникийн чадамж, байгууллагын зохион байгуулалт, санхүүгийн нөөц бололцоо дутмаг байна.

4. Байгаль, цаг уурын хүчтэй үзэгдлүүд байнга болдог явдал нь Улаанбаатар хотын замын системд сөргөөр нөлөөлж байна. Үер, хүчтэй шуурга, хахир өвлийн улирал нь Улаанбаатар хотын байгаль орчин болон тээврийн хэрэгслийн дэд бүтцэд бодитой нөлөөллийг хамгийн ихээр үзүүлж байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн олон жилийн дундаж температур болон хур тунадасны орох хэмжээ өөрчлөгдөж, хотын барилга бүтээн байгуулалт хурдацтай хөгжиж, гэр хорооллын талбайн тархац мөн хурдацтай тэлж, үерийн хамгаалалтын байгууламж дутмаг байгаа явдлууд нь хотод үер болох эрсдэлийг ихээр нэмэгдүүлж байна. Одоо байгаа үерийн хамгаалалтын дэд бүтцүүд муудсаны зэрэгцээ засвар үйлчилгээ хангалтгүй хийгдэж байна. Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг байгаа явдал нь төлөвлөлт, менежментийн чадамж муу байгаа байдлыг улам доройтуулж байгаагийн дээр урьдчилан сэргийлэх систем, хуулийн орчин, техникийн чадамж дутмаг байдалтай байна.

5. Улаанбаатар хотын захиргаа болон Дэлхийн банкны холбогдох багынхан зургаан жилийн туршид зохицуулалт сайтай, нэгдсэн тогтолцоог бий болгохын тулд Улаанбаатар хотын автозам, тээврийн тогтолцоон дахь олон талт асуудлуудыг шийдвэрлэн ажиллаж байна. Техникийн туслалцаа (ТТ)-ны цуврал хөтөлбөрийн хүрээнд зам тээврийн салбарын дэлгэрэнгүй дүн шинжилгээг хийж гүйцэтгэсэн бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтын

төлөвлөлт, зам тээврийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын менежмент, нийтийн тээврийн санхүүгийн тогтвортой байдал, автобусны менежментийн систем, зорчигчийн мэдээллийн систем, масс тээврийн нэвтрүүлэлт, автозамын аюулгүй байдал болон цаг агаарын эрсдэлийг даван туулах чадавхыг сайжруулахад чиглэсэн тусгай зөвлөмжүүд бүхий салбарын стратегийг боловсруулсан байна.

1.2. Төслийн зорилго

6. Улаанбаатар хотын тогтвортой автозам тээвэр (УБТАТ) төсөл нь Улаанбаатар хотын захиргаанд хотын алслагдсан хэсгүүдэд амьдарч буй хамгийн эмзэг бүлгийн хүн амд нийтийн үйлчилгээ, ажлын байр, эдийн засгийн боломжуудыг бий болгоход саад болж буй зам тээврийн дэд бүтцийн бэрхшээлтэй асуудлуудыг багасгахад чиглэгдсэн шалгуур үзүүлэлтүүд бүхий зорилго, зорилт, хүлээгдэж буй үр дүнд хүрэх боломжтой зам тээврийн тогтвортой хөгжлийн дэлгэрэнгүй стратеги болон төлөвлөгөөг боловсруулахад тусалцаа үзүүлнэ.

7. Зам тээврийн салбарын тогтвортой засаглал, төлөвлөлт, хотын зам тээврийн аюулгүй үйлчилгээ зэргээр дамжуулан илүү уян хатан байдалд хүрнэ гэж төлөвлөж байна. Монгол улсын улс төр, эдийн засаг, санхүүгийн төв болох нийслэл хотод зам тээврийн дэд бүтцийг сайжруулах явдал нь эмзэг бүлгийн хүн ам, оршин сууж буй ард иргэдийн амьдралыг сайжруулах төдийгүй хотын өрсөлдөх чадварыг сайжруулах, улс орны эдийн засгийн өрсөлдөх чадварыг олон улсын тавцанд нэмэгдүүлж, хөрөнгө оруулалт болон дэлхийн хэмжээний хамтын ажиллагааг улам нэмэгдүүлэх болно.

Санал болгож буй төслийн хөгжлийн зорилтууд:

- 1) Улаанбаатар хотод тогтвортой авто зам, тээврээр хангах цогц тогтолцоог боловсруулах,
- 2) Сонгосон авто зам, тээврийн коридоруудад замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, авто замын аюулгүй байдлыг сайжруулах, цаг агаарын гаралтай асуудлуудыг шийдвэрлэхэд тус тус оршино.

8. УБТАТ төслийн бүрэлдэхүүн хэсгүүд, өртөг болон боломжит арга хэмжээнүүдийг дор хүснэгтэд жагсаав. Эхний 18 сард хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг доогуур зурав тодотгосон (I үе шатны үйл ажиллагаа).

Хүснэгт 1 УБТАТ төслийн бүрэлдэхүүн хэсэг, төсөв болон үйл ажиллагаа

Бүрэлдэхүүн хэсгүүд	Үйл ажиллагаанууд
Бүрэлдэхүүн хэсэг 1. Гудамж замын цогц коридор: Энэхүү бүрэлдэхүүн нь Улаанбаатар хотын гудамж, замын бүх төрлийн хэрэглэгчид (үүнд тээврийн хэрэгслийн зорчигчид, явган болон	1.1 Гудамж замын коридорын дэд бүтцийн тусгайлсан хөрөнгө оруулалт • <u>I төрөл: коридор шинэчлэл ба өөрчлөн зохион байгуулалт</u>

<p>дугуйгаар зорчигчид, нийтийн тээврийн хэрэгслээр зорчигчид орно)-ийн ашиг тусын төлөө гудамж замын орон зайн үр ашигтай зориулалтын хэрэглээг дэмжихийн зэрэгцээ замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох чадавхийг нэмэгдүүлэх, авто аюулгүй байдлыг сайжруулахын хамт, хотын тархай, хоорондоо холбогдоогүй салангид тус тусдаа байгаа гудамж замын сүлжээ болон замын хөдөлгөөний удирдлагын системийг боловсронгуй болгоход анхааран гудамж замын коридоруудыг сайжруулна</p> <p>(тооцоолж буй нийт өртөг: 90 сая америк доллар, ОУСБХБ-ны зээл: 81 сая америк доллар)</p>	<ul style="list-style-type: none"> • II төрөл: коридор сайжруулалт <p>1.2 Ухаалаг тээврийн систем (ITS)</p> <ul style="list-style-type: none"> • Талбайн замын хөдөлгөөний удирдлага (ТЗХУ)-ын систем ба тоног төхөөрөмж зэрэг төвлөрсөн системүүдийн шинэчлэл • Гэрлэн дохио, замын хөдөлгөөний дүрэм сахиулах, хяналтын камер зэрэг Тээврийн ухаалаг системийн тоног төхөөрөмжийн шинэчлэл <p>1.3 Ухаалаг авто зогсоолын удирдлагын систем</p> <ul style="list-style-type: none"> • Ухаалаг авто зогсоолын удирдлагын системийг хөгжүүлэн, ашиглалтанд оруулах ба үүнд техник хангамжийг худалдан авах, програм хангамжийг хөгжүүлэх мөн ялгавартай үнэ тарифаар бүсчилсэн авто зогсоолын системийг хэрэгжүүлэх зэрэг багтана.
<p>Бүрэлдэхүүн хэсэг 2. Нийтийн тээврийн тогтвортой систем: төслийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь нөөц бололцоо, бэлэн байдлын харгалзан үзэх асуудлуудаас хамааран хязгаарлагдмал хамрах цар хүрээ, далайцтай болно (дэд бүрэлдэхүүн 1.1-т сонгогдсон гудамж, замын коридорт нийтийн тээврийн сайжруулалтанд чиглэсэн байна). (тооцоолж буй нийт өртөг:15 сая америк доллар, ОУСБХБ-ны зээл:10 сая америк доллар)</p>	<p>2.1 Коридорт зориулсан хөрөнгө оруулалтууд</p> <ul style="list-style-type: none"> • Сонгогдсон коридоруудад автобус эгнээ байгуулах • Төслийн коридоруудын дагуу автобусны буудлуудыг сайжруулах <p>2.2 Хотын хэмжээний хөрөнгө оруулалтууд</p> <ul style="list-style-type: none"> • Нийтийн тээврийн удирдлагын системүүдийн шинэчлэл • Эрэлтэд суурилсан тээврийн үйлчилгээ нэвтрүүлэлт
<p>Бүрэлдэхүүн хэсэг 3. Зам, тээврийн төлөвлөлт, менежментийн үр дүнтэй институциуд: Улаанбаатар хотын зам, тээврийн дэд бүтцийн төлөвлөлт, менежмент, үйлчилгээ хүргэлтийг цогц байдлаар шинэчлэхэд зориулсан стратегиуд,</p>	<p>3.1. Стратегийн судалгаанууд:</p> <p>(а) <u>алсын хараа, стратеги; үүнд Улаанбаатар хотын тогтвортой бөгөөд цаг агаарын эрсдлийг даван туулах чадавхтай зам, тээврийн стратеги болон авто зогсоолын удирдлагын төлөвлөгөө орно.</u></p> <p>(б) <u>замын дэд бүтцийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, менежмент; үүнд Зам, замын байгууламжийн хөрөнгө</u></p>

<p><i>аргачлал, арга хэрэгсэлийг боловсруулна.</i></p> <p><i>(тооцоолж буй нийт өртөг: 10 сая америк доллар, ОУСБХБ-ны зээл: 9 сая америк доллар)</i></p>	<p><u>оруулалтын төлөвлөгөө (ЗЗБХОТ) ба зам, замын байгууламжийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн програм, мөн Зам, замын байгууламжийн хөрөнгийн менежментийн төлөвлөгөө (ЗЗБХМТ)-г хамруулна.</u></p> <p><u>(в) авто замын аюулгүй байдал; үүнд Зам тээврийн ослын мэдээллийн платформ ба хурдны зохицуулалтын төлөвлөгөө, хурд сааруулах арга хэмжээнүүдийг хамт тодорхойлно.</u></p> <p>(г) нийтийн тээврийн шинэчлэл: үүнд Улаанбаатар хотын зам, тээврийн салбарт хувийн хэвшлийн оролцоонд зориулсан бодлогын ба институцийн тогтолцооны хүрээ мөн Mobility-as-a-Service (MaaS)-т чиглэсэн ухаалаг, цогц нийтийн тээврийн системийг хөгжүүлнэ.</p> <p>3.2 Чадавх бэхжүүлэх ба хэрэгжилтийн дэмжлэг</p> <ul style="list-style-type: none"> • Төслийн менежмент болон хэрэгжилтийн дэмжлэг • ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах • Семинар, сургалт, хурал, танилцах аялал
<p><i>Бүрэлдэхүүн хэсэг 4: Болзошгүй, онцгой байдлын хариу арга хэмжээ (CERC)</i></p> <p><i>(нийт өртөг: 0 америк доллар)</i></p>	<p>Энэхүү тэг өртөгтэй бүрэлдэхүүн хэсэг нь онцгой хямрал гэж хүлээн зөвшөөрөгдсөн онцгой байдлын үед түргэн хариу арга хэмжээ авахад зориулагдсан бөгөөд Улаанбаатараас шаардлагатай тохиолдолд яаралтай тусламж үзүүлэх, сэргээн босгох ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор төслийн санхүүжилтийг дахин хуваарилуулах хүсэлтийг Дэлхийн банкинд гаргах суваг, боломжийг олгоно.</p>

9. Нэгдүгээр бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 2 төрлийн ажлыг төлөвлөсөн:

- I-р төрлийн ажлуудад одоо байгаа автозамын зурваст явган хүний зам, автобус давуу эрхтэй зорчих эгнээ, дугуйн замд илүү орон зай хуваарилахаар автозам, гудамжны орчинг өөрчлөн зохион байгуулан, уулзварын сувагчлал, хучилтын засвар болон тэмдэглэл, гэрлэн дохио, тэмдэг, хайс, хашилт г.м. замын хөдөлгөөний инженерчлэлийн тоноглолыг засах, солих, нэмэлтээр суулгах ажлууд хийгдэнэ.
- II-р төрлийн ажил нь сүлжээний холбогдох байдлыг сайжруулах, гэр хорооллыг холбохоор коридорын өргөтгөл, шинэчлэлийн ажлууд хамаарна. Энэ төрлийн ажил нь одоо байгаа автозамын зорчих хэсгийг өргөтгөх зорилгоор газар чөлөөлөх шаардлагатай болно. Төслийн I үе шатны явцад II төрлийн ажлуудын гудамж замын коридор эцэслэгдэнэ.



Зураг 1. I-р төрлийн ажлын хүрээний коридорууд

1.3. Хэрэгжилтийн бүтэц зохион байгуулалт

10. Улаанбаатар хотын захиргааны хэрэгжүүлэгч агентлагууд болох Нийслэлийн авто замын хөгжлийн газар (НАЗХГ), Нийтийн тээврийн үйлчилгээний газар (НТҮГ), Замын хөдөлгөөний удирдлагын төв (ЗХУТ) зэрэг байгууллагууд нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (НЗДТГ)-ын удирдлага дор үндэсний болон хотын түвшний засгийн газрын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

- Төслийн удирдах хороо ЗТХЯ/СЯ/УБХЗ
- Төсөл хэрэгжүүлэх нэгж: ТУА
 - Төсөл батлагдан, хүчин төгөлдөр болмогц ТУА нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэд байгуулагдах бөгөөд Нийслэлийн Засаг даргын захирамжаар захирлыг томилно, СЯ-ны удирдамжийн¹ дагуу Улаанбаатар хотын захиргаа нь албан хаагчдыг гэрээлэн ажиллуулах ба үйл ажиллагааны зардлыг Дэлхийн банкны зээлийн үйл ажиллагааны нэмэгдэл зардлаас гаргана.
 - Үүрэг хариуцлага: Төслийн менежмент ба зохион байгуулалт, худалдан авалт ба гэрээний менежментийг шаардлагатай өөр өөр техникийн багуудын удирдлага зохион байгуулалтаар хэрэгжүүлэх ба санхүүгийн менежмент, байгаль орчин, нийгмийн хүрээний хэрэгжилт, гомдлыг хянан шийдвэрлэх механизм, хяналт үнэлгээ, тайлан ба ДБ тай харилцах харилцаа, холбооны асуудлыг хариуцна.

¹ Сангийн сайдын 2021 оны 1-р сарын 11-ний өдрийн 4 тоот тушаал, “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”

- Хэрэгжүүлэгч байгууллагууд (ХБ):
 - НАЗХГ
 - ЗХУТ
 - НТҮГ

1.4. БОНМХ-ний зорилго, цар хүрээ ба арга зүй

11. Энэхүү БОНМХ нь хөрөнгө оруулалтын дэд төслүүдийн үйл ажиллагааны байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл болон эрсдэлийг удирдан зохион байгуулах, хянах зарчим, дүрэм, журмууд удирдамжуудыг багтаан тайлбарласан болно. Дэд төслийн зураг төсөл нь төсөл хэрэгжих явцад нарийвчлан тодорхойлогдох ба нэмэлт зөвлөлдөөн болон байгаль орчин нийгмийн нөлөөллийг техникийн нарийвчилсан зураг төсөлд үндэслэн боловсруулах шаардлагатай. Иймд, энэхүү хүрээ нь цаашид дэлгэрэнгүй боловсруулагдах дэд төслүүдийн сөрөг нөлөө ба эрсдэлүүдийг багасгах, арилгах, дүйцүүлэн нийцүүлэх байгаль орчин ба нийгмийн нөлөөллийг бууруулах арга хэмжээ, төлөвлөгөөг боловсруулсан.

12. Хүрээ нь төслийн үйл ажиллагаа болон дэд төслүүдэд хамаатай Монгол Улсын хуулиуд, байгаль орчин ба нийгмийн менежментийн журмууд, Дэлхийн банкны байгаль орчин ба нийгмийн стандартууд (БОНС), Дэлхийн банкны эрүүл мэнд ба аюулгүй ажиллагааны удирдамжуудыг тодорхойлсон. Энэ нь тогтвортой, нийгмийн хариуцлагатай төслийн дизайн болон хэрэгжилтийг хангахын тулд хэрэгжүүлэгч нэгжүүдийн зайлшгүй дагаж мөрдөх шаардлагатай хуулиуд, стандартууд, удирдамжуудыг багтаан оруулсан бөгөөд төслийн хэрэгжилтийг хангах байгууллагын зохион байгуулалт, чадавхыг сайжруулах хүрээг (Бүлэг 8) тодорхойлж өгсөн. Тайлангийн үндсэн агуулга:

- Байгаль орчин ба нийгмийн суурь судалгаа,
- Байгаль орчин, нийгмийн үнэлгээ ба эрсдлийн үнэлгээ,
- Байгаль орчин, нийгмийн болзошгүй нөлөөлөл ба түүнийг бууруулах арга зам,
- Дэд төслийн байгаль орчин, нийгмийн менежментийн журам,
- Талуудын оролцоо ба гомдол барагдуулах механизм,
- Байгууллагын зохион байгуулалт, чадавхи бэхжүүлэлт.

13. Энэхүү тайлан нь төслийн бүх үе шатанд, төслийн техникийн туслалцааны үед төслийн бүх оролцогч талуудад (ТУА, ГБ, гүйцэтгэгчид, зөвлөхүүд) нөлөөллийг бууруулах, төлөвлөгөө гарган ажиллахад зааварчилгаа болох ба хавсралт баримт бичгүүд багтсан болно. Үүнд:

- Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын хүрээ
- Хөдөлмөрийн менежментийн журам
- Талуудын оролцоог хангах төлөвлөгөө
- Дэд төслүүдийн эрсдэлийг үнэлэх арга зүй

- Байгаль орчин, Нийгмийн Менежментийн Төлөвлөгөө
- Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө болон Замын хөдөлгөөний түр зохицуулалтын хүрээ
- Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөний даалгавар
- Жишиг сахилгын дүрэм

14. Энэхүү БОНМХ нь КОВИД-19 цар тахлын үеийн хязгаарлалт, хатуу хөл хорио болон дэглэмийн үед боловсруулагдав. Тиймээс, талуудаас авах мэдээлэл нь хоцорч ирэх, төслийн талбай дээр ажиллах, мөн уулзалтууд нь хойшлогдсон болон хязгаарлагдмал байв. Мөн түүнчлэн талуудын хэлэлцээр нь цахимаар болон боломжтой нөхцөлд уулзалт хэлбэрээр зохион байгуулагдсан болно. Тиймээс, БОНМХ нь төсөл хэрэгжүүлэх явцад Банкны шаардлагад нийцэх байдлаар шинэчлэгдэн/засагдах болно.

2. Бодлого, эрх зүйн орчин

2.1. Дэлхийн банкны Байгаль Орчин, Нийгмийн Хүрээ

15. Улаанбаатар хотын захиргаа нь байгаль орчин болон нийгмийн тогтвортой байдлыг хангасан энэхүү төслийн дизайн, хэрэгжилтэд тавигдах Дэлхийн банкны байгаль орчин ба нийгмийн шаардлагуудыг дагаж мөрдөх төдийгүй төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөлөл эрсдэлийг үнэлэх, удирдах, байгаль орчин, нийгмийн хүрээнд заагдсан байгууллагын чадавхыг сайжруулна. Байгаль орчин, нийгмийн хүрээ (БОНХ) нь аливаа төслийн байгаль орчин нийгмийн эрсдэл, сөрөг нөлөөллөөс зайлсхийх, эрсдэлийг багасгах, бууруулах зорилгоор боловсруулагдсан Байгаль орчин, нийгмийн 10-н стандарт (БОНС)-ыг агуулдаг. (Дэлхийн Банк, 2016) Энэхүү 10-н стандартын 9 нь УБТАТ төслийн үйл ажиллагаанд хамааралтай юм.

16. Холбогдох стандартууд

- БОНС1 Байгаль орчин, нийгмийн эрсдэл болон нөлөөллийн үнэлгээ. Улаанбаатар хотын захиргаа болон Төсөл хэрэгжүүлэх нэгж нь энэхүү стандартаар тухайлсан төслийн бүрэлдэхүүн хэсгүүд дэх коридоруудын дэд бүтцийн хөрөнгө оруулалтын төслүүдийн байгаль орчин нийгмийн боломжит нөлөөллийн үнэлгээг хийж БОННУ-ийн нэг хэсэг болох БОНМТ болон БОННУ-г хариуцлагатайгаар хэрэгжүүлнэ. Тус үнэлгээгээр бусад боломжит хувилбарыг хянах бөгөөд мөн үнэлгээ нь нөлөөллийг багасгах, менежментийн болон мониторингийн тохирох арга хэмжээнүүдийг төлөвлөхөд тусалдаг.
- БОНС2 Хөдөлмөр, ажлын нөхцөлийн талаарх энэхүү стандарт нь төслийн замуудыг барьж байгуулах болон засварлах үед ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд хамаатай бөгөөд гэрээ байгуулсан талууд Мэргэжлийн Эрүүл мэнд, Аюулгүй Ажиллагааны Төлөвлөгөө (МЭМААТ) боловсруулан Дэлхийн банкны группийн Байгаль Орчин Эрүүл Мэнд Аюулгүй Ажиллагааны (БОЭМАА) удирдамжууд, Байгаль Орчин Нийгмийн Менежментийг Хүрээг (БОНМХ) дагаж мөрдөх шаардлагатай.

- БОНС3 Нөөцийг үр ашигтай ашиглах, бохирдлоос сэргийлэх менежмент. Нөөцийг үр ашигтай ашиглах болон хог хаягдлын үр дүнтэй менежментийг багтаасан ногоон зураг төсөл бол төслийн үндсэн хэсэг юм. Улаанбаатар хотын авто зам, тээврийн тогтолцоо цаг агаарын гаралтай эрсдэлийг даван туулах чадавхыг сайжруулахад анхаарч төслийн дизайныг боловсруулахдаа цаг агаарын гаралтай болон байгалийн гамшгийн эрсдэлийг нарийвчлан судалж үзэн төсөлд нөлөөлөх үер, шуурга, хахир өвлийн нөхцөлүүд гэх мэт гол гол цаг агаарын эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлж авч үзсэн байхад анхаарна.
- БОНС4 Оршин суугчдын эрүүл мэнд ба аюулгүй байдал. Эрсдэлийн үнэлгээ ба түүнийг бууруулахад тохирох арга хэмжээг авахад дараах зүйлүүдийг анхаарна: (i) Тээврийн хэрэгслийн хурдыг явган зорчигчдын хөдөлгөөнтэй уялдуулж аюулгүй байлгахаар гудамжийг зохион байгуулах; (ii) тээврийн хэрэгслийн хурдыг багасгаж зам хөндлөн гарах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээнүүд; (iii) явган зорчигч ба дугуйтай зоригчдод зориулсан дэд бүтэц ба нийтийн эзэмшлийн талбай нэвтэрч орох гарах, орц, гарц; (iv) тээврийн хэрэгслийн коридорууд, зогсоолууд, буудлуудад хүрч очих аюулгүй орц. Дэд төслүүдийн дор хийгдэх бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд (сонгогдсон коридоруудыг засварлах, сайжруулах, дахин бүтээн байгуулах) аюулгүй ажиллагааны зайлшгүй дагаж мөрдөх ёстой зүйлүүдэд яаралтай хариу үйлдлүүд ба бэлэн байдлыг хангах үйл ажиллагаанууд багтах ба бүтээн байгуулалтын ажиллагааны ойр орчмын оршин суугчид ялангуяа Улаанбаатар хотын хүн амын нягтаршил ихтэй газрууд болон замын хөдөлгөөний ачаалал ихтэй газруудад Ковид 19-ээс үүдэх үр нөлөөллийг бууруулах арга хэмжээг авах нь үүнд багтана.
- БОНС5: Газар чөлөөлөлт, газрын ашиглалтын хязгаарлалт ба албадан нүүлгэн шилжүүлэлт; Газар эзэмшил ба амьжиргаатай холбоотой эрсдэлийг үнэлэхийн тул Нүүлгэн Шилжүүлэлтийн Бодлогын Хүрээ (НШБХ)-г БОНС5-ын дагуу боловсруулдаг ба санал болгож буй хөрөнгө оруулалт болгон дээр ирээдүйд хийгдэх үнэлгээнүүдийн шалгуурыг урьдчилан боловсруулдаг, мөн холбогдох бүрэлдэхүүн хэсгүүдийн дор дууссан бүтээн байгуулалтын нөлөөллийн ирээдүйн шинжилгээний ажилд зориулсан шалгууруудыг мөн боловсруулдаг.
- БОНС6: Биологийн олон янз байдлыг хамгаалах ба амьд байгалийн нөөцийн тогтвортой менежмент. Төсөл нь дэд төслүүдэд зориулсан үнэлгээний тайлан ба менежментийн төлөвлөгөөг боловсруулж зам ба тухайн газарт үүсэх эрсдэл, эрсдэлийг бууруулах арга хэмжээг тодорхойлон тусгай хамгаалалттай газруудад (амьдрах орчин, зэрлэг амьтан ба бусад) учруулах эрсдэл нөлөөллийг хамгийн бага байлгахаар төлөвлөнө. ТУА нь байгаль орчны Мэргэжлийн хяналтын газрын зохион байгуулах ажлууд, судалгааны ажлууд, техникийн болон нөлөөллийн мониторингийн ажлуудыг хийж гүйцэтгэхэд нь зориулж төсөв баталж өгнө.
- БОНС7: Уугуул иргэд/Сахар орчмын Африкийн уламжлалт хэв маягаар амьдарч буй эрх ашиг нь орхигдох хандлагатай орон нутгийн иргэд. Угсаатны цөөнх иргэд гэр

хороололд амьдардгийг анхаарч үзэх хэрэгтэй хэдий ч хотын нийгэм эдийн засгийн нэг хэсэг болж амьдардаг. Иймд БОНС7 төслийн хувьд хамааралгүй бөгөөд ТОХТ-д угсаатын цөөнхийн оролцоог хангах арга хэмжээг тусгасна.

- БОНС8: Соёлын өв. БОНС8 нь төслийн үйл ажиллагаатай холбоотой инженерийн байгууламжид хамаатай юм. Бүтээн байгуулалтын явцад урьд нь мэдэгдэж байгаагүй соёлын өвийн олдвор гарч ирвэл ямар журмыг дагаж мөрдөхийг төслийн БОНХТ-д тусгаж өгсөн байдаг. Биет бус соёлын өвд үзүүлж болох боломжит нөлөөлөлтэй холбоотой дүн шинжилгээнүүдийг БОНМХ-нд тусгах болно.
- БОНС10 Талуудын оролцоог хангах ба мэдээллийн ил тод болгох. Талуудын оролцоог төлөвлөгөө (ТОХТ) г энэхүү БОНМХ-нд хамруулан боловсруулдаг. Оролцоо ба хэлэлцүүлгүүдтэй холбоотой үйл ажиллагааг БОНС10-ын дагуу зохион байгуулж төслийн үйл ажиллагаа, БОНМХ-ний холбогдох оролцооны процессууд мөн төсөл хэрэгжих үед өөрчлөлтүүдийг хийх үед, эрсдэл үүсэх үед, төсөл нөлөөлөгдөж буй талууд болох бизнесийн эзэд, ажилчид, оршин суугчид, төрийн бус байгууллагууд (ТББ), хэвлэл мэдээлэл, олон нийт, бизнесийн холбоод зэргийг оролцуулах үед дагаж мөрдөгдөнө.

2.2. Дэлхийн банкны байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны удирдамж

17. Байгаль орчин, Эрүүл мэнд болон Аюулгүй ажиллагаа (БОЭМАА)-ны удирдамж нь Олон Улсын Аж Үйлдвэрийн Сайн Туршлагын (ОУАҮСТ))2 ерөнхий болон аж үйлдвэрийн онцлог жишээнүүд бүхий техникийн лавлах баримт бичиг юм. Төслийн үйл ажиллагааны онцлог, Ковид-19 цар тахлаас үүдэлтэй нөлөөллийг харгалзан БОНМХ нь дараахь БОЭМАА-ны удирдамж, бэлтгэл ажлын явцад гарах сайн туршлагыг тэмдэглэж байна.

- Дэлхийн банк группын Байгаль орчин, Эрүүл мэнд болон Аюулгүй байдлын удирдамжууд (БОЭМАА)-ыг дагаж мөрдөнө.
- Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын ажлын байрыг Ковид-19 -т бэлтгэх, 2020 оны 3 дугаар сар. (<https://www.who.int/docs/default-source/coronaviruse/getting-workplace-ready-for-covid-19.pdf>)

2.3. Монгол Улсын бодлого ба журам

18. Монгол Улс нь байгаль орчны хамгаалал, менежмент, бохирдлын хяналт, биологийн олон янз байдлын хамгаалалтай холбоотой 100 гаруй хууль, журам, тушаал, олон улсын

²Дэлхийн хэмжээнд ижил буюу төстэй нөхцөлд ижил төрлийн ажил эрхэлж буй чадварлаг, туршлагатай мэргэжилтнүүд мэргэжлийн үр чадвар, хичээнгүй байдал, хянамгай байдал, алсын хараатай ажиллана гэж тодорхойлсон болно. Чадварлаг, туршлагатай мэргэжилтнүүд төслүүдээс үүдэх бохирдлоос сэргийлэх ба бохирдлыг хянах аргуудыг олж тодорхойлох үед хүрээлэн буй орчны доройтлын олон янзын түвшингүүд, хүрээлэн буй орчныг шингээх олон янзын чадварыг тогтоож, санхүүгийн болон техникийн олон янзын нөхцөл байдалтай тулгарах боломжтой.

гэрээ, стандартыг дагаж мөрддөг. Монгол Улс байгаль орчинтой холбоотой үндсэн олон улсын конвенц, гэрээ, хэлэлцээрт нэгдэн гарын үсэг зурсан байдаг боловч үр дүнтэй хэрэгжүүлэх нь нөөц бололцоо нь тулгамдаж буй асуудлуудын нэг байна. Донорууд болон төрийн бус байгууллагууд Монгол Улсын Засгийн газартай хамтран байгаль орчны хамгаалалтай холбоотой олон тооны стратеги, хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж байна. Эдгээрт Байгаль орчны үндэсний хөтөлбөр, Байгаль орчны талаар төрөөс баримтлах бодлого, Биологийн олон янз байдлыг хамгаалах үйл ажиллагааны хөтөлбөр, тусгай хамгаалалттай газар нутгийн үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр, 21 дүгээр зууны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг орно. Монгол Улсын Засгийн газар 1990, 2012 онд газрын тухай, тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, усны тухай, ойн тухай, амьтны тухай, байгалийн ургамлын тухай хууль зэрэг байгаль орчны талаарх гол гол хуулиудыг шинэчилсэн.

19. Улаанбаатар хотын тогтвортой автозам тээвэр төслийн хүрээнд төлөвлөж буй дэд төслийн үйл ажиллагаанд холбогдох Монгол Улсын үндсэн хууль, стандартууд энэ бүлэгт тайлбарлав. Байгаль орчны хяналт, талуудын оролцоо болон байгаль орчны шийдвэр гаргах явцад олон нийтийн оролцоо зэргийг Байгаль орчныг хамгаалах тухай хууль (2002 онд нэмэлт өөрчлөлт оруулсан), Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар (2012 онд нэмэлт өөрчлөлт оруулсан) баталгаажуулсан байдаг.


20. Санал болгож буй төслүүдийн байгаль орчин, нийгмийн аюулгүй байдлыг Байгаль орчны тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар зохицуулдаг. Нийгмийн суурь үзүүлэлт, нөлөөллийг нарийвчилсан БОНБУ-ний хэсгээр үнэлдэг, ба түүнчлэн Монгол Улсад нийгмийн нөлөөллийн тухай бие даасан хууль байдаггүй.

21. Байгаль орчныг хамгаалах тухай хууль: хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, экологийн хувьд нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулдаг. Энэ нь газар, хөрс; байгалийн нөөц ба ашигт малтмалын нөөц, ашигт малтмал (газрын дээрх болон доорх); ус; ургамал; амьтан ба агаар зэргийг хамгаалах суурь хууль юм.

22. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль: Энэ хуулийн заалтууд нь бүх дэд-төслүүдэд хамааралтай. Энэхүү хуулийн зорилго нь байгаль орчныг хамгаалах, экологийн тэнцвэрт байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх, байгалийн нөөцийн ашиглалтыг зохицуулах, аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, төслийн хэрэгжилтийн талаар шийдвэр гаргахыг журамлах явдал юм. Хууль нь байгалийн нөөцийг ашигладаг төслүүд, бүтээн байгуулалтын үйл ажиллагаа, одоо байгаа үйлдвэрлэл үйлчилгээг нөхөн сэргээх өргөжүүлэхэд хамаатай. Төлөвлөсөн үйл ажиллагааны төрөл ба хэмжээ нь Байгаль Орчин, Аялал Жүүлчлалын Яам эсхүл Нийслэлийн Байгаль орчны газар (Орон нутгийн засаг захиргаа)-ын баталсан эрх үүргийн хүрээнд тодорхойлогддог.

23. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн Ерөнхий- БОНБЕУ болон Нарийвчилсан БОНБНУ гэсэн хоёр төрөл байдаг. Төсөл хэрэгжүүлэгч нь төсөл хэрэгжүүлэх газрын төлөв байдлын үнэлгээ (ТБҮ), төслийн техник эдийн засгийн үндэслэл судалгаа (ТЭЗҮ), техникийн тодорхойлолт, зураг төсөл,

бусад мэдээллийн БОАЖЯ-д байгаль орчны ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлтийг гаргана. Яам нь хянан судалж дараах дөрвөн төрлийн дүгнэлтийг нэгийг гаргана. (i) БОНБНУ нь шаардлагагүй; (ii) тусгай нөхцөлтэй төслийг хэрэгжүүлэх боломжтой; (iii) БОНБНУ нь шаардлагатай; эсвэл (iv) төсөл хэрэгжүүлэх боломжгүй.



Зураг 2. Монгол улсын БОННУ-ний зарчим

24. Байгаль орчны мониторингийн үндэсний шаардлага:

Байгаль орчны мониторингийн суурь үзүүлэлтийг бий болгох явдал нь орчны агаар ус, орчны чимээ, хөрс зэргийн чанарыг илтгэх үзүүлэлт бөгөөд энэ нь чанарын үзүүлэлт нь бохирдуулагч, бусад хүний хүчин зүйлүүд, хог хаягдлын боловсруулалт (нөлөөллийн мониторинг) зэрэгт хэрхэн нөлөөлөгдөж буйг харуулдаг. Төсөл хэрэгжүүлэх газар болон ойр орчмын газарт эсхүл газрын доорх ус ба нуур агаар мандалд бохирдуулагч бодисууд ба шимт бодисууд зөөвөрлөгдөн очиж буйг болон шингэж буйг байгаль орчны мониторингоор судалдаг. Мониторинг хяналт нь аливаа төсөл эхлэхээс өмнө мөн төсөлтэй холбоотой үйл ажиллагаа явагдаж эхлэх үед тэдгээрийн нөлөөллийг хянах зорилгоор байгаль орчны чанарыг харьцуулан судалдаг. Нөлөөлөлд автаагүй нөхцөл байдалд гэнэтийн өөрчлөлт гарахыг мөн шалгаж судалдаг.

Цаг уур, орчны хяналт шинжилгээний үндэсний газрын (ЦУОШГ) -ын дэргэдэх Байгаль орчны лаборатори нь хүрээлэн буй орчны чанарыг хянах болон ус, агаар, хүчлийн хуримтлал, хөрс, тоосжилт зэргийн байгаль орчны мониторингийг хариуцан ажилладаг. Улаанбаатар дахь лабораториуд нь агаар, ус, хөрсний чанарын талаар тогтмол хэмжилт хийж, цахилгаан станц, автомашин гэх мэтийн бохирдлын хог хаягдлын үүсвэрийг хянадаг ба байгаль орчны үнэлгээнд шаардлагатай хяналт шинжилгээний ажлыг гүйцэтгэж, үйлдвэрлэлийн хог хаягдлыг бусад байгаль орчны хяналтын байгууллагуудтай хамтран хянадаг.

26. Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт. Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх асуудлыг зохицуулсан зориулагдсан тухайлсан, тодорхой хууль байхгүй байна. Монгол Улсын үндсэн хуулиар засгийн газрын газрыг чөлөөлөх эрх мэдлийг заасан хэдий ч газартай холбоотой бүх хуулиудад хувийн эзэмшил газрыг олон нийтийн зорилгоор төр болон аливаа нэгэн байгууллага ашиглах талаар дурдаагүй байдаг. Одоогийн Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу аливаа газар чөлөөлөлтийг, түүний дотор нийтийн бохирын гол дамжуулах хоолой барих газар зэрэг нийтийн хэрэгцээнд зориулагдсан газрыг хэлэлцээр болон тохиролцооны үндсэнд тулгуурлан авч байна. Хэрэв хэлэлцээр бүтэлгүйтвэл энэ тохиолдолд хэргийг шүүхээр шийдвэрлэх шаардлагатай байдаг. Хуулиудад газрыг албадан чөлөөлөх талаар заагаагүй боловч газар солилцох, нөхөн олговор олгох замаар улсын тусгай хэрэгцээнд авах заалтууд байдаг. Гэсэн хэдий ч холбогдох журам нь бүрэн бус, тодорхой бус бөгөөд нөлөөлөлд өртсөн хүмүүсийн эрх болон эд хөрөнгийн эрхийг зохих ёсоор хамгаалж чадахгүй байна. Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн хууль эрх зүйн үндсэн хүрээ түүнтэй холбоотой асуудлууд: (i) Монгол Улсын Үндсэн хууль, (ii) Газрын тухай хууль, (iii) Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, (iv) Монгол Улсын иргэний хууль. Эдгээр хуулиас гадна Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 4-р хавсралтын "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах журам" -ыг Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагаанд хэрэглэдэг.

27. Хотын хөгжил төлөвлөлт ба бүтээн байгуулалтын шат шатны хэрэгжүүлэлтэд иргэдийн оролцоог хангах явдлыг Хот байгуулалтын хуульд (2015 оны 17, 18 дугаар заалтад) зааж өгсөн байдаг. Хотын хөгжил төлөвлөлттэй холбоотой аливаа шийдвэрийг олон нийтэд цаг алдалгүй хүргэж олон нийтэд ил тод түгээх ёстой байдаг.

28. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль (1999), Үйлдвэрчний эвлэлийн тухай хууль (1991), Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011), Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2015 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан) мөн Засгийн газар болон гурван талт байгууллагуудаас баталсан холбогдох журам нь Монгол Улсын ажилчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн орчныг баталгаажуулдаг. Олон улсын Хөдөлмөрийн Байгууллагын (ОУХБ) суурь найман конвенцийг Монгол улс бүгдийг соёрхон баталж хэрэгжүүлдэг. Үүнд: Эвлэлдэн нэгдэх ба зохион байгуулах эрхийг хамгаалах тухай 1948 оны 87 дугаар конвенц; Зохион байгуулах эрх ба хамтын хэлэлцээний тухай 1949 оны 98 дугаар конвенц; Албадан хөдөлмөрийн тухай ОУХБ-ын 1930 оны 29 дүгээр конвенц, 1930 он (№ 29); Албадан хөдөлмөрийг устгах тухай 1957 оны 105 дугаар конвенц; Хөдөлмөрийн

насны доод хязгаарын тухай 1973 оны 138 дугаар конвенц; Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 1999 оны 182 дугаар конвенц; Тэгш шан хөлс олгох тухай 1951 оны 100 дугаар конвенц; Ялгаварлан гадуурхахгүй байх (ажил, мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай 1958 оны 111 дүгээр конвенц. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2015 онд нэмэлт өөрчлөлт оруулсан) нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар төрийн бодлого, зарчмуудыг тодорхойлж өгдөг бөгөөд ХАБЭА-н менежментэд тавигдах шаардлага ба хяналтын системийг хангаж байдаг.

2.4. Хууль зүйн дүн шинжилгээ

29. Монгол Улсын байгаль орчны талаар төрөөс баримтлах бодлогын үндсэн зарчим нь эдийн засгийн хөгжлийн аливаа үйл ажиллагаа нь байгалийн нөөцийн олборлолт ба ашиглалттай уялдах үед агаар, ус, хөрсний бохирдлыг хяналтанд байлгана гэсэн зарчмыг Монгол Улсын байгаль орчны талаар төрөөс баримтлах бодлогот тусгасан байдаг. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үндэсний хороо нь 1996 оны 4 сард тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах зорилготой байгуулагджээ. Улс орны стратеги нь байгаль орчинд ээлтэй эдийн засгийн хувьд тогтвортой, нийгэмд ээлтэй хөгжлийг урт хугацааны тогтвортой хөгжлийг хөдөлгөгч хүчин зүйл нь хүн юм гэж тодотгон боловсруулагдсан байдаг. Гэсэн хэдий ч, хэрэгжүүлэлтийн түвшинд Дэлхийн Банк-ны Байгаль орчин, нийгмийн хүрээнтэй харьцуулахад доор дурьдсан ялгаа хэвээр байна.

2.4.1. Монгол орны байгаль орчны нөлөөлөх байдлын журмуудыг Дэлхийн Банкны бодлогуудтай харьцуулсан байдал.

30. Монгол Улс "байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний менежмент" -ийн зарчмыг олон улсын хөрөнгө оруулалт, тусламжийг татах зорилт болон нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны тулгамдаж буй асуудлуудад үндэслэн боловсруулсан. Шаардлагатай Байгаль орчны нөлөөллийн журам, БОНБУ-ний тухай хуулийг анх 1998 онд боловсруулж 2012 онд нэмэлт өөрчлөлт оруулсан. Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн үндсэн зарчим нь, бохирдол ба байгаль орчны нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг "бохирдуулагч нь төлөх" буюу төсөл хэрэгжүүлэгч тал нь байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, нөхөн сэргээх нөлөөллийг бууруулах арга хэмжээний өртөг зэргийг хариуцан гаргадаг. Энэ зарчим нь Дэлхийн банкны байгаль орчин нийгмийн стандартын шаардлагуудтай уялдаж байна. Гэвч хууль тогтоомжийг хэрэгжүүлэх мэдлэг чадвар, институцийн чадавхи дутагдалтай байгаа нь Монгол улсад дутагдалтай байна.

- **Эрсдэлд суурилсан байгаль орчин, нийгмийн менежмент**

31. Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль:

Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу хөгжлийн бүх төслүүд нь тухайн төсөл дараах шийдвэрүүдийн төрлийн аль нэгд хамаарч байгааг тодорхойлохын тулд байгаль орчин ба нийгмийн нөлөөллийн түргэвчилсэн судалгааг хийлгэх шаардлагатай байдаг: Судалгааны үндсэн дээр гарах шийдвэрүүд нь дараах байдлаар гардаг. 1)Төсөл нь байгаль орчны нөлөөллийн бүрэн үнэлгээг хийлгэх шаардлагатай; 2)Төсөл нь тусгай нөхцөлийн дагуу байгаль орчны зөвшөөрлийг

баталгаажуулах шаардлагатай; 3) Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэх шаардлагагүй төсөл. Ерөнхий буюу түргэвчилсэн үнэлгээ нь анхдагч үнэлгээний процессуудыг агуулдаг. БОАЖЯ орон нутгийн байгаль орчны газар нь санал болгож буй хөгжлийн төлөвлөгөөнд байгаль орчны үнэлгээ хийлгэх шаардлагатай эсэхийг шийдвэрлэдэг. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний ажилд үндэсний стандартууд хангалтгүй байвал хөгжлийн төслийг хэрэгжүүлэгч нар үндэсний болон олон улсын стандартыг дагаж мөрдөх ёстой байдгийг хуулиар заасан байдаг.

32. Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн стандарт нь бүх төслүүдийг 1) Өндөр эрсдэлтэй; 2) Чухал ач холбогдол бүхий эрсдэлтэй; 3) Дунд зэргийн эрсдэлтэй; 4) Бага зэргийн эрсдэлтэй (БОНС1) гэж тус тус ангилдаг. Банкны зөвлөл батлахаас өмнө төслийн эхний шатанд эрсдэлийг ангилдаг. Төслийн ангилал ба тухайн ангилалд оруулсан үндэслэлийг банкны вэбсайт, төслийн бичиг баримтууд дээр дэлгэн ил болгон тавьдаг.

- **Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ):**

33. Дэлхийн банкны бодлого нь Монгол Улсын хуулиудын адилаар хөрөнгө оруулагч, төслийг дэмжигч, зээлдэгч нарыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхийг шаарддаг. БОНБҮТХ -д 6 заалт байдаг нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдаж тодорхойлогдсон байдаг. Дэлхийн банкны бодлогын бичиг баримттай харьцуулан доорх байдлаар нэгтгэн дүгнэнэ.

Монголын Улсын байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд дараах зүйлүүдийг багтаадаг:

- сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, арилгах байгаль орчны арга хэмжээ
- байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны хуваарь, төсөв
- хяналт, тайлагнал, түүнийг хэрэгжүүлэх хугацааны хүснэгт, хэрэгжүүлэх алхмууд
- оролцогч талуудын оролцооны төлөвлөгөө

Дэлхийн банкны байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөнд дараах зүйлүүдийг багтаадаг:

- Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн багц
- нөлөөллийн эсрэг бууруулах арга хэмжээ
- хяналтын төлөвлөгөө
- чадавхыг бэхжүүлэх
- БОНХТ -ийг хэрэгжүүлэх арга хэмжээний хуваарь, төсөв
- тайлагнах шаардлага
- гомдлын механизм
- оролцогч талуудын оролцооны төлөвлөгөө

- **Ил тод байдал**

34. Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар байгаль орчны нөлөөллийн үнэлгээ болон бусад бичиг баримтуудыг олон нийтэд ил болгохыг албан ёсоор шаарддаггүй байна. БОНБ-ын үнэлгээний бичиг баримтыг 4 хувь боловсруулж байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /БОАЖЯ/ , аймаг сумын Засаг Даргын тамгын газар /төсөл нь Улаанбаатар хотод байрладаг бол/, сүүлийн нэг хувийг төсөл хэрэгжүүлэгч эсвэл төслийн бүрэлдэхүүнийг хэрэгжүүлэгч хадгална / Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8.7 дэх заалт/. Тийм учраас байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланг нийтэд ил болгохыг албан ёсоор шаардаггүй байна.

35. Хуульд байгаа энэ тодорхой бус байдлаас болоод байгаль орчны нөлөөлөх байдал оролцогч талууд, олон нийт хэрэгжилтийн талаар буруу ойлголт авах байдал байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний явцын үед бий болдог. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төслийн талаарх мэдээллийг /үндэслэл, зорилго, үр дүн/ түгээн дэлгэрүүлэх үүрэгтэй байдаг хэдий ч төслийн нөлөөллийг ил тод болгож, мэдээлдэггүй.

36. БОНХ нь зээлдэгчээс ирүүлсэн бүхий л баримт бичигт Дэлхийн банкны Мэдээллийн Хүртээмжтэй Байдлын бодлогыг хэрэгжүүлэхийг шаарддаг. Банк нь өндөр чухал ач холбогдолтой, эрсдэлтэй төслүүдийг төслийн үнэлгээг хийхээс өмнө олон нийтэд ил болгох ёстой байдаг. Энэхүү баримт бичиг нь төслийн байгаль орчин, нийгмийн үнэлгээг тусгасан байх ба эцсийн (боломжтой бол) эсвэл төсөл хувилбар байна. Эдгээр баримт бичиг нь төслийн үндсэн эрсдлүүд болон нөлөөллийг арилгах, засаж сайжруулах аргыг тодорхойлсон байх ба холбогдох талууд болон Банк эцсийн шийдвэр гаргахад хангалттай мэдээллийг агуулсан байх ёстой. Аливаа шинэчлэл, өөрчлөлт, нэмэлт төлөвлөгөө нь нийтэд ил тод байх болно.

- **Олон нийтийн оролцоо:**

37. Монгол Улсын хуульд төслийн талаар шийдвэр гаргах эхний шатанд талуудын оролцоо, олон нийтийн оролцоог хангах дүрэмтэй. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг судласан тал нь нөлөөлөлд өртөх орон нутгийн иргэдэд байгаль орчны нөлөөллийн үнэлгээний үр дүнг танилцуулах ажлыг зохион байгуулах үүрэгтэй байдаг. Гэвч эмзэг бүлгийн хүмүүс болон эмэгтэйчүүдийг нэн тэргүүнд хамааруулахын ач холбогдлыг цохон тэмдэглээгүй байдаг. 18.4-д зааснаар төсөл ба түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн талаар нөлөөлөлд өртөх иргэдийн санал бодлыг сонсож тэмдэглэн авч байгаль орчны нөлөөлөх байдлын бичиг баримтад оруулахыг заасан байдаг. Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (БОНБҮТХ) нь талуудын оролцоог хангаж хэлэлцүүлэг хийх цаг хугацааны хуваарийг тодорхой зааж өгөөгүй байдаг бөгөөд энэ асуудалд ач холбогдол өгөөгүй байдаг.

38. Дэлхийн банкны БОНС10 нь талуудын оролцоо ба мэдээллийн ил тод байдлыг зээлдэгч ба төсөлд оролцогч талуудын хооронд бий болгохыг чухалчилж үзсэн байдаг. Санал болгож буй төсөлд нөлөөлөгдөх хувь хүмүүс, бүлгүүд, оршин суугчид гэх мэт

оролцогч талуудыг болон бусад сонирхогч талуудад зээлдэгч нь мэдээлэл түгээх зөвлөлдөх эрсдэл ба нөлөөллийн талаар мэдээлэл өгөх хэлбэрээр оролцуулах ёстойг шаарддаг.

39. Ерөнхийдөө, Монгол Улсын байгаль орны үнэлгээтэй холбоотой хуулиуд нь Дэлхийн Банкны бодлоготой ерөнхий зарчмын хувьд нийцэж байна. Монгол Улсын байгаль орчны нөлөөллийн үнэлгээний бодлогын давуу тал бол байгаль орчны ихээхэн нөлөөлөл үзүүлэх магадлалтай санал болгож буй төслүүдийн хэрэгжилтээс өмнө хууль эрх зүйн хувьд байгаль орчны нөлөөллийн үнэлгээг гүйцэтгэсэн байхыг шаарддаг явдал юм. БОНБҮТХ нь санал болгож буй бүх бүтээн байгуулалтын төслүүдэд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг хамгийн багадаа гүйцэтгэсэн байх эсвэл урьдчилсан үнэлгээ хийсэн байхыг шаарддаг байна. Мөн бохирдуулагч (хөрөнгө оруулагч, зээлдэгч болон төсөл хэрэгжүүлэгч) нь байгаль орчны хамгаалах үйл ажиллагаа, нөлөөллийн бууруулах арга хэмжээний зардлыг хариуцах боломжийг хангаж, төсөл хэрэгжүүлэгч болон байгаль орчны эрх бүхий байгууллагуудын оролцоог олгож байгаа юм. Мөн Монгол Улсын байгаль орчны үнэлгээний бодлого нь Монгол Улсын засгийн газар болон олон улсын байгууллагын хооронд хийсэн гэрээний нөхцөлүүдээр дамжуулан олон улсын бодлогыг дэмжиж байдаг /2012, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 2.2 дахь заалт/.

40. Монгол Улсын байгаль орчны үнэлгээний хуульд дараах сайжруулах шаардлагатай. 1) Хуулийн олон заалтууд нь тодорхой бус, ойлгомжгүй байна. 2) Хууль нь боломжит нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тэдгээрийн ангилал ба тодорхойлолтод түлхүү анхаарахын оронд байгаль орчны үнэлгээний шат дараа болон талуудын оролцоотой холбоотой харилцаанд түлхүү анхаарсан. 3) Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг санал болгож буй төслийн эцсийн шийдвэр гаргахад ашиглах явдлыг хуульд орхигдуулсан байна.

2.4.2. Нийгмийн бодлого, зохицуулалт

41. Газар чөлөөлөлт ба нүүлгэн шилжүүлэлт. Монгол Улсад хувийн өмчийг төрөөс хүчээр авах бараг тохиолддоггүй, Үндсэн хуулиар хувийн үл хөдлөх хөрөнгийн эрх, үүсмэл эрхийг хүлээн зөвшөөрсөн тул хэрэв шаардлагатай үед Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрөөс эдгээр хөрөнгийг зохих ёсоор, зах зээлийн үнэлгээнд суурилсан нөхөн олговрын төлбөргүйгээр авахыг хориглох бөгөөд газар чөлөөлөлттэй холбогдох эрсдлийг бууруулна.

42. ДБ-ны БОНХ, БОНС5 нь төсөлтэй холбоотой газар чөлөөлөх газар ашиглалтын хязгаарлалтууд нь оршин суугчид ба иргэдэд сөрөг нөлөөлөл үзүүлэх асуудлыг хамруулсан байдаг. Төсөлтэй холбоотой газрын чөлөөлөлт ба газар ашиглалтын хязгаарлалтаас болж нүүлгэн шилжүүлэлт /байршлаа өөрчлөх, амьдарч буй газраа алдах, эсвэл амьдарч буй орон гэрээ алдах/, эдийн засгийн хохирол /газраа алдах, хөрөнгөө алдах, орлогын эх үүсвэрээ алдах, амьжиргааны бусад хэлбэрүүдээ алдах/ эсхүл аль алиныг нь амсах болдог. Газар чөлөөлөх эсвэл газар ашиглалтын хязгаарлалтыг зайлшгүй хийх шаардлагатай үед зээлдэгч нь байгаль орчин ба нийгмийн үнэлгээний дагуу төсөлд нөлөөлөгдөх иргэдийг илрүүлэх судалгааг хийх, нөлөөлөлд өртөх газар ба хөрөнгийн судалгаа хийх, тусламж нөхөн олговорт хамрагдах шаардлагатай хүмүүсийг тодорхойлох, үүнд хамаарахгүй хүмүүс болох үр өгөөж горьдогчид түр зуур ирж хорогдогч нарыг тодорхойлдог. Нийгмийн үнэлгээгээр судалгаа хийж байх үед төслийн газар нутаг дээр байхгүй байсан хэдий ч тухайн газрыг

улирлын чанартай ашиглагч нар болох оршин суугчид бүлэг хүмүүсийг мөн анхаарч үздэг. Зээлдэгч нь хамрагдах он сар өдрийг судалгаанд үндэслэн тогтоодог. Хамрагдах он сар өдрийн талаар бичиж тэмдэглэсэн мэдээллийг төслийн газар нутагт тогтмол тодорхой давтамжтайгаар бичгээр болон бусад хэлбэрээр орон нутгийн хэл дээр түгээн тараадаг. Төслийн газар нутаг дээр оршин сууж буй хүмүүст нүүлгэн шилжүүлэх өдрийн талаар анхааруулага, сануулгыг өгөх ёстой байдаг. Гэвч Монгол Улсын одоогийн хууль журмууд ба түгээмэл хэрэгжиж буй арга хэмжээнүүд нь дараах байдлаар хэрэгждэг. (а) Газар ба хөрөнгийг албан ёсоор эзэмших эрхгүй нөлөөлд автсан хүмүүс нь нөхөн олговор үр өгөөж хүртэх эрхгүй байдаг. (б) Орон нутгийн газрыг чөлөөлөх асуудалд орлого ба аж амьдралыг эргэн сэргээх асуудлыг тусгаагүй байдаг. (в) Нөхөн олговор олгох мөнгөнд үйл ажиллагааны зардлыг оруулаагүй байдаг. (г) Төслийн асуудалтай холбоотой маргааныг Засаг дарга ба шүүх шийдвэрлэх журам байхгүй. (д) Олон нийтийн дунд хэлэлцүүлэг хийх мэдээлэл түгээх асуудал нь хязгаарлагдмал эсвэл дурдагдаагүй, (е) Хамрагдах он сар өдрийг зарладаггүй. (ё) Газар чөлөөлөх журмыг хэрэгжүүлсний дараа инженерийн байгууламжийг эхлүүлэхэд хязгаарлалт байхгүй. (ж) Холбогдох үйл ажиллагааны төлөвлөгөө эсвэл мониторингийн үйл ажиллагаа байхгүй.

43. БОНС7 нь Уугуул иргэд/Сахар орчмын Африкийн уламжлалт хэв маягаар амьдарч буй орон нутгийн иргэд гэдэгт нийгэм соёлын хувьд ялгаатай бүлгийг хэлдэг. БОНС7-оор хөгжлийн процесс нь уугуул иргэд ба уламжлалт хэв маягаар амьдардаг ард иргэдийн хүний эрх, нэр төр, хүсэл эрмэлзэл, бусдаас ялгарах онцлог, соёл, байгалийн нөөцөд тулгуурласан амьдралын хэв маягийг хүндэтгэн үзэх шаардлагатайг заасан байдаг. Угсаатны цөөнхийн эрхийг Монгол Улсын Үндсэн хууль (1992) -ын 14.2-т зааснаар: "аливаа хүнийг угсаа гарал, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, ядуурлаар ялгаварлан гадуурхаж болохгүй, ажил мэргэжил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол. Түүний 8-р зүйлд үндэс угсаатны цөөнх үндэстнийхээ соёл иргэншлийг хэрэгжүүлэх, өөрийн хэлийг ашиглах эрхийг "бусад хэлний үндэстний цөөнхүүд боловсрол, харилцаа холбоо, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаанд төрөлх хэлээ ашиглах эрх" хэмээн баталгаажуулав. Монгол Улсын Засгийн газарт уугуул иргэд, үндэстний цөөнхийн асуудал, асуудалтай холбоотой тусгайлсан хууль, тогтоомж байхгүй бөгөөд Хөдөлмөрийн тухай хууль нь угсаатны бүлгүүдийн тэгш байдлыг баталгаажуулдаг.

3. Байгаль орчин ба нийгмийн суурь судалгаа

3.1. Байгаль орчны суурь судалгаа

3.1.1. Газар зүй

44. Улаанбаатар хот нь Монгол Улсын хойд төв хэсэгт, Туул голын хөндийн тэгш өндөрлөгт, далайн түвшнээс дээш 4,430 фут (1350 метр) өндөрт байрладаг. Туул, Сэлбэ голууд хотын өмнөд төв хэсгийг дайран өнгөрдөг бөгөөд энэ нь Богд Хан, Баянзүрх, Чингэлтэй, Сонгино хайрхан гэсэн дөрвөн уулаар хүрээлэгдсэн байдаг. Богд Хан уулын орчимд хотын өмнөд хэсэг байрладаг.

45. Улаанбаатар нь Хэнтийн нурууны төгсгөл болох ой тайгын бүс болон Дорнод Монголын тэгш өндөрлөгөөс эхэлж Богд Хан уулын өмнөд бэл хүртэл үргэлжлэх хуурай хээрийн завсар оршдог. Улаанбаатар нь ойн бараан хөрс болон хээрийн хар хүрэн Кастанозем³ бүхий хөрстэй.

3.1.2. Уур амьсгал

46. Улаанбаатар хот бол дэлхийн хамгийн хүйтэн нийслэл бөгөөд 1 дүгээр сард агаарын дундаж температур -24.5 хэм байдаг. Өвлийн улиралд агаарын температур -40 хэмээс доош буурч болно. Уур амьсгалын вариациас болж хавар намрын улиралд ч зузаан хяруу унадаг. Зун нь тааламжтай байдаг: 7, 8 дугаар сард агаарын температур хамгийн ихдээ 25.5 хэм байдаг ба шөнөдөө сэрүүхэн бөгөөд агаарын температур 15 хэм орчим болдог. Жилд 300 мм бороо ба цас унадаг бөгөөд харьцангуй бороо оромтгой.

Хүснэгт 2. Улаанбаатар - Жилийн 12 сарын агаарын дундаж температур

Улаанбаатар – Дундаж температур												
Сар	I сар	II сар	III сар	IV сар	V сар	VI сар	VII сар	VIII сар	IX сар	X сар	XI сар	XII сар
Хамгийн бага (°C)	- 26	-23	-17	-6	0	8	11	8	0	-14	-21	- 22
Хамгийн их (°C)	-16	-11	0	11	17	23	30	27	17	8	-5	-14
Хамгийн бага (°F)	-27	-22	1	21	32	46	52	46	32	19	-6	-20
Хамгийн их (°F)	3	12	32	52	63	73	79	73	63	46	23	7

3.1.3. Агаарын чанар


47. Улаанбаатар нь дэлхийн хамгийн их бохирдол ихтэй нийслэл хотуудын нэг юм. 2019 онд хотын PM2.5-ны түвшин ДЭМБ-ын жилийн долоон сарын аюулгүй түвшнээс⁴ өндөр байв. Улаанбаатарын бохирдлын хамгийн том асуудал бол тоосонцор (PM) юм.Тээврийн

³ Кастанозем нь Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (FAO) -ын ангиллын систем дэх 30 бүлэг хөрсний нэг нь юм. Кастанозем бол язмагаар баялаг хөрс хээрийн унаган ургамалжилт бүхий газар үүсэж бор хүрэн давхаргыг бий болгодог онцлогтой. Эдгээр нь ихэвчлэн өмнөд ба төв Ази, Аргентины хойд хэсэг, АНУ-ын баруун хэсэг, Мексик зэрэг хуурай бүс нутгуудтай хиллэдэг харьцангуй хуурай уур амьсгалын бүсэд (жилд 200-400 мм [8-16 инч] хур тунадас унадаг), тохиолддог. Кастаноземыг гол төлөв усалгаатай газар тариалан, бэлчээрт ашигладаг. Энэ нь дэлхий дээрх эх газрын нийт нутгийн 3.7 хувийг эзэлдэг.

⁴Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын агаарын чанарын удирдамж. Агаарын чанарын удирдамж нь тооцонцрын жилийн дундаж хуримтлалыг авч үздэг. Удирдамжид PM2PM 2.5 жилийн дундаж нь 10 мкг / /м³ буюу 24 цагийн дундаж хэмжээ 25 мкг / /м³-ээс хэтрэхгүй байхаар заасан.

хэрэгслээс үүдэх агаарын бохирдлын үндсэн шалтгаан нь том хэмжээтэй, олон жил эдэлж хэрэглэсэн тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгслийн бөглөрөл, замын хучилт мүү байгаа зэргээс үүсдэг. Өвлийн улиралд Улаанбаатарын агаарын бохирдол нь гэр хорооллын айл өрхүүд, нам даралтын халаалттай уурын зуух (ХБ) –нууд түүхий нүүрс түлснээс (80%); моторт тээврийн хэрэгслээс (10%); нүүрсээр ажилладаг цахилгаан станцуудаас (6%); хатуу хог хаягдал ба хөрсний доройтлоос (4%) болж үүсдэг.

48. Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотын оршин суугчдын хувьд орчны болон гэр, байшингийн доторх агаарын бохирдол нь байгальорчны эрүүл мэндийн хамгийн тулгамдсан асуудлын нэг болоод байна. Зураг дээр үзүүлсний дагуу Улаанбаатар хотын агаарын бохирдлын жилийн $PM_{2.5}$ концентрац (дунджаар бараг 70 мкг / м³) нь Монгол Улсын агаарын чанарын стандарт (25 мкг / м³) ба ДЭМБ-ын агаарын чанарын удирдамж (10 мкг / м³) -аас өндөр байна. 2016 онд НҮБ-ын Хүүхдийн сангаас санхүүжүүлэн сургуулиудын доторх агаарын чанарыг үнэлэхэд дээж авсан сургуулиудад $PM_{2.5}$ -ийн агууламж агаарын чанарын үндэсний стандартаас 3.1-10.05 дахин их байгаа нь харагдсан (Зураг 2).



Зураг 3. Улаанбаатарын $PM_{2.5}$ / PM_{10} (мкг / м) -ын жилийн дундаж агууламж, 2011-2015 он

3.1.4. Усан орчин ба Туул гол

49. II-р төрлийн ажлын хүрээнд санал болгох төсөл хэрэгжүүлэх газрын байршлаас шалтгаалан Туул голд нөлөөлөх магадлалтай юм. Хоёр дахь үе шатны үйл ажиллагааны дэлгэрэнгүйг төсөл хэрэгжилтийн сүүлийн явцад тодорхойлно.

50. Туул гол нь Чисаалайн сарьдаг, Шороотын даваанаас (далайн түвшнээс дээш 2289.2 м) эх авдаг бөгөөд Орхон голд цутгадаг. Голын хөндий цутгал хэсэг рүүгээ өргөсөж, Улаанбаатар хот орчимд ирээд 8-10 км өргөн болдог. Туул голын сав газар нь 5 аймгийн 37 сум, Улаанбаатар хотын 7 дүүргийн нутаг дэвсгэрийг хамран нийтдээ 49774.3 км² талбайг эзэлдэг. Голын сав газрын 65.5% нь Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт, 39.8% нь Төв аймагт, 20.8% нь Булган аймагт, 6.0% нь Өвөрхангай аймагт, 4.4% нь Архангай аймагт, 2.2% нь Сэлэнгэ аймагт харьяалагддаг (FAO, 2012).

51. Хүний үйл ажиллагаанаас болоод Улаанбаатар хот орчимд болон сав газрын 2 ба 3 дугаар дэд сав газруудад амьтны аймаг бага байдаг. Сав газрын голын эхэнд, дунд, адагт байх амьтны аймгийг хөхтөн, загас, хоёр нутагтан, мөлхөгчид тус бүрээр ангилсан. 2011 онд

хэвлэгдсэн Монгол орны шувууны улаан номын дансанд үндэслэн сав газрын шувууны зүйлийн бүрдлийг нарийвчлан тодорхойлсон.

52. Төслийн хүрээнд сонгогдсон Баянхошуу коридороос (хамгийн баруун талд байрлах санал болгож буй төслийн газар) ойролцоогоор 8 км зайд хаягдал усны нуур (ногоон нуур) байрлах бөгөөд 1964 онд баригдсан төв цэвэрлэх байгууламжаас үүссэн. Энэхүү орчим нь 187 зүйлийн нүүдлийн шувуудын дайран өнгөрдөг болон үржлийн шувуудын амьдрах орчинг бүрдүүлдэг байна. 187 зүйлийн, 42 зүйл нь үржлийн, 22 зүйлийн шувуу нь бүс нутгийн болон олон улсын улаан дансны ангилалын дагуу хамгааллын статус өндөр шувууд бүртгэгдсэн байна. Сүүлийн найман жилийн турш орон нутгийн шувуу судлаачид Хошуу галуу (*Anser cygnoides*), Гээзэгт нугас (*Anas falcata*), Улаан хүзүүт шумбуур (*Aythya ferina*), Ундар шумбуур (*Aythya nyroca*), Усны бух шувуу (*Botaurus stellaris*), Зээрд шонхор (*Falco naummanni*), Идлэг шонхор (*Falco cherrug*), Цагаан сүүлт нөмрөг бүргэд (*Haliaeetus albicilla*), Ооч ёл (*Gypaetus barbatus*), Нөмрөг тас (*Aegypius monachus*), Тарважи бүргэд (*Aquila nipalensis*), Хонин тоодог (*Otis tarda*), Цэн тогоруу (*Grus vipio*), Хархираа тогоруу (*Grus grus*), Умардын хавтгаалж (*Vanellus vanellus*), Морин цууцал (*Limosa limosa*), Морин тутгалжин (*Numenius arquata*), Шар түрүүт элсэг (*Calidris ruficollis*), Хадуур элсэг (*Calidris ferruginea*), Ойн шийхнүүхэй (*Anthus trivialis*) болон Шар элэгт хөмрөг (*Emberiza aureola*) зэрэг шувуудыг бүртгэж тэмдэглэсэн байна.

3.1.5. Ургамалан нөмрөг

54. Хотын зах хэсэг нь цэцэрлэгт хүрээлэн, мод, ногоон зүлгээр хучигдсан газраар хомс юм. Хот төлөвлөлт муу байснаас шалтгаалан 1990-ээд оны шилжилтийн үед ногоон бүс, ногоон цэцэрлэгүүд, моднууд устаж алга болсон.

55. Хөдөө орон нутгаас Улаанбаатарт чиглэсэн хүн амын хурдацтай шилжилт хөдөлгөөн, хуучин автомашины тоо нэмэгдсэн, замын хөдөлгөөний зохицуулалтгүй байдал, хот төлөвлөлт байхгүй, барилга байгууламж нэмэгдсэн, Улаанбаатар хотын газар, цэцэрлэгт хүрээлэнгийн менежмент байхгээс болон бусад төлөвлөлт, байгууллагын чадавх дутагдалтай байгаас шалтгаалан нийслэл нь бараг ургамалан нөмрөггүй нүцгэн хот болж байна. Зохицуулалтгүй жижиг дунд хувийн хэвшлийн үйлдвэрлэгчид, машин засварын газраас үүдэлтэй хортой металлуудаар бохирдсон хөрстэй. Гэр хороолол нь гол төлөв хүн, малын ялгадсаар ихээхэн бохирдсон байдаг. Сүүлийн 20 жилийн хугацаанд ногоон байгууламж болон модлог ургамал эрс багассан нь агаарын бохирдол, тоосжилт, амьсгалын замын өвчлөл болон Туул, Сэлбэ голын суурьшлын талбай ба тэдгээрийн гүүр болон сав газрын ойролцоох газрын үерялэлт зэргийг мэдэгдэхүйц ихэсгэж байгаа болно. Гэр хороололд оршин суудаг ядуу иргэдийн тоо нэмэгдсэн нь өвлийн улиралд хотын гудамжинд байгаа модыг тайрч түлшинд хэрэглэх болсон. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд болон компаниуд нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын удирдлага дор (төсвийн хуваарилалт, жилийн ажлын төлөвлөгөө батлах) цэцэрлэгжүүлэлт, хог хаягдлын менежментийг хэрэгжүүлдэг.

56. Улаанбаатарын авто замын сүлжээний эргэн тойрны орчны дуу чимээ нь хөгжиж буй улс орны хотын жишгийн адилаар тээврийн хэрэгслүүд болон үйлдвэрээс голдуу үүсэлтэй

байдаг. Орчны дуу чимээ нь хөдөө орон нутагтай харьцуулахад харьцангуй өндөр байдаг. Дуу чимээний үзүүлэлт нь дундаж үзүүлэлтээс дээгүүр байдаг.

3.1.6. Хог хаягдлын менежмент

57. Улаанбаатар хотын захиргаа нь Морингийн даваа, Нарангийн энгэр, Цагаан даваа гэсэн гурван хог хаягдлын цэгүүдтэй бөгөөд эдгээр нь бүгдээрээ барилга байгууламж, зам засварын хатуу хог хаягдлыг хүлээн авдаг. Төслийн гүйцэтгэгч нь барилга байгууламжийн хог хаягдалд гэрээ байгуулж, хураамж төлөх шаардлагатай. Шингэн хог хаягдал (бохир ус, шуудууны ус, даралтыг шалгасан ус) нь системийн оператортай тохиролцсоны үндсэн дээр бохирын хоолой руу орох ёстой. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний нэг хэсгийн дор хуурай хог хаягдлын хогийн цэгүүдийн даацыг үнэлж үзэх хэрэгтэй.

3.2. Нийгмийн суурь үзүүлэлт

3.2.1. Хүн ам, хот зохион байгуулалт

58. Улаанбаатар хот нь анх байгуулагдсан газар нутгаасаа 30 дахин томорсон бөгөөд засгийн газар, үйлдвэрлэл, санхүү, соёлын үйл ажиллагааны улсын төв нь юм. 2030 он гэхэд хотын хүн ам 1.8 сая болж өснө гэсэн урьдчилсан тооцоо байдаг. Улаанбаатар хотын хүн амын дийлэнх нь угсаатны хувьд халх монголчууд байдаг.

59. Хүснэгт 1-ээр Нийслэлийн өргөжин тэлсэн гэр хорооллын амьдарч буй хүн амыг гэр, байшин, орон сууцанд амьдарч байгаа хувь хэмжээгээр 2019 оны байдлаар харуулсан. Гэр хороололд нийт 206,446.0 хүн, ам амьдардаг бол харин орон сууцанд 176,166.0 хүн ам амьдардаг байна (Үндэсний статистикийн хороо, 2019). Сонгинохайрхан дүүрэгт хамгийн олон өрх гэрт амьдардаг бол сонгогдсон коридорууд нь төвийн болон дундын зайнд орших гэр хорооллын айл өрхүүд хамгийн ихээр байдаг Сонгинохайрхан дүүргийн төв хэсэгт байрлаж байна.

Хүснэгт 3. Улаанбаатар хотын дүүргүүд, гэр хороолол, орон сууцны төрөл 2019

Улаанбаатар											
Гэр хорооллыг тохилог орон сууц, байшин, гэр, орон гэргүй гэх зэрэг ангиллаар нь судласан судалгаа, 2018 он											
2019 оны 1-р сарын 1-ний байдлаар											
	Улаанбатырын дүүргүүд			Гэр хороолол							
				Тохилог орон сууц		Байшин		Гэр		Орон гэргүй	
	Нэр	Нийт өрхийн тоо	Нийт хүн амын тоо	Нийт өрхийн тоо	Нийт хүн амын тоо	Нийт өрхийн тоо	Нийт хүн амын тоо	Нийт өрхийн тоо	Нийт хүн амын тоо	Нийт өрхийн тоо	Нийт хүн амын тоо
1	Баянгол	59536	226869	243	1154	6316	25403	5325	19655	4	9
2	Баянзүрх	95714	343619	334	1241	24616	90368	26958	93271	6	15

3	Сонгино хайрхан	84236	32115 0	227	848	31560	124116	29994	111479	21	52
4	Сүхбаатар	38563	145335	311	1155	10422	39255	8960	32572	11	37
5	Хан Уул	48940	178919	341	1171	11277	40170	9705	32524	16	30
6	Чингэлтэй	40017	157258	463	1805	19933	79838	11281	42575	70	138
7	Улаанбаатар	377612	141075 8	1948	7482	107642	413123	96725	346828	131	284
Гэр хороололд амьдардаг айл өрхийн тоо										206446	
Орон сууцны хороололд амьдардаг айл өрхийн тоо										177766	

58. Улаанбаатар хотын нягтшил багатай хэсэг нь хотын хэв маягаас хамааралтай байдаг. Нийт хот даяар 2 төрлийн ялгаатай хотын хэв маяг ажиглагдаж байна. Эхний хэв маяг нь хотын төв хэсэгтээ төвлөрч социализмын үеийн хот төлөвлөлтийг⁵ сүүлийн үеийн бизнес болон оршин суугчдын хосолмол хөгжилтэй хослуулсан байна. Орон сууцууд нь бүтцийн хувьд 4-5 давхар барилгуудаас бүрдсэн ба хамгийн өндөр барилга 15-20 давхар байна. Задгай талбайн хуваарилалт нь орон сууцныхаа голд (энэ талбайнуудад ихэвчлэн машин тавьсан байдаг) эсхүл урд хэсэгтээ тархсан байдаг. Хоёр дахь хэв маяг нь хотын захаар ажиглагддаг ба хүн бүрд хашааны газрыг өмчлүүлэх хууль гарсны үр дүнд хөдөө орон нутгаас хот руу шилжин ирэгсэд энд зонхилон амьдардаг. Эдгээр газруудад орлого багатай иргэд гэрт оршин суудаг ба энд үндсэндээ дэд бүтэц ба нийтийн үйлчилгээ багатай эсвэл огт байдаггүй (хучилттай зам талбай бүхий гудамж, явган хүний зам, цэцэрлэг, гудамжны гэрэл, цэвэр бохир ус).

3.2.2. Хотын хөгжил ба гэр хороолол

59. Монгол улсын Алсын Хараа 2050, Улаанбаатар Хотыг Хөгжүүлэх Мастер Төлөвлөгөө 2030, Засгийн Газрын Мөрийн Хөтөлбөр 2020-2024 гэх зэрэг бодлогын баримт бичгийн дагуу Улаанбаатар хотын гэр хорооллын оршин суугчдад үйлчилгээг хүртээмжтэй болгож илүү дээр амьдрах орчныг бий болгож, бохирдлын түвшнийг бууруулахын тулд томоохон хэмжээний дахин төлөвлөлтийг хийж байна. Дахин төлөвлөлтийг аажмаар хийж байгаа бөгөөд ирэх арван жилд эдгээр төлөвлөгөөг хэрэгжүүлэх юм. Зарим төслүүд удаашралтай байгаа нь төлөвлөсөн хугацаанаасаа хоцорч, санхүүжилт батлагдахгүй хойшлох, газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлт, бүтээн байгуулалтын чанар зэрэг олон хүчин зүйлээс хамааралтай байна.

⁵ 1924-1990 онуудад Зөвлөлтийн хамааралтай улсын хувьд Монгол Улс Зөвлөлтийн хяналтанд байсан. Зөвлөлт хот төлөвлөлтийн үзэл баримтлал нь Улаанбаатар хотын 1960, 1970, 1980-аад оны хөгжлийг тодорхойлж байв.

60. Тээврийн дэд бүтцийн хэтийн төлөвийн хувьд Улаанбаатар хотын одоогийн газар ашиглалтын бүтэц нь нэг цэгт төвлөрсөн бүтэцтэй. Хотын төвийн бизнесийн бүс нь хотынхоо яг төвд, Засгийн газрын ихэнх яамдууд, салбар нэгжүүд, бизнес, худалдаа үйлчилгээний байгууллагууд, их дээд сургуулиуд нь энд төвлөрдөг. Хотын бусад бүсүүдэд үйл ажиллагааны ийм төвүүд байхгүй. Ажлын өдрүүдэд ихэнх хүмүүс хотын төвийн бизнесийн бүс рүү, үдээс хойш гэр лүүгээ чиглэж хөдөлгөөнд оролцдог. Оргил цагуудад энэ урсгал замын түгжрэлийг үүсгэж нийтийн тээврийн системийн ашиглалт, хүмүүст тухгүй байдлыг бий болгож, аялах хугацааг уртасган төвөгтэй болгодог.

61. Гэр хороолол нь ихэнхдээ сууршлийн бүс байдаг бөгөөд үйлчилгээ худалдааны төвүүдмүү хөгжсөн байдаг. 2030 оны Мастер төлөвлөгөөнд 2010 он гэхэд Улаанбаатар хотын холимог газар ашиглалттай нийт бүсүүд 2 хувиар, 2030 он гэхэд холимог газар ашиглалттай бүсүүд дахин 1.4 хувиар багасна гэж заасан байдаг. Холимог газар ашиглалтууд (жишээ нь оршин суух ба бизнесийн үйл ажиллагааны нэгдэл, үйлдвэрлэл ба худалдааны газрын нэгдэл зэргүүд орно) нь хотын тээврийн дэд бүтцийн эргэлтийг багасгаж, нэгдсэн байдлыг бий болгон, зорчихоор зорьсон газруудыг ойртуулдаг. Улаанбаатарт байгаа газар ашиглалтын хэлбэрүүд нь оршин суугчдын нягтруулж, ажлын байруудыг бас нэг дор бөөгнүүлж, мөн хүүхдээ сургуульд нь хүргэж өгөх авах, хоол хүнсээ цуглуулахын тулд хорооллоос хорооллын хооронд аялах шаардлагыг бий болгож байна.

3.2.3. Төрийн үйлчилгээний хүрээмж

62. Үйлчилгээнээс хүртэх эсэх нь оршин суугчид хаана амьдарч байгаагаас шалтгаалж байна. Боловсрол ба эрүүл мэндийн үйлчилгээ, гудамжны гэрэлтүүлэг, нийтийн тээврийн хэрэгслийн хүртээмж ба чанар нь хот даяараа төдийгүй дүүргүүд дотроо ч ихээхэн ялгаатай байна. Хотын захын гэр хороолол эсхүл төвийн орон сууцны хорооллын байршилүүд нь орлогын түвшинтэй нь харьцуулсан үйлчилгээний чанар ба хангамжийг эдэлж байна. Сүүлийн жилүүдэд өргөжин тэлсэн, төлөвлөлт хангалтгүй, гэнэтийн үер, хүчтэй шуурга, өвлийн хүндрэл гэх мэт эрсдэл өндөр гэр хороололд хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд суурьшиж байна. Эдгээр газрын үйлчилгээ хангалтгүй тул гэр хорооллын оршин суугчдын сайн сайхан байдлыг сайжруулах арга хэмжээнүүдэд хамрагдаж байна.

63. Монгол улсын боловсролын систем нь ясли, цэцэрлэг, бага сургууль, дунд сургууль, их дээд сургуулиас бүрддэг. Нийт 361,600.0 хүүхдүүд нь Улаанбаатар хотын зургаан дүүрэгт байрлах 233 сургуулиудад, 649 цэцэрлэгт явдаг (НДТГ, 2019). Боловсролын томоохон санаа зовоож байгаа асуудал бол гэр хороолол дахь амьдарч буй газарт нь ойрхон байрлах сургуулийн байрлал ба хүрч очих орон зайн бэрхшээл байдаг. Гэр хороололд байгаа сургуулиуд нь амьдарч буй газраас ихэвчлэн хол байдаг байхад төвийн бүсүүдэд орон зайн эрэлт нь нийлүүлэлтээсээ давсан байдаг. Дунджаар гэр хороололд амьдардаг хүүхдүүдэд орон сууцанд амьдардаг хүүхдүүдийг бодвол 2 дахин их замыг туулж сургуульдаа очдог (18 минут ба 9 минут)⁶. Эрүүл мэндийн дэд бүтцийн орон зайн тархалт нь хотын төвдөө

⁶ Гаяатри Сингх. (2017: 16). Улаанбаатар хот дахь ядуурлын байдал: Ядуурлын хэлбэрүүдийг ойлгон, тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх нь. Дэлхийн Банк. Вашингтон хот.

төвлөрсөн байдаг учраас оршин амьдарч буй газруудад дутагдалтай байдаг. Сургуулиуд эмнэлгүүдийн байрлал хүртээмж хязгаарлагдмал байдгийн улмаас эдгээр үйлчилгээг хүртэхгүй байх эсхүл тэдгээр үйлчилгээнд хүрч очихын тулд өндөр өртөг зарцуулдаг байна.

Гэр хороололд гудамжны гэрэлтүүлэггүйээс шөнийн цагийн хулгай дээрэм, явган зорчигчид осолд өртөмтгий байдаг. Хөнгөн осолд орж бэртсэн явган зорчигчид жолоочтойгоо тохиролцож мөнгө авсан тохиолдолд албан ёсоор гомдол гаргаж бүртгүүлдэггүй. Сүүлийн үед сургууль орчим дахь замын аюулгүй байдал ба гэмт хэргийг бууруулах зорилгоор "Сургуулийн цагдаа-School police" хөтөлбөрийг хэрэгжүүлэн эцэг эх, асран хамгаалагч нар сургууль цуглах болон тарах үед идэвхтэй үйл ажиллагааг явуулдаг болсон байна.

3.2.4. Тээврийн үйлчилгээ

64. Сүүлийн жилүүдэд хүн ам, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаа хурдацтай өсөж байгаагаас улбаалан хотын тээврийн системд учирч буй дарамт ба эрэлт ихсэж 2014 оны байдлаар өдөрт 3.4 сая зорчилтыг бүртгэгджээ. Гэвч Улаанбаатар хотын тээврийн дэд бүтэц ба үйлчилгээ хязгаартай төдийгүй ихэнх иргэд зам дээр цагийг удаан өнгөрүүлж, бусад салбарыг бодвол үр ашигтай байдал багатай байна. Хот доторх замын чанар ба хүртээмж харилцан адилгүй, дүүргүүд хорооллуудыг холбосон хоёрдогч замууд байхгүй байдгаас болоод нийтийн тээврийн хэрэгслийн хүртээмж хотын төвөөс алслагдах тусмаа буурдаг. Гэр хороололд гудамж талбайн зөвхөн 10 хувь нь хучилттай байдаг болохоор тээврийн хэрэгслүүд өвлийн улиралд хүрч очиж нэвтрэх боломж хязгаарлагдмал байдаг.

65. Улаанбаатар хот дахь зам талбайн ашиглалт ерөнхийдөө бууралттай. Хүн амын ихэнх нь буюу дунд болон доогуур орлоготой хүмүүс нийтийн тээврийн хэрэгслийг ашиглаж, эсвэл алхдаг. Нийтийн тээврийн хэрэгслийн хүртээмж хангалтгүй байдгаас улбаалан хувийн машинууд нь замын талбайг тэнцвэргүйгээр ашиглах нөхцөл байдлыг өдөр бүр улам дордуулж байдаг. Машин худалдаж авах хүмүүсийн тоо ихсэж хот дахь тээврийн нөхцөлийг улам муутгаж байна.

66. Хотын захиргаанаас арга хэмжээ авч байгаа хэдий ч Улаанбаатар хотын нийтийн тээврийн систем нь үнэн бодит байдал дээрээ маш чанар муутай үйлчилгээг үзүүлдэг. Гэр хороолол нь хотын төвөөсөө улам алслагдан тэлж байна. Эдгээр захын бүсүүдэд автобусны маршрутыг бий болгох нь маршрут урт байх тусам ашиглалтын зардал (түлш, ажиллах хүч гэх мэт) 7 өндөр байх тул маш өртөг өндөртэй. Үүнээс гадна нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолууд нь тархай бутархай ба маршрутынхаа дагуу тодорхой давтамжтайгаар явахад хэцүү. Хотын захын алслагдмал бүсүүдийн ихэнхэд нь нийтийн тээврийн үйлчилгээ хүрч очоогүй байдаг. Бага орлоготой бүлгийнхэн ажил, сургууль бусад үйлчилгээнд очих асуудлаа өөрсдөө зохицуулах шаардлагатай болдог. Тэргэнцэртэй хүмүүс болон бага насны

⁷ Гаяатри Сингх. (2017: 29). Улаанбаатар хот дахь ядуурлын байдал: Ядуурлын хэлбэрүүдийг ойлгон, тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх нь. Дэлхийн Банк. Вашингтон хот.

хүүхдээ дагуулж яваа эмэгтэйчүүд нийтийн тээврийн хэрэгсэлд нэн тэргүүнд зорчих ёстой байтал тэдэнд зориулсан хаалга болон бусад бүтэц нийтийн тээврийн хэрэгсэлд байдаггүй.

67. *Гэр хороололд тохиолддог бэрхшээлүүд.* Хотын төвд ойрхон байдаг гэр хорооллуудад хүрч очсон маршрут цөөхөн байдаг. Оршин суугчид автобусныхаа буудал руу очихын тулд хол замыг туулдаг. Тухайн маршрутаар аялах автобусандаа суухын тулд удаан хугацаагаар хүлээх шаардлага гардаг ба автобус нь ойрхон давтамжтайгаар ирдэггүй. Буудлаа алгасаж явах, маршрутаасаа хазайж явах, ирэхгүй удах тохиолдол байнга гардаг.

68. Автобусны буудал нь тэмдэглэгээ муутай, зорчигчид хүлээх нөхцөл муутай, гэрэлтүүлэг муутай, явган хүний зам байхгүй, нар салхи борооноос хамгаалах саравч байхгүй, байдаг тохиолдлууд олонтоо. Гэр хороололд автобус зогсдог газар очихын тулд эгц налуу өөд авирах, хад чулуутай замаар явах нь хөгшин настай хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хэцүү байдаг. Өвлийн улиралд зам дээр мөс тогтдогоос болоод автозамын осолд орох нөхцөл бүрддэг.

69 Хотын захиргаа нь оюутнууд, өндөр настай иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аялалд зориулж автобусны компаниудад нөхөн олговор өгдөг. Хөнгөлөлт эдэлдэг эдгээр зорчигчид маршрутын дагуу жилийн турш тооцоолж байснаас бага давтамжтайгаар аялдгийг үр дүнтэй хянах механизм байдаггүй. Хөнгөлөлт эдэлдэг эдгээр зорчигчид тус бүр өдөрт 2 удаа нийтийн тээврийн хэрэгслээр зорчино гэсэн таамаглалд дээр үндэслэж тооцоог гарган автобусны компаниудад нөхөн олговрыг хотын захиргааны зүгээс хуваарилан тараадаг.

70. Албан бусаар үйлчилгээ үзүүлдэг микро автобуснууд эсвэл жирийн машинууд, нийтийн тээврийн хэрэгслийн хүртээмж муутай газруудад байгаа зорчигчдод үйлчилж гэр хороололд тээврийн хэрэгсэл хязгаарлагдмал газруудыг хамардаг бөгөөд зорчигчдын аюулгүй байдалд баталгаа өгөх боломжгүйгээс гадна харьцангуй өндөр үнээр үйлчилдэг. Микро автобуснууд ба бөөнөөрөө сууж мөнгөө хувааж төлдөг таксинууд нь маршрут ба үнэ зорчигчтой ихэвчлэн тохиролцож тогтоодог.

71. Гэр хорооллын оршин суугчдын ихэнх нь албан ёсны автобус эсвэл микро автобусанд нэг ба түүнээс дээш удаа дамжин сууж албан ба албан бус үйлчилгээг хүртэн, нэг удаа аялал хийхэд 1000-2000⁸ төгрөг зарцуулан өдөрт ирж очих аялалдаа 2000-4000⁹ төгрөгийг зарцуулдаг байна. Сард 20 ажлын өдөр ийнхүү нэг хүн зорчиход сардаа 40-80 мянган төгрөгийг зарцуулдаг. Долоо хоногтоо 12 удаа аялал хийдэг айл өрх нь сардаа 60-120 мянган төгрөгийг тээврийн хэрэгсэлд зарцуулж байгаа явдал нь тухайн өрхийн орлогын 9-18 хувийг эзэлж байна.

⁸ Албан ёсны автобусанд 2 эсхүл 3 удаа дамжиж суухад 500 төгрөг төрлдөг, микроавтобусанд 1000 төгрөг, бөөнөөрөө суудаг таксинд үүнийг илүү өртөг төлдөг.

⁹ Энэ хэсэгт орсон бүх дүн шинжилгээг MAD Investment Solutions. 2014.-ын Хөрөнгө Оруулалтын Шийдэл, Улаанбаатарт үйлчилгээ хүргэх. Улаанбаатар хот. дээр үндэслэв.

3.2.5. Коридоруудын өнөөгийн нөхцөл байдал

72. Санал болгож буй замын коридорууд нь сургуулийн бүс, бизнес санхүүгийн завгүй газруудад байдаг. Замууд нь ерөнхийдөө нарийхан ба зам тээврийн хөдөлгөөнийг улам хэцүү болгодог. Явган зорчигчид зам хөндлөн гарах боломжгүй хаалтуудыг байрлуулсан байдаг. Явган зорчигчид явахад хангалттай гэрэлтүүлэг байхгүй, аюулгүй байдлыг нь хангах өндөрлөгөө байхгүй, түр зогсох тавцан байхгүй байдаг. Дугуйны зам ба явган зорчигчийн замыг тусгаарласан хангалттай зай байхгүй. Шөнийн цагаар үзэгдэх орчин муутай байдаг нь явган зорчигчдод аюултай байдлыг бий болгодог. Хурд ихтэй төв замууд нь явган зорчигчийг нэвтрэн өнгөрүүлэх тогтмол давтамжаар хангагдсан байдаг. Жолооч нар явган зорчигчдод зам тавьж өгөхдөө хойрго байдаг. Тээврийн хэрэгслийг цахилгааны болон гэрлийн шонг тойруулан явуулах хамгаалалтын хашлага байхгүй байдаг.

3.2.6. Замын аюулгүй байдлын асуудлууд

73. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас (2018 он) зам тээврийн бэртэл гэмтэл нь бүх насны хүмүүсийн нас баралтын 8 дахь шалтгаан болдог, 5-29 настай хүүхэд залуучуудын нас баралтын гол шалтгаан болдог болохыг харамсалтайгаар илрүүлж судалжээ. Дэлхий нийтийн зам тээврийн ослоор нас барагчдын талаас илүү хувь нь замын хөдөлгөөнд эмзэг оролцогчид байдаг: ихэнх улс орнуудад замын системийн дизайныг гаргахдаа явган зорчигчид, дугуйгаар зорчигчид, мотоциклтой зорчигчдыг орхигдуулсан байдаг.

74. Аюулгүй хурдны хувьд Улаанбаатар хотын хурдны хязгаар нь 60 км/цаг сургуулийн бүсэд 20 км/цаг байдаг. Хурдны камер болон хурд тодорхойлох гараар хэмждэг багаж байдаг хэдий ч маш цөөхөн нь ашиглагддаг. Хурд хэтрүүлсэн зөрчлийг 50,000.0 төгрөг (19 орчим америк доллар) -өөр торгох бөгөөд хурдыг зөвшөөрөгдсөн дээд хязгаараас тавь хүртэл хувиар хэтрүүлсэн тохиолдолд бүртгэлийн 2 оноо, хурдыг зөвшөөрөгдсөн дээд хязгаараас 50% -иас дээш хэтрүүлсэн тохиолдолд эрхийг зургаан сараар түдгэлзүүлэх журамтай. Хурдыг үр дүнтэй удирдах нь замын аюулгүй байдлын системийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм.

76. Зам тээврийн хөдөлгөөнд аюулгүй оролцоход тохиолддог 3 үндсэн асуудал байдаг ба энэ нь 1) согтууруулах ундаа хэрэглэсэн үед тээврийн хэрэгсэл жолоодох чадвар буурсан, 2) хамгаалах бүс, хүүхдийн хамгаалалтын хэрэгсэл ашиглалт, 3) явган зорчигчид ба нийтийн тээврийн хэрэгслээр зорчигчдын аюулгүй байдлын асуудлууд юм. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил нь буурч байгаа хэдий ч зам тээврийн ослын шалтгааны 2.2 хувийг эзэлж байна. Суудлын бүс, хүүхдийн хамгаалалтын хэрэгсэл ашиглалт, мотоциклын малгай зэргийг НҮБ-ын хүүхдийн сангаас хийсэн судалгаанд¹⁰ зам тээврийн осол гарах үед зам тээврийн осол гаргасан жолоочийн маш өндөр хувь нь хүүхдийн хамгаалалтын хэрэгсэл ашиглаагүй байсан болон мотоциклын малгай өмсөөгүйгээсээ болж тархины гэмтэл авч нас барагсдын тоо өндөр байсныг харуулжээ. Эдгээр төрлийн зөрчилтэй иргэд 20,000.0 төгрөгөөр торгуулдаг. Нийтийн тээврийн хэрэгсэл нь харьцангуй найдвартай, аюулгүй үйлчилгээгээр хангадаг боловч автобуснуудын ариун цэврийн асуудлыг сайжруулах,

¹⁰ НҮБ-н Хүүхдийн Сан (2018), Монгол Улс дахь Хүүхдийн зам дээрх аюулгүй байдал ба зам тээврийн осол гэмтэл, Үнэлгээний тайлан, Улаанбаатар хот.

жолоочийн эелдэг зан авирыг улам сайжруулах шаардлагатай. Хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настай иргэдэд зориулсан төхөөрөмж хангалтгүй байдаг. Зорчигчид согтууруулах ундаатай холбоотой гэмт хэрэг тухайлбал, бэлгийн хүчирхийлэл, дээрэм, хулгай зэрэгт санаа зовдог.

77. Монгол Улс зөв дүрмийн жолоодлоготой байгаа хэдий ч баруун талдаа жолоодлоготой тээврийн хэрэгслийг өргөнөөр ашигладаг бөгөөд энэ нь жолоочийн үзэгдэх орчныг хязгаарлаж хүлээн авах боломжгүй эрсдэлд ордог. Автобусны парк нь импортоор орж ирсэн автобуснуудаас бүрдэх бөгөөд 9-ээс 12 жилийн насжилттай автобуснууд байдаг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ахмад настнуудад нэвтрэхэд хялбар байдлаар тохируулаагүй байдаг байна. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан болон бусад эмзэг бүлгийн хүмүүсд ээлгүй байдаг.

Хүснэгт 4. Монгол Улсын аюулгүй байдлын индикаторууд¹¹

БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ		АЮУЛГҮЙ ЗАМЫН ХЭРЭГЛЭГЧ	
Тэргүүлэгч агентлаг	Зам тээврийн хөгжлийн яам, Үндэсний хороо	Хурдны хязгаарлалтын тухай Үндэсний хууль	Тийм
Улсын төсвөөр санхүүжигддэг	Тийм	Хотын хурдны дээд хязгаар	60 км/цаг
Үндэсний замын аюулгүй байдлын стратеги	Тийм	Хөдөөгийн хурдны дээд хязгаар	80 км/цаг
Стратеги хэрэгжүүлэх санхүүжилт	Хэсэгчлэн санхүүжүүлсэн	Автомашин хурдны дээд хязгаар	100 км/цаг
Нас баралтыг бууруулах зорилт	50% (2012-2020)	Орон нутгийн эрх баригчид хязгаарыг өөрчлөх боломжтой	Үгүй
АЮУЛГҮЙ ЗАМ, ХӨДӨЛГӨӨНТ БАЙДАЛ		Шийдвэр	12345678910
Авто замын шинэ дэд бүтцэд шаардлагатай аудит эсвэл од үнэлгээ	Тийм	Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны давамгайлсан хэлбэр	гарын авлагын болон автоматжуулсан
Явган зорчигчдын аюулгүй байдлыг хангах дизайны стандарт / дугуйчин	Хэсэгчилсэн	СОГТУУРУУЛАХ УНДАА ЖОЛООДЛОГО ҮНДЭСНИЙ ХУУЛЬ	
Хяналт шалгалт / одоо байгаа замын од үнэлгээ	Үгүй	ВАС хязгаар – нийт хүн ам	<0.04g/dl ^b
Өндөр эрсдэлтэй байршлыг сайжруулах хөрөнгө оруулалт	Үгүй	ВАС хязгаар -залуу эсвэл шинэхэн жолооч нар	<0.04g/dl ^b
Хотын нийтийн тээврийн бодлого, хөрөнгө оруулалт	Тийм	Амьсгалын санамсаргүй шалгалтыг хийсэн	Тийм ^d
АЮУЛГҮЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ		үхлийн аюултай ослын тохиолдолд шалгалт хийсэн	Бүх жолооч нар шалгагдана
2016 оны нийт бүртгэлтэй тээврийн хэрэгсэл	841 537	Шийдвэр	12345678910
Автомашинууд болон 4 дугуйтай хөнгөн тээврийн хэрэгслүүд	547 299	Согтууруулах ундааны хэрэглэснийг оруулаад зам	25%

¹¹ Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, 2018, Замын аюулгүй байдлын дэлхийн статистикийн тайлан.

		тээврийн ослын улмаас нас баралт %	
Моторт 2 ба 3 дугуйт	42 751	мотоциклийн дуулга малгайны Үндэсний хууль	Тийм
Хүнд даацын автомашин	175 648	Жолооч, зорчигчдод хамаатай	Тийм
Автобус	6 823	Дуулга өмсөх шаардлагатай	Үгүй
Бусад	69 016	Дуулга малгайны стандарт ба / эсвэл тусгайлан заасан	Үгүй
Тээврийн хэрэгслийн стандартыг ашигласан (UNECE WP.29)		мотоциклтой зорчигч хүүхдүүд	хязгаарлаагүй
Урд талын нөлөөллийн стандарт	Үгүй	Шийдвэр	12345678910
Цахилгааны тогтвортой байдлын хяналт	Үгүй	Дуулга өмсөх харьцаа	-
Явган хүний хамгаалалт	Үгүй	Үндэсний суудлын бүсийн тухай хууль	Тийм
Мотоциклийн түгжээнээс хамгаалах тоормосны систем	Үгүй	Урд болон хойд суудалд суусан хүмүүст хамаатай	Тийм
ОСЛЫН ДАРААХ АРЧИЛГАА		Шийдвэр	12345678910
Үндэсний яаралтай тусламжийн үйлчилгээний дугаар	Үндэсний, Энгийн дугаар	Суудлын бүс зүүх харьцаа	-
Гэмтлийн бүртгэл	Үндэсний	Хүүхдийг хамгаалах үндэсний хууль	Үгүй
Эмнэлгийн өмнөх үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан албан ёсны гэрчилгээ	Үгүй	Хүүхэд урд суудалд суух	хязгаарлаагүй
Яаралтай тусламжийн системийн үндэсний үнэлгээ	Үгүй	хүүхдийн хязгаарлалт шаардлагатай	-
МЭДЭЭЛЭЛ		хүүхдийн хамгаалалтын стандартыг ашигласан ба / эсвэл тусгайлан заасан	-
Тайлагнасан зам тээврийн нас баралт	484*(75% эрэгтэй, 25% эмэгтэй)	Шийдвэр	-
ДЭМБ-аас тооцоолсон зам тээврийн нас баралт	499 (95% CI 471-527)	Хүүхдийн хамгаалалтыг ашиглаж буй хүүхдүүд	-
ДЭМБ-аас 100000 хүн ам тутамд ногдох хэмжээг тооцоолсон тооцоо	16.5	Жолоо барьж байх явцдаа гар утас хэрэглэх үндэсний хууль	Тийм
*Эрүүл мэндийн үзүүлэлт 2016, Эрүүл мэндийн хөгжлийн төв, ослын 30 өдрийн доторх нас баралт		Гар утас хэрэглэхийг хориглосон	Тийм
		Гар биш утас хэрэглэхийг хориглосон	Үгүй
		Мансууруулах бодис жолоодлого үндэсний хууль	Тийм


^b Хуульд суурилсан амьсгалын архины концентраци, утгыг ВАС болгон хувиргасан

^c Хууль тогтоомж нь жолооч нарыг шалгах эсвэл замын хөдөлгөөний зөрчил гаргах магадлалтай шалтгааныг тодорхойлдог


^d 2016 он, Цагдаагийн ерөнхий газар, " гэмтэл, зөрчлийн статистик"

^e 12-оос доош насны хүүхдийг арын суудалд тусгай тулгуур суулгасан тохиолдолд мотоциклоор тээвэрлэх боломжтой

Зам тээврийн ослын улмаас бүртгэгдсэн нас баралтын чиг хандлага (Эх сурвалж: Эрүүл мэндийн хөгжлийн төв, Эрүүл мэндийн индекаторууд 2016)



Source: 2016, General Police Department, "Statistics on road traffic injury and violation"



Source: Center for Health Development, Health Indicators 2016

195

Зураг 4. Зам тээврийн ослоос үүдэлтэй эндэгдэл

3.2.7. Эмзэг байдал ба жендэрийн асуудал

Төслийн нөлөөллийн хүрээнд дараах болон бусад эмзэг бүлгийн иргэд хамаарч болно. Үүнд: хөгжлийн бэрхшээлтэй иргэд ба тэдний асран хамгаалагчид; бага насны хүүхдүүд, өсвөр насны залуучууд, эмэгтэйчүүд, өндөр настан, бага орлоготой, өрх толгойлсон өрхүүд, жижиг худалдаа эрхлэгчид болон оршин суух болон газар өмчлөлийн бүртгэлгүй түр оршин суугчид (хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд). Угсаатны цөөнх нь тухайн газар нутагт тусдаа хүйн элгэн үүсгэх бус айл өрхөөр амьдардаг, бие даасан эсвэл гарч болох нөлөөллийг энэ хэсэгт тооцоолоогүй болно.

БОНМХ-ний нийгмийн үнэлгээг Дэлхийн банкны Ядуу, Эмзэг иргэд, бүлэгт үзүүлэх болзошгүй эрсдэл, нөлөөллийг шийдвэрлэх удирдамжийн дагуу бэлтгэсэн байна. Төслийн нөлөөллийн хүрээнд эмзэг бүлэгт дараахь зүйлийг багтааж болох бөгөөд зөвхөн уг жагсаалтаар хязгаарлагдахгүй.

78. Жендерийн тэгш байдлыг

Гол эмзэг бүлгүүд	Эмзэг байдлын гол хүчин зүйлүүд	Болзошгүй нөлөөлөл
Гэр хорооллын оршин суугчид	Аюулгүй байдал, хөдөлгөөний хязгаарлалт, нийгмийн байдал, нийгэм эдийн засгийн сул тал, газар өмчлөл, тээврийн үйлчилгээнээс ихээхэн хамааралтай байдал	Ерөнхий байдлаар эерэг боловч төслийн хэрэгжилтийн явцад түр хугацаанд сөрөг байж болно
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний асран хамгаалагчид	Бие махбодь, сэтгэц болон бусад хөгжлийн бэрхшээл, хүйс, аюулгүй байдал, хөдөлгөөнт хязгаарлалт, нийгмийн байдал, жендэрт суурилсан хүчирхийлэл, нийгэм, эдийн засгийн дорой байдал, тээврийн үйлчилгээнээс хамаарал өндөр, хөгжлийн бэрхшээлийн иргэд, бүлгүүдийн ялгаатай онцлог, хэрэгцээний асуудал шийдвэр гаргах, төлөвлөлт/ дизайн боловсруулах үйл явцад тусгагдахгүй, оролцоог орхигдуулах	Ерөнхий байдлаар эерэг боловч төслийн хэрэгжилтийн явцад түр хугацаанд сөрөг байж болно
Бага насны хүүхдүүд, залуучууд	Нас, хүйс, аюулгүй байдал, хөдөлгөөний хязгаарлалт, жендэрт суурилсан хүчирхийлэл, шийдвэр гаргах, төлөвлөх / боловсруулах үйл явцад оролцоог орхигдуулах	Ерөнхий байдлаар эерэг боловч төслийн хэрэгжилтийн явцад түр хугацаанд сөрөг байж болно
Эмэгтэйчүүд, охид	Хүйс, нийгмийн байдал, нийгэм эдийн засгийн дорой байдал, аюулгүй байдал, жендэрт суурилсан хүчирхийлэл, тээврийн үйлчилгээний өндөр хамаарал, хөдөлгөөний хязгаарлалт	Ерөнхий байдлаар эерэг боловч төслийн хэрэгжилтийн явцад түр хугацаанд сөрөг байж болно
Өндөр настан	Нас, аюулгүй байдал, нийгмийн байдал, хөдөлгөөний хязгаарлалт, тээврийн үйлчилгээнээс ихээхэн хамааралтай	Ерөнхий байдлаар эерэг боловч төслийн хэрэгжилтийн явцад түр хугацаанд сөрөг байж болно
Бага орлоготой, ганц бие өрх толгойлсон айл	Нас, хүйс, нийгмийн байдал, нийгэм, эдийн засгийн дорой байдал, тээврийн үйлчилгээнээс хамаарал өндөр, шийдвэр гаргах, төлөвлөлт/ дизайн гаргах үйл явцад оролцоог орхигдуулах.	Ерөнхий байдлаар эерэг боловч төслийн хэрэгжилтийн явцад түр хугацаанд сөрөг байж болно
Жижиг арилжаа болон албан бус бизнес эрхлэгчид	Орлого, амьжиргаа алдагдах, нийгэм эдийн засгийн дорой байдал, шийдвэр гаргах, төлөвлөх/дизайн боловсруулах үйл явцад оролцоог орхигдуулах.	Эерэг ба сөрөг

Оршин суух болон газар өмчлөх бүртгэлгүй түр оршин суугчид (хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд)	Нийгмийн байдал, нийгэм, эдийн засгийн дорой байдал, шийдвэр гаргах ба төлөвлөлт/ дизайн боловсруулах үйл явц оролцоог орхигдуулах	Эерэг ба сөрөг
--	--	----------------

82. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай 2016 онд батлагдсан хуульд саадгүй орчин бүрдүүлэх, алсын харааг тодорхойлсон тодорхой зүйл заалтууд тусгагдсан байдаг. Хэдийгээр гадаад орчин, тээвэр, мэдээлэл, хүртээмжийг дэмжих төхөөрөмж, хэрэгслийг хуульчилж өгсөн ч хуулийн хэрэгжилт нь системчилсэн бус, сул байна. (Рожерс ба бусад, 2019) Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооны мэдээллээр 2018 онд Улаанбаатар хотод байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийт тоо 35,589 бөгөөд, тэдгээрийн 19,728 эрэгтэй, 15,861 нь эмэгтэй байна. Монгол Улсын Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын яамны мэдээлснээр Улаанбаатар хотод 34,246 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байдаг. Үүнээс 3617 нь 0-14 насны хүүхдүүд, 830 нь 15-17 насныхан, 29,799 хүн 18 ба түүнээс дээш насныхан байна. Дэд бүтцийн хөрөнгө оруулалт, тээврийн үйлчилгээнд сонсгол, хараа, хөдөлгөөний гэх мэт хөгжлийн бэрхшээлийн онцлог ялгаатай хэрэгцээг тусган оролцоог хангасан дизайн, төлөвлөлтийн үйл явц дутагдалтай хэвээр байна. Хөдөлгөөний хүндрэл, тээврийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй байдал нь төрөөс хүртэх үндсэн үйлчилгээ болох боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэх боломжийг хязгаарлаж улмаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн олонх нь нийгмийн халамжаас хамааралтай, бие даан амьдарч чадахгүй хэвээр байна.

83. Монгол Улсад хүйсийн харьцааны дундаж наслалт нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс дунджаар 9.6 насаар бага (эмэгтэйчүүд 76.0; эрэгтэйчүүд 66.4) насалдаг гэж таамаглаж байна (ҮСХ 2018). Энэ нь дэлхийн 12 дахь том ялгаа бөгөөд Зүүн өмнөд Ази, Номхон далайн орнуудын хоёр дахь том ялгаа юм (ДЭМБ, 2020). Сүүлийн үед Монголд үндэсний баялаг хуримтлагдаж байгаа хэдий ч эрэгтэйчүүдийн дундаж наслалт 1992-2018 оны хооронд ердөө 5.4 жилээр нэмэгдсэн байхад эмэгтэйчүүдийн дундаж наслалт мөн хугацаанд 10.9 жилээр нэмэгдсэн байна (АХБ 2017).

84. Зам тээврийн ослын улмаас цаг бусын нас баралт нь Монгол Улсын хувьд нас баралтын гурав дахь том шалтгаан болж байна. Дэлхийн банкны 2019 онд хамрах хүрээний судалгаагаар амиа хорлох, аллага, санаандгүй гэмтэл, зам тээврийн осол, халдварт бус өвчний улмаас нас барах нь эрэгтэйчүүдийн хувьд эмэгтэйчүүдээс хамаагүй өндөр байгааг харуулсан. 2018 онд эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйчүүдийн нас баралтаас амиа хорлож нас барахаас 5.8 дахин, хүн амины хэргээс 4.1 дахин, санамсаргүй байдлаар гэмтэхээс 3.8 дахин, зам тээврийн ослоос 2.8 дахин, халдварт бус өвчнөөс 1.5 дахин их байна (Дэлхийн банк 2019). Архидан согтуурахтай холбоотой зам тээврийн осолд монгол эрчүүд эмэгтэйчүүдээс хамаагүй илүү өртдөг

85. Монгол Улсын статистикийн мэдээнээс харахад эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо 2006 оноос хойш буурч 2018 он гэхэд 64.8% -иас 53.4% болсон байна. Энэ нь эдийн засгийн хямрал эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд илүү их нөлөөлсөн болохыг харуулж байгаа бөгөөд ялангуяа эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо 2018 оны байдлаар хот суурин газарт, тухайлбал нийслэлд (44.8%) хөдөөгийн эмэгтэйчүүдтэй (60.5%) харьцуулахад илүү нөлөөлөгдсөн байна (АХБ 2018). Чанаргүй, үр ашиггүй тээврийн үйлчилгээ нь эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээлийн оролцооны өөр нэг хүчин зүйл хэдий ч хүйсээр нь ангилсан тоо баримт, судалгааны үр дүн хязгаарлагдмал дутагдалтай хэвээр байна.

86. Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр, Монгол эмэгтэйчүүд 2019 оны байдлаар ижил албан тушаал эрхэлж буй эрэгтэйчүүдээс 19.6 хувиар бага цалин авдаг байна. Түүнчлэн, эмэгтэйчүүд ихэвчлэн цалин багатай мэргэжил эзэмшдэг бөгөөд тэдний хувийн чадвараас үл хамааран эмэгтэйчүүд төрийн болон хувийн хэвшлийн ажлын шатлалд эрэгтэйчүүдээс доогуур зэрэглэл эзлэх чиг хандлагатай байдаг. Нэмж хэлэхэд, эмэгтэйчүүд гэрийн ажил, асрамжлах ажил үүргээ эрэгтэйчүүдээс хоёр дахин илүү хийдэг ба үүний дүнд тэднээс эдийн засгийн байдлаараа улам дорддог байна.

3.2.8. Жендэрт суурилсан хүчирхийлэл

87. Тээврийн үйлчилгээтэй холбоотойгоор бэлгийн дарамт, хүчирхийлэл үйлдэх, бие махбодын болон хэл амаар доромжлох явдал ихэвчлэн эмэгтэй зорчигчдод тохиолддог бөгөөд харамсалтай нь ийм хүчирхийллийн хэргийг ховор мэдээлдэг, эсвэл хангалттай авч үздэггүй, эсвэл статистикийн мэдээлэлд тэмдэглэдэг. Үндэсний Статистикийн Хороо, НҮБ-ын Хүн амын сангаас 2017 онд явуулсан судалгаагаар Монгол Улсын эмэгтэйчүүдийн 58 хувь нь бие бялдар, бэлгийн, сэтгэл хөдлөл, эдийн засгийн болон дотно харилцагчийн зан авирыг хянах (ихэнхдээ тэдний нөхөр байдаг) зэрэг хүчирхийлэлд өртөж байсан байдаг. Судалгааны өмнөх жил эмэгтэйчүүдийн 35 хувь нь эдгээр хүчирхийллийн дор хаяж нэг хэлбэрийг амсаж байжээ. Тээврийн үйлчилгээтэй холбоотойгоор бэлгийн дарамт, хүчирхийлэл үйлдэх, бие махбодын болон хэл амаар доромжлох явдал ихэвчлэн эмэгтэй зорчигчдод тохиолддог бөгөөд харамсалтай нь ийм хүчирхийллийн хэргийг ховор мэдээлдэг, эсвэл хангалттай авч үздэггүй, эсвэл статистикийн мэдээлэлд тэмдэглэдэг.

88. Ковид 19-ийн нөлөөллөөс болоод эмэгтэйчүүд охидууд эрүүл мэндийн үйлчилгээ авах мөн нэг цэгийн үйлчилгээний төвүүдээс тусламж авах явдал хязгаарлагдан хүндрэлтэй болсон. 2020 оны эхний улиралд Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газарт ирүүлсэн гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийг 2019 оны мөн үетэй харьцуулан үзэхэд бараг 50 хувиар өссөн байна. Харамсалтай нь нэг цэг үйлчилгээгээр үйлчлүүлсэн хүмүүсийн дундаж тоо нь 2019 үеийн мөн үетэй харьцуулахад 90 хувиар нэмэгдсэн байна. Хүчирхийлэлд өртсөн, хохирогчдод зориулсан үйлчилгээ хаагдаагүй ч зөвлөгөө өгөх, зөвлөлдөх үйл ажиллагааг утсаар болон онлайнгаар явуулжээ. Жендэрт суурилсан хүчирхийллийн тухай ойлголт, түүнийг бууруулах арга хэмжээг яаралтай сайжруулах хэрэгтэй ба хорио цээрийн үед нэг цэгийн үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулж байх шаардлагатай.

3.2.9. Ковид 19 цар тахал

86. Эхний тохиолдол 2020 оны 3-р сард бүртгэгдсэнээс хойш 2021 оны 3-р сарын 19-ний байдлаар Улаанбаатар хотод батлагдсан 3254 тохиолдол бүртгэгдсэн байна. Засгийн газар ба орон нутгийн засаг захиргаа нь маск зүүх, гараа угаах, зай барих, хөл хорио тогтоох, хавьтлуудыг илрүүлэх, шинжилгээнд хамруулж тусгаарлах зэрэг арга хэмжээг яаралтай авсан нь хөдөө орон нутагт үүссэн кластар өвчлөлүүдийг арилгахад нөлөөлсөн. Гэсэн хэдий ч Улаанбаатар (УБ) хотод гарсан эерэг тохиолдлын тоо эрс нэмэгдсэн байна. Халдварт өвчин судлалын үндэсний төв (ХӨСҮТ), Хавдар судлалын үндэсний төв (ХСҮТ), Цэргийн госпиталь, Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэг зэрэг дөрвөн эмнэлэг эдгээр халдварын шинэ голомтод тооцогдож байна.

87. Нөхцөл байдлуудаас хамаарч Монгол улсын Засгийн Газрынзасгийн газрын хуралдаанаас гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын янз бүрийн дэглэмийг тодорхой хугацаагаар хэрэгжүүлж байгаа явдал нь Улаанбаатар хотын захирагчийн шийдвэрт нөлөөлж, Улаанбаатар хотын бүх дүүргүүдэд эсвэл хэсэгчлэн байдлаар дэглэм тогтооход хүргэж байна. Төслийн үйл ажиллагаанууд болох олон нийттэй уулзаж хэлэлцүүлэг хийх эсвэл бүтээн байгуулалтыг хийх ажил нь цаг хугацаанаас хоцорч хойшлогдож, Ковид 19-ийн нөлөөллийг бууруулахтай холбоотойгоор болзошгүй зардлууд гарахаар байна.

4. Байгаль орчин, нийгмийн судалгаа, эрсдлийн үнэлгээ

4.1. Байгаль орчин, нийгмийн судалгаа, эрсдлийн үнэлгээ

91. Төслийн Байгаль орчин, нийгмийн тандалт, эрсдлийн үнэлгээ тогтоохдоо (БОН) төслийн үйл ажиллагаа бүрэн тодорхойлогдоогүй, төсөл хэрэгжүүлэгчдийн хязгаарлагдмал чадавхийг харгалзан Их (substantial) гэж тодорхойлно. Төслийн байгаль орчин, нийгмийн тандалт, эрсдлийн үнэлгээ нь төслийн биет хөрөнгө оруулалт (Бүрэлдэхүүн хэсэг 1 ба 2) буюу төслийн эхний үе шатанд сонгосон зам талбайн сайжруулалт, бусад бага хэмжээний зам барилгын үйл ажиллагааг (нийтийн тээврийн буудал/терминал) шинэчлэлт, сайжруулах зэрэгт хамаарна. Үйл ажиллагааны I дүгээр төрлийн хувьд сөрөг нөлөөлөл бага бол II дугаар төрлийн хувьд (зам өргөсгөхөөс улбаатай бага хэмжээний газар чөлөөлөлтөөс) нөлөөлөл тодорхой хэмжээнд үүсч болзошгүй.

92. Энэхүү БОНМХ-г бэлтгэх явцад, санал болгож буй зам барилгын дэд төслийн байгаль орчны болзошгүй эрсдэл болон нөлөөлөл нь голчлон i) гол орчмын газар шорооны ажил ихсэх, ii) ажлын талбайн дагуух мод унах, iii) замын хөдөлгөөн нэмэгдэх, iv) хог хаягдал үүсэх, зайлуулах, v) хөдөлмөрийн болон олон нийтийн эрүүл ахуй, аюулгүй байдал, vi) агаарын бохирдол, vii) машин механизмаас гарах дуу чимээ зэрэгтэй холбоотой байхаар байна. Энэхүү БОНМХ-ний тухай 5-р бүлэгт нөлөөллийг бууруулах арга хэмжээг санал болгосон болно. Мөн барилгын материалын олборлолт, тээвэрлэлт, зөөвөрлөлт, олборлолтын дараа талбайг сэргээх зэрэгтэй холбоотой эрсдэл, нөлөөлөл бий болно. Эдгээр нөлөөллийг инженерингийн арга хэмжээ авах, барилгын талбайн менежментийг

хэрэгжүүлэх замаар зохицуулах боломжтой. Төслийн үеэр бэлтгэх тухайлсан дэд төслийн БОННУ/ БОНМТ-нд үерийн болон үүнээс үүдэлтэй ус зайлуулах системийн хүчин чадал, газар хөдлөлттэй холбоотой эрсдэл, хот суурин газрын халалтын эрсдэл, мөнх цэвдэгтэй холбоотой эрсдлүүд, шар усны үерийн эрсдэл (гэр хорооллын нийтлэг асуудал) зэрэг байгаль орчны эрсдэл, түүнийг бууруулах арга хэмжээг нарийвчлан тодорхойлно.

93. Төсөл хэрэгжүүлэх явцад, Улаанбаатар хотын захиргааны ТУА-аас төслийн үйл ажиллагаа, түүний дотор техникийн туслалцаа (ТТ)-ны үйл ажиллагаа нэг бүрээр БОН-ийн эрсдэлийн дүн шинжилгээ хийх шаардлагатай. I дүгээр төрлийн гудамж, замын коридорын ажил болон түүнтэй холбоотой жижиг хэмжээний барилгын ажилд зориулсан БОН-ийн арга хэрэгсэл болох Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ), Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө (ЗХМТ), Сахилгын дүрмийг боловсруулж БОНМХ-нд хавсаргах ба гэрээт ажил гүйцэтгэгчийн хүлээх үүрэгт энэ талаар тусгасан байх ёстой. II дугаар төрлийн гудамж, замын коридорын ажил болон бусад биет хөрөнгө оруулалт, БОН-ийн нэмэлт арга хэрэгслийг БОН-ийн эрсдэлийн дүн шинжилгээний үр дүнд үндэслэн нэмэлт БОН-ийн арга хэрэгсэл болгон зохих ёсоор бэлтгэх ёстой ба үүнд жишээлбэл, тухайн газар нутагт зориулсан Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ) болон/эсхүл БОНМТ, Нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (НШҮАТ), Хөдөлмөрийн харилцааг зохицуулах журам (ХХЗЖ), ажлын талбайд зориулсан Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө (ЗХМТ) багтана.

94. Дараахь хүснэгтэд төслийн хүрээнд санал болгож буй ТТ-ны тухайн төрөлд тохирсон ТТ-ны үйл ажиллагаа болон БОН-ийн арга хэрэгслийг ашиглах талаарх санал дүгнэлтийг тусган харуулав.

Хүснэгт 5. ТТ-нд зориулж хийсэн БОН-ийн эрсдэлийн дүн шинжилгээ

ТТ-ны хэв шинж	Төслийн хүрээнд хийж гүйцэтгэх үйл ажиллагааны жишээ	БОН-ийн болзошгүй нөлөөлөл ба шалган нягтлах шаардлага	Жишээ болгосон эрсдэлийн түвшин
1 дүгээр төрөл: Ирээдүйн хөрөнгө оруулалтын төслүүдийн бэлтгэл ажлыг хангахад дэмжлэг үзүүлэх	Төслийн үйл ажиллагааны ТЭЗҮ болон зураг төсөл	Дэмжигдсэн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх явцад БОН-ийн шууд бус нөлөөллийг анхааралдаа авах шаардлагатай. Үүнтэй нийцүүлэн, холбогдох ТТ-г боловсруулж, хэрэгжүүлэхдээ ТТ-ны хүрээнд дэмжлэг үзүүлэх тодорхой биет хөрөнгө оруулалт нэг бүрийн БОН-ийн болзошгүй нөлөөллийг дараахь зүйлийг тодорхойлох зорилгоор шинжилж үзэх шаардлагатай: (а) БОН-ийн эрсдэлийн ангилал; болон (б) инженерийн зураг төсөл боловсруулж байх үедээ бэлтгэх БОН-ийн арга хэрэгслүүд (БОННУ, БОНМТ,	Дунд зэргээс Бодитой буюу их

		<p>НШҮАТ, ХХЗЖ гэх мэт).</p> <p>1 дэх төрлийн ТТ нь техникийн нарийвчилсан дизайн хийхэд дэмжлэг үзүүлэх бөгөөд энэ нь эцэстээ хөрөнгө оруулалтад зориулж Банкны бодлогод нийцсэн Байгаль орчин, нийгмийн (БОН) хэрэгслийн багцыг (Банкнаас санхүүжүүлэх эсэхээс үл хамаарч) бэлтгэх ТТ-ны зорилго болгосон үр дүн байж болох юм. Хэрэв 1 дүгээр төрлийн ТТ нь ТЭЗҮ боловсруулах ажлыг дэмжихээр бол энэ нь судалгааг БОНХ-тэй нийцүүлэн хийхдээ холбогдох байгаль орчин, нийгмийн асуудлыг анхааралдаа авсан ТЭЗҮ боловсруулах Ажлын даалгаврын талаар Зээлдэгчтэй тохиролцоо хийхэд хангалттай байж болно.</p>	
<p>2 дох төрөл: Бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, стратеги эсвэл хууль эрх зүйн хүрээг боловсруулахад дэмжлэг үзүүлэх гэх мэт.</p>	<p>Хотын түвшний тогтвортой, уян хатан хөдөлгөөнт байдлыг хангах стратеги, зогсоолын менежментийн төлөвлөгөө, Зам, замын байгууламжийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө (ЗЗБХОТ) болон Зам, замын байгууламжийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн арга хэрэгслүүдТ, хурдны менежментийн төлөвлөгөө, хувийн хэвшлийн оролцооны бодлого,</p>	<p>2 дох төрлийн ТТ-ны хүрээнд БОН-ийн шууд бус нөлөөллийг өөртөө багтаасан бодлого, стратеги, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулахад зөвлөгөө өгөх бөгөөд Ажлын даалгаварт хангалттай түвшинд хийгдсэн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг оруулах талаар тохиролцох ба өгсөн зөвлөгөө нь БОНХ-тэй нийцсэн байх ёстой. Үүний сацуу, ТТ-ны хүрээнд хийгдэх бодлого, төлөвлөгөө болон хөтөлбөрийг дэмжих чиглэлийн судалгаа нь тэдгээрийн үзүүлэх нийт нөлөөллийг тодорхойлох ба боломжтой тохиолдолд, БОН-ийн нэгдсэн нөлөөллийн зайлшгүй шаардлагатай үнэлгээг холбогдох ТТ-ны судалгааны үр дүнд нэгтгэсэн байх шаардлагатай.</p>	<p>Бодитой буюу их</p>

	институцийн бүтэц гэх мэт.		
3 дахь төрөл: Зээлдэгчийн чадавхийг бэхжүүлэх	Засгийн газрын байгууллагууд, техникийн ажилтнуудад зориулсан уулзалт семинар, сургалт, бага хурал, туршлага судлах үйл ажиллагаа	Эдгээр үйл ажиллагаа нь нийгэм эсхүл байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө багатай эсхүл огт нөлөөлдөггүй хэдий ч нийгэм болон байгаль орчинд нөлөөлж болзошгүй үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих байгууллагуудад дэмжлэг үзүүлж байж болох юм. Чадавхи бэхжүүлэхэд чиглэсэн дэмжлэгийн загварыг боловсруулж, хэрэгжүүлэхдээ эдгээр нөлөөллийг харгалзан үзэх шаардлагатай. Холбогдох Ажлын даалгаварт зайлшгүй шаардлагатай БОН-ийн асуудлыг тусгасан эсэхийг шалгаж үзэх шаардлагатай.	Бага

95. Дээр дурдсанчлан, төслийн хүрээнд 3 төрлийн ТТ-ны үйл ажиллагааг санал болгож байна. Эдгээр ТТ-ны БОН-ий нөлөөлөл хамгийн бага түвшинд гэж тооцсон хэдий ч, тэдгээрийн үр дүнг (стратегийн, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө г.м.) хэрэгжүүлснээр доорхи БОН-ийн эрсдэл/ нөлөөлөл учирч болзошгүй. Жишээлбэл, хэрэв ТТ-ны төсөл нь ирээдүйн томоохон дэд бүтцийн хөрөнгө оруулалтын зураг төсөл боловсруулах ажилд дэмжлэг үзүүлэх тохиолдолд, ТТ-ийн эрсдлийн ангилалд ТТ-ны хүрээнд дэмжлэг үзүүлэх дэд бүтэцтэй холбогдон гарч болзошгүй эрсдэлийг тусгасан байх шаардлагатай.

96. Мөн ТТ-ны төслүүдийн тухайд, талуудын оролцоог хангах, олон нийтийг мэдээллээр хангах замаар ил тод байдлыг хангах явдал чухал. Зохистой гэж үзвэл, стратеги төлөвлөлтийн санаачлагуудад үйл ажиллагааны бүхий л чухал үе шатанд **фокус бүлгийн ярилцлага, иргэдтэй хийх зөвлөлдөх уулзалт, шинжээчдийн болон олон нийтийн хэлэлцүүлэг зэргийг оруулна.**

97. Нийгмийн эрсдлийн үнэлгээ. Дээр дурдсан байгаль орчны эрсдэлд тусгасан нийгмийн хэсгийг авч үзвэл **нийгмийн эрсдэл үүсэх магадлал бодит буюу Их (substantial)** байна. Эдгээр эрсдэлд газар чөлөөлөлт, бизнес болон амьжиргаанд үзүүлэх нөлөө, оролцоог хангах, эс хангахтай асуудлууд багтана. Нийгмийн гол эрсдэл, нөлөөлөл нь дараах зүйлс хамаарч болно: газар түр хугацаагаар болон бүрмөсөн чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны улмаас газар алдах, газар дээрх эд хөрөнгөө алдах, амьжиргаа болон бусад эд хөрөнгөө алдах; орон нутгийн иргэдийн амьжиргааны үйл ажиллагаа, бизнесийн үйл ажиллагааны тасалдал; хөдөлмөрийн шилжилт хөдөлгөөний улмаас хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал (ХЭААБ), жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ), бэлгийн мөлжлөг, бурангуй үйлдэл (БМБҮ); Ковид-19-ийн халдвар, тархалт зэрэг олон нийтийн аюулгүй байдал, тасалдалтай холбоотой эрсдэл; тээврийн үйлчилгээ эрхлэгчдийн шинэ дизайн, үйл ажиллагаа эрхлэх зохицуулалтад эсэргүүцэл үзүүлэх; хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хүүхдүүд, ядуу, эсвэл өрх толгойлсон эсвэл үндэстний цөөнхийн өрх зэрэг эмзэг бүлгийн

хүмүүс төслийн үр шимийг тэгш бус хүртэх байдал. Төлөвлөж буй төслийн болзошгүй нөлөөлөл / эрсдлүүд нь олон янз байдаг бөгөөд тэдгээрийг зохицуулах боломжтой бөгөөд төсөл боловсруулах, хэрэгжүүлэх явцад боловсруулах байгаль орчны болон нийгмийн зохих үнэлгээ, нөлөөллийг бууруулах төлөвлөгөөгөөр бууруулах / нөхөн олговор олгох боломжтой.

92. Төслийн хэрэгжилтийн явцад НЗДТГ-ын удирдлагад ажиллах Төслийн удирдлагын алба (ТУА) болон Хэрэгжүүлэгч байгууллагууд (ХБ) БОНХ-ний бодлогын шаардлагад нийцүүлэн төслийн бүх үйл ажиллагаа, техник туслалцаа (ТТ)-нд БОН эрсдэлийн тандалт үнэлгээг хийх ёстой. Тандалт үнэлгээнд үндэслэн холбогдох БОН-ийн эрсдэл / нөлөөллийг тодорхойлж дотоодын хууль тогтоомж, Дэлхийн банкны БОНХ бодлогын дагуу нэмэлт БОН арга хэрэгслийг боловсруулж, хэрэгжүүлж, хяналт тавих шаардлагатай. БОН-ийн менежментийн нарийвчилсан журмыг 6-р бүлэгт тусгасан.

98. Нийгмийн гол нөлөөллийг дараах хүснэгтэд хураангуйлав.

	Нөлөөлөл: Үйл ажиллагааны төрөл I	Нөлөөллийг бууруулах хариу арга хэмжээ. Үйл ажиллагааны төрөл I	Болзошгүй нөлөөлөл: Үйл ажиллагааны төрөл II	Нөлөөллийг бууруулах хариу арга хэмжээ. Үйл ажиллагааны төрөл II
Нийгмийн Эрсдлийн үнэлгээ	<i>Бага ба дунд зэргийн эрсдэл</i>		<i>Дунд болон их хэмжээний эрсдэл</i>	
Хөрөнгийн алдагдал	Сонгогдсон коридорын дагуу одоо бизнес эрхэлдэг газруудад бага зэргийн нөлөөлөл үзүүлж болзошгүй	<ul style="list-style-type: none"> Тасалбар хугацаа өгөх Зөвлөлдөх Нөхөн олговор олгох НШБХ-ний баримт бичигт тусгах 	Барилга байшин, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, бусад эд хөрөнгийн алдагдал гарах болзошгүй	Төслийн эхний 1-2 дугаар жилд үйл жиллагааны төрөл I-ийг хэрэгжүүлэх явцад судалгаа шинжилгээний ажил, бүрэн үнэлгээ хийх
Амьжиргаа, бизнесийн үйл ажиллагаа дахь үр нөлөө	Сонгогдсон коридорын дагуух зөвшөөрөлтэй бизнесийн орц гарцын өөрчлөлт	<ul style="list-style-type: none"> Нөлөөллийг бууруулсан зам барилгын арга зүй Зөвлөлдөх Гарцаагүй тохиолдолд нөлөөллийн 	Үйл ажиллагааны төрөл I-тэй ижил	Дизайны шатанд нөлөөллийг бууруулах

	Нөлөөлөл: Үйл ажиллагааны төрөл I	Нөлөөллийг бууруулах хариу арга хэмжээ. Үйл ажиллагааны төрөл I	Болзошгүй нөлөөлөл: Үйл ажиллагааны төрөл II	Нөлөөллийг бууруулах хариу арга хэмжээ. Үйл ажиллагааны төрөл II
		нөхөн төлбөр олгох		
Явган зорчигчийн нэвтрэх чадвар, хөдөлгөөн буурах	Явган зам, автозамыг хааснаас гарч болох нөлөөлөл	<ul style="list-style-type: none"> Нөлөөллийг хамгийн бага байлгахуйц зам барилгын ажлын арга сонгох Зөвлөлдөх Дохиолол Бусад шаардлагтай арга хэмжээ Замын хөдөлгөөний түр зохицуулалт 	Зам барилгын ажлын цар хүрээ өргөн байх магадлалтай тул орц гарцад нөлөөлөл үзүүлж болзошгүй	Нөлөөллийг хамгийн бага байлгахуйц зам барилгын ажлын арга, дарааллыг сонгох Дэд төслийн БОНМТ, ТОХТ, ХХЗЖ, зэрэг төлөвлөгөө, ажлын удирдамж, хяналт шинжилгээний механизмыг боловсруулж хэрэгжүүлэх, хяналт тавих
Эмзэг бүлгийн оролцоог хязгаарлах	Ялгаатай хэрэгцээ, сонирхолыг үйл ажиллагаа, дэд төслийн дизайн боловсруулалт, төлөвлөлтөд харгалзаж үзэхгүй байх	<ul style="list-style-type: none"> ТОХТ, ГБМ-ыг хэрэгжүүлэх, зөвлөлдөх НШБХ, НШҮАТ-нд нарийвчлан тусгах 	Ялгаатай хэрэгцээ, сонирхолыг үйл ажиллагаа, дэд төслийн дизайн боловсруулалт, төлөвлөлтөд харгалзаж үзэхгүй байх	Төсөл хэрэгжих 3-5 дахь жилд Ковид 19 цар тахал хяналтад орсон байж үзэх ч нөхцөл байдлаас хамаарч ажиллана.
ЖСХ/БМБҮ	Холбогдох эрсдэлд өртөх магадлал нэмэгдэх	<ul style="list-style-type: none"> ТОХТ, ГБМ-ыг хэрэгжүүлэх, зөвлөлдөх ХМТ, Ёс зүйн дүрэм, БОНМТ-нд нарийвчлан тусгах 	Холбогдох эрсдэлд өртөх магадлал нэмэгдэх	

	Нөлөөлөл: Үйл ажиллагааны төрөл I	Нөлөөллийг бууруулах хариу арга хэмжээ. Үйл ажиллагааны төрөл I	Болзошгүй нөлөөлөл: Үйл ажиллагааны төрөл II	Нөлөөллийг бууруулах хариу арга хэмжээ. Үйл ажиллагааны төрөл II
Ковид 19 цар тахалын нөлөөлөл	I Холбогдох эрсдэлд өртөх магадлал нэмэгдэх, Оролцогч талуудтай нүүр тулан харилцах, чадавх бэхжүүлэх гэх үйл ажиллагаа удаашрах	<ul style="list-style-type: none"> • ТОХТ, ГБМ-ыг хэрэгжүүлэх, зөвлөлдөх • ХХЗЖ, Ёс зүйн дүрэм, БОНМТ-нд нарийвчлан тусгах • Үйл ажиллагааны төлөвлөгөө, болзошгүй зардлын төсөвт өөрчлөлт оруулах 	Холбогдох эрсдэлд өртөх магадлал нэмэгдэх, Оролцогч талуудтай нүүр тулан харилцах, чадавх бэхжүүлэх гэх үйл ажиллагаа удаашрах	
Хөдөлмөрийн эрүүл мэнд ба аюулгүйн ажиллагаа (ХЭМАА)	Ажилчид, оршин суугчдад түр хугацаанд багахан нөлөөлөл үзүүлэх болзошгүй	<ul style="list-style-type: none"> • ТОХТ, ГБМ-ыг хэрэгжүүлэх, зөвлөлдөх • ХМТ, Ёс зүйн дүрэм, БОНМТ-нд нарийвчлан тусгах 	Ажилчид, оршин суугчдад түр хугацаанд багахан нөлөөлөл үзүүлэх болзошгүй	
Газар чөлөөлөлт	Автозамыг түр хааснаас гарч болох бага хэмжээний нөлөөлөл	<ul style="list-style-type: none"> • ТОХТ, ГБМ-ыг хэрэгжүүлэх, зөвлөлдөх • ХХЗЖ, Ёс зүйн дүрэм, БОНМТ-нд нарийвчлан тусгах 	Коридорыг өргөсгөх ажилд газар чөлөөлөлт шаардлагатай.	

99. I дүгээр төрлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд газар чөлөөлөлт шаардлагагүй бол цар хүрээгээрээ илүү II дугаар төрлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд газар чөлөөлөлт, амьжиргаанд нөлөөлөхүйц байна. I дүгээр төрлийн үйл ажиллагааны хүрээнд газар чөлөөлөлт шаардлагагүй хэдий ч нийслэлийн замын коридорын

хэсгүүдэд албан бус бизнес эрхлэгчид тогтмол эсвэл улирлын чанартайгаар үйл ажиллагаагаа эрхэлдэг байх, тэдгээрийн үйл ажиллагаанд нөлөөлөх боломжтой, зохицуулахад төвөгтэй байж болзошгүй. II дугаар төрлийн үйл ажиллагаа нь газар чөлөөлөлт, эмзэг бүлгийн иргэдийн амьжиргаанд үзүүлэх нөлөөллийн хувьд их буюу ихээхэн эрсдэлтэй байна. Бүрэлдэхүүн 1-ийн хүрээнд хэрэгжүүлэх судалгаа шинжилгээний ажлаар 2 дугаар төрлийн үйл ажиллагааны урьдчилсан тодорхойлсон Их хэмжээний эрсдлийг нарийвчлах болно.

100. Төслийн хүрээнд (ихэнхдээ II дугаар төрлийн үйл ажиллагаа) гэр хорооллын замыг сайжруулах ажил хийгдэнэ. Гэр хороолол ерөнхийдөө хот суурины үйлчилгээ дутмаг хөгжсөн, гэр хорооллын иргэдийн зорчих асуудлыг шийдвэрлэн амьдрал ахуйг сайжруулах хэрэгцээтэй байдаг. Сонгосон гэр хорооллын хувьд хийгдэх ажлуудыг Бүрэлдэхүүн 3 хэсгийн хүрээнд судалгаа шинжилгээ, зөвлөх үйлчилгээний ажил болон талуудтай хийх хэлэлцүүлгийн үр дүнгээр тодорхойлно. Төслийн хувьд болзошгүй нийгмийн эрсдлийг төслийн урьдчилан таах боломжгүй зүйлс болон хөрөнгө оруулалтыг тодорхойлох, үнэлэх, батлахтай холбоотой нарийн дүн шинжилгээний ажлаас үүдэн ерөнхий Хүрээг ашиглан тодорхойлсон. Түүнчлэн нийслэлийн удирдах байгууллуудын хязгаарлагдмал чадавх зэргийг харгалзсан болно. Нийгмийн холбогдох үнэлгээг төслийн дизайн боловсруулалтын явцад хийн БОНМХ-с гадна хийснээр зарим урьдчилан таамаглаагүй зүйлсийг цөөрүүлэхээс гадна ирээдүйд гүйцэтгэх судалгаа шинжилгээний ажлын удирдамжид тусган нийгмийн болзошгүй эрсдэл, тохиолдлуудыг амжилттай удирдах боломжт бүрдэнэ. БОНМХ-нд тусгасан Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын хүрээ (НШБХ) баримт бичигт төслийн хэрэгжилтийн явцад хийхгазар чөлөөлөлт болон Нүүлгэн шилжүүлэлтийн арга хэмжээний төлөвлөгөөг (НШАХТ) боловсруулахад тавигдах хамгийн доод хэмжээний шаардлагыг тодорхойлсон.

4.2. Хамаарахгүй үйл ажиллагааны жагсаалт

94. Төслийн удирдах нэгж болон байгаль орчин, нийгмийн мэргэжилтнүүд төслийн бүрэлдэхүүнд тусгасан үйл ажиллагаануудыг дараах жагсаалттай харьцуулан тулгаж үзнэ. Дараах төрлийн үйл ажиллагааг хүчингүйд тооцож, төслийн санхүүжилтэнд хамруулахгүй:

- Байгалийн тусгай хамгаалалттай газар, байгалийн чухал бэлчээр газар, байгалийн үзэсгэлэнт газар, соёлын өвийн төв бүхий газарт шинээр барилга байгууламж барих,
- Байгаль орчин, экосистем, түүний дотор усны экосистем, агаарын чанар, хөрсний бохирдол зэрэгт онц ноцтой хохирол учруулах үйл ажиллагаа болон зохих ёсны нөхөн сэргээлтгүйгээр хөрс хуулах,
- Олон нийт, эмзэг давхарга, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хэсэг бүлэг хүн, эмэгтэйчүүдийн ашиг сонирхолыг үл хүндэтгээгүй төслийн үйл ажиллагаа,
- Хүүхдийн албадан хөдөлмөр, ялгаварлан гадуурхалт, бэлгийн мөлжлөг болон дарамт, жендерийн тэгш бус байдлыг улам нэмэгдүүлэхүйц төслийн үйл ажиллагаа,

- Үндэсний цөөнхийн газар, соёлын өв зэрэгт сөрөг нөлөөтэй эсвэл нүүлгэн шилжүүлэхэд үнэ төлбөртэй, урьдчилан мэдэгдэх болон зөвшөөрөл авах боломжгүй үйл ажиллагаанууд.
95. Түүнчлэн ДБ дараах үйл ажиллагаатай холбоотой төслүүдийг санхүүжүүлэхгүй¹²:
- Тухайн хүлээн авагч орны хууль, ОУ-ын дүрэм журам, конвенци, гэрээ хэлэлцээрээр хууль бусд тооцогдох эсвэл олон улсын хориг үйлчлэх бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, арилжаа худалдаа,
 - Зэвсэг, сумны үйлдвэрлэл болон арилжаа худалдаа,
 - Согтууруулах төрлийн ундааны үйлдвэрлэл болон арилжаа худалдаа,
 - Тамхины үйлдвэрлэл болон арилжаа худалдаа,
 - Мөрийт болон бооцоот тоглоом, казино болон ижил төрлийн үйл ажиллагаа,
 - Цацраг идэвхит материалын үйлдвэрлэл болон арилжаа худалдаа. Үүнд зөвшөөрөгдсөн эмнэлэгийн тоног төхөөрөмж, чанарын хяналтын (хэмжилтын) багаж зэрэг хамаарахгүй.
 - Ойролцоох голд (Жишээ нь Туул) явуулж буй хууль бус загасчлал, загасны тор ашиглах, тэслэх замаар загасчлал хийх зэрэг.

¹² IFC Exclusion List, www.ifc.org

5. Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөл, тэдгээрийг бууруулах арга хэмжээ

5.1. Байгаль орчинд үүсэх үр ашиг

103. Төсөл нь байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх хэдий ч I, II төрлийн хөрөнгө оруулалтын төслүүд чамгүй боловч хянаж болохуйц сөрөг нөлөөтэй. Төслөөр сонгосон коридорт баригдах сайжруулсан болон шинээр барих автозам тухайн орон нутгийн газар, (хөрс, ургамал зүй), усны болон хотын агаарын чанарт шууд болон нэлэнхүйдээ эерэг нөлөө үзүүлнэ. Сайжруулсан болон шинээр барьсан автозам ашиглалтад орсноор автомашинууд шороон зам ашиглаж байгаагаас бага хэмжээний хүлэмжийн хий ялгаруулах бөгөөд улмаар шатахууны хэрэглээ болон нүүрсхүчлийн давхар ислийн ялгаралт буурна. Гэвч машины тоо нэмэгдвэл сайжруулсан замаас үүдэлтэй эерэг нөлөөг бууруулах магадлалтай.

104. Сайжруулсан болон шинэ автозам дагуулан ус зайлуулах тогтоцыг байгуулна. Ингэснээр иргэдийн ахуйн болон ААН-үүдийн үйл ажиллагаанаас үйдэлтэй ил задгай усны бохирдлыг бууруулна. Сайжруулсан автозамын тусламжтайгаар бохирдол бүхий тогтоол усыг цуглуулснаар усны чанар болон хөрсний эрүүл мэнд, ургамал зүйд нэлэнхүйдээ эерэгээр нөлөөнө.

105. Сайтар бодож төлөвлөсөн автозам болон өөрчлөлтүүд, түүний дотор явган хүний болон дугуйн замууд явган алхах эсвэл дугуй унах автомашингүй иргэдийн тоог нэмэхэд чиглэнэ. Түүнчлэн уг ажил хэрэгжсэнээр газар ашиглалтын төлөвлөгөөний сайн туршлага бий болох, технологийн шинэчлэлийг дэмжихээс гадна эдийн засгийн тохирох хэрэгслийг ашиглах (мөнгөн) хөшүүргийг бий болгоно.

5.2. Нийгэмд үүсэх үр ашиг

106. Санал болгож буй төслүүдийн нийгэм дэх үр ашиг нь богино болон дунд хугацааных бөгөөд тэдгээр нь төсөл амжилттай хэрэгжиж дууссан тохиолдолд зам, коридорын засвар, нягтаршилын бууралт, нийтийн тээврийн үйлчилгээний сайжруулалтаар хязгаарлагдахгүй бөгөөд хотын тогтвортой тээврийн хөгжил болон нийгмийн ерөнхий ахуй амьдралд эерэг нөлөөтэй. Тэдгээрээс дурдвал:

- Автозамын коридор шинээр барьж, сайжруулснаар сонгосон замын сүлжээ, дэд бүтэц, автобусны маршрутын сонголт хоорондын уялдаа холбоог сайжруулж, илүү аюулгүй, хүртээлтэй, үр ашигтай аяллыг дэмжих болно.
- Аюулгүй, найдвартай, тогтвортой тээврийн үйлчилгээ бий болсноор оршин суугчдын, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй болон бага насны хүмүүсийн зорчих хөдөлгөөн нэмэгдэж, тээврийн зардал буурна.
- Төрийн бодлоготой уялдуулан тухайн орон нутагт бизнес эрхлэх болон хөрөнгө оруулахад таатай нөхцөл бүрдсэнээр нийгэм-эдийн засгийн өсөлт, гэр хорооллын дахин төлөвлөлт болон төрийн нэгдсэн үйлчилгээний хүртээмжийг хувь нэмэр оруулна.

- Орон нутгийн удирдлага болон төрийн бодлого хэрэгжүүлэгч байгууллагууд өөрсдийн техник чадамж, чадвараа бэхжүүлэхийн зэрэгцээ нэгдсэн автозамын дэд бүтцийн менежмент болон хэрэгжүүлэлтийн туршлагатай болно.

5.3. Байгаль орчин, нийгмийн болзошгүй сөрөг нөлөөлөл ба бууруурах арга хэмжээнүүд

107. Дэд-төслийн үнэлгээ, менежментийн төлөвлөгөөнүүд нь төслийн хэрэгжилтийн үе шатанд боловсруулагдах ба төслийн талбай тус бүрийн эрсдэл болон тэдгээрээс сэргийлэх арга хэмжээг тусгана оруулсан байна. ТХН нь БОНМХ-г хэрэгжүүлэх мөн хянан шалгахад шаардлагатай төсвийг хуваарилах ба дэд төслийг хэрэгжүүлэх үед шаардлагатай үед нэмэлт БОН-ын хариу арга хэмжээг авна.

108. БОНМХ-г боловсруулах явцад дийлэнх байгаль орчин, нийгмийн боломжит эрсдэл, нөлөө нь голчлон зам засварын хөрөнгө оруулалтын (Бүрэлдэхүүн 1-ын I болон II-р төрлийн ажлуудтай) ажилтай холбоотой ба онцлох нөлөөлөл болон хариу арга хэмжээг доор тодорхойлон бичив. 5,6 дугаар хавсралтууд болох **Хавсралт 5 Байгаль орчин, нийгмийн менежментийн ерөнхий төлөвлөгөө, Хавсралт 6 БОНМТ-г боловсруулах удирдамж нь цаашдаа дэд-төслүүд тус бүрт хэрэглэгдэнэ. Байгаль Орчин, Нийгмийн Хариуцлагын Төлөвлөөнд (БОНХТ) зээлдэгч нь техникийн туслалцааны үйл ажиллагааг төслийн хүрээнд аливаа ажлыг гүйцэтгэх, судалгаа болон судалгааны удирдамжийг боловсруулахдаа Банкинд хүлээн зөвшөөрөгдөх, БОНХ-ын холбогдох нөхцөлийг бүрдүүлсэн байна.** Техникийн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааны цар хүрээ, үр дүн, ажлын удирдамж, төлөвлөгөө, болон бусад **баримт бичиг нь БОМС1-10 стандартыг хангаж байх шаардлагатай.** Төсөл хэрэгжиж дууссаны дараа зээлдэгчийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь Банкны санхүүжилт бус, мөн техникийн туслалцаатай шууд холбоогүй үйл ажиллагаа хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилт нь Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн бодлогод хамааралгүй болно.

Байгаль орчинд үзүүлэх нөлөө болон бууруулах арга хэмжээ

109. I-р төрлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь (коридорын засвар, арчилгаа) богино хугацаанд бага хэмжээтэй газрын эвдрэл, гол орчмын газар шорооны ажил нь хөрсний элэгдэл үүсгэх, авто замын зурвас дагуух мод, бутыг хөдөлгөх эрсдэлтэй. Газар шорооны ажлын явцад машин механизмын хөдөлгөөн, тэдгээрээс ялгарах тос тослох материал, засвар хийхэд ашиглах будаг, бохир ус болон химийн бодис асгарснаас үүдэлтэй бага хэмжээний хөрсний бохирдол үүсэх магадлалтай.

110. II-р төрлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас (коридорын шинэчлэл) шимтэй хөрс алдах, хөрс доройтох, өөрчлөгдөх, хөрсний эвдрэл явагдах зэрэг эрсдэл үүснэ. Газар шорооны ажлын явцад машин механизмын хөдөлгөөн, тэдгээрээс ялгарах тос тослох материал, засвар хийхэд ашиглах будаг, бохир ус болон химийн бодис асгарснаас үүдэлтэй бага хэмжээний хөрсний бохирдол үүсэх магадлалтай. Мод болон бусад ногоон ургамал бүрмөсөн устах эрсдэлтэй. Үер үүсэх нөхцөл бүхий хөрсний шилжилт хөдөлгөөн үүсэх эрсдэлтэй. Шуудуу нь тогтоол ус цуглуулах болон орчны үзэмжид сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Хайрга олборлолтоос үүдэлтэй газарзүйн тогтоцын мэдэгдэхүйц өөрчлөлт гарч

болзошгүй. Гэвч менементийн зөв зохистой арга хэмжээ нь хөрсний бохирдлоос сэргийлэх боломжтой.

Хөрс

111. Газар тэгшлэх, ухах, дүүргэх зэрэг барилгын үйл ажиллагаанаас үүдэн хэсэгчилсэн гадаргууны элэгдэл, тогтоол ус, эвдрэл гэмтэл үүсч болзошгүй. Эрэг дагуух эсвэл усан биет орчим дахь хөрсний элэгдэл илүү ноцтой байж болзошгүй бөгөөд нөхөн сэргээх ажлыг зохих ёсоор хийгээгүй тохиолдолд барилгын ажил дууссаны дараа ч бий болох эрсдэлтэй. Хэрэв дэд төслийн газар харьцангуй тэгш бөгөөд усан биет, онц ач холбогдолтой бүс, суурин газар, сургууль, эмнэлэг зэргээс хол байх тохиолдолд нөлөө нь цар хүрээ багатай, хугацаа богинотой бөгөөд хэсэгчилсэн байна.

Бууруулах арга хэмжээ

112. Төслийг гүйцэтгэгч (гүйцэтгэгч) нь хөрсний гадаргууг хуулах, хадгалах, эвдэрсэн газар болон хөрсийг нөхөн сэргээх Монгол Улсын болон олон улсын аргачлалыг даган мөрдөнө. Өнгөн хөрсний нөхөн сэргээх хиймэл давхарга болгон ашиглана. Инженерчлэлийн арга болон барилгын газрын зөв менементийг хэрэгжүүлэх замаар нөлөөг зүй зохистой бууруулна. Эвдрэх болон авагдах хөрсний хэмжээ, талбайг тодорхойлно. Монгол Улсын Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний дагуу (EIA) (эсвэл зохих олон улсын стандарт) зам засвар, барилгын стандарт болон аргачлалыг баримтална. Үүнд: бохирдсон хөрсийг арчлах стандарт (Азот бордоо ашиглах болон боловсруулалтанд орсон хөрсийг дахин сэргээх тухай дотоодын болон олон улсын аргачлал болон зааварчилгаа). Гүйцэтгэгч байгууллагаас Шингэн бодисыг зохицуулах төлөвлөгөөг боловсруулж, ТХН-ээр батлуулсан байх. Мөн түүнчлэн байгаль орчны менементийн төлөвлөгөөний нэг хэсэг болгож гүйцэтгэгч бнь Хөрсний элэгдлийг зохицуулах төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх болно.

Агаарын бохирдол ба тоос шороо

113. Зам барилгын ажлаас үүдэлтэй дараах агаарын бохирдол үүсч болзошгүй: (i). Газар ухах, дүүргэх, ачих, тээвэрлэх, буулгах зэргээс үүдэлтэй тоос шороо, (ii) Нээлттэй барилгын талбайгаас, ялангуяа салхитай өдөр үүсэх тоос шороо, (iii) Барилгын материалын агуулах, ялангуяа салхитай өдөр үүсэх тоос шороо, (iv) тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хүнд механизмын хөдөлгөөнөөс үүсэх тоос шороо, (v) Бетон үйлдвэрлэл, зуурмагаас үүдэлтэй тоос шороо, (vi) Тоног төхөөрөмжийн хийн ялгаралт (тээврийн хэрэгсэл болон дизелиэр ажиллах машин, тоног төхөөрөмжөөс ялгарах CO, NO₂).

114. Дэд төслийн газар дахь нөлөөллийг тухайн газар нутгаар хязгаарлах бөгөөд богино хугацаатай байхаас гадна оршин суугчдад нөлөөлж болзошгүй. Нэвтрэх зам дагуух тээврийн хэрэгслийн хийн болон тоос шороон ялгаралт агаарын чанарын стандартын хязгаарыг давахгүй бөгөөд бусад тээврийн хэрэгслийн хийн болон тоос шороон ялгаралтай харьцуулахад бага цар хүрээтэй байна.

Бууруулах арга хэмжээ

115. Хэдийгээр бага хэмжээний ч гэсэн эдгээр болзошгүй нөлөөллийг барилгын газрын болон тоног төхөөрөмжийн зөв менежментийн аргаар бууруулах боломжтой. Эдгээр арга нь тээвэрлэж буй ачааг хучих, барилгын хөдөлгөөний зөв зохион байгуулалтанд оруулах зэрэг байна. Мөн түүнчлэн газрыг чийглэнэ. Зам барилгын явцад нөлөөллийг бууруулах зарим арга хэмжээнүүдээс дурдвал: асфальт болон бусад бетон зуурмагийн үйлдвэрлэлийг эмзэг цэгүүдээс багадаа 500 метрийн зайд байршуулах; тоос шороо үүсгэх зүйлсийг хучиж тээвэрлэх; замын гадаргууг чийглэх; газар шороо, элс, чулуу зэргийг тээвэрлэж буй ачааны машинуудад тэдгээр зүйлсийг тархаахгүй байх зорилгоор брезент эсвэл зохих материалаар бүхий хучлагаар бүрхэх; хүнд машин механизмыг бохирдлын хяналтын хамгийн боломжит төхөөрөмжөөр тоноглох; ил задгай гал гаргахгүй байх; уусгагч болон ууршимтгай бодисыг дүрэм журмын дагуу ашиглахыг гэрээ болон баримт бичигт тусгах.

116. Барилгын өмнөх эргэн тойрны агаарын чанарыг хэмжиж тэмдэглэх нь барилгын үе шат хяналттай харьцуулж агаарыг хэмжих суурийг тодорхойлно.

Усны чанар

117. I болон II төрлийн засвар, шинэчлэх ажлууд нь гадаргууны болон тогтоол усыг засвар болон шинэчлэлд ашиглах химийн бодисоор бохирдуулах бага хэмжээний эрсдэл үүсгэж байна. Үйл ажиллагааны аль нэг шатанд хүнд метал болон техникийн тос замын хажууд цугларч усан орчинд нэвчиж, улмаар ургамал зүйд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Усархаг бороо болон аадар борооны улмаас шар усны үер үүсч болзошгүй. Болзошгүй нөлөөллийг зөвхөн барилгын газраар хязгаарлах бөгөөд II-р төрлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай голдуу холбоотой.

118. II-р төрлийн Бүрэлдэхүүн 1.1.-т заасан шинэчлэлийн ажилд Туул гол ойр орчмын дэд төсөл багтвал Туул гол Байгаль орчны нөлөөний ерөнхий үнэлгээг болон Байгаль орчны нарийвчилсан үнэлгээгээр нөлөөллийг тодорхойлох шаардлагатай. Уг үнэлгээний явцад нөлөөллийг бууруулах менежментийн төлөвлөгөөг мөн боловсруулна.

Бууруулах арга хэмжээ

119. Дээрх болзошгүй нөлөөг бохир усны менежментийн аргаар шийдэхийн дотор ажилчдын ариун цэврийг хангах байгууламж бий болгох, барилгын явцад гарсан бохирдол усыг зохицуулах, тоног төхөөрөмж болон тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг барилгын талбайгаас гадна хийлгэх зэрэг үйл ажиллагаанууд багтана.

120. Ойролцоох гэр хорооллын газрын гүний худаг болон гар худгуудын байршлыг тогтоон тэмдэглэж, тээвэрлэлт болон барилгын явцад химийн болон барилгын материалаас үүдэлтэй усны хордлогоос эрсдлээс зайлсхийх үнэлгээг хийнэ.

Дуу чимээ болон чичиргээ

121. Барилгын үйл ажиллагаанд экскаватор ашиглах, барилгын материал тээвэрлэх зэрэг барилгын явцад хүнд машин механизмын дуу чимээ үүснэ. Энэ нь ойролцоох оршин суугчдад нөлөөлнө гэж тооцоолж байна. Барилга угсралтын материалыг хүнд даацын тээврийн

хэрэгслээр тээвэрлэхтэй холбоотойгоор зам болон / эсвэл одоо байгаа бусад дэд бүтцээс үүсэх чичиргээ, дуу чимээ нэмэгдэж болзошгүй юм.

Бууруулах арга хэмжээ

122. Болзошгүй нөлөөг барилгын дуу чимээний зөв менежментийн арга хэмжээ авснаар бууруулна. Эдгээр арга хэмжээнд ажлын цаг хязгаарлах, дуу чимээ тусгаарлагч босгох, шаардлагатай тохиолдолд дуу чимээ багатай тоног төхөөрөмж ашиглах, тоног төхөөрөмжийг төрийн холбогдох шаардлагын дагуу дуу намсгагчаар тоноглох зэрэг ажил орно. Зам засварын ажлын өмнө дуу чимээ, чичиргээг хэмжиж тогтоох.

Хатуу хаягдал

123. Барилгын явцад гарсан хатуу хаягдал гэдэгт барилгын болон хэрэглээний хатуу биет хог багтана. Барилгын хатуу хаягдалд замын материал болон бусад хог хаягдал орно. Хэрэглээний хаягдал гэдэгт органик, органик бус биет багтах бөгөөд нэг ажилчин өдөрт 0,4 кг хог хаягдал үүсгэдэг тооцоо бий. Хог хаягдлыг буруу хадгалж, хаяснаар хөрс, гүний болон гадаргуу усны нөөц, улмаар нийтийн эрүүл мэнд, ахуйд сөргөөр нөлөөнө.

Бууруулах арга хэмжээ

124. Эдгээр болзошгүй нөлөөллийг хог хаягдлын зөв менежментийн аргаар бууруулж болох бөгөөд эдгээр аргуудад барилгын талбай бүрт хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах, хогны сав бэлдэх, улсын дүрэм журмын дагуу хийж болох түвшинд бүх материалыг дахин ашиглах, зохих хогийн цэгт үлдэгдэл хог хаягдлыг цуглуулах зэрэг орно. Дэд бүтцийн талбайд хог хаягдал шатаах хориотой. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд хог асгарч тарахаас урьдчилан сэргийлэх, барилгын хог хаягдлыг өдөр тутам цуглуулах, барилгын талбайг тойруулан хашаа босгох, замын зөв тэмдэг тэмдэглээ байршуулах зэргээр хатуу биет хог хаягдлыг зохицуулахад чиглэсэн нөлөөллийг бууруулах зөвлөмж бүхий төлөвлөгөөг багтаана.

125. Байгаль орчинд хортой хогийг хорт хог хаягдлыг зохицуулах дүрэм журмын дагуу боловсруулан хогийн цэг рүү тээвэрлэх бөгөөд гэрээлэгч байгууллага шатааж болохгүй.

Аюултай болон бохирдуулагч материал

126. Шатахуун болон аюултай материалыг буруу тээвэрлэх, хадгалах, ашиглах, хаях, асгах зэрэг нь барилгын ажлын үеэр үүсч болох үнэмлэхүй эрсдлүүд юм. Аюултай хог хаягдал хөрс, гадаргуу болон гүний усыг хордуулдаг.

Бууруулах арга хэмжээ

127. Эдгээр болзошгүй нөлөөллийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид заасны дагуу аюултай материалын зөв менежментийн аргаар бууруулах боломжтой. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд тээвэрлэлтийн явцад асгарах болон хог хаягдлыг хууль бусаар, ялангуяа Түүл болон Сэлбэ гол руу цутгах, хаях зэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн аюултай материалыг зохицуулах иж бүрэн процедуртай байна.

Ургамал ба амьтны аймаг

128. II-р төрлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны газруудад болон тэдгээртэй ойр орчимд чухал, ховордсон, нэн ховордсон ургамал болон амьтан зүй байхгүй болно. Тиймээс барилгын ажил нь эдгээр нөөцөд аливаа нөлөөлөлгүй болно.

Бууруулах арга хэмжээ

129. Ерөнхий нөлөө багатай бөгөөд хөрсний гэмтэл, хаягдал ус зөв зохицуулахад чиглэсэн арга хэмжээгээр авч эдгээр асуудлыг зохицуулна. Авто замын зураг төсөл нь биомимик гэх мэт тогтвортой зураг төсөл, загварыг оруулах, бүс нутгийн ургамлын төрөл зүйл, (ус шингээгч ургамал, мод бут) хэрэглэх. Улиас модны (*Populus sect. Aigeiros*) тарихаас зайлсхийх.

Зам дагуух мод авах шаардлагатай тохиолдолд гүйцэтгэгч нь өөр боломжит газар шилжүүлэн суулгах шаардлагатай.

Бусад байгаль орчны эрсдлүүд

130. Дэд төслүүдийн байршилд хур ихтэй үед ус нэвчих боломжгүй гадаргуу, ус зайлуулах сувгийн ачаалал ихэссэн үед тухайн орчим үерлэх эрсдэлтэй. Үүний зэрэгцээ зам гудамж нь халуун үед хэт халах (urban heat) эрсдлийг үүсгэх боломжтой. Өнөө үед шар усны үерлэлт нь элбэг тохиолдож байгаа ба гэр хорооллын оршин суугчдын гэр болон эд хөрөнгийг усанд автуулж орон гэргүй болгох эрсдэл өндөр байна.

Бууруулах арга хэмжээ

131. Үерийн болон болон ус зайлуулах сувгийн ачаалал хүчин чадлын, зам гудамжийн халалтыг судлаж тогтоож, шаардлагатай бол сэргийлэх төлөвлөгөө боловсруулан БОМТ-ийн хүрээнд хэрэгжүүлэн ажиллах.

Газар хөдлөлт болон цэвдэг

132. Газар хөдлөлттэй холбоотой эрсдэл; мөнх цэвдэгтэй холбоотой эрсдлийг зураг төсөл боловсруулах үе шатанд тооцож судлах. Бүрэлдэхүүн хэсэг 2-тэй холбоотойгоор сонгосон коридоруудад автобусны эгнээ байрлуулах, төслийн коридоруудын дагуу автобусны зогсоолуудыг сайжруулах зэрэгт тогтвортой инженерийн зураг төслийг боловсруулахыг зөвлөж байна.

Нийгмийн нөлөө болон бууруулах арга хэмжээ

Замын хөдөлгөөний менежмент

133. Сонгосон коридоруудад засвар, дахин шинэчлэх, төлөвлөх ажлын үед төслийн талбайгаар олон тооны тээврийн хэрэгсэл дамжин өнгөрөх шаардлага үүсч болзошгүй. Барилгын материал, тоног төхөөрөмж тээвэрлэх хүнд ачааны машинууд замын урсгалд саад болох магадлалтай. Замын хэсгийг түр хааснаар замын зохицуулалт болон тойруулах шаардлага үүсч болно.

134. Барилгын үед замын хэсгийн түр хааснаар замын хэрэглэгчдэд томоохон бэрхшээл үүсч болзошгүй. Нэг эгнээ бүхий зам эсвэл ямар нэгэн байдлаар саатал үүсч болох зам дээр

тээврийн хэрэгслийг барилгын талбайгаар аюулгүй, саад багатай нэвтрүүлэх үүрэгтэй гүйцэтгэгч байгууллагаар дамжуулан замын хөдөлгөөний менежментийг бий болгоно. Түүнчлэн замын хөдөлгөөний саад болон ачааны хүнд машинууд нь тухайн хэсгээр зорчигч болон барилгын ажилчдын зам дээрх хөдөлгөөний аюулгүй байдалд эрсдэл үүсгэх боломжтой. Барилгын материал тээвэрлэж буй ачааны хүнд машинууд зам болон бусад дэд бүтцийн байгууламж эвдлэх магадлалтай. Тиймээс өөр тээврийн зам ашиглах эсвэл зөвхөн зөвшөөрөгдсөн жин бүхий ачаатай машиныг хөдөлгөөнд оролцуулах зэргээр эдгээр нөлөөллөөс сэргийлэх боломжтой.

Бууруулах арга хэмжээ

135. Зам тээврийн эрдлээс урьдчилан сэргийлэх, багасгах, бууруулах зорилгоор Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөөг уг төслийн хүрээнд боловсруулах бөгөөд төлөвлөгөө боловсруулах удирдамж, замын хөдөлгөөний түр зохицуулалтын арга хэмжээний талаар Хавсралт 7-д тусгасан болгоно.

Ажил хөдөлмөрийн нөхцөл (Ажлын байрны хамгаалалт, эрүүл мэнд)

136. Нэгдүгээр бүрэлдэхүүний хүрээнд гэрээгээр ажиллах ажилчин нь тэслэлт, газар шорооны ажил, машин механизмын ажиллагаа зэргээс үүсэх тоос шороо их болон хортой нөхцөлд ажиллах магадлалтай. Эдгээр нь ажлын үед ядарч сульдах, дотор муухайрах зэрэг шинжээр илэрч болно. Түүнчлэн ажилчид барилгын талбай дээр цахилгааны утас, хүчдэлтэй тоног төхөөрөмж, биет аюул болон бусад машин механизмд өртөх магадлалтай бөгөөд ялангуяа ажлын байран дээр анхаарал болгоомжгүй эсвэл тоомжиргүй хандах, ажлын аюулгүй байдлын зааварчилгааг мэдэхгүй зэргээс энэ төрлийн эрсдэл эрс нэмэгдэнэ.

137. Төслийн гүйцэтгэгч байгууллага дотоодын хөдөлмөрийн зах зээлээс ажиллах хүч авах бөгөөд ажилчид ажлын дараа гэр рүүгээ харих зохицуулалттай, харин зайлшгүй тохиолдолд гадаад орноос цөөн тооны өндөр түвшний нарийн мэргэжлийн инженер, мэргэжилтнүүд ажиллуулж болно. Хоол хүнс, цэвэрлэгээний үйлчилгээ, тоног төхөөрөмж, материал болон хангамжийн хүргэлт, мэргэжлийн туслан гүйцэтгэгчээр хэсэгчилсэн ажил гүйцэтгэх зэргээр тогтмол орох, гарах нэмэлт үйлчилгээ байж болно.

138. Барилгын явцад барилгын ажилчид ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэндтэй холбоотой асуудал үүсэх эрсдэлтэй. Орон нутгийн иргэд болон ажилчид халдварт өвчин болон Ковид-19 өвчинд нэрвэгдэх магадлалтай. Мөн түүнчлэн гадаадаас, ялангуяа өвчлөлт ихтэй орноос ажилтан ирсэн тохиолдолд гадаадын ажилчид болон нутгийн иргэдийн хооронд нийгмийн хурцадмал байдал үүсэх боломжтой. Гэвч энэхүү эрсдэл нь Ковид-19-ийн эсрэг авч буй Монгол Улсын арга хэмжээний хүрээнд харьцангуй дунд түвшинд байх магадлалтай. Төслийн гүйцэтгэгчид Ковид-19-с урьдчилан сэргийлэх, хянахаар төрөөс хэрэгжүүлж буй бүхий л арга хэмжээг дагах шаардлагатай.

Бууруулах арга хэмжээ

139. Эдгээр нөлөөг бууруулах зорилгоор Хөдөлмөрийн харилцаа зохицуулах журамд (ХХЗЖ) (Хавсралт 2) тодорхой шаардлагуудыг заасан байгаа. ХХЗЖ-ын хүрээнд халдварт

өвчний эрсдэл болон урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлж, үнэлэхэд чиглэсэн дэд төслийн байгаль орчин болон нийгмийн үнэлгээний нэг хэсэг болгож судалгааг явуулна. Ялангуяа, Ковид-19 цар тахлын үед Дэлхийн банк болон ДЭМБ-с гаргасан зөвлөмж, зааварчилгааг барилгын менежментэд хэрэгжүүлнэ. Гадны ажиллах хүчтэй холбоотойгоор кэмпийн менежментийн төлөвлөгөөг бэлдэж, гүйцэтгэгчийн гэрээ болон бодлогод тусгана.

Эмзэг (Vulnerable) бүлэг болон оролцоог бүрэн хангах

140. Бүрэлдэхүүн 1.-т заасан зам барилгын явцад явган зорчигчийн аюулгүй байдалд түр хугацаанд эрсдэл үүсч болзошгүй. Нөлөөлөл хүрэх газарт оршин суугчдын болон үйлдвэр үйлчилгээний байр, цэцэрлэг, сургууль, өрхийн эрүүл мэндийн төв, эмнэлэг зэрэг нь шигүү байна. Санал болгож буй коридор нь Улаанбаатар хотын төв болон нягтаршил ихтэй бүсүүдэд байх тул явган хүний зам мөн адил өртөнө. Барилгын талбайн ойролцоо автобусны үйлчилгээ болон бусад үйлчилгээ тасалдах эрсдэлтэй.

141. Хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай зэрэг нийгмийн эмзэг бүлгийнхэнд Бүрэлдэхүүн 1-ний хүрээнд гарч болзошгүй зарим нөлөөллийг зохих арга хэмжээний тусламжтой багасгах боломжтой. Улмаар явган зорчигчид барилга байгууламжаар аюулгүй орж гарахад чиглэсэн арга хэмжээг гүйцэтгэгчтэй хамтран хэрэгжүүлэх шаардлагатай.

142. Бүрэлдэхүүн 2 нь ирээдүйд гэр хорооллын оршин суугчдад эерэг нөлөө үзүүлнэ гэж таамаглаж байна. Бүрэлдэхүүн 3-т заасны дагуу боловсруулах төлөвлөгөө, стратегитэй холбоотойгоор тээврийн үнэд өөрчлөлт орох магадлалтай. Ингэснээр эмзэг бүлгийнхний аяллын өртгийг төлөх чадамжид тэгш бус нөлөөлөх эрсдэлтэй. Бүрэлдэхүүн 1,2 болон 3-тай холбоотой хөрөнгө оруулалтын шийдвэрт олон нийтийг хязгаарлагдмал байдлаар оролцуулах эрсдэлтэй тул олон нийтийн зөвлөлдөх уулзалт зохион байгуулан тээврийн үйлчилгээний менежмент, зорилтот бүлгийнхэнд зориулсан дизайн шийдэл, шаардлагатай арга хэмжээнүүдийг тодорхойлоход оршин суугчдыг оролцуулж саналыг тусгах шаардлагатай байна.

Бууруулах арга хэмжээ

143. Бүрэлдэхүүн 1, 2 болон 3-н төлөвлөлт, тодорхойлолтын үйл явцад нийгмийн оролцоо чухал бөгөөд уг оролцоог төслийг хэрэгжүүлэх үед Талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ), Өргөдөл гомдлын механизм–т тусгана.Төлөвлөлт болон үр дүнд нөлөөлөх дуу хоолойгоо зөвхөн иргэд төдийгүй бизнес эрхлэгчид хүргэх зорилгоор тэдгээрийн оролцоог хангасан зохих сувгуудыг бий болгоно. Олон нийтийн дэмжлэгийг хангах зорилгоор УБ хотын захирагч төслийн үе шатыг олон нийтэд мэдээлэхэд чиглэсэн дэс дараатай арга хэмжээ авах хэрэгтэй. Төсөл жендер болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй дэд бүтэц, үйлчилгээний дизайн болон аюулгүй байдлын асуудлуудыг дэмжинэ. Бүх нийтийн хүрээмж, дизайны арга хэрэгслүүдийг тусгасан байвал зохино.

144. Түүнчлэн эмэгтэйчүүд болон охид, эрэгтэйчүүд болон хөвгүүдийн онцлог ялгаа бүхий хэрэгцээнд суурилсан жендер анализ, жендертэй холбоотой асуудлыг шийдвэрлэх бөгөөд хүйсийн хоорондын ялгаа хоцрогдлыг /гар/ арилгаж, төслийн үр дүнгийн хүрээнд жендерийн нөлөөг хянах, үнэлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Газартай холбогдох үр нөлөө

145. Нэгдүгээр бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд тэргүүлэх чиглэлийн коридоруудын байршил урьдчилан тодорхойлогдсон тул биет болон эдийн засгийн хувьд томоохон нүүлгэн шилжүүлэлт хийх шаардлагагүй. Бүрэлдэхүүн 1, 2 дугаар хэсгийн Зарим газар II төрлийн үйл ажиллагааг тодорхой газар нутагт хэрэгжүүлэхэд газар чөлөөлөлтийг (байнгын болон түр хугацаагаар) хамруулахаар хүлээлт бий. Энэ хүрээнд тухайн орон нутгийн хүмүүсийн орлого, амьжиргаанд (нүүлгэн шилжүүлэлт, газар, бизнесийн үйл ажиллагаа, орлого алдах, эмзэг бүлэг) нөлөөлөх болно. Газар чөлөөлөлтийн нөлөөлөл нь дунд зэргээс их байж болно.

146. Энэхүү Нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээгээр (НШБХ) нь (i) барилга байгууламж, үндсэн хөрөнгөд үзүүлсэн нөлөөллийг нөхөн төлөх протокол; болон (ii) зам барилгын ажлыг хэрэгжүүлэхээс өмнө, төсөл батлагдсаны дараа боловсруулах Нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг (НШҮАТ) боловсруулах шаардлагыг тодорхойлсон нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөллийн талаархи бодлого, журам тус бүрийг тодорхойлно.

147. Энэхүү НШБХ нь газар чөлөөлөх, газар ашиглалтын хязгаарлалт, албадан нүүлгэн шилжүүлэх тухай Монгол Улсын хууль тогтоомж, Дэлхийн банкны БОНС5 шаардлагыг тусгасан болно. Нөлөөлөлд өртсөн хүмүүсийн (НӨХ) төслийн өмнөх шиг илүү сайн, эсвэл дор хаяж сайн сайхан байх ёстой. Төслийн нөлөөлөлд эрх ашиг нь хөндөгдөх бүх хүмүүстэй төслийн туршид зөвлөлдөх, төлөвлөлтөд оролцуулах, төслийн үр өгөөжийг хүртэх боломж бүрдүүлнэ. Үүнтэй холбогдуулан дараах зарчмуудыг харгалзана: оролцогч талууд, ялангуяа НӨХ-ийг эрт тодорхойлох; урьдчилсан мэдэгдэж буй аливаа нөлөөллийг олон нийтэд үр дүнтэй ил тод мэдээлэх; тодорхойлсон сөрөг нөлөөллөөс зайлсхийх эсвэл багасгах зорилгоор нийгмийн бүх талын төлөөлөлтэй зөвлөлдөж, оролцоог хангах; хэн нэгэн эсвэл нөлөөллийг үл тоох, орхигдуулахгүй байх; төслийн хэрэгжилт, нүүлгэн шилжүүлэх, амьжиргааг сэргээх явцад НӨХ-ийг дэмжих үйл ажиллагааг шударга, ил тод, цаг алдалгүй авч хэрэгжүүлэх; ялангуяа ядуурал, үндэс угсаа, хүйс, нас, хөгжлийн бэрхшээл, нийгмийн байдлаас шалтгаалан эмзэг байж болзошгүй хүмүүсийн хувьд нөхцөл байдлыг сайжруулах үүрэг хүлээх.

148. Хэрэв алдагдсан үндсэн хөрөнгө (дэлгүүр гэх мэт байгууламж) байвал ижил зүйлээр дүйцүүлэн солих, хэрэв боломжгүй бол алдагдсан хөрөнгө болон орлого, нүүлгэн шилжүүлэх, амьжиргааг сэргээх зардлыг нөхөн олгоно. Нөхөн сэргээхэд зөвхөн биет хөрөнгө төдийгүй нийгэм, соёлын үнэт зүйлс багтана. Хэрэв уг явцад саатал гарах эрсдэлтэй (эмэгтэйчүүдэд ихэвчлэн тулгардаг) бол НӨХ-т нөлөөллийн бууруулах арга хэмжээны сонголтыг олгоно.

Бууруулах арга хэмжээ

149. Газар худалдан авах ажиллагааг аль болох бага хэмжээнд байлгаж, одоо байгаа оршин суугч бүхий газрыг худалдан авахаас зайлсхийх бөгөөд Дахин нүүлгэн суурьшуулах төлөвлөгөөний хавсралт 1-т заасан арга хэмжээг авна. НШҮАТ-г Дэлхийн Банкны 2017 оны Байгаль орчин, нийгмийн стандартын хүрээ (БОНСХ), газар чөлөөлөх, газар ашиглалтын

хязгаарлалт, албадан нүүлгэн шилжүүлэх (БОНС5), Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу боловсруулна.

150. НЗДТГ-ын дэргэдэх Төслийн удирдлагын алба (ТУА)-д энэхүү НШБХ-нд тодорхойлсон зарчмын дагуу барилга байгууламж, үндсэн хөрөнгөд үзүүлсэн нөлөөллийг илрүүлэх, хариу арга хэмжээ авах эрх бүхий хүмүүсийг хамруулна. Хот доторх авто замын төлөвлөлт, барилга угсралт, засвар, арчилгааг хариуцдаг НАЗХГ-тай нягт уялдаатай ажиллана.

Амьжиргаанд үзүүлэх үр нөлөө

151. Амьжиргаанд үзүүлэх нөлөөллийн хувьд хамгийн анхаарал татах асуудал нь авто замын хажуугаар албан бус үйл ажиллагаа явуулж иргэд, тэдгээрийг нүүлгэн шилжүүлэх явдал юм. Зам барилгын ажлын үед Бүрэлдэхүүн 1.1-т дурдсан үйл ажиллагаанууд ажил болон гэр рүүгээ ирж очиход саад болох зэргээр бизнес, орон сууц, офисуудад бэрхшээл үүсгэж болзошгүй. Түүнчлэн 2-3 метр гүн бүхий шуудуу татсанаар явган зорчигчийн аюулгүй байдалд асуудал үүсгэж болзошгүй. Төслийн нөлөө бүхий газруудад орон сууц, албан газар, сургууль, цэцэрлэг, ӨЭМТ, эмнэлэг зэрэг нь шигүү байршилтай байна. Санал болгож буй коридор нь Улаанбаатар хотын төв болон нягтаршил ихтэй бүсүүдэд байх тул явган хүний зам мөн адил өртөнө.

152. Хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай зэрэг нийгмийн эмзэг бүлгийнхэнд үзүүлэх нөлөөг багасгах арга хэмжээг Бүрэлдэхүүн 2.1.-т заасанчлан авч болно. Улмаар явган зорчигчид барилга байгууламжаар аюулгүй орж гарахад чиглэсэн арга хэмжээг гүйцэтгэгчтэй хамтран хэрэгжүүлэх шаардлагатай.

Бууруулах арга хэмжээ

153. Газаргүй болсон болон газар дээрх хөрөнгө нь үгүй болсонд олгох нөхөн олговороос гадна газар болон бизнесийн боломжуудаа алдсанаас үүдэлтэй орлогогүй болох амьжиргааны эрсдлүүд байгаа тул амьжиргааг төсөл хэрэгжихээс өмнө үеийн ижил түвшинд хадгалах, бизнест үзүүлэх нөлөөллийн хамгийн бага байлгахад дэмжлэг үзүүлэх нь зүйтэй. Энэ тохиолдолд авах холбогдох арга хэмжээнүүдийг Нүүлгэн Шилжүүлэх бодлогын хүрээ хавсралт 1-т заасан болно.

Онцгойлон нөлөөлж болох цэгүүд

154. Барилгын явцад оршин суугч болон аж ахуйн нэгжүүдэд, түүний дотор жижиг бизнесүүдэд тайгүй, хүндрэл учрах ч түр зуурын шинжтэй байна. Явган зорчигч, дугуй унагч, мотоциклын жолоочдод зориулалтын дэд бүтэц түр байхгүй болсноор бэртэл, гэмтэл авах нөхцөл үүснэ. Замын аюулгүй байдлын хяналт шалгалт, замын системчилсэн үнэлгээ, оддын үнэлгээ нь осол үүсгэх магдалтай дэд бүтцийн доголдлыг илрүүлэх арга механизм бий болгох чадвартай. Уламжлалт зам төлөвлөлтийн хэв маяг болон стандарт ихэвчлэн дамжин өнгөрөөх багтаамжийг хангахад болон моторт тээврийн хэрэгслийн аяллын хугацаанд анхаарлаа нэн тэргүүнд хандуулж, харин эмзэг тодорхой бүлгийн онцлог хэрэгцээг хоёрдугаарт тавьсаар ирсэн.

155. Барилгын ажил нь ойр орчмын өрх болон компаниудын өдөр тутмын амьжиргаа ахуй болон бизнесийн үйл ажиллагаанд саад учруулж болзошгүй. Барилгын ажлын дуу чимээ оршин суугчдад дунд зэргийн нөлөө үзүүлж болох бөгөөд байшингуудын нэгдүгээр эгнээ барилгын талбайтай зэрэгцэж байна. Барилгын талбайтай ойролцоо ӨЭМТ, сургууль, цэцэрлэг, орон нутгийн удирдлагын нэгжүүд байна.

156. I төрлийн үйл ажиллагаа явагдах газарт болон ойр орчимд биет соёлын нөөц байхгүй. Соёлын өвд үзүүлэх нөлөөг тодорхойлох хэрэгтэй бөгөөд соёлын өвд үзүүлэх нөлөөллөөс зайлсхийх шаардлагатай.

157. Түүнчлэн барилгын краны үйл ажиллагаа цахилгаан утас, телефон шугам, ус зайлуулах хоолой зэрэг дэд бүтцэд нөлөөлөх магадлалтай. Газрын талбайг сайтар шалгах, орон нутгийн удирдлага болон холбогдох агентлагуудтай зөвшилцсөнөөр уг нөлөө үүсэхээс зайлсхийх, багасгах боломжтой.

Бууруулах арга хэмжээ

158. Холбогдох эрсдэл, нөлөөллийг бууруулах үүднээс сургууль, цэцэрлэг, өрхийн эмнэлэг зэрэг онцгойлсон газруудын ойролцоо хийгдэж буй ажлын тэмдэг тэмдэглэгээ, аюулгүй байдлын хаалт, замын хөдөлгөөнийг тайвшруулах зэрэг олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандарт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Арга хэмжээний талаархи дэлгэрэнгүй мэдээллийг ХХЗЖ,

158. ХХЗЖ болон ТОХТ буюу Хавсралт, 2, 3-аас лавлаж болно. Соёлын олдвортой холбогдох “Боломжуудыг эрэлхийлэх” журамд холбогдох арга хэмжээнүүдийг тусгаж болно.

- Биет соёлын нөөц илэрсэн тохиолдолд барилгын явцыг нэн даруй зогсоох
- Биет соёлын нөөцийг устгах, эвдлэх, муутгах, нуух зэрэг нь Монгол Улсын хууль журмын дагуу хатуу хориотой.
- Соёлын өв хариуцсан орон нутгийн байгууллагад нэн даруй мэдэгдэж, зөвлөгөө авна.
- Барилгын ажлыг зөвхөн Соёлын өв хариуцсан орон нутгийн байгууллагаас судалгаа явуулж, зөвшөөрсний дараа сэргээнэ.

Жендэрт суурилсан хүчирхийллийн эрсдлүүд

159. ЖСХ-ийн эрсдлийн үнэлгээг тодорхой хэрэгслийн дагуу хийхэд төслийн эрсдэлийг бага гэж дүгнэв. Төслийн амьдралын мөчлөгийн туршид төслийн холбогдох байгаль орчны болон нийгмийн эрсдлийг үнэлэх, ялангуяа Бэлгийн мөлжлөг, бурангуй үйлдэл/Бэлгийн дарамт үнэлгээ хийх зорилгоор төслийн БОННУ-г хийлгэнэ.

160. Орон нутгийн иргэд, эмэгтэйчүүд, хүүхдүүд зэрэг эмзэг бүлгийнхэн нь хөдөлмөрлөх хүчний хөдөлгөөнөөс үүдэлтэй жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ), хүүхдийн эсрэг хүчирхийлэл (ХЭХ), бэлгийн мөлжлөг, бурангуй үйлдэл (БМБҮ)-д өртөх магадлалтай. Зам барилгын талбай болон ажилчдын хуаранд соёлын зан үйлийн харилцан ялгаатай байдлаас орон нутгийн иргэд болон түр ажилчдын хоорондох зөрчилдөөн үүсэж болзошгүй юм.

Түүнчлэн эрэгтэй түр ажилчин болон тухайн нутгийн ажилчдаас үүдэлтэй ЖСХ, бэлгийн дарамт гарч болзошгүй.

161. Хот суурин газрын нөхцөл байдал, орон нутгийн ажиллах хүчин чадал, зам барилгын ажлын богино хугацааг харгалзан үзвэл хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөр, БМБҮ, ХЭХ, ЖСХ-ийн болзошгүй эрсдэл бага төлөвтэй байна. Зам барилга гүйцэтгэлийн үеэр гэвч эмэгтэйчүүд рүү чиглэсэн ажиллах хүчнээс буруутай зан авир гарч болзошгүй хэвээр байна. Эдгээр эрсдлийг тодорхойлох, үнэлэх зорилгоор нийгмийн үнэлгээний хүрээнд судалгаа хийж, бууруулах арга хэмжээг боловсруулж болно.

Бууруулах арга хэмжээ

162. Холбогдох нөлөөллийг бууруулах арга хэмжээг Хавсралт, 2, 3-т буюу ХХЗЖ, ТОХТ-нөөс гадна Хавсралт 8-т заасны дагуу ёс зүйн дүрэм, ажилчдын дүрэм гэх мэт баримт бичгээс үзэж болно. Түүнчлэн, БОНМТ-ийн хүрээнд БМБҮ, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг тодорхойлох, шаардлагатай тохиолдолд тэдгээрээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах зэргээр эрсдлийг шийдвэрлэх тодорхой арга замыг тусгана. БОНМТ-г тендерийн багцад тусган дэд төслийн гэрээний нэг хэсгээр бүрдүүлэх бөгөөд гэрээ гүйцэтгэгч нь БОНМТ -ийн ерөнхий төслийг ашиглан дэд төслийн БОНМТ-г боловсруулна. Төслийн түвшинд БМБҮ, бэлгийн дарамтын эрсдлийг шийдвэрлэх арга хэмжээг өргөн хүрээнд ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад чиглэсэн бусад хүчин чармайлтыг харгалзан авч үзэн, БМБҮ, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрүүл мэндийн салбарт хийгдэж буй үйл ажиллагаа, ЖСХ-тэй холбогдох нэг цэгийн үйлчилгээний төв, лавлах утас, зөвлөгөө тусламжийн үйлчилгээ, хууль сахиулах/ аюулгүй байдал, сэтгэлзүй, нийгмийн дэмжлэг, эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх хөтөлбөртэй уялдуулах ёстой.

163. ТОХТ-ний дагуу холбогдох талуудын оролцоог төслийн амьдралын мөчлөгийн түршид хангах явдал төслийн эрсдэлийг удирдахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Дэлгэрэнгүй мэдээлэл, ерөнхий удирдамжийг Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй төслүүдэд БМБҮ, бэлгийн дарамтын гомдол барагдуулах механизм (ГБМ), эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллийн талаархи мэдээлэл, зөвлөмж, ялангуяа аюулгүй, ёс зүйтэй зөвлөгөө өгөх тухай ёс зүйн хэсэгт дурдсан болно. Бүх зөвлөгөө өгөх уулзалтыг Хөрөнгө оруулалтын төслийн оролцогч талуудтай зөвлөлдөх удирдамж зааврын дагуу хийх ёстой.

164. Орон нутгийн иргэдэд учирч болзошгүй эрсдэл ба нөлөөлөл, мөн бусад чухал мэдээлэл болох Байгаль орчин, нийгмийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа (БОНЭМАА), БМБҮ, бэлгийн дарамт, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний үр дагавар, Ёс зүйн стандарт, орон нутгийн ЖСХ-ийн эсрэг үйлчилгээ үзүүлэгчид, талуудын оролцооны үйл явц, ГБМ-ын сувгуудын тухай төслийн холбогдох бүх оролцогч талууд хамгийн багадаа ойлголт, мэдээлэлтэй байна. Түүнчлэн, жендэрийн мэдрэмж, ЖСХ-тэй холбогдох асуудлаар чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ.

ХМЖ, ТОХТ, Нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээ, Хавсралт 2 болон 3, ХМЖ-д заасан ажилтны бие авч явах дүрэм зэрэгт холбогдох арга хэмжээнүүдийг заасан болно.

Хэрэглээний тасалдал

166. Бүрэлдэхүүн 1.1-т заасан барилгын ажлын явцад түр хугацаанд цахилгаан, харилцаа холбоо, шилэн кабель болон бусад үйлчилгээний түр эсвэл ослын тасалдал, доголдол гарч болзошгүй. Бүртгүүлж мэдүүлээгүй газар доорх эдгээр дэд бүтэц барилгын талбайд гарч ирж болзошгүй.

Бууруулах арга хэмжээ

167. Талуудын оролцоог хангах төлөвлөгөөнд (ТОХТ) заасан өрх айлуудад мэдэгдэх, тасалдлын хугацааг богиносгох зэрэг арга хэмжээнүүдийг авна. Урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг тодорхойлж, саад үүсэх эрсдлийг бууруулах зорилгоор бүртгүүлж мэдүүлээгүй газар доорхи дэд бүтцийг зохицуулахад хэрэгжүүлнэ.

Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал

168. Төсөл хэрэгжих орон нутгийн иргэд, түүний дотор ажилчид, замын хөдөлгөөнд оролцогчдод үзүүлэх сөрөг нөлөөлөл нь замын хөдөлгөөний болон замын аюулгүй байдлын эрсдэл, өвчин, хор аюултай материалд өртөх эрсдэлтэй холбоотой байх болно. Төслийн хүрээнд хийгдэж буй талбайн гүйцэтгэл, угсралтын ажил (үүнд сонгогдсон коридоруудыг засах, шинэчлэх, сэргээн засварлах ажил орно) нь тухайн талбайг тойрсон оршин суугчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж болзошгүй юм. Төслийн явцад машины ашиглалт, тээвэрлэлт, газрын суулт, байгууламжийн нуралт, таглаагүй нүхнүүдийн улмаас тоосжилт, дуу чимээ, аюултай хог хаягдал, үнэр, гадаргын усны бохирдол, замын хөдөлгөөний нягтрал нэмэгдэх боломжтой. Талбайн үйлдвэрлэлийн хог хаягдлыг зохих ёсоор ачиж хаяхгүй бол барилгын талбайн орон зайг эзэлж, ландшафтад нөлөөлж, явган зорчигч / замын хөдөлгөөнд аюулгүй байдлын эрсдэл учруулж болзошгүй юм.

169. Хүлээгдэж буй ажлын цар хүрээ, хот суурин газрын нөхцөлд гарч болзошгүй жендэрт суурилсан хүчирхийллийн эрсдэл бага байна. Төсөл хэрэгжих орон нутаг нь аюулгүй байдал, холбогдох эрсдэл багатайд тооцогддог. Хашаа барих, тэмдэглэгээ суурилуулах, гэрэлтүүлэг хийх, аюулгүй байдлын талаархи анхан шатны мэдлэг олгох сургалт, харуул хамгаалалт зэрэг нь төслийн байршил дахь аюулгүй байдлын эрсдлийг удирдахад шаардагдах бүх зүйлийг хангах шаардлагатай.

170. Шаардлагатай эрсдэлийн үнэлгээ, эрсдэл бууруулах зохих арга хэмжээг төслийн бүх арга хэмжээ, БОНСХ-ний боловсруулалт, хэрэгжүүлэлтэд тусгана. Үүнд: (i) тээврийн хэрэгслийн аюулгүй хурд, явган хүний хөдөлгөөнийг хангасан гудамж төлөвлөлт; (ii) тээврийн хэрэгслийн хурдыг бууруулах, аюулгүй нэвтрэхэд чиглэсэн хөдөлгөөнийг сааруулах арга хэмжээ; (iii) явган хүний болон дугуйчинд аюулгүй байдлыг хангасан нийтийн зам талбай олгох; (v) коридор зам, буудал зогсоол, түр зогсоол руу аюулгүй нэвтрэх боломж олгох. Энэ ажлыг төсөл хэрэгжүүлэх явцад гол оролцогч талуудтай нягт зөвлөлдсөний үндсэн дээр хийх болно. Тээврийн цагдаа нь замын хөдөлгөөний аюулгүй байдал, аюулгүй байдлын аливаа арга хэмжээнд оролцох үүрэгтэй тул төслийн үр дүнг сайжруулах чухал оролцогч байх болно.

Бууруулах арга хэмжээ

171. Холбогдох арга хэмжээг ХХЗЖ, ТОХТ, БОНМТ-с гадна Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө, түр арга хэмжээний удирдамжийг хавсралт 7-д тусгасан болно. Уг удирдамжийн дагуу орон нутгийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс тухайн газарт зориулсан Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө, хөдөлгөөний аюулгүй байдлын түр арга хэмжээ нь зам барилгын талбай, ялангуяа явган зорчигч, дугуйчин, материал хангамжийн ажилчид, барилгын ажилчид, тээврийн хэрэгслийн жолооч нарыг хамгаалахад чиглэнэ. Төслийн амьдралын мөчлөгийн туршид замын хөдөлгөөний аюулгүй байдлын үнэлгээг хийж, НЗДТГ-ын орон нутгийн шаардлага болон ДБ-ны БОНСХ-ний дагуу ХЭМАА-ын удирдамж, Замын аюулгүй байдлын талаархи дараах сайн туршлагын зөвлөмж чиглэлд үндэслэн зохих аюулгүй байдлын арга хэмжээг боловсруулна. Үүнд (i) Зам барилгын талбай дахь аюулгүй ажлын байр, (ii) Зам барилгын талбай дахь аюулгүй тээврийн хэрэгсэл, (iii) Аюулгүй жолооч, жолоочтой холбоотой дадал, (iv) Замын хөдөлгөөний аюулгүй байдал, (v) Онцгой байдлын үед бэлэн байдал, хариу арга хэмжээ авах тухай тус бүр багтана.


6. Дэд төслийн байгаль орчин болон нийгмийн удирдлага, зохицуулалтын журам

172. **Гол зорилт, баримтлах чиг хандлага.** Төслийн болон дэд төслийн үйл ажиллагааг төслийг хэрэгжүүлэх явцад тодорхойлох тул Байгаль орчин, нийгмийн менежментийн стандартын хүрээг (БОНМХ) боловсруулж, бүх дэд төслүүд, түүний дотор дэд бүтцийн хөрөнгө оруулалт болон техникийн туслалцаа хамааруулж мөрдүүлнэ. Төслийн дэд төсөл болон үйл ажиллагааны улмаас орон нутгийн байгаль орчин болон оршин суугчдад сөрөг нөлөө үүсгэхгүй байх, төслийн дараах болзошгүй эсвэл зайлшгүй нөлөөг ДБ-ны Байгаль орчин болон нийгмийн бодлого, үндэсний хууль, дүрэм журмын дагуу зохих ёсоор бууруулахад БОНМХ баримт бичгийн гол зорилт оршино.

173. **Үндсэн үе шатууд.** БОН-ын удирдлагын үйл явц нь дараах 4 алхамтай. Энэ хэсэгт диаграмм 6.1-д нэгтгэн харуулсан гол алхмуудыг товч тайлбарлав.

- Алхам 1: БОН-ийн болзошгүй эрсдэл, эрсдлийн ангилал төрлийн тандан шинжилгээ, БОН-ийн баримт бичиг, зохицуулах арга хэрэгслийн бэлдэх, хэрэгжүүлэх шаардлагыг тодорхойлох.
- Алхам 2: БОН-ийн эрсдлийн тандалт, үнэлгээний үр дүнд үндэслэн БОН-тэй холбогдох баримт бичгийг бэлтгэх,
- Алхам 3: БОН-ийн холбогдох баримт бичгийг батлуулах, мэдээллийг ил тод болгох;
- Алхам 4: Хэрэгжүүлэлт, хяналт шинжилгээ, тайлагналт.

Зураг 5. Төслийн үйл ажиллагаанд баримтлах Байгаль орчин, нийгмийн менежментийн журам



6.1. БОН-ийн тандалт/шинжилгээ

174. Энэхүү алхам (1-р алхам) нь төслийн хүрээнд санхүүжүүлэх дэд төсөл ба/эсхүл үйл ажиллагаанд хамрагдах эрхийг баталгаажуулах, мөн шаардлагатай БОН-ийн асуудлыг тодорхойлох, БОНС 1, БОНС 2, БОНС 3, БОНС 4, БОНС 5, БОНС 6, БОНС 8 болон БОНС10-аар шаардсаны дагуу БОН-ийн баримт бичгийг бэлтгэх хэрэгцээ зэрэг дэд төсөл/үйл ажиллагааны болзошгүй нөлөөллийг үнэлэхэд чиглэгдэнэ. Дэд төсөл/үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагууд нь тандалт буюу дүн шинжилгээний хуудсыг бөглөж, гарын үсэг зурах үүрэгтэй (Хавсралт 4). Нийслэлийн удирдлага болон хэрэгжүүлэгч байгууллагууд нь байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан хөндлөнгийн мэргэжилтнүүдийн дэмжлэгтэйгээр тандалт буюу дүн шинжилгээний маягтуудыг бөглөсөн байдалд хийх чанарын хяналтыг хариуцна. БОН-ийн дүн шинжилгээний үр дүнг Дэлхийн банкинд бүртгүүлж, хянуулахаар хадгална.

175. БОН-ийн дүн шинжилгээний маягыг бөглөсний дараа (Хавсралт 4) санал болгож буй үйл ажиллагаа тус бүрийн (биет хөрөнгө оруулалт болон ТТ-ны хүрээнд хийгдэх үйл

ажиллагааг оруулсан) БОН-тэй холбоотой асуудалд дор дурдсан зүйлсийг хамруулан дүн шинжилгээ хийнэ. Үүнд:

- 1) БОН-ийн өндөр эрсдэлтэй гэж тооцсон бүх үйл ажиллагааг хасах зорилгоор 4.2 дох хэсэгт тусгасан БОН-ийн хасагдах үйл ажиллагааны жагсаалтад хамаарах БОН-ийн шаардлага.
- 2) БОН-ийн эрсдэлийн ангилал болон мөн чанар, цар хүрээ болон болзошгүй эрсдэл болон нөлөөлөлд тэнцэхүйц, Дэлхийн Банкны БОНХ болон дотоодын холбогдох хууль тогтоомжийн шаардлагад нийцсэн БОН-ийн арга хэрэгслийг олж тодорхойлох.

176. Төслийн хүрээнд хэрэгжүүлэх төрөл бүрийн үйл ажиллагаанд хамааралтай БОН-ийн эрсдэлийн ангилал болон БОН-ийн арга хэрэгслийг доорх хүснэгтэд тоймлон харуулсан болно. Үүнд:

Үйл ажиллагааны төрөл	Эрсдэлийн ангилал	Тайлбар	БОН-ийн арга хэрэгсэл ба шалган нягтлах шаардлага
I төрлийн гудамж, замын коридорын ажил (замын засвар үйлчилгээ, авто замыг сэргээн засварлах) ба түүнтэй холбоотой биет хөрөнгө оруулалт	Дунд зэргийн	Бага хэмжээний барилгын ажил, тухайлсан ажлын талбайд үзүүлэх нөлөөлөл, барилгын ажлын чирэгдэл	Хэрэгжүүлэгч байгууллага болон түүнтэй байгуулсан гэрээнд заасан үүргийнхээ хүрээнд гэрээт ажил гүйцэтгэгч Гэрээлэгчдийн хэрэгжүүлэх БОННУ, Байгаль орчин, нийгмийн менежментийн ерөнхий төлөвлөгөө (БОНМТ, Хавсралт 5), Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө (ЗХХЗЖ, Хавсралт 7), Сахилгын дүрэм (Хавсралт 8).
II төрлийн гудамж, замын ажил (авто зам шинэчлэх) ба түүнтэй холбоотой биет хөрөнгө оруулалт	Бодитой буюу их	БОН-ийн бодитой буюу их хэмжээний эрсдэл/нөлөөлөл үзүүлэх хэдий ч, эрсдэл, нөлөөллийг буруулахад чиглэсэн үр дүнтэй арга хэмжээ авах боломжтой.	Холбогдох хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс тодорхой ажлын талбайд зориулсан БОННУ болон БОНМТ, Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөө (НШҮАТ), Хөдөлмөрийн харилцааг зохицуулах журам (ХХЗЖ), тодорхой ажлын талбайд зориулсан Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө (ЗХМТ) зэрэг хамаарал бүхий БОН-ийн баримт бичгийг дэд төсөл хэрэгжиж эхлэхээс өмнө дүн

Үйл ажиллагааны төрөл	Эрсдэлийн ангилал	Тайлбар	БОН-ийн арга хэрэгсэл ба шалган нягтлах шаардлага
	Дунд зэргийн	БОН-ийн дүн шинжилгээний үр дүнгээр, хүн ам болон эсхүл байгаль орчинд учруулж болзошгүй эрсдэл/нөлөөлөл их биш.	<p>шинжилгээний үр дүнд үндэслэн бэлтгэж, хянуулж, зөвшөөрүүлсэн байна.</p> <p>Холбогдох хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс тодорхой ажлын талбайд зориулсан БОНМТ, Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөө (НШҮАТ), Хөдөлмөрийн харилцааг зохицуулах журам (ХХЗЖ), тодорхой ажлын талбайд зориулсан Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө (ЗХМТ) зэрэг хамаарал бүхий БОН-ийн баримт бичгийг дэд төсөл хэрэгжиж эхлэхээс өмнө дүн шинжилгээний үр дүнд үндэслэн бэлтгэж, хянуулж, зөвшөөрүүлсэн байна.</p>
1 дэх төрлийн ТТ: Ирээдүйн хөрөнгө оруулалтын төслүүдийн бэлтгэл ажлыг хангахад дэмжлэг үзүүлэх	Дунд зэргийн – Бодитой буюу их	Эрсдлийн ангилал нь дэмжлэг авах хөрөнгө оруулалтын төслүүдтэй холбоотой эрсдлийг харгалзан үзэх ёстой. ТТ-ны үр дүнгүүд шууд бус хөрөнгө оруулалтын нарийвчилсан төлөвлөгөөтэй шууд холбогддог.	Тодорхой ажлын талбайд зориулсан БОННУ болон БОНМТ, Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөө (НШҮАТ), Хөдөлмөрийн харилцааг зохицуулах журам (ХХЗЖ), тодорхой ажлын талбайд зориулсан Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө (ЗХМТ) зэрэг хамаарал бүхий БОН-ийн баримт бичгийг дүн шинжилгээний үр дүнд үндэслэн ТТ-ны нэг хэсэг байхаар тооцож бэлтгэнэ.
1 дэх төрлийн ТТ: Ирээдүйн хөрөнгө оруулалтын төслүүдийн ТЭЗҮ эсхүл	Дунд зэргийн – Бодитой буюу их	Эрсдлийн ангилал нь дэмжлэг авах хөрөнгө оруулалтын төслүүдтэй холбоотой	Анхааралдаа авбал зохих БОН-ийн асуудлыг ТТ-ны төслийн хүлээлгэн өгөх ажлын нэг хэсэг болгон нэгтгэх нөхцлийг

Үйл ажиллагааны төрөл	Эрсдэлийн ангилал	Тайлбар	БОН-ийн арга хэрэгсэл ба шалган нягтлах шаардлага
үүнтэй адилтгах судалгааны ажил		эрсдлийг харгалзан үзэх ёстой. ТТ-ийн үр дүнгүүд шууд бус хөрөнгө оруулалтын анхны бэлтгэл ажлыг хангахад дэмжлэг үзүүлдэг.	бүрдүүлэхийн тулд холбогдох Ажлын даалгаврыг БОН-ийн мэргэжилтэнд илгээж хянуулах ёстой.
2 дох төрлийн ТТ: Бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, стратеги эсхүл хууль эрх зүйн хүрээг боловсруулахад дэмжлэг үзүүлэх гэх мэт.	Дунд зэргийн – Бодитой буюу их	Гол төлөв, БОН-ийн шууд бус эрсдэл/нөлөөлөл, жишээлбэл, хотын төвшний стратеги/тээврийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилттэй холбоотой эрсдэл буюу нөлөөлөл	Санал болгож буй нөлөөллийг бууруулах арга хэмжээнд БОН-ийн болзошгүй шууд бус эрсдэл ба нөлөөллийг бүрэн хэмжээгээр авч үзсэн эсэхийг баталгаажуулах зорилгоор тухайлсан ТТ-ны төслийг хэрэгжүүлэхээс өмнө холбогдох ТТ-ны үйл ажиллагааг БОН-ийн мэргэжилтэнд хүргүүлж, хянуулна. 2 дох төрлийн ТТ-ны үйл ажиллагааны хүрээнд хийсэн хүлээлгэн өгвөл зохих ажил нь БОН-ийн нэгтгэсэн нөлөөлөл, зохих ёсоор санал болгосон нөлөөллийг бууруулах арга хэмжээг багтаана.
3 дахь төрлийн ТТ: Зээлдэгчийн чадавхийг бэхжүүлэх	Бага	Үгүй/ялимгүй эрсдэл/нөлөөлөл.	БОН-ийн нэмэлт арга хэрэгсэл шаардлагагүй.

6.2. Байгаль орчин ба нийгмийн баримт бичгүүдийн боловсруулалт

177. Энэхүү 2-р алхам нь 1-р алхамд дурдсан асуудлуудтай уялдуулан урьдчилан сэргийлэх, хамгаалалтын баримт бичгийг бэлтгэхэд чиглэсэн болно. БОНМТ-г бэлтгэх ажлын удирдамжийг хавсралт 6-д тусгасан бол Байгаль орчны практик журам (БОПЖ), Сахилгын дүрэмд бэлгийн мөлжлөг, бурангуй үйлдэл болон зам барилгын талбайн ажилтай холбогдох болон Ковид-19-н цар тахлаас урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах үйл ажиллагаатай холбоотой арга хэмжээг тусгана. НШҮАТ—г боловсруулах удирдамжийг НШБХ баримт бичигт буюу Хавсралт 1-д тусгасан болно. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагууд нь өмнөх 6.1 дэх хэсэгт заасан холбогдох баримт бичгийг бэлтгэх ажлыг хариуцах бол нийслэлийн ТУА-аас хөндлөнгийн БОН-ийн мэргэжилтнүүдийн дэмжлэгтэйгээр бэлтгэсэн БОН-н баримт бичгийг хянах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй. Шаардлагатай тохиолдолд илүү нарийн оролцоотой дэд төслүүдийн асуудлаар ДБ-ны хамгаалалтын мэргэжилтэнтэй зөвлөлдөж болно.

178. Дэд төслийг хэрэгжүүлэгч байгууллагууд холбогдох БОН-н баримт бичгийг МУ-д даган мөрдөж буй БОН-ийн Нөлөөний Үнэлгээний шаардлагын дагуу бэлдэж, боловсруулан холбогдох агентлагуудаар баталгаажуулах ажлыг хариуцна.

179. БОН-ийн үйл ажиллагаануудын гол онцлогуудаас дурдвал дараах байдалтай байна:

- Санал болгож буй дэд төсөл, үйл ажиллагаануудад нь өндөр эрсдэлтэй, ихээхэн эрсдэлтэй үйл ажиллагаанууд багтаж болохгүй бөгөөд уг төрлийн үйл ажиллагааг Төслөөс хасагдах жагсаалт болон БОН-ийн тандалт, үнэлгээний хяналтын хуудсын дагуу хасах ёстой.
- Тендерийн баримт бичиг болон зөвлөхүүдийн гэрээнд БОНМТ, БОПЖ зэргийг дунд хэмжээтэйгээр тусгах бөгөөд гүйцэтгэгч байгууллагын гүйцэтгэлийг хэрэгжүүлэгч агентлагаас хариуцахаар томилогдсон албан тушаалтан нягт хянах болно.
- Тендерийн баримт бичиг болон зөвлөхүүдийн гэрээнд БОНМТ болон бүх бүрэлдэхүүн хэсэгт багтсан, барилгын талбайн онцлогоос үүдэлтэй БОН-ийн нөлөөг тусгах бөгөөд гүйцэтгэгч байгууллагын гүйцэтгэлийг хэрэгжүүлэгч агентлагаас хариуцахаар томилогдсон албан тушаалтан нягт хянах болно.
- Газар чөлөөлөлт, газар ашиглахыг хязгаарлах, албадан нүүлгэн шилжүүлэх зэрэг асуудал үүсэх тохиолдолд дэд төслийн Нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг НШБХ баримт бичгийн дагуу боловсруулж, энэ талаарх удирдамжийг тусад нь гаргана.

180. Эхний гурван дэд төслийн болон "Их" эрсдэлтэй ангилал тус бүрт багтсан " дэд төслүүдийг (Төрөл I коридор, Төрөл II коридор, ТТ-ны 1-р хэлбэр: ирээдүйн хөрөнгө оруулалтын төслүүдийн нарийвчилсан зураг төслийг дэмжих) бүх БОН баримт бичгийг (БОННУ, БОНМТ, ба НШҮАТ, г.м.) ДБ-нд илгээн баталгаажуулж, хэрэгжүүлэхээс өмнө хянуулт зөвшөөрөл авна. ТУА-аас БОН-ийн асуудлыг бие даан удирдах чадвараа харуулах хүртэл Дэлхийн банк урьдчилсан хяналт, дэд төслүүдийг цэвэрлэх эрхийг хэвээр хадгална.

6.3. Хяналт, баталгаажуулалт

181. Засгийн газрын батламж: Засгийн газраас тогтоосон дүрэм журмын дагуу шаардагдах ХБОННҮ-ний холбогдох бүх баримт бичгийг хариуцсан агентлагуудаар батлуулахыг ДБ-с шаарддаг. Монгол хэл дээрх ХБОННҮ болон батлах нөхцлийн талаарх мэдээллийг ДБ-д хүргэнэ. ХБОННҮ-ний тайлан болон түүнийг батлах нөхцөлийг олон нийтэд ил тод мэдээлэх болно.

182. Бүх ХБОН-ийн баримт бичгүүдийг төслийн албан ёсны вэбсайт дээр байрлуулах бөгөөд монгол хэл дээрх хэвлэмэл хувилбарыг Төслийг хэрэгжүүлэгч нэгж болон дэд төслийн газруудаас авах боломжтойгоор байлгана. Санамж болон ил тод болсон мэдээллийн талаарх мэдэгдлийг тухайн мэдээллийг ил тод болгосон өдрөөс хойш нэг сарын дотор дэлгэнэ. ХБОННҮ, ХБОНМТ-ийн англи хэл дээрх хувилбарыг ДБ-ны вэбсайтууд дээр зарлах болно.

183. ДБ-ны хяналт, зөвшөөрөл: Дэд төслийн ХБОН-н баримт бичгийг баталж, эхлүүлэхээс өмнө тэдгээрийг хянуулж, зөвшөөрүүлж, олон нийтэд ил болгох зорилгоор ДБ руу илгээнэ. Төслийн хувьд ДБ нь төслийн нэгж тус бүрт ХБОННҮ, ХБОНМТ-ийг урьдчилж хянах бөгөөд шаардлагатай бол засвар өөрчлөлт оруулж болно. Зөвшөөрөх үйл явцыг тогтмол хийх бөгөөд хэрэгжүүлэгч агентлагуудын ХБОН-ийн чадавхийг зохих зөвлөхүүдийн дэмжлэгтэйгээр бэхжүүлсний дараа ДБ нь зарим ХБОННҮ, ХБОНМТ-үүдэд санамсаргүй сонгох зарчмын дагуу хяналт шалгалт явуулж болно.

184. БОН-ийн хяналтын үр дүнд БОН-ны өндөр эрсдэлтэй гэж тодорхойлсон бүх дэд төслүүдэд Дэлхийн Банк урьдчилсан хяналт явуулах бөгөөд БОН-ийн хяналт хийх явцад БОН-ийн ноцтой асуудал илэрсэн тохиолдолд Банкны зүгээс БОН-ийн асуудлыг шийдэж буй арга механизмыг давхар шалгах эрхтэй. Бусад дунд болон бага эрсдэлтэй үйл ажиллагааны хувьд бэлтгэл болон хэрэгжүүлэлтийн явцад оролцогч талуудын хангалттай оролцоог хангах механизм нь БОНХТ-ийн нэг хэсэг байж болно.

6.4. Хэрэгжүүлэлт ба хяналт

185. БОНМХ-ний хэрэгжилт, хяналт, тайлагнал нь Төсөл болон дэд төслийн хэрэгжилтийн салшгүй нэг хэсэг байх бөгөөд үйл ажиллагаа бүрт хариуцсан БОН-ийн ажилтныг томилно. ДБ-ны БОН-ийн мэргэжилтнүүд ДБ-ны хэрэгжилтийг дэмжих ажлын хэсгийн хүрээнд БОН-ийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих болно. Хэрэгжүүлэгч байгууллагуудын хариуцах чиг үүргүүдийг дор тайлбарласан болно.

- НШҮАТ-ын хяналт: БОНС5 даган мөрдүүлэхийн тулд ТУА нь НШҮАТ-ийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг нь ДБ-д тайлагнах бие даасан зөвлөх ажиллуулна.
- Барилга угсралтын явцад гүйцэтгэгчийн гүйцэтгэлд БОН-н хяналт шалгалт хийх: Дэд төслүүдийн шатанд МУ-ын хууль тогтоомж болон БОНС1, 2, 3, 4, 6, 8, 10 –т заасан зарим тодорхой шаардлагыг дагаж мөрдүүлэхийн тулд Төсөл удирдах нэгж нь үндэсний мэргэшсэн зөвлөхүүдийг ажиллуулна. Тэдгээр зөвлөхүүд нь төслийн гүйцэтгэгчид өдөр тутам хяналт тавих барилгын хянагч зөвлөх болон талбайн инженерүүдийг томилох бөгөөд сар тутам хяналт, тайлан гаргах үүрэгтэй.

- Төслийн түвшинд ТУА нь Байгаль орчны, нийгэм, эрүүл ахуй, аюулгүй байдлын зөвлөх ажиллуулж, тэрхүү зөвлөх нь барилгын ажлын явцад гүйцэтгэгчийн гүйцэтгэлийг тогтмол хянаж, үр дүнг ДБ-д илгээх Төслийн БОН-ийн хяналтын тайланд 6 сарын эсвэл ДБ-тай тохиролцсоны давтамжийн дагуу тусгана. ТУА нь ТОХТ, ХХЗЖ-ын хэрэгжилтийг хянах, үнэлэх үүрэгтэй бөгөөд үүнд Төслийн болон дэд төслийн нөлөөлөлд өртсөн ард иргэд, мөн төслийн ажилчдын гомдол, гомдолд хариу өгөх зэрэг ажил орно.
- Хэрэгжилтийн үе шат дахь БОН-ийн хамгааллын бодлогын хяналт. Төслийн явцад гарч болзошгүй БОН-н эрсдэл, нөлөөллөөс урьдчилан сэргийлэхийн тулд НЗДТГ-ын Байгаль орчны газраас тодорхой үйл ажиллагаа, дэд төслийн талбайнуудад хяналт тавьж, төслийн үйл ажиллагаа нь байгаль орчныг сайжруулахад хувь нэмэр оруулах эсэхийг үнэлэх шаардлагатай. Нийгмийн хувьд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хянахад анхаарал хандуулах бөгөөд байгаль орчны нэн чухал асуудлууд, түүний дотор ядуу, үндэсний цөөнх, жендер дээр суурилсан хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг дарамттай холбоотой нийгмийн бусад асуудлаарх мэдлэг, туршлага солилцох уулзалт зохион байгуулна. Эдгээр үйл ажиллагаанд орон нутгийн удирдлагын ажилтнууд; хотын захиргаа, дүүргийн байгаль орчны асуудал эрхэлсэн ажилтнууд; НЗДТГ-ын болон Төсөл удирдлагын албаны техникийн ажилтнууд, БОН-н чадавхийг сайжруулах үүрэгтэй зөвлөхүүд; эмэгтэйчүүд болон хүүхдийн эрхийг хамгаалах, жижиг бизнес эрхлэгчдийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зэрэг орон нутгийн ТББ-уудын төлөөлөгчид оролцох ёстой. Төсөл удирдлагын албанд хүргүүлэх БОН-ийн асуудлын хяналтын тайланд БОН-ийн холбогдох мониторингийн үр дүнг нэгтгэх бөгөөд тэдгээрийг ДБ-д илгээнэ

6.5. Эцсийн гүйцэтгэл ба хянах ажиллагаа

186. Дэд төсөл, үйл ажиллагаа дууссаны дараа дэд төсөл, үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан, үр дүнг хянах, холбогдох гүйцэтгэх байгууллага, БОН-ийн мэргэжилтнүүдийг томилох бөгөөд тэдгээр нь тэдгээр материалыг архивжуулж, холбогдох байгууллага, ТУА-нд тайлагнах үүрэгтэй.

6.6. Талуудын оролцоо

187. Төслийн бүх үе шатанд, өөрөөр хэлбэл дэд төслүүд болон тэдгээрийн БОН-ийн менежментийг тодорхойлоход ДБ-ны БОНС10 удирдамжийн тэмдэглэлийн шаардлагыг биелүүлэх ёстой. Энэхүү тайлангийн 7-р бүлэг болон 3-р хавсралтад дэлгэрэнгүй тодорхойлсон бөгөөд талуудтай оролцоог ханган хамтран ажиллах нь төслийн байгаль орчин, нийгмийн үнэлгээ, төслийн зураг төсөл боловсруулах үе шат, мөн хэрэгжүүлэлтийн үед ихээхэн ач холбогдолтой юм.

188. 2021 оны 3-р сарын 20-ны байдлаар Улаанбаатар хотод COVID-19 цар тахалт өвчний дэгдэлт өндөр байгаа бөгөөд уг өвчний тархалтыг хяналтанд авахын тулд Улсын онцгой комисс (УОК)-с доорхи дөрвөн ангиллын түвшинээр цар тахлын эсрэг бэлэн байдал, COVID-19-ийн эсрэг арга хэмжээг тодорхойлж байна.

Улаан - Түвшин 4: Олон нийтийг хамарсан халдвар илэрсэн;

Улбар шар - Түвшин 3: Кластер халдвар илэрсэн;

Шар - Түвшин 2: Дамжсан (эсвэл гаднаас орж ирсэн) халдвар илэрсэн;

Ногоон - Түвшин 1: 28 хоногийн хугацаанд халдварын нэмэлт тохиолдол бүртгэгдээгүй.

Талуудын оролцоог хангахад бүхий л харилцааг Ковид-19-өөс урьдчилан сэргийлэх, хязгаарлах зарчмыг баримтлана.

Хүснэгт 6. Олон нийтийн хэлэлцүүлгийн тэмдэглэлийн маягт

Огноо	Байршил	Оролцогчдын бүтэн нэр	Зөвлөгөөний үеэр оролцогч талуудын ярилцсан, хөндөж тавьсан асуудлууд	Шийдвэрлэх гарц	Хүйс

7. Талуудын оролцоо, өргөдөл гомдлыг барагдуулах

7.1. Мэдээллийн ил тод байдал

189. 3 дугаар сарын 29-ний өдөр НЗДТГ нь БОНМХ-ийн хураангуйг (монгол хэлээр) www.ulaanbaatar.mn цахим хуудас дээр олон нийтэд мэдээлсэн. НЗДТГ нь хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран мэдээллийг цаг тухайд нь мэдээллэх ба эмзэг бүлгүүдийн онцлог хэрэгцээнд зохих ёсоор анхаарч ажиллана.

190. Мэдээлэл, холбогдох материалыг олон нийт саадгүй нэвтрэх боломжтой, иргэд олноор цуглардаг газарт байрлуулах байдлаар мэдээллийн ил тод байдлыг ханган мэдээлэл түгээнэ. НЗДТГ-ын байранд оролцогч талуудыг оролцуулах төлөвлөгөө; байгаль орчин, нийгмийн менежментийн үзэл баримтлал; байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө, Нүүлгэн шилжүүлэх бодлогын үзэл баримтлалын талаар монгол хэл дээр хэвлэсэн материалыг байрлуулах, олон нийтэд үнэ төлбөргүй тараах боломжтой. Зээл батлагдсаны дараа оролцогч талуудын дунд эхний уулзалтыг зохион байгуулахаас гадна хэвлэлийн бага хурал хийнэ. Оршин суугчдад илгээх захидал, сонины зар, барилгын ажлын зарын самбар, сууц өмчлөгчдийн холбоо, цахим хуудсаар дамжуулан төсөл хэрэгжүүлэх явцад бий болсон саад бэрхшээлийн талаар мэдээлэл тараана.

7.2. Оролцогч талуудын хамтын ажиллагаа

191. НЗДТГ/төслийн удирдлагын алба нь төсөл боловсруулах, хэрэгжүүлэх явцад оролцогч талуудын дунд утга учиртай, үр дүнтэй, мэдээлэлтэй оролцоог бий болгоход үйл ажиллагаагаа чиглүүлнэ. Энэхүү үйл явц нь ил тод байдал, хоёр талын харилцаа, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж, төсөл хэрэгжсэнээр сөрөг нөлөөнд өртөж болзошгүй

хүн амын бүлгүүд түүний дотор эмзэг бүлгийн иргэдийг багтаасан шударга, төлөөллийн оролцоог хангахыг зорьж байна.

192. Сонирхол, хэрэгцээ, төсөлд гүйцэтгэх боломжит үүрэг, чадавхи, боломж, хамтран ажиллах хязгаарлалт зэрэг хүчин зүйлийг харгалзан оролцогч талуудыг тодорхойлно. Төслийн оролцогч талуудыг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

Хүснэгт 7 Оролцогч талуудын үүрэг хариуцлага

Оролцогч талууд	Төслийн хэрэгжилтэд гүйцэтгэх үүрэг
Дэлхийн банк	Төслийг санхүүжүүлнэ. Төслийн зорилгыг биелэлтэд хяналт тавина.
Зам тээврийн хөгжлийн яам	Төслийн удирдах зөвлөлөөр дамжуулан төслийг хэрэгжүүлэх ерөнхий чиглэлээр хангах
Байгаль орчин, аялал жуулчлалын яам/ Нийслэлийн байгаль орчны газар	Байгаль орчин, аялал жуулчлалын яам/Нийслэлийн байгаль орчны газар нь байгаль орчны зөвшөөрөл олгох, өөрсдийн шийдвэрт тулгуурлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх
Сангийн яам	Сангийн яамны сайдын 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын биелэлтийг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх. Төслийн удирдах зөвлөлөөр дамжуулан төслийн хэрэгжилтийг үндсэн чиглэлээр хангах.
Барилга, хот байгуулалтын яам	Барилга, хот байгуулалтын яам зөвшөөрөл олгох, өөрсдийн шийдвэрт үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.
НЗДТГ	Гүйцэтгэх болон хэрэгжүүлэгч агентлаг. Төслийн удирдлагын албаны гишүүдийг томилох болон төслийн төлөвлөлт, удирдлага, зохицуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг хариуцана.
НАЗХГ	Төслийг хэрэгжүүлэгч байгууллага Төслийн хэрэгжилтэд оролцох
ЗХУТ	Төслийг хэрэгжүүлэгч агентлаг
Тээврийн цагдаагийн алба	Төслийг хэрэгжүүлэгч агентлаг
НТҮГ	Төслийг хэрэгжүүлэгч агентлаг
Замын хөдөлгөөний төлөвлөлт, менежмент, инженерийн агентлаг	ЗХТМИА нь Бүрэлдэхүүн хэсэг 1: Нэгдсэн коридорууд Дэд бүрэлдэхүүн хэсэг 3.1: стратегийн судалгаа. Хэрэгжүүлэгч түнш байх болно. Энэхүү байгууллага нь НЗДТГ-т шинээр байгуулагдсан агентлаг бөгөөд нэг аж ахуйн нэгжийн хүрээнд түгжрэлийг сааруулах арга хэмжээг нэгтгэх зорилгоор замын сүлжээг илүү үр ашигтай төлөвлөж, замын түгжрэлийг бууруулах зорилгоор холбогдох журам, дүрэм, стандарт, инженерийн оролцоог боловсруулж өгөх үүрэгтэй Улаанбаатарт. Тус газар нь авто зогсоолтой холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд РМО-г дэмждэг
Хот байгуулалт хөгжлийн газар	Дэмжлэг, зөвшөөрөл

Улаанбаатар хотын Хот төлөвлөлт, архитектур, дизайны институт	Дэмжлэг, зөвшөөрөл
Нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын алба	Хамаарал бүхий дүүргийн газар зохион байгуулалтын албадууд газар өмчлөлийн гэрчилгээ, газрын сертификат, газар ашиглах гэрээ, кадастрын зураг гаргах зэрэг зөвшөөрөл олгох. Төслийн удирдлагын албыг Нүүлгэн шилжүүлэх бодлогын үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.
Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар	Бүтээн байгуулалтын явцад тогтмол давтамжтай хяналт тавих
Нийслэлийн болон дүүргийн захиргаа	Дэмжлэг үзүүлэх, мэдээллийн ил тод байдал, оролцогч талуудын оролцоог хангах
Төслийн удирдах хороо	НЗДТГ-аар удирдуулсан, Сангийн яам, ЗТХЯ, дараа тодорхойлогдох бусад байгууллагуудын төлөөллийн бүрэлдэхүүнтэй удирдах хороо нь СЯ-ны сайдын 4 дүгээр тушаалаар батлагдсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын дагуу дагуу төслийн хэрэгжилтэд ерөнхий чиглэлээр хангана.
Төсөл удирдлагын алба	Төслийн хэрэгжилтийг бүхэлд нь хариуцна.
Гэрээлэгч	Төслийн хамтрагч
	Төслийн хэрэгжилтэд оролцох
Зөвлөхүүд	Төслийн хамтрагч
	Төслийн хэрэгжилтэд оролцох
Орон нутгийн судалгааны институт	Төслийн боломжит түнш
	Төслийн хэрэгжилтэд оролцох
Иргэний нийгмийн байгууллагууд	Төслийн боломжит түнш
	Төслийн хэрэгжилтэд оролцох
Төрийн бус байгууллагууд	Төслийн боломжит түнш
	Төслийн хэрэгжилтэд оролцох
Төслийн үр нөлөөнд автах төрийн хэвшлийн байгууллагууд	Төслийн хэрэгжилтэд оролцох; хэрэглэгч талуудтай тогтвортой харилцаа тогтоох
Төслийн үр нөлөөнд автах хувийн хэвшлийн байгууллагууд	Төслийн хэрэгжилтэд оролцох

Төслийн сөрөг нөлөөнд өртөж болзошгүй болзошгүй иргэд	Төслийн хэрэгжилтэд оролцох
Хэрэглэгчид (зорчигч)	Төслийн хэрэгжилтэд оролцох

191. Төслийн удирдлагын алба нь Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны хууль тогтоомжийн дагуу оролцогч талуудын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах үүрэгтэй. Төслийн удирдлагын алба нь оролцогч талуудын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Дэлхийн банкны "Байгаль орчин, нийгмийн хүрээний ESS10" стандартын шаардлагыг дагаж мөрдөнө. Төслийн оролцогч талуудын хамтын ажиллагааны төлөвлөгөөнд "Талуудын оролцоог хангах төлөвлөгөө" -нд оруулсан бөгөөд үүнд оролцогч талуудын зөвлөлдөх уулзалтыг удирдан чиглүүлэх нарийвчилсан журам, тавигдах шаардлагыг тусгасан болно (Хавсралт 3).

192. Талуудын оролцоог хангах төлөвлөгөөний зорилго нь төслийн оролцогч талуудыг тодорхойлох, төсөл хэрэгжих хугацаанд зөвлөлдөх, мэдээлэл түгээх хэлбэр, өргөдөл, гомдлыг барагдуулах арга замыг тодорхойлоход оршино. "Оролцогч тал"-д дараах хүмүүс эсвэл бүлгүүд багтана. Үүнд: (а) төслийн үйл ажиллагааны сөрөг нөлөөнд өртөж болзошгүй, эрх ашиг нь хөндөгдөх магадлалтай (төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй талууд); (б) төслийн үйл ажиллагааг сонирхогч талууд байж болно (бусад сонирхогч талууд).

193. Дэлхийн банкны байгаль орчин, нийгмийн хүрээ нь "Байгаль орчин, нийгмийн стандарт 10", "Оролцогч талуудын оролцоо ба мэдээллийн ил тод байдал" багтдаг бөгөөд эдгээрт "...зээлдэгч ба төслийн оролцогч талуудын дундах нээлттэй, ил тод хамтын ажиллагаанд ач холбогдол өгөх нь олон улсын сайн туршлагын чухал элемент болохыг" хүлээн зөвшөөрсөн байдаг. Зээлдэгчид төслийн мөн чанар, цар хүрээ, түүний болзошгүй эрсдэл, үр нөлөөг харгалзсан пропорциональ буюу тэнцүү байдлаар оролцогч талуудын төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай. Мөн түүнчлэн "Байгаль орчин, нийгмийн стандарт 10" нь өргөдөл, гомдлыг барагдуулах механизмыг боловсруулж хэрэгжүүлэхийг шаарддаг.

194. 2015 онд батлагдсан "Хот байгуулалтын" тухай хуулийн 17, 18 дугаар зүйлд дараах заалт бий. Үүнд:

- Хот төлөвлөлтийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоотой төлөвлөлтийн зарчмыг тусгаж ажиллана.
- Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, хотын захирагчийн ажлын алба нь энэ хуулийн хүрээнд гаргасан аливаа шийдвэрийн талаар тухай бүр олон нийтэд мэдээлнэ.
- Хэрэглээний тасалдлыг оршин суугчид болон аж ахуйн нэгжүүдэд 24 цагийн өмнө мэдээлэх шаардлагатай.

195. 2012 онд батлагдсан "Байгалд орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийн 5, 8 дугаар зүйлд дараахыг тусгасан. Үүнд:

- Хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа хөтөлбөр, төлөвлөгөөнд стратегийн үнэлгээ хийх талаарх мэдээллийг нийтэд мэдээлж, төрийн захиргааны төв байгууллага өөрийн цахим хуудсанд байрлуулах бөгөөд хэвлэмэл хувилбартай танилцах боломжийг бүрдүүлнэ.
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх зөвлөх орон нутгийн удирдлага, орон нутгийн иргэдтэй оршин сууж буй газар нутагт үзүүлэх нөлөөний талаар зөвлөлдөн санал авах бөгөөд олон нийтээс санал ирүүлэх хугацаа нь ажлын 30-аас дээшгүй өдөр байх бөгөөд амаар болон бичгээр санал авна.
- Байгалд орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хурлын тэмдэглэл, орон нутгийн удирдлагын санал, нөлөөнд автах орон нутгийн иргэдтэй зөвшилцсөн байдал зэргийг тусгасан байна.

196. БОНМХ-г боловсруулах явцад талуудтай зөвлөлдөх уулзалтийг 3 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт НЗДТГ, хэрэгжүүлэгч байгууллагууд, болон бусад шийдвэр гаргахад нөлөөлөх түвшиний байгууллагууд, жендерийн шинжээчид, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо болон тусгай хэрэгцээт хүүхдүүдийн эцэг эхийн төлөөлөл оролцсон. Хэлэлцүүлгийн үеийн гол саналуудыг доор тэмдэглэв.

- Нийтийн тээврийн үйлчилгээ нь хүртээмжгүй, аюулгүй байдлыг хангах асуудлууд элбэг, эмэгтэйчүүд шөнийн ээлжинд ажиллахад хүндрэл учирдаг,
- автозам төлөвлөлт менежмент нь нотолгоонд суурилсан, жендерийн мэдрэмжтэй шалгуур үзүүлэлт байхгүй, шалгуур үзүүлэлт нь жендерийн мэдрэмжтэй эсэхийг шалгах шийдвэр гаргах түвшин албан хаагчдад урт хугацааны жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай чадавхи бэхжүүлэх хөтөлбөр байхгүй
- Зам тээврийн салбарын удирдах түвшинд эрэгтэй эмэгтэй болон шийдвэр гаргах түвшинд хүйсийн харилцааг судлах
- Дэд төслийн зураг төсөлд бүх нийтийн (universal) загварын шийдлийг нэвтрүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийтийн тээврийн хүртээмжгүй. Нийт 954 нийтийн тээврийн автобуснаас 54 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх боломжтой байдаг ба үүнээс зөвхөн 8 автобус л ганцхан чиглэлд үйлчилгээ үзүүлдэг.
- Явган зорчигчийн зам нь стандарт бус харааны бэрхшээлтэй болон сонсголын бэрхшээлтэй хүмүүст замд шонгийн мод, усны нүх, болон бусад аюултай учруулах зүйлс байдаг нь аюулд орох нөхцлийг бүрдүүлдэг.
- Тогтсон хаягжилт байхгүй тул зорьсон газартаа очих боломжгүй байдаг.
- Инженерийн шийдлүүд нь энгийн хэрэглээг хангадаггүй ба тусгай хэрэгцээт хүүхдүүдэд шаардлагатай загвараар автозам, явган хүний зам нь зохион бүтээгдээгүй.
- Автобусны зогсоолд нийтийн ариун цэврийн байгууламж шаардлагатай байдаг

- Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн сургуульд явах чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээ байдаггүй
- Тэргэнцэртэй иргэд такси болон нийтийн тээврийн хэрэгсэлд орж чаддаггүй, автобусны зосгоол замын хашлага нь саад болдог ба инженерийн зураг төсөл нь нэвтрэх боломж бүрдүүлдэггүй
- Зам дээр хурсан ус нь тэргэнцэртэй иргэдийг зорчиход саад болдог ба харааны бэрхшээлтэй иргэд зам дээр алхахад хэцүү нөхцөл бүрддэг.
- Зам тээврийн салбарт хөдөлмөрийн хуулинд эрх зүйн тусгагдсан хэдий ч бодитоор хэрэгждэггүй, гүйцэтгэгч байгууллагуудын ажилчдын хөдөлмөрийн эрх нь зөрчигддөг тул хяналт болон засаж сайжруулах шаардлагатай
- Энэхүү салбар нь дийлэнх нь эрэгтэйчүүд байдаг тул эмэгтэйчүүд хувийн хэвшил эрхлэгчдийг дэмжих шаардлагатай тус салбараас эмэгтэйчүүдэд эдийн засгийн хүртээмжийг эрх тэгш боломжийг бүрдүүлэх хэрэгтэй

197. Зөвөлгөөний үеэр зөвлөлдсөн саналууд болон засаж сайжруулах арга хэмжээс нь Бүлэг 3 (нийгмийн суурь судалгаа) мөн Бүлэг 5 (Нийгмийн нөлөөлөл болон бууруулах арга хэмжээ)-д тусгасан.


7.3. Өргөдөл, гомдол барагдуулах механизм

198. Өргөдөл, гомдол барагдуулах механизм нь төслийн хэрэгжилтийн сөрөг нөлөөнд өртөж болзошгүй хүмүүс/орон нутагт тулгамдсан асуудал, өргөдөл гомдлыг шийдвэрлэх практик арга замаар хангана. ТУА-ны инженерийн ажилтнууд төслийн бүх үе шатанд өргөдөл, гомдлыг хянан үзэх, бүртгэх, жижиг асуудлуудыг газар дээр нь шийдвэрлэх, өргөдөл, гомдлыг анхаарах, оролцогч талуудад хариу өгөх зорилгоор өргөдөл, гомдол барагдуулах механизмыг хэрэгжүүлэх санаачилгыг гарган, ТУА нь өргөдөл, гомдол барагдуулах механизмыг хэрэгжүүлэх явц, дарааллыг боловсруулна.

199. Төсөл хэрэгжих явцад өргөдөл, гомдол барагдуулах механизмын талаар олон нийтэд танилцуулан, Монгол хэлээр оролцогч талуудын дунд мэдээлэл тараана. Өргөдөл, гомдлыг дараах дөрвөн үе шатаар шийдвэрлэнэ.


- Нэгдүгээр үе шат: Орон нутгийн түвшинд өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ба өргөдөл гомдол барагдуулах механизмд хандах боломж. Өргөдөл, гомдол барагдуулах механизмын систем нь төслийн сөрөг нөлөөнд өртөж болзошгүй талуудаас (орон нутгийн оршин суугчид, аж ахуйн нэгжийн төлөөлөгчид, гэрээлэгчдийн ажилтнууд гэх мэт) гомдол, саналыг хэд хэдэн хувилбараас хамгийн боломжит арга замыг сонгон гаргах нөхцлийг бүрдүүлнэ. Төслийн сөрөг нөлөөнд өртсөн хүний санал, гомдлыг НЗДТГ-ын дотоод цахим төв серверт шууд бүртгэх бөгөөд энэ нь хариу өгөх системтэй холбогддог. Өргөдөл, гомдлын бүртгэлд санал/ өргөдөл гомдлын асуудал, төслийн сөрөг нөлөөнд өртсөн хүний нэр, холбоо барих хаяг, өргөдөл, гомдол хүлээн авсан огноо зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг оруулна.

- Хоёрдугаар үе шат: НЗДТГ-аас гаргасан шийдвэр, өргөдөл, гомдлын шаардлагыг хангах боломжтой эсэхийг үнэлэн, шийдвэрлэнэ. Хүлээн авсан өргөдөл, гомдлыг ТУА-ны холбогдох ажилтнуудад эсвэл НЗДТГ-ын холбогдох хэлтэс / хэлтэс / нэгжид хуваарилна. ТУА нь асуудлыг шалгаж, шийдвэрлэх арга хэмжээг авна. Үүнд ажил гүйцэтгэгчийн үйл ажиллагааны алдааг залруулах арга хэмжээ багтана. Гэрээлэгч өргөдөл, гомдол барагдуулсан шийдлийг хэрэгжүүлэн, түүний үр дүнг ТУА-нд уламжилж, ДБ-д мэдэгдэх ёстой. Өргөдөл, гомдлын төрөл, ярвигтай байдлаас шалтгаалан ТУА/НЗДТГ нь тухайн өргөдөл, гомдлыг хүлээн авснаас хойш 1-30 өдрийн дотор асуудлыг шийдвэрлэнэ.
- Гуравдугаар үе шат: Өргөдөл, гомдлыг төслийн удирдлагын алба, удирдах хороо шийдвэрлэнэ. Гуравдугаар үе шатанд НЗДТГ, төслийн удирдлагын алба нь асуудлыг судалж 10 хоногийн дотор олон талын оролцогчдын дунд уулзалт зохион байгуулж, түүнээс хойш 10 хоногийн дотор асуудлыг шийдвэрлэнэ.
- Дөрөвдүгээр үе шат: Дээд байгууллагын тогтоол. Хэрэв өргөдөл, гомдлыг барагдуулаагүй бол төслийн сөрөг нөлөөнд өртсөн тал шүүхэд хууль ёсны дагуу хандах хандах боломжтой.



Зураг 6. Төслийн санал болгож буй өргөдөл, гомдол барагдуулах механизм

200. НЗДТГ-ын өргөдөл гомдлыг барагдуулах систем нь Нийслэлийн засаг даргын А/1086 тоот журмаар зохицуулагдана. Бүх агентлаг, НЗДТГ-ын төслүүд өргөдөл, гомдлын нэгдсэн систем (Зураг 1-д үзүүлэв) хэрэгжүүлэхийг шаарддаг. Уг төслөөс төсөл өргөдөл, гомдол барагдуулах өнөөгийн системд тулгуурлан үр дүнтэй менежмент хийж байна. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага төслийн бүх үе шатанд төслийн сөрөг нөлөөнд өртөж болзошгүй хүмүүс болон/бусад сонирхогч талуудтай илүү сайн хамтран ажиллах зорилгоор ТУА өргөдөл, гомдол барагдуулах журмыг илүү боловсронгуй болгож болно.



Зураг 7. Төслийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх менежмент нь НЗДТГ-ын ухаалаг өргөдөл, гомдлын системтэй уялдсан байдал

Тайлагнах

201. Хэрэгжүүлэгч байгууллага тус бүр өргөдөл гомдлын бүртгэл, шалгалт, тодорхой үе шат бүхий арга хэмжээ, үр дүнгийн талаарх мэдээллийг НЗДТГ, төслийн удирдлагын албанд тайлагнана. НЗДТГ-ын төслийн удирдлагын алба нь эдгээр мэдээллийг ДБ болон төслийн удирдах зөвлөлийн гишүүдэд зориулсан байгаль орчин, нийгмийн удирдлагын хэрэгжилт, хяналт шинжилгээний тайланд тусгана.

202. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн тухай баримтад дараах зүйлс багтана. Үүнд: i) төслийн ажилтнууд болон өргөдөл, гомдол гаргагчдаас мэдээлэл цуглуулах хэлбэр, журмыг тодорхойлох; ii) өргөдөл, гомдлын хэлбэрийг тодорхойлох зорилгоор тодорхой хугацаанд хяналт тавих, өргөдөл, гомдлын шалтгааныг системчлэн тогтоох, өргөдөл, гомдол хүлээн авах механизмыг үнэлэх зорилгоор тодорхой давтамжтай үнэлгээ хийх; iii) нөхцөл байдлын талаар оролцогч талууд ялангуяа эмзэг бүлэгт мэдээлэл өгөх үйл явц; iv) тодорхой цаг хугацаанд ДБ, НЗДТГ, СЯ-нд өгөх тайлангийн зорилгоор мэдээлэл цуглуулах журам зэрэг нь багтана.

8. Институцийн зохион байгуулалт, чадавх бэхжүүлэх

8.1. Институцийн зохион байгуулалт, байгаль орчин, нийгмийн менежментийн хүрээний хэрэгжилт

203. Төслийг НЗДТГ-ын холбогдох агентлагууд болох НАЗХГ, НТҮГ, ЗХУТ, Тээврийн цагдаагийн алба нь НЗДТГ-ын хяналт, зохицуулалтын доор үндэсний болон хотын түвшний холбогдох төрийн захиргааны байгууллагуудтай нягт хамтран ажиллана.

204. 2021 оны 1 сарын 11-ний өдөр Сангийн яамны сайдын 4 тоот тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын дагуу байгаль орчин, нийгмийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилго бүхий төслийн удирдлагын алба байгуулагдана. Хэрэгжүүлэгч байгууллага, төслийн удирдлагын албаны байгаль орчны мэргэжилтэн болон нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтний хамтын ажиллагааны хүрээнд бусад аюулгүй байдлыг хангах чиглэлээрх баримт бичгүүд болон байгаль орчин, нийгмийн менежментийн хүрээний төлөвлөлт, хэрэгжилтийг хариуцан ажиллана.

Удирдах хороо

205. Удирдах хороог НЗДТГ тэргүүлэн Сангийн яам, Зам тээврийн хөгжлийн яам зэрэг нь төсөл хэрэгжүүлэх нийтлэг чиглэлээр ханган ажиллана.

НЗДТГ ба ТУН

206. НЗДТГ нь төслийн удирдлага болж төлөөлөн Дэлхийн банктай холбоо барих үндсэн үүрэг гүйцэтгэнэ. НЗДТГ-ын төслийн баг байгаль орчин, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан ажилтнуудыг томилох бөгөөд төслийн ерөнхий төлөвлөлт, удирдлага, зохицуулалт, хяналт-шинжилгээг хариуцах болно. Байгаль орчны аюулгүй байдлын асуудлаар НЗДТГ-ын төслийн баг дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- Байгаль орчин, нийгмийн менежментийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх ерөнхий хариуцлагыг хүлээнэ.
- Байгаль орчин, нийгмийн менежментийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ хийхэд хүрэлцэхүйц хэмжээний төсвийн хуваарилалтыг баталгаажуулах.
- Төслийн аюулгүй байдлыг хангах, шаардлагатай байгаль орчны зөвшөөрлийг баталгаажуулах.
- Хэрэгжүүлэгч агентлагууд дэд төслийг дэмжих, хянан шалгах, зохицуулах.
- Өргөдөл, гомдол барагдуулах механизмын дагуу өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохицуулах.
- Байгаль орчин, нийгмийн менежментийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх, зохисгүй арга хэмжээг залруулах талаар ДБГ-тай холбоо тогтооно.

- Дэд төслийн хэрэгжүүлэгч агентлагаас ирүүлсэн байгаль орчин, нийгмийн хяналт-шинжилгээний тайланг хянах.
- Мэдээллийн ил тод байдлыг хангах үүднээс байгаль орчны хяналт-шинжилгээний тайланг ДБ-д ирүүлэх.
- Байгаль орчны хяналт-шинжилгээний тайлангийн явцын үр дүнг Дэлхийн Банк Групп (ДБГ)-д илгээх явцын тайланд тусгах.
- Шаардлагатай тохиолдолд БОНМХ, БОНМТ-г нарийвчилсан зураг төслийн үед шинэчлэх.
- БОННУ, БОНМХ, БОНМТ-ний шаардлагыг тендерийн баримт бичиг, барилгын ажил гүйцэтгэх гэрээнд тусгасан эсэхийг шалгах.
- Төслийн зөвшөөрөл, байгаль орчны зөвшөөрөл зэрэг шаардлагатай зөвшөөрөл авах
- Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө дэд төслийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, зохицуулах.
- БОНМХ-ний дагуу байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (дэд төсөл тус бүрт) боловсруулахыг гэрээлэгчдээс шаардаж, гүйцэтгэгчийн БОНМТ-г батлаж хянах
- Гүйцэтгэгч нь байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөг зохих ёсоор нь хэрэгжүүлж, холбогдох байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө шаардлага хангасан эсэхэд хяналт тавих
- Гэрээлэгчид Монгол Улсын болон ДБГ-ийн байгаль орчны менежмент, хамгааллын холбогдох шаардлага, журам, төслийн байгаль орчны болон нийгмийн зээлийн аливаа гэрээ, баталгааг дагаж мөрдөхийг баталгаажуулах.
- Төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчны аливаа асуудлыг тодорхойлж, шаардлагатай залруулж болохуйц арга хэмжээг санал болгох.
- Төслийн оролцогч талууд болон төслийн сөрөг нөлөөнд өртөж болзошгүй талуудтай байнгын харилцаа холбоо тогтоох, харилцаа холбоог байнга өргөжүүлэх.
- Төслийн сөрөг нөлөөнд өртсөн хүмүүсээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг үр дүнтэй, үр ашигтай шийдвэрлэхийн тулд өргөдөл, гомдол барагдуулах механизмын хэрэгжилтийг хангах.
- Дэд төслийн байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө байгаль орчны хяналт-шинжилгээний төлөвлөгөөнд тусгагдсан байгаль орчны хяналт-шинжилгээний хэрэгжилтийг хангах.
- Гэрээлэгчдээс ирүүлсэн улирал тутмын байгаль орчны хяналт-шинжилгээний тайланг хянаж, нэгтгэх.
- НЗДТГ, төслийн удирдлагын багт ирүүлэх байгаль орчны хяналт шинжилгээний хагас жилийн болон жилийн нэгтгэсэн тайланг бэлтгэх, хүргүүлэх цааш нь ДБ-д илгээх.

Хэрэгжүүлэгч байгууллагууд

207. Хэрэгжүүлэгч байгууллагууд байгаль орчны болон нийгмийн хамгааллын асуудал хариуцсан ажилтнуудтай байна. Хэрэгжүүлэгч байгууллагууд байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах өдөр тутмын ажлыг шууд хариуцана. Үүнд:

- ТУН-д байгаль орчин, нийгмийн менежментийн хүрээний бүх үйл ажиллагааг дэмжих
- БОНМХ-ний хэрэгжилтийг хангах
- Гэрээлэгчид Монгол Улсын болон ДБГ-ийн байгаль орчны менежмент, хамгааллын холбогдох шаардлага, журам, төслийн байгаль орчны болон нийгмийн зээлийн аливаа гэрээ, баталгааг дагаж мөрдөхийг баталгаажуулах.
- Өргөдөл, гомдол барагдуулах механизмын хэрэгжилтийг хангах.
- Байгаль орчны, нийгмийн хяналт шинжилгээний тайланг бэлтгэн ТУН-д өгөх
- Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө дэд төслийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэн, зохицуулах.

Дэд төслийн гэрээт гүйцэтгэгч байгууллага

208. Барилгын гүйцэтгэгчид дэд төсөл тус бүрийн хор хөнөөлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй. Гүйцэтгэгчид тендерийн баримт бичигт заасан байгаль орчны талаарх саналд заавал хариу өгнө. Гэрээлэгч бүр байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө боловсруулж, байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хариуцан ажиллах ажилтныг томилно. Төсөл хэрэгжиж дууссаны дараа байгаль орчны менежментийн үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэгч байгууллагын засвар үйлчилгээ, ашиглалт хариуцсан хэсэгт хүлээлгэн өгнө.

8.2. Байгаль орчин, нийгмийн менежментийн чадавх бэхжүүлэх төлөвлөгөө

209. Төсөл нь Дэлхийн Банкнаас Улаанбаатар хотын захиргаатай анх удаа хэрэгжүүлж буй Хөрөнгө Оруулалтын Төслийн Санхүүжилийн үйл ажиллагааны нэг юм. Хөгжлийн түншүүд, төслийн удирдлагын албаны хөлсөлсөн техникийн чадавхийг бэхжүүлэх багуудын дэмжлэгтэйгээр НЗДТГ нь сүүлийн 10 жилд олон улсын хөрөнгө оруулалтын хэд хэдэн төслийг хэрэгжүүлсэн. ДБ-ны байгаль орчин, нийгмийн хүрээний дагуу байгаль орчин, нийгмийн арга хэрэгслийг боловсруулах НЗДТГ-ын чадавх тааруу, одоогоор асуудал хариуцсан ажилтангүй байна. Тэдний чадавхийг дээшлүүлэхийн тулд олон улсын болон үндэсний зөвлөхүүдийн туслалцаа шаардлагатай байна. Үр дүнг дээшлүүлэхийн тулд Дэлхийн банкны аюулгүй байдлын багийн дэмжлэгтэйгээр байгаль орчин, нийгмийн сургалтыг олон улсын болон үндэсний мэргэшсэн зөвлөхүүдийн тусламжтай хийх хэрэгтэй байгаа болно. Байгаль орчин, нийгмийн хүрээ ба байгаль орчин, нийгмийн стандарт нь эрүүл мэнд, ажилтнуудын болон орон нутгийн иргэдийн аюулгүй байдалтай холбоотой зохих үйлчилгээг үзүүлэх зэрэг гэрээлэгчдийн үр дүнтэй гүйцэтгэлийг хангахад анхаарал

хандуулах шаардлагатай байгаа тул энэ чиглэлээр тодорхой сургалт зохион байгуулах шаардлагатай болно.

210. Байгаль орчин, нийгмийн хүрээний дасан зохицох менежмент, тэнцвэрт харьцаа, оролцогч талуудын хамтын ажиллагааны төлөвлөгөө ба хөдөлмөрийн менежментийн журмын хэрэгжилт, ялангуяа хөдөлмөрийн удирдлага, иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчин, аюулгүй байдалтай холбоотой байгаль орчин, нийгмийн асуудлын хяналт-шинжилгээ, гэрээлэгчийн удирдлага, оролцогч талуудын хамтын ажиллагаанд тавигдах шаардлагын талаарх үзэл баримтлал, ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэхэд байгаль орчин, нийгмийн хүрээний чадавхийг бэхжүүлэх сургалт нь чиглэгдэх болно хэмээн найдаж байна. Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагад чиглэсэн сургалтын зорилтот хөтөлбөрүүд нь газар худалдан авах, нийтийн хэрэглээний үйлчилгээний тасалдал болон бусад асуудлын үр дүнтэй менежментийг хангахад чухал үүрэг бүхий байгууллагууд хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд туслах болно.

211. Хэрэгжилтийн шатанд Байгаль орчин, Нийгмийн сургалтыг техникийн дэмжлэг үзүүлэх байгууллагууд болон холбогдох оролцогч талуудын дунд зохион байгуулна. Нэн тэргүүнд зохион байгуулах шаардлагатай сургалтын сэдвийг дурдвал:

- Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө, оролцогч талуудыг оролцуулах төлөвлөгөө, хөдөлмөрийн менежментийн журам, Нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээнд анхаарал хандуулах байгаль орчин, нийгмийн арга хэрэгслийг бэлдэх, хэрэгжүүлэх, хяналт тавих байгаль орчин, нийгмийн менежментийн хүрээний удирдамж, үйл ажиллагаа
- Нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээ /Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө, оролцогч талуудыг оролцуулах төлөвлөгөө, хөдөлмөрийн менежментийн журмын төлөвлөлт, хэрэгжилт үүний дотор өргөдөл, гомдол барагдуулах механизмын ашиглалтын талаарх тусгай сургалт
- Гэрээлэгчийн гүйцэтгэлд хяналт тавих, хяналт-шинжилгээ хийх тусгай сургалт үүнд шаардлагатай маягтууд бөглөх, тайлагнах үйл явц, эрүүл мэнд, аюулгүй байдлын талаарх мэдлэг ойлголт, орон нутагт болон байгаль орчинд бий болж болзошгүй үр нөлөөг бууруулсан барилгын ажлын сайн туршлага, өргөдөл, гомдол барагдуулах механизмын журам болон бусад нийгмийн асуудлуудтай холбоотой анхан шатны мэдлэг, ойлголт олгох тодорхой сургалт, мөн түүнчлэн COVID-19, ЖСХ зэрэг бусад халдварт өвчинтэй холбоо бүхий нийгмийн асуудлууд зэрэг болно.

212. Эхний 2 жилийн хугацаанд ТУА-ны зүгээс хэрэгжүүлэгч байгууллагуудад зориулж БОНМСХ-ий үйл явц, БОНМТ, ТОХТ, ХХЗЖ, БОУАЖ, НШУАТ зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээний баримт бичгийг бэлтгэх хэрэгцээ шаардлагын талаар дор хаяж 2 удаагийн сургалт семинар зохион байгуулах нь зүйтэй. Сургалтанд хамруулбал зохих санал болгож буй зорилтот бүлгүүдийг Хүснэгт 8.1-д тусгасан болно.

Хүснэгт 8. Төсөл хэрэгжүүлж эхлэх үед зохион байгуулах Урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай сургалт

#	Агуулга	Сургалтанд хамруулах зорилтот бүлгүүд
1	БОНМСХ-ий процесс, хэрэгжилт, хяналт болон БОНХ-ний үзэл баримтлал, БОНС-ууд, ТОХТ, ХХЗЖ, үүний дотор БОУАЖ болон БМД, ЖСХ, ГБМ-тэй холбоотой Сахилгын дүрэм	Төслийн удирдлагын алба (ТУА), Хэрэгжүүлэгч байгууллагууд (ХБ), зөвлөхүүд эсхүл зөвлөх компаниуд
2	НШҮАТ-г оролцуулаад Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын хүрээг (НШБХ) бэлтгэх	ТМА, ХБ-ууд, зөвлөхүүд эсхүл зөвлөх компаниуд болон орон нутгийн эрх бүхий байгууллагууд
3	БОНМСХ, ТОХТ, ХХЗЖ боловсруулах, хяналт тавих, үүнд гэрээний менежмент болон БМД ба ЖСХ-тэй холбоотой Сахилгын дүрэм зэрэг чадавхийг дээшүүлэх асуудал багтана.	ТМА, ХБ-ууд, зөвлөхүүд эсхүл зөвлөх компаниуд болон гэрээт ажил гүйцэтгэгчид буюу гэрээлэгчид
4	Байгаль орчин, нийгмийн хяналтын үр чадварыг сайжруулах	ТМА, ажлын талбайд ажиллах инженерүүд, гэрээт ажил гүйцэтгэгчид, байгаль орчны болон нийгмийн асуудал хариуцсан зөвлөхүүд, орон нутгийн эрх бүхий байгууллагууд
5	БОУАЖ болон БМД ба ЖСХ-тэй холбоотой Сахилгын дүрмийг мөрдөх, байгаль орчны эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ, КОВИД-19 зэрэг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаарх сургалт	Ажлын талбайд ажиллах инженерүүд, гэрээт ажил гүйцэтгэгчид, зөвлөхүүд эсхүл зөвлөх компаниуд, орон нутгийн иргэд

213. БОН-ийн сургалтын төрөл бүрийн хэрэгцээ болон байгууллагуудын чадавхи хязгаарлагдмал тул, ТМА нь БОНМСХ-г хэрэгжүүлэх, БОН-ийн баримт бичгүүд болон тухай тухайн хариуцсан дэд төслийн хүрээнд авч хэрэгжүүлэх эрсдэл буюу нөлөөллийг бууруулах арга хэмжээг боловсруулахад туслуулах зорилгоор БОН-ийн зөвлөхүүдийг (хувь хүн эсвэл компани) гэрээгээр дайчлан ажиллуулж болно. БОНМСХ-ий хэрэгжилт, БОНХ болон БОНС-ын үзэл баримтлалын талаархи чадавхийг бэхжүүлэх сургалтанд шаардагдах зардал нь ойролцоогоор 0.4 сая доллар байх ба ТУА нь энэхүү төсвийн менежментийг хариуцна.

ХАВСРАЛТ 1. Нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээ

1. Оршил

Энэхүү баримт бичигт “Улаанбаатар хотын тогтвортой автозам, тээвэр” төслийн (P174007) Нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээ буюу үзэл баримтлал (НШБХ), тухайлбал бүрэлдэхүүн хэсэг 1.1-д заасан коридорын онцлог бүхий дэд бүтцийн хөрөнгө оруулалт; бүрэлдэхүүн хэсэг 4-д заасан онцгой байдал үүсэн үед үзүүлэх шаардлагатай хариу арга хэмжээ авах зорилгоор нэмэлтээр хэрэгжих дэд төслүүдийн талаар авч үзнэ.

Бүрэлдэхүүн хэсэг 1-д үзүүлсэн I дэх хэлбэрийн үйл ажиллагааны хүрээнд авто зам засварлах, автобусны тэргүүлэх эгнээ, автобусны зогсоол, явган зорчигч зорчигчийн болон дугуйн замын талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор гудамжны хөндлөн огтлолын хэсгийг өөрчлөх; уулзваруудыг хоолойтой болгох; инженерийн барилга байгууламжуудын тэмдэг, замын тэмдэглэгээ, гэрлэн дохио, аюулгүйн хаалт хашлага суурилуулах, үер болон мөстлөгийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор авто замын хучилт, бохир ус зайлуулах сувгийг сайжруулна. Нэгдүгээр бүрэлдэхүүн хэсгийн дагуу II дугаар хэлбэрийн үйл ажиллагаа нь сүлжээний холболтыг сайжруулах зорилгоор коридорыг сэргээн засварлах, гэр хорооллын иргэдэд үйлчилгээ үзүүлэх, одоогийн авто замуудыг өргөтгөх зорилгоор газар чөлөөлөх шаардлагатай болно. Бүрэлдэхүүн хэсэг 1-д тэргүүлэх чиглэлийн коридорын байршлыг урьдчилан тодорхойлсон байгаа боловч холбогдох нэмэлт дэлгэрэнгүй мэдээлэл хараахан эцэслэгдэж боловсруулагдаагүй байгааг харгалзан үзэж төслийн үнэлгээний өмнө энэхүү ндахин суурьшлын бодлогын үзэл баримтлалыг боловсруулав.

Нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой олон чухал шаардлага урган гарна гэдгийг урьдчилан таамаглаагүй байсан тул энэхүү НШБХ нь биет хөрөнгө, эдийн засгийн шинжтэй зүйлсийг нүүлгэн шилжүүлэх, зохион байгуулах удирдамж болно.

Энэхүү НШБХ-нд (i) барилга байгууламж, үндсэн хөрөнгөнд үзүүлэх нөлөөллийг нөхөн төлүүлэх протокол; (ii) нүүлгэн шилжүүлэлтээс үүсэх нөлөөллийн тухай холбогдох бодлого, журам нь үнэлгээ хийж дууссаны дараагаар зам барилгын ажлыг эхлэхийн өмнө Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулах хэрэгцээг бий болгож байгаа тухай өгүүлнэ.

Ямар ч хэлбэрийн нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө нь Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн хүрээ, 2017 оны Газрын хууль, Газар ашиглахыг хязгаарлах болон албадан нүүлгэн шилжүүлэлт (ESS5), Монгол Улсын хууль тогтоомжтой нийцсэн байна.

НЗДТГ-ын дэргэдэх Төслийн удирдлагын алба (ТУА) нь НШБХ-ний зарчмын дагуу барилга байгууламж, үндсэн хөрөнгөд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох, хариу арга хэмжээ авах эрх бүхий албан хаагчдыг ажиллуулна. Эдгээр албан хаагчид хотын замын төлөвлөлт, барилга, засварыг хариуцах чиг үүрэг бүхий Нийслэлийн Авто замын хөгжлийн газартай нягт хамтран ажиллана.

2. Зорилго, үндсэн зарчим

Нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээ нь Монгол Улсын хууль тогтоомж, Дэлхийн банкны “Газар чөлөөлөлт, газар ашиглах хязгаарлалт болон албадан нүүлгэн шилжүүлэлтийн стандарт (БОНС5)”-ын хүрээнд тавигдах шаардлагуудтай нийцсэн байна. Нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээний үндсэн зорилго нь төслийн явцад албадан нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх эсвэл хамгийн бага хэмжээнд байлгахад оршиж байна. Зайлсхийх боломжгүй үед тус бодлогын зорилго нөлөөллийг хамгийн бага хэмжээнд байлгахад оршино. Өөрөөр хэлбэл төслийн хэрэгжилтийн нөлөөлөлд өртсөн хүмүүс¹³ төсөл хэрэгжихийн өмнөх үеийнхээс “илүү сайн” эсвэл “наад захын хангалттай сайн” түвшинд амьдрах ёстой юм. Төсөл хэрэгжүүлэх явцад төслийн нөлөөнд өртсөн бүх хүмүүстэй зөвлөлдөн, төлөвлөлт болон төслийн үр шимийг хүртэх боломжоор хангана. Төсөл тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах ёстой.

Эдгээр зарчим нь оролцогч талуудыг ялангуяа төслийн нөлөөлөлд өртөгч талуудыг аль болох эрт тодорхойлохыг шаардах; урьдчилан тодорхойлсон аливаа нөлөөллийг олон нийтэд ил тод мэдээлэх; сөрөг нөлөөллөөс зайлсхийх эсвэл бууруулах боломжийн талаар орон нутгийн бүх талын оролцогч талуудтай урьдчилан зөвлөлдөх, амьжиргааг сэргээх; Нүүлгэн шилжүүлэх, төслийн сөрөг нөлөөнд өртсөн талуудыг дэмжих үйл ажиллагааг шударга, ил тод, цаг алдалгүй авч хэрэгжүүлэх; хүмүүсийг болон аливаа нөлөөллийг ижил түвшинд анхааран ялгаварлахгүй авч үзэх, нийгмийн байдал, ядуурал, үндэс угсаа, хүйс, нас, хөгжлийн бэрхшээлээс шалтгаалан орхигдож болзошгүй эмзэг бүлгийн нөхцлийг нь сайжруулах зэрэг боломжийг амлана.

Хүмүүс үндсэн хөрөнгөө (дэлгүүрийн барилга гэх мэт) алдсан бол түүнтэй яг ижлээр нь орлуулах, хэрэв боломжгүй бол алдагдсан хөрөнгө, орлогод нөхөн төлбөр олгох, нүүлгэн шилжүүлэх, амьжиргааг сэргээх зардлыг нөхөн олгох зорилготой болно. Сэргээн босгох хөрөнгө гэдэгт зөвхөн биет хөрөнгө төдийгүй нийгэм, соёлын өмч хөрөнгө багтана. Энэхүү үнэт зүйлтэй холбоотой төвөгтэй асуудал үүсвэл, ялангуяа энэ асуудал эмэгтэйчүүдэд тулгарахаар байвал, бодлогын зорилтыг хангах үүднээс тухайн асуудлын шийдлийг төслийн сөрөг нөлөөнд автсан талуудын оролцоотой сонгон авна.

3. Нүүлгэн шилжүүлэх төлөвлөлтийн зарчим

Нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Нүүлгэн шилжүүлэх бодлогыг боловсруулах явцад шилжин суурьших хүмүүстэй зөвлөлдөнө. Ингэснээр нөхөн олговрын талаарх тэдний сонирхол, сонголтыг харгалзан үзэх боломж бүрдэнэ.

¹³ “Шилжин суурьшигч” хэмээх нэр томьёо нь төслийн нөлөөнд өртсөн хүмүүсийг нийгэм\эдийн засгийн болон эд хөрөнгийн хувьд нүүлгэн шилжүүлэх гэсэн утгыг илэрхийлнэ. “Нөлөөнд автсан хүн” хэмээх нэр томьёог хольж солихгүй байх үүднээс төслийн сөрөг нөлөөнд автсан хүмүүс хэмээн ойлгоно. Тэд газар, хөрөнгө эзэмших албан ёсны эрх мэдэлтэй, хууль тогтоомжийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөн газар, эд хөрөнгийн нэхэмжлэл гаргах эрхтэй эсхүл газар, эд хөрөнгө шаардах хууль ёсны эрхгүй байж болно.

- Нөхөн төлбөр олгох эцсийн хугацаа, хөрөнгийн хохирлын судалгааны товыг өдөр тутмын сонинд мэдээлнэ.
- Төслийн нөлөөнд өртсөн бүх хүмүүс өмчийн байдал, түүний дотор зөвшөөрөлгүйгээр газар эзэмшиж байгаа хүмүүс хүртэл ашиглаж буй эд хөрөнгийн хэлбэрээс (орон сууц, худалдааны, нийтийн болон орон нутгийн) үл хамааран орон байраа нөхөн сэргээх төлбөр авах боломжтой болно. Хууль ёсны эрхгүй хүмүүсийн нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор, хохирсон эд хөрөнгийн нөхөн олговор, бусад хэлбэрийн тусламж авах эрхийг нь хасаж болохгүй.
- Элэгдэл, хорогдлын хэмжээг суутгалгүйгээр зах зээлийн үндсэн өртөгтэй харьцуулан нөлөөлөлд өртсөн барилга байгууламж, үндсэн хөрөнгийг орлуулах нөхөн төлбөр олгоно. Нөлөөлөлд өртсөн хүмүүс материалаа авах боломжтой.
- Түр зуурын зөрчил, түүний дотор хашааг нь буулгах, ROW-аас гадуурх талбай дээрх барилгын ажлын нөлөөлөлд өртсөн байгууллагуудтай харилцан тохиролцсоны үндсэн дээр бэлэн мөнгөөр нөхөн олговор олгоно. Нөлөөлөлд өртсөн байгууллагууд өөрийн газар, оршин суух байраа үргэлжлүүлэн ашиглаж болно. Ажил дууссаны дараа барилгын ажлын гүйцэтгэгч компаниуд газрыг нь дахин сэргээн, хашааг нь барьж өгнө.
- Дахин суурьшлын бодлогод тусгагдсан нөхөн олговрын хувь хэмжээ гэдэг нь хөрөнгийн өмчлөгч буюу хэрэглэгчдийн гар дээр элэгдэл хорогдлын хэмжээг суутгалгүйгээр бүрэн хэмжээгээр очих төлбөрийн хэмжээг хэлнэ.
- Барилга байгууламж, үндсэн хөрөнгийн нөхөн төлбөрийг нөлөөлөл бий болохоос өмнө төлнө.
- Нүүлгэх, шилжүүлэх болон мөнгөн хэлбэрийн шилжүүлгийн бүх зардлыг (төлбөр, хураамж) чөлөөлөх буюу нөлөөлөлд өртсөн үл хөдлөх хөрөнгийн гэрээний үнийн дүнд тусгасан байна.
- Нөхөн олговор олгох болон нүүлгэн шилжүүлэх ажил хийгдээгүй тохиолдолд барилгын ажил эхлэхгүй, богино хугацааны орлого алдсаныг нөхөж санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.
- Бэлэн мөнгөний нөхөн төлбөрт татвар ногдуулахгүй бөгөөд үл хөдлөх хөрөнгө бүртгэх бүх төлбөр, гүйлгээний зардлыг төслийг эзэмшигч тал гаргана.
- Нөлөөлөлд өртсөн дэлгүүрүүд төслийн автозамын хамгаалалтын зурвасаас гадагш нүүх шаардлагатай тул тэдгээрийг сэргээн босгоход шаардлагатай зардал, орлогын хохирлын тэтгэмжийг төлнө.
- Оролцогч талуудын хамтын ажиллагааны төлөвлөгөөний дагуу төслийн хэрэгжилттэй холбоотой өргөдөл, гомдлыг барагдуулах механизмыг ашиглана.
- Төслийг дэмжигч/банкны зээлдэгч нь нөхөн төлбөрийн өртөгтэй холбоотой бүх хариуцлагыг хүлээнэ. Дахин суурьшлын бодлого нь газар чөлөөлөхтэй холбоотой бүхий л зардлыг багтаан тооцсон төсөвтэй байна.
- Боловсруулсан нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг олон нийтэд хүртээмжтэй, ил тод тарааж, 2017 оны байгаль орчин, нийгмийн хүрээний шаардлагын дагуу хяналт-шинжилгээ хийнэ.

4. Эрх зүйн болон зохицуулалтын хүрээ

НШБХ-ний бүх шаардлага нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж (доор үзүүлсэн) болон Дэлхийн Банкны "байгаль орчин, нийгмийн стандарт 5 (ESS5)"-тай нийцнэ. Энэ хэсэгт

үндэсний хууль тогтоомж, Дэлхийн банкны бодлогын холбогдох заалтуудыг дүгнэн, тухайн бодлогын хүрээнд тавигдах шаардлагын зөрүүг арилгах арга хэмжээг үзүүлж байгаа болно.

НШБХ дэхь Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн хүрээ (ESF, 2017), үндэсний хууль тогтоомжуудтай нийцэж байгаа заалтуудыг дүгнэн, Банк болон үндэсний хууль тогтоомжийн хүрээнд тавигдах шаардлага хоорондын зөрүүг арилгах арга хэмжээг нэгтгэн үзүүлэв. Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх чиглэлээр хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль тогтоомжийн үндэс суурийг дараах эрх зүйн барит бичиг бүрдүүлж байна. Үүнд: Үндсэн хууль (1992); Газрын тухай хууль (2006); Монгол Улсын Иргэний хууль (2002); Иргэнд өмчлүүлэх газрын үнэлгээний тухай аргачлал (Засгийн газрын 2003 оны 103 дугаар тогтоол); Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль (2003); Хот байгуулалтын тухай хууль (2015) зэрэг болно.

Монгол улсын Үндсэн хуулинд “Төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно”, “Төр ба төрийн байгууллагууд нийтийн онцгой хэрэгцээний үндсэн дээр хувийн өмчийг ашиглах тохиолдолд зохих нөхөн төлбөр олгох болно” гэж заасан байдаг.

Газрын тухай хууль нь газар эзэмшүүлэх, ашиглуулах болон эзэмших эрхийн хугацаа дуусах харилцааг зохицуулдаг. Газар өмчлөх эрхгүй газар эзэмшигч нь хууль бус газар ашиглагч гэж тооцогддог тул Газрын тухай хуулийн 27.4-т “Хүчин төгөлдөр эрхийн гэрчилгээгүй аливаа этгээд газар эзэмшихийг хориглоно” гэсэн заалтыг үндэслэн албадан нүүлгэж болно. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулинд хувийн өмчийн газрыг чөлөөлөхтэй холбоотой заалтууд орсон. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 35 дугаар зүйл мөн хуулийн 28 дугаар зүйлийг зөрчсөн тохиолдолд иргэний эзэмшлийн газрыг хураахаар заасан байдаг. Иргэнд өмчлүүлэх газрын үнэлгээний тухай аргачлалаар (Засгийн газрын 2003 оны 103 дугаар тогтоол) нь газрын үнэлгээний тарифыг тогтоодог.

Хүснэгт 9. Монгол улсын хууль, Дэлхийн банкны албадан нүүлгэн шилжүүлэлтийн журмын харьцуулалт

Сэдэв	Монгол улсын хууль тогтоомж	ДБ-ны Байгаль орчин, нийгмийн хүрээ
Нөлөөлөлд өртсөн байгууллагуудад тавигдах шаардлага	Тусгай зөвшөөрөлтэй газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нь Газрын тухай хууль (35, 38 дугаар зүйл), Иргэдэд газар өмчлүүлэх тухай хууль (27 дугаар зүйл)-д заасны дагуу хүлээн зөвшөөрөгдсөн бусад хуулийн этгээдэд эрхээ шилжүүлж болно. Газрын хууль бус өмчлөгч нь хууль бус өмчлөгч хэмээн тооцогдож	(БОНС5) Нөлөөлөлд өртсөн хүн гэдэгт дараах хүмүүс багтана. Үүнд: 1. (а) Газар болон эд хөрөнгө өмчлөх албан ёсны эрхтэй хүмүүс; 2. (b) Газар болон эд хөрөнгө өмчлөх албан ёсны эрхгүй ч, үндэсний хууль тогтоомж 14-ийн дагуу газар, эд хөрөнгийн нэхэмжлэл гаргагч хэмээн хүлээн

	<p>газар шилжүүлэх, нөхөн төлбөр авах эрхгүй (Газрын тухай хууль, 27.4-р зүйл).</p> <p>Иргэний тухай хуулийн 104.2-д “Хуульд өөрөөр заагаагүй бол эзэнгүй үл хөдлөх эд хөрөнгийг олж авсан өмчлөгч бус этгээд уг эд хөрөнгийн өмчлөгчөөр улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш 15 жилийн хугацаанд уг эд хөрөнгийг өмчлөгчийн адил эзэмшиж байсан бол дээрх хугацаа дууссанаар уг этгээд өмчлөх эрхийг олж авна” гэж заасан.</p>	<p>зөвшөөрөгдсөн хүмүүс;</p> <p>3. (с) Хууль ёсны эрх болон нэхэмжлэл гаргах эрхгүй ч газар, өмч хөрөнгийг эзэмшиж, ашиглаж байгаа хүмүүс.</p>
<p>Барилга байгууламжийн нөхөн төлбөр</p>	<p>Худалдан авсан газар дээр байрлах байгууламжийг шилжүүлэх төлбөрийг гэрээний дагуу тохиролцоно. Барилга байгууламжийн үнэ цэнийг тухайн зах зээлийн ханшаар барилгын нийт үнээс элэгдлийг хасч тогтоодог. Газрын тухай хуулинд тусгагдсан зүйл бол газар болон үл хөдлөх хөрөнгийг зах зээлийн үнэ ханшаар нөхөн төлүүлэх ёстой.</p>	<p>Газар чөлөөлөлт, газар ашиглалтын хязгаарлалтаас үүсэх нийгэм, эдийн засгийн зайлшгүй сөрөг үр дагаврыг дараах байдлаар бууруулна. Үүнд: (а) хөрөнгөө алдсаны нөхөн төлбөрийг цаг тухайд нь олгох замаар (БОНС)¹⁴.</p>

¹⁴ “Орлуулах өртөг” гэдэг нь хөрөнгийг орлуулахад шаардлагатай хангалттай хэмжээний нөхөн олговор олгох үнэлгээний арга бөгөөд дотроо хөрөнгө орлуулахтай холбоотой шилжүүлгийн зардлыг агуулсан байдаг. Үйл ажиллагаа эрхлэх зах зээл байгаа тохиолдолд орлуулах өртөг нь үл хөдлөх хөрөнгийн бие даасан, өрсөлдөх чадварын үнэлгээгээр дамжуулан зах зээлийн үнэлгээ болж түүн дээр шилжүүлгийн зардлыг нэмж тооцдог. Үйл ажиллагаа эрхлэх зах зээл байхгүй тохиолдолд нөхөн олговрын өртгийг өөр аргаар тодорхойлно. Тухайлбал газар, бүтээмж бүхий хөрөнгө, газрын гарцын өртгөөр тооцох; хөрөнгийн гарцын өртөг тооцох; орлуулах материалын холбогдох өртөг болон барилга байгууламж эсвэл бусад үндсэн хөрөнгийг барихад зарцуулсан хөдөлмөрөөр тооцох аргыг ашиглаж болох бөгөөд үүн дээр шилжүүлгийн зардлыг нэмж тооцно. Бодит биетийн нүүлгэн шилжүүлэлт нь орон байргүй болоход хүргэх бүх тохиолдолд орлуулах өртөг нь дор хаяж олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн чанар, аюулгүй байдлын хамгийн бага стандарт шаардлагад нийцсэн орон сууц худалдан авах эсвэл барихад хүрэлцэхүйц байх шаардлагатай. Орлуулах өртгийг тооцох үнэлгээний аргыг баримтжуулж, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөний холбогдох баримт бичигт хавсаргана. Шилжүүлгийн зардалд захиргааны зардал, бүртгэлийн төлбөр, шилжин нүүлгэх боломжит зардал, төслийн сөрөг нөлөөлөлд өртсөн хүмүүст ногдуулах ижил төстэй зардал зэрэг нь багтана. Орлуулах өртгийн нөхөн төлбөр, төлөвлөсөн нөхөн олговрын хувь хэмжээг баталгаажуулахыг төсөл хэрэгжиж буй газар нутгийн онцлогоос хамааруулан шинэчилж болно. Ингэхдээ инфляц, нөхөн олговрын хэмжээг тооцох цаг хугацаа, нөхөн олговрын шилжүүлэх зэргийг харгалзан үзнэ.

	Бодит байдал дээр нөхөн олговор нь зах зээлийн үнээс хамаардаггүй. Тухайн талбайд ашиглаж буй барилга байгууламжийг нөхөн төлөх тухай заалт байхгүй.	
Эмзэг буюу орхигдож болзошгүй бүлэг	Нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд зориулсан хууль тогтоомжийн заалт байхгүй.	Эдийн засаг, биет хөрөнгийн нүүлгэн шилжүүлэлтийн хувьд жендэрийн асуудал, орон нутгийн эмзэг бүлгийн хэрэгцээнд анхааран, ил тод, тогтвортой, тэгш байдлаар (БОНС5) хангахад Нүүлгэн шилжүүлэх бодлого анхаарлаа хандуулна.
Өргөдөл, гомдол барагдуулах журам	Газрын тухай хуулинд газартай холбоотой маргааныг засаг захиргааны нэгжийн Засаг дарга, цаашилбал нь шүүхэд гаргаж болно гэж заасан (60 дугаар зүйл). Иргэний хууль, Иргэдэд газар өмчлүүлэх тухай хуульд төрөл бүрийн маргааныг шүүхэд шилжүүлнэ хэмээн тусгасан.	Төслийн эрсдэл, нөлөөлөлтөй холбоотой өргөдөл, гомдолд энэ тэнцүү хандан тулгарч буй асуудал, гомдлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.
Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө, мэдээллийн ил тод байдал, иргэдтэй зөвлөлдөх	Хот байгуулалтын тухай хууль (17, 18 дугаар зүйл)-д хотын хөгжлийн төлөвлөлтөд иргэдийн оролцоог хангаж, хот төлөвлөлтийг хэрэгжүүлэх явцад иргэдтэй зөвлөлдөнө. Хот байгуулалттай холбоотой шийдвэрийг цаг тухайд нь олон нийтэд мэдээлж, нийтэд мэдээлнэ.	Зээлдэгч төсөлтэй холбоотой эрсдэл, нөлөөлөлд пропорциональ байдлаар хандсан төлөвлөгөө боловсруулна. Бага хэмжээний газар чөлөөлөлт, газар ашиглалтын хязгаарлалт бүхий төслүүдийн үр дүн хүмүүсийн орлого, амьжиргаанд их нөлөө үзүүлэхгүй бол нөлөөлөлд өртсөн хүмүүсийн шаардлага хангасан байдлыг тодорхойлох төлөвлөгөөг болон нөхөн олговор олгох, зөвлөлдөх уулзалт зохион байгуулах, өргөдөл гомдлыг барагдуулах болон хяналт-шинжилгээ хийх арга хэмжээг зохицуулах дүрэм журам боловсруулна (БОНС5).
Дуусгах хугацаа	Эзэмшил, ашиглалтад байгаа газрыг чөлөөлөх огнооны тухай заалт байхгүй.	Тооллогын судалгааг эхлүүлэхтэй зэрэгцэн зээлдэгч тал нүүлгэн шилжүүлэх хугацааг тогтооно. Үйл ажиллагааны эцсийн хугацааны талаарх мэдээллийг сайтар баримтжуулж, төслийн талбайд амьдарч, ажиллаж буй олон нийтэд тодорхой давтамжтай хугацаанд бичгээр

		болон бусад зохимжтой хэлбэрээр (БОНС5) тараана.
Үл хөдлөх хөрөнгийг чөлөөлөх, барилгын ажил эхлүүлэхийг тухай мэдэгдэх хугацаа	Үл хөдлөх хөрөнгийг чөлөөлөх хугацааг гэрээнд тодорхойлж болно. Барилгын ажил нь үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэхтэй зэрэгцэн эхлэх боловч хүлээлгийн хугацааны талаар тодорхой дурдаагүй байдаг.	“Байгаль орчин, нийгмийн стандарт” ESS5-д заасны дагуу нөхөн олговор олгогдсоны дараа зээлдэгч нь газар болон холбогдох хөрөнгийг эзэмшинэ. Барилгын ажил эхлэхээс өмнө үүнийг хийж гүйцэтгэсэн байна.

Хүснэгтэд үзүүлснээр Монгол Улсын хууль эрх зүйн орчин болон Дэлхийн банкны “Байгаль орчин, нийгмийн хүрээ”-ний хооронд хэд хэдэн бодлогын зөрүү гарч байна. Монгол Улсын хууль тогтоомж буюу практикт заасны дагуу: (i) газрыг хууль бус өмчлөгч нь хууль бус өмчлөгч хэмээн тооцогдож газар шилжүүлэх, нөхөн төлбөр авах эрхгүй; (ii) орлого, амьжиргааны нөхөн сэргээлтийг орон нутгийн газар чөлөөлөх практикт харгалзан үздэггүй; (iii) нөхөн төлбөрт гүйлгээний зардлыг оруулан тооцдоггүй; (iv) өмнө нь хэрэгжсэн төслүүдийн хувьд дотоод өргөдөл, гомдол барагдуулах механизм байдаггүй, гомдлыг засаг дарга, шүүх шийддэг; (v) олон нийтийн хэлэлцүүлэг, олон нийтийн дунд мэдээлэл сурталчлах ажил хийгддэггүй; (vi) тавигдах шаардлага, гүйцэтгэх хугацааг зарладаггүй; (vii) газар чөлөөлөх бүхий л процедурыг дуусгах болон барилгын ажил эхлүүлэх цаг хугацааны хязгаарлалт байхгүй; (viii) Нүүлгэн шилжүүлэх Нүүлгэн шилжүүлэх бодлого боловсруулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шаардлагагүй байсан.

Эдгээр зөрүүг арилгахын тулд энэхүү НШБХ-д Монгол улсын хууль тогтоомж болон Дэлхийн банкны шаардлагыг хоёуланг нь нэгтгэсэн заалтуудыг оруулсан (Эрхийн матрицыг үзнэ үү) бөгөөд Дэлхийн банкны “Байгаль орчин, нийгмийн хүрээ”-нд (БОНС5) тавигдах шаардлагыг нэн тэргүүнд харгалзан авч үзнэ. Нэмж дурдахад энэхүү НШБХ нь өмнө нь дурдагдаж байсан төслийн үндсэн зарчмыг тусгаснаас гадна хоёр талын зөрүүтэй үйл явцыг нэгтгэх (үнэлгээний арга зүй, Нүүлгэн шилжүүлэх Нүүлгэн шилжүүлэх бодлого боловсруулах, зөвлөлдөх уулзалт зохион байгуулах, өргөдөл гомдол барагдуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх гэх мэт) заалтуудыг агуулсан болно.

5. Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө боловсруулах, батлуулах

Санал болгож буй сонгогдсон коридоруудыг төслийн удирдлагын албаны аюулгүй байдлын мэргэжилтний хамт шалгаж, нийгмийн болон нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны орцын хүчин зүйлийг бэлдэнэ. Байршлыг шалгаж, нүүлгэн шилжүүлэхээс үүдэн бий болох нөлөөллийг авч үзэж, эхний ээлжинд бий болох нөлөөллөөс зайлсхийх, бууруулахыг эрмэлзэн ажиллана.

Коридорыг сэргээн засах ажил тодорхой болж эцсийн хувилбар бэлэн болоход төслийн удирдлагын албаны аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Барилгын ажлын үр дүнд гарч болзошгүй түр зуурын болон байнгын нүүлгэн шилжүүлэх ажлын нөлөөллийн хэмжээг тодорхойлох зорилгоор нэмэлт судалгааны ажил хийх

Нүүлгэн шилжүүлэх ажлын нөлөөллийг тодорхойлсон бол төслийн удирдлагын алба дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Дэлхийн банкны үйл ажиллагааны багтай нүүлгэн шилжүүлэх бодлогын арга хэрэгсэл боловсруулах, бэлтгэх үйл явцын талаар ярилцах
- Засгийн газрын оролцогч яам, агентлагийн холбогдох албан тушаалтнуудтай яаралтай зөвлөлдөх
- Төслийн параметрууд, хүлээгдэж буй үр нөлөө, туслалцаа, шалгуур үзүүлэлт, эрх олгох хугацааг тодорхойлсон төслийн мэдээллийн бюллетенийг монгол, англи хэлээр боловсруулах (Арга хэрэгсэл 3-ыг үзнэ үү)
- Нөлөөлөлд өртөж болзошгүй хүмүүстэй уулзах, бюллетенаар дамжуулан төслийн мэдээллийг тараах
- Нөлөөлөлд өртөх хүмүүсийн тооллого, хөрөнгийн хохирлын судалгааг гүйцэтгэх (Арга хэрэгсэл 3 буюу Тооллогын судалгаа, хөрөнгийн тооллогын асуумжийг үзнэ үү).
- Орлуулах өртгийн тооцоог эргэн хянах, 9 дүгээр хэсэгт үзүүлсний дагуу шаардлагатай үнэлгээний судалгааг хийх
- Дэлхийн банкны “Байгаль орчин, нийгмийн стандарт”, НШБХ-тэй нийцүүлэн Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний төслийг боловсруулах. Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний тоймыг арга хэрэгсэл 4-д үзүүлсэн болно. Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөнд төслийн нөлөөнд автах хүмүүсийн шинж байдал, хөрөнгийн тооллого, эрхийн матрицын төсөл (арга хэрэгсэл 2-т үзүүлсэн НШБХ-ний матрицыг боловсронгуй болгох), Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний үр дүнд бий болох үр нөлөөг бууруулах төсөв багтсан байна.
- Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний төслийн талаарх мэдээллийг ил тод болгох, төслийн мэдээллийн бюллетенийг шинэчилэх.
- Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг эцэслэн зээлдэгч тал Дэлхийн банкаар батлуулах
- Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний эцсийн хувилбарыг зээлдэгч тал болон Дэлхийн банкны цахим хуудсанд байршуулах
- Төслийн нөлөөнд автсан талуудын эрхийн матриц, нөхөн төлбөрийн хэмжээ, олгох хугацаа, олгох газар, төлбөрийн хэлбэрийг боловсруулах
- Төслийн нөлөөнд өртөх талуудын эрхийг шилжүүлэн авах
- Хандивлагч, санхүүжүүлэгчдэд тодорхой давтамжтайгаар тайлан гаргах
- Төслийн нөлөөнд өртөх талуудын болон олон нийтийн оролцоонд хяналт-шалгалт хийх, үр дүнг нь хэвлэх

Төлөвлөгөө батлагдсаны дараа урьдчилан тооцоолоогүй үр дагавар гарч ирвэл дахин суурьшлын төлөвлөгөөг шинэчилэн боловсруулж, энэ талаар талуудтай зөвлөлдөн, мэдээлийг ил тод болгоно. Боловсруулсан дахин суурьшлын төлөвлөгөөг Дэлхийн банк хянана.

6. Урьдчилан тооцоолсон хүн амын шилжилт

Төсөл нь нийслэл Улаанбаатар хотод хэрэгжинэ. Бүрэлдэхүүн хэсэг болох 1.1 нь Улаанбаатар хотын сийрэг, уялдаа холбоогүй гудамжны сүлжээг боловсронгуй болгох, одоогийн авто замын орон зайн ашиглалтыг үр өгөөжтэй болгох, түгжрэлийг бууруулах, уур амьсгалын тогтвортой байдал, замын аюулгүй байдлыг сайжруулахад чиглэж байна. 1.1 болон 4 дүгээр бүрэлдэхүүн хэсэгт зориулж НШБХ-г боловсруулсан юм.

НЗДТГ нь нотолгоонд суурилсан тээврийн дэд бүтцийн хөрөнгийн менежментийн арга хэрэгсэл, практикийг ашиглан нэн тэргүүнд шаардлагатай байгаа замын хэсэг, уулзварыг сонгох, зэргэлдээ орших гудамжуудыг коридороор холбон үр ашгийг нь сайжруулах, интервенц хийхийн зэрэгцээ 3.1 дүгээр бүрэлдэхүүн хэсэгт тусгагдсан өмнө нь хийгдсэн болон ирээдүйд хийгдэх ТТ шинжилгээний ажлын арга зүй, зөвлөмжийг боловсруулна.

Ялангуяа бүрэлдэхүүн хэсэг 1.1, Ухаалаг тээврийн камер хяналт бүрэлдэхүүн 1.2-т дурдагдсан (өмнөх ТТ) замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналт шалгалтын үр дүн, бүрэлдэхүүн хэсэг 3.1-т тусгагдсан зөрчлийн болон ослын дүн шинжилгээ зэрэгт үндэслэн дэд бүтцийг сайжруулахын зэрэгцээ уулзвар, замын хашлага, явган хүний зам, эгнээ, замын хөдөлгөөний тэмдэг, тэмдэглэгээ, гэрлэн дохио, нийтийн тээврийн буудал станц руу нэвтрэх зэргийг анхааран эмзэг бүлгийн ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд, хөгшид, явган зорчигчийн аюулгүй байдлыг сайжруулна.

Бүрэлдэхүүн хэсэг 3.1-д багтсан ЗХМТ нь холбогдох тээврийн хөрөнгийн засвар үйлчилгээ, удирдлагын асуудлуудыг шийдвэрлэх бол бүрэлдэхүүн хэсэг 1.1-т коридортой холбоотой дэд бүтцийн зураг төслийг боловсруулах, мөн ус зайлуулах хоолой, хучилтын ажлыг сайжруулж мөстөх, үерт автах зэрэг эрсдэлийг бууруулахад чиглэж байна

7. Шалгуур үзүүлэлт

Төсөлтэй холбоотой нүүн шилжих хүмүүсийн дараах ангилал бий. Үүнд:

- Барилга байгууламж, үндсэн хөрөнгийн өмчлөгч, хэрэглэгч
- Коридорын ойролцоо байрладаг барилгын ажлын үр нөлөөг мэдэрч буй хохиролд түр хугацаагаар орох өмчлөгч, байгууллагууд

Төслийн нөлөөнд өртөх хүмүүс болон өмчийг тодорхойлох шалгуур үзүүлэлт бий. Нүүлгэн шилжүүлэх нийт хүмүүсийг дараах гурван бүлгийн аль нэгэнд нь хамааруулна. Үүнд: (а) газар өмчлөх албан ёсны эрх бүхий хүмүүс (тухайн улсын хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн уламжлал, зан заншлын эрх орно); (б) тооллого эхлэх үед газар эзэмших хуулийн дагуу албан ёсны эрхгүй ч нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөнд зохих ёсоор тодорхойлогдсон, тухайн нутаг дэвсгэрийн хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн, газар, эд хөрөнгийг нэхэмжлэгч;

(в) хууль ёсны эрх нь хүлээн зөвшөөрөгдөөгүй буюу тухайн оршин сууж буй газраа нэхэмжлэл гаргах эрхгүй хүмүүс.

Тэмдэглэл: (1) Хохирол нь түр зуурын эсвэл байнгын байж болно; (2) нүүлгэн шилжүүлэх дэмжлэг гэсэн нэр томъёо нь нүүлгэн шилжүүлэх зардал, эсвэл шинээр шилжин очих газарт хийх бэлтгэлтэй холбоотой амьжиргааны үйл ажиллагааг эхлүүлэх зардал гэсэн утгыг илэрхийлнэ.

Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө нь нөлөөлөлд өртсөн хүмүүсийн алдах хөрөнгийг орлуулах, амьжиргааны түвшин, орлогоо нөхөн сэргээхэд хангалттай боломжоор хангах болно. Цаашилбал, төлөвлөлт нь нөлөөлөлд өртсөн хүмүүсийг хүйс, нийгмийн байдал, хэл, бусад шалгуураар ялгаварлан гадуурхахгүй байна. Дээрх зорилгод хүрэхийн тулд төслийн удирдлагын алба нөлөөлөлд өртөх бүх хүмүүсийг тодорхойлж, тухайн нөлөөлөлд өртөх хүмүүс Нүүлгэн шилжүүлэх Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөнд тусгасан нөлөөлөл бууруулах арга хэмжээг хүртэх эрхтэй гэж үзнэ.

Газрын бус өмчийн хохирлыг түр зуурын болон байнгын гэж хоёр ангилан төслөөс үүдэн бий болох нөлөөллийг дараах байдлаар ангилна. Үүнд:

- Хувь хүний бизнес, орлого
- Мэдээлэл ил тод болох, зөвлөлдөх явцад Монгол Улсын хууль тогтоомж болон Байгаль орчин, нийгмийн стандартад (ESS5)-т хүлээн зөвшөөрөгдсөн амьжиргааны элементүүд, бусад өмчийг тодорхой болгож болно.

Өөрийн хүсэл зоригоос үл хамааран дээр дурдсан шалтгааны улмаас хохиролд орсон хүмүүсийг нүүлгэн шилжүүлэх шалгуур үзүүлэлтийг хангасан хэмээн үзэж хугацааг товлон. Төслийн товлосон хугацаанаас хойш аливаа зөрчил, үйл ажиллагаанаас үүдэн гарах хохирлыг төсөл хариуцахгүй.

8. Үнэлгээний арга зүй

“Орлуулах өртөг” гэдэг нь хөрөнгийг орлуулан тооцоход шаардлагатай хангалттай хэмжээний нөхөн олговор олгох үнэлгээний арга бөгөөд дотроо хөрөнгө орлуулахтай холбоотой шилжүүлгийн зардлыг агуулсан байдаг. Үйл ажиллагаа эрхлэх зах зээл байгаа тохиолдолд орлуулах өртөг нь үл хөдлөх хөрөнгийн бие даасан, өрсөлдөх чадварын үнэлгээгээр дамжуулан зах зээлийн үнэлгээ болж түүн дээр шилжүүлгийн зардлыг нэмж тооцдог. Үйл ажиллагаа эрхлэх зах зээл байгаа тохиолдолд орлуулах өртөг нь үл хөдлөх хөрөнгийн бие даасан, өрсөлдөх чадварын үнэлгээгээр дамжуулан зах зээлийн үнэлгээ болж түүн дээр шилжүүлгийн зардлыг нэмж тооцдог. Үйл ажиллагаа эрхлэх зах зээл байхгүй тохиолдолд нөхөн олговрын өртгийг өөр аргаар тодорхойлно. Тухайлбал газар, бүтээмж бүхий хөрөнгө, газрын гарцын өртгөөр тооцох; хөрөнгийн гарцын өртөг тооцох; орлуулах материалын холбогдох өртөг болон барилга байгууламж эсвэл бусад үндсэн хөрөнгийг барихад зарцуулсан хөдөлмөрөөр тооцох аргыг ашиглаж болох бөгөөд үүн дээр шилжүүлгийн зардлыг нэмж тооцно. Бодит биетийн нүүлгэн шилжүүлэлт нь орон байргүй болоход хүргэх бүх тохиолдолд орлуулах өртөг нь дор хаяж олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн чанар, аюулгүй байдлын хамгийн бага стандарт шаардлагад нийцсэн орон

сууц худалдан авах эсвэл барихад хүрэлцэхүйц байх шаардлагатай. Нөлөөлөлд өртсөн хөрөнгө түүний үнэ цэнийг Нүүлгэн шилжүүлэх Нүүлгэн шилжүүлэх бодлогод нийцүүлэн олон нийтийн хэлэлцүүлгийн явцад бүрэн тодорхойлно. Үүнтэй адил зүйлийг орлуулах, алдагдсан хөрөнгө, орлогыг орлуулах өртөг, амьжиргааг бүрэн сэргээх зарчмуудыг дахин суурьшлын бодлогод ашиглана.

Үнэлгээний баг нөлөөлөлд өртсөн бүх хөрөнгийг харьцуулж болох хөрөнгийн зах зээлийн үнэлгээнд үндэслэн орлуулах өртгөөр тооцож нөхөн олгоно. Үнэлгээний багт дараах мэргэжилтнүүд багтана. Үүнд: нүүлгэн шилжүүлэх асуудал хариуцсан мэргэжилтэн; Өмчийн харилцааны болон Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын өмчийн үнэлгээний мэргэжилтнүүд; мөн нөлөөлөлд өртсөн байгууллагуудын болон хүмүүсийн төлөөлөл зэрэг болно. Үнэлгээний багийг байгуулахдаа Дэлхийн банкны үйл ажиллагааны багтай зөвлөлдөнө. Төслийн удирдлагын алба нь газрын бус хөрөнгө, хохирлын өртгийг тооцоолох үйл явцыг хөнгөвчлөх, хяналт тавих үүрэгтэй. Төслийн нөлөөлөлд өртөх хүмүүстэй тохиролцох явцад нөхөн олговрын хувь хэмжээтэй холбоотой санал зөрөлдвөл төслийн удирдлагын алба нь хараат бус хувийн үнэлгээний мэргэжилтэнг татан оролцуулж, нөхөн төлбөрийн хэмжээг дахин үнэлж үр дүнг нь нөлөөлөлд өртөх хүмүүст эргэн мэдээлнэ.

Дэлгүүр, барилга байгууламж, газар, байшин. Нөлөөлөлд өртсөн айл өрхүүд зах зээлийн үндсэн үнэ ханш, шилжүүлгийн үнэ, буулган авах материалын үнэ зэрэгт үндэслэн орлуулах өртгийг тооцуулан нөхөн олговор авна. Төсөл эхлэхээс өмнө дахин суурьшлын бодлогод үнэ өртгийн тооцоог тусган оруулах бөгөөд 12 сараас бага хугацаанд тухайн тооцоог ашиглана.

Орлогын байнгын хохирол. Ажилчдын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 сарын хугацаанд алдсантай дүйцэх хэмжээний орлогын тэтгэмж

Орлогын түр зуурын хохирол. Татварын баримт болон бусад хүчин төгөлдөр баримт бичигт үндэслэн тооцоолсон эсвэл боломжгүй бол төсөл хэрэгжиж буй газар нутгийн авто замын бизнес эрхлэгчдийн олдог дундаж цэвэр орлогыг үндэслэн гэрээнд тусгах түр зогсолтын үеийн цэвэр орлогын алдагдалтай дүйцэх хэмжээний нөхөн олговор юм

9. Хэрэгжилтийн үйл явц

Шударга байдлыг хангах үүднээс Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулахдаа газар чөлөөлөх, нөхөн олговор олгохтой холбоотой бүхий л үйл ажиллагааг хэрэгжүүлэх цаг хугацааны хуваарийг тусгана. Нөлөөлөлд өртсөн иргэнд дасан зохицох, нүүлгэн шилжүүлэх хугацаа олгохын тулд барилгын ажил эхлэхээс өмнө нөхөн олговрыг олгоно. Хөрөнгийн үнэлгээ хийснээс хойш нөхөн олговрын төлбөр хийх хугацаа нэг болон түүнээс дээш жилээр хойшлогдвол инфляц, бусад зардлын хүчин зүйлсийг харгалзан нөхөн олговрын хэмжээг дахин хянаж, шаардлагатай гэж үзвэл бол дахин тохируулга хийнэ. Шилжүүлгийг тохиролцсон боловч үндэслэлтэйгээр хойшлуулах шаардлага урган гарвал тухайлбал өмчлөгчийг эрж олоход бэрхшээл үүсэх зэрэгт нөхөн олговрын хэмжээг аль болох богино хугацаанд олгох зорилго дэвшүүлэн Засгийн газрын нөхцөлт (эскроу) дансанд байршуулна. Хууль ёсны нэхэмжлэгчдэд нийт мөнгийг хуримтлагдсан хүүгийн хамт өгнө. Энэ нь эзэмшигч талд ямар нэгэн сөрөг үр дагавар үүсгэхгүйгээр төсөл үргэлжлэх боломжийг олгоно.

10. Албадан нүүлгэн шилжүүлэлтийн зөвлөлдөх уулзалт, ил тод байдал, зохион байгуулалт

Төслийн бүхий л асуудлыг талуудын оролцоог ханган төлөвлөгөөнд (ТОХТ) тусгаж, энэ хэсэгт нүүлгэн шилжүүлэхээс үүдэн бий болох нөлөөлөлтэй холбоотой асуудлаар зөвлөлдөх/мэдээллийн ил тод байдлыг хангах талаар тусгасан байна. Нүүлгэн шилжүүлэх төлөвлөлтийн үе шатанд үндсэн зөвлөлдөх арга хэмжээ болох институцийн болон арилжааны гол мэдээлэгчидтэй уулзалт хийх; Төслийн мэдээллийн товхимол боловсруулах, түгээх; төслийн сөрөг нөлөөлөлд өртөх талуудыг тодорхойлох, тооллогын судалгаа зохион байгуулах; иргэд хэрхэн оролцох, хохирлоо хэрхэн барагдуулах тухай мэдээллийг тараан Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний эхний хувилбарыг олон нийтэд мэдээлнэ. Нүүлгэн шилжүүлэх үйл явцын нөлөөлөл, бусад зохицуулалтын талаар нөлөөлөлд өртсөн хүмүүстэй шууд зөвлөлдөнө.

Төлөвлөлтийн үе шатны гол гарцын үр дүн нь нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний зөвшилцөлд хүрэх, зөвлөлдсөний үр дүнд ирээдүйд хийгдэх үйл ажиллагааг нэгтгэн дүгнэх, зөвлөлдөх үйл явцыг төлөвлөх зэрэг болно. Бусад гарцын үр дүнд олон нийтийн хэлэлцүүлэгт оролцсон хүмүүсийн гарын үсэг бүхий бүртгэл, бүх зөвлөлдөх уулзалтуудын шийдвэр, шийдвэрийн тойм зэргийг багтаасан байна.

Төслийн удирдлагын алба нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний төслийг боловсруулан олон нийтэд тараах, эцсийн шатанд бэлэн болсон бодлогыг төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт амьдарч буй төслийн сөрөг нөлөөнд өртөх иргэд болон нийт иргэдийн дунд цахим хуудсаар болон мэдээлэл авах боломжтой байршлаар дамжуулан хэвлэмэл байдлаар тараана. Ирээдүйд хийгдэх бүхий л үйл ажиллагааг Банктай хамтран хэрэгжүүлэхээс гадна нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний төслийг Дэлхийн банкинд доор хаяж нэг сарын өмнө хянуулахаар илгээнэ. Банк хүлээн зөвшөөрсний дараа дахин суурьшлын бодлогын эцсийн хувилбарыг нийтэд мэдээлнэ.

Зөвлөлдсөний үндсэн дээр НШБХ болон БОНМХ-г ил тод болгоно. Дэлгэрэнгүй мэдээллийг БОНМХ-нээс уншина уу.

11. Газар шилжүүлэхтэй холбоо бүхий өргөдөл, гомдол барагдуулах

Өргөдөл, гомдлыг барагдуулах механизмын талаар оролцогч талуудын хамтын ажиллагааны төлөвлөгөөнд тодорхой бичсэн бөгөөд засгийн газраас одоо мөрдөж буй журамд нийцүүлэн төсөлтэй шууд холбоотой асуудлаарх өргөдөл, гомдлоо (шууд утсаар, биечлэн, бичгээр) Төслийн удирдлагын албанд хүргүүлнэ. Ямар ч Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөнд өргөдөл, гомдол барагдуулах механизм багтсан байна (доорхийг харна уу). Аливаа нүүлгэн шилжүүлэлтийн сөрөг үр дагавраас зайлсхийх зорилгоор өргөдөл, гомдол барагдуулах дараалал, дамжлагыг шинээр боловсруулахаас гадна төслийн урьдчилан сэргийлж болохуйц үр дагаврыг багасгах зорилгоор орон нутгийн өргөдөл, гомдол барагдуулах механизмыг давхар ашиглана. Өргөдөл, гомдол хүлээн авах үйл явцыг дараах байдлаар зохион байгуулна (ТОХТ-өөс өргөдөл, гомдол барагдуулах талаар дэлгэрүүлэн үзнэ үү).

Түвшин 1:

Төслийн удирдлагын алба, хоёр утас, 24/7 цагийн турш ажиллах дуудлагын төвөөр дамжуулан төслийн үйл ажиллагаатай холбоотой санал, гомдлыг хүлээн авахаас гадна барилгын ажлын зарлалын самбар, өргөдөл, гомдол барагдуулсан тухай брошур, төслийн сөрөг нөлөөнд автсан хүмүүст илгээх захидлаар дамжуулан санал, гомдлын хариуг илгээнэ. Өргөдөл, гомдол гаргагч нь мөрдөгдөж буй механизмын дагуу өргөдөл, гомдлоо бичгээр эсвэл өөрийн биеэр өгч болно. Дуудлагын төвд ирүүлсэн гомдлыг төслийн удирдлагын албанд шууд хүргүүлнэ. Ажлын бус цагаар хүлээн авсан санал, гомдлыг маргааш нь төслийн удирдлагын албанд мэдээлнэ. Төслийн удирдлагын алба дотоод хэлтэс эсвэл барилгын ажил гүйцэтгэгч компанитай хамтран асуудлыг 7 хоногоос доошгүй хугацаанд аль болох хурдан шийдвэрлэх эсвэл гомдлыг хоёрдугаар түвшинд шилжүүлсэн талаар гомдол гаргагчдад эргэн мэдээлнэ.

Түвшин 2:

Хэрэв төслийн удирдлагын алба өргөдөл, гомдлыг 7 өдрийн дотор шийдвэрлэж чадаагүй бол тухайн өргөдөл, гомдлоо НЗДТГ-т илгээн 15 өдрийн дотор тухайн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэнэ. Хэрэв эвлэрүүлэн зуучлах ажиллагаа үр дүнд хүрээгүй, гаргасан шийдвэрт сэтгэл дундуур байгаа бол сөрөг нөлөөлөлд өртсөн талууд хөндлөнгийн шинжээчид хандах эсвэл Монгол Улсын хууль тогтоомж, журмын дагуу Монгол Улсын шүүхийн системээр дамжуулан бичгээр болон аман хэлбэрээр гомдлоо гаргаж болно.

12. Санхүүжилт, институцийн зохион байгуулалт

НЗДТГ-ын дэргэд төслийн удирдлагын алба хэрэгжүүлэгч байгууллагуудтай нягт хамтран зохицуулалт хийж ажиллана. Төслийн зээлдэгч нь нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой зардлын асуудлаар хурал зохион байгуулах үүрэг хүлээнэ. НШБХ-нд Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулах бөгөөд төлөвлөгөөг хэрэгжүүлэх төсөвтэй байна.

Нөлөөлөлд өртсөн газар, эд хөрөнгийн тооллогын үеэр төслийн сөрөг нөлөөлөлд өртсөн бүх хүмүүсийг тодорхойлох ёстой боловч алдаа гарсан, орхигдуулсан тохиолдолд эсвэл тооллогын судалгаа эхлэх үед хууль ёсны нэхэмжлэл гаргах эрхтэй байсан боловч нүүлгэн шилжүүлэлт төлөвлөлт хийсний дараа нэхэмжлэл гаргасан хүмүүст санхүүжилтийг анхнаас нь хуваарилаагүй байсан ч нөхөн төлбөр олгоно. Эдгээр болон гарч болзошгүй бусад гэнэтийн зардлыг тооцох зорилгоор нийт өртгийн 10 хувьтай дүйцэхүйц хэмжээний гэнэтийн зардлыг НШТ-нд тусгана. Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөнд тусгасан нөхөн төлбөрийн хэмжээ нь нөхөн төлбөрийн хувь хэмжээг тооцох үндэслэл болно. Төслийн сөрөг нөлөөнд өртсөн хүн эсвэл газар, бусад хөрөнгө, орлогоо алдаж буй хүмүүст барилгын ажил эхлэхээс өмнө нөхөн төлбөрийг бүрэн хэмжээгээр нь олгоно. Төслийн удирдлагын алба нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий аюулгүй ажиллагааны мэргэжилтэнтэй байна.

НШТ-ний төсөвт дараах зүйлсийг багтаана. Үүнд:

- Захиргааны зардал:

- Захиргааны зардал, тоног төхөөрөмж, нөөц хангамж
- Тээвэр
- Зар сурталчилгаа, хэвлэмэл бүтээгдэхүүн

Нүүлгэн шилжүүлэх зардал:

- Төслийн сөрөг нөлөөнд өртсөн иргэдийн зөвлөлдөх уулзалтын зардал (тээврийн/интервенцийн)
- Төслийн нөлөөнд өртсөн барилга байгууламж, өмчийн нөхөн төлбөрийн зардал
- Төслийн сөрөг нөлөөнд өртсөн өрхийн нөхөн олговор
- Дахин суурьшихад үзүүлсэн дэмжлэг
- Шилжүүлгийн зардал (нотариат, кадастрын зураг, өмч бүртгэлийн зэрэг үйлчилгээний зардал)
- Боломжит эмзэг байдал, урьдчилан тооцоогүй гэнэтийн зардал зэрэг нь дээрх нийт үнийн дүнгийн арван хувь болно.
- Нэхэмжлэлийн нөхөн төлбөрт шинжилгээ хийх зардал

Ямарч шалтгаанаар нөхөн олговрыг хасч тооцохгүй. НШТ нь НЗДТГ-ын шилжүүлгийн бүртгэл, төслийн сөрөг нөлөөнд автсан хүмүүст олгох нөхөн олговрын сангийн урсгалын явцыг ил тод мэдээлнэ. Өрхийн эхнэр, нөхрийн хоёулангийнх нь гарын үсгийг зуруулж авахыг зөвлөж байна.

13.Албадан нүүлгэн шилжүүлэлтийн хяналт-шинжилгээ

Энэ хэсэг нь Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөнд хамаарах хяналт-шинжилгээний шаардлагуудтай уялдана. Хяналт-шинжилгээ хийх нь зээлдэгчийн үүрэг юм. Төслийн удирдлагын алба Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний нийцэлд хяналт-шинжилгээ хийж төслийн явцын хагас жилийн тайланг Дэлхийн банканд илгээнэ. Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тус бүр хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлттэй байна.

Төслийн удирдлагын алба Дэлхийн банктай байгуулсан зээлдэгчийн гэрээнд заасан шалгуур үзүүлэлт болох НШТ-ний явцын тодорхой давтамжтай илгээх тайланг боловсруулахдаа дараах зүйлийг хянана. Үүнд:

- Бодлогын зорилтыг хангах үүднээс НШТ-нд өөрчлөлт оруулах шаардлагатай асуудал үүссэн эсэх
- Нүүлгэн шилжүүлэх үйл явц, түүний дотор төслийн бlyютенийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах
- Төслийн сөрөг нөлөөнд автсан хүмүүстэй зөвлөлдөх хуваарь
- Нүүлгэн шилжүүлэх бодлогын зөвлөлдөх уулзалтад оролцогчдын гарын үсгийн жагсаалт, оролцоог баталгаажуулах гэрэл зураг болон бусад баримтууд

- Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний хэлэлцүүлгийн тэмдэглэл, шийдвэр
- Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэсэн явц, үр дүн
- Газар шилжүүлэх, газрын зориулалт өөрчлөх зэрэг төсөлтэй холбоотой аливаа өөрчлөлтийн бүртгэлийн албан ёсны хуулбар
- Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний төлбөрийн нэхэмжлэл, нэхэмжлэлийн матрицын шинэчилсэн хэлбэр
- Нэхэмжлэлээр нөхөн төлбөр олгосон санхүүжилтийн дүгнэлт



Арга хэрэгсэл 1: Орон сууц, хүн ам, хөрөнгийн тоолого

УБ ХОТЫН ТОГТВОРТОЙ АВТО ЗАМ, ТЭЭВЭР ТӨСӨЛ ӨРХИЙН ХҮН АМЫН ТООЛЛОГЫН АСУУМЖ

Огноо:

--	--	--	--	--	--	--

 Асуулгын дугаар:

--	--	--	--	--	--	--	--	--	--

1. ТӨСЛИЙН СӨРӨГ НӨЛӨӨНД ӨРТСӨН ӨРХИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Асуумжийг байгууламж| хөрөнгө эзэмшигч тус бүрээр бөглүүлнэ(бизнес эрхлэгч тус бүр нэг асуумж бөглөнө г.м).

1.1 Эзэмшигчийн нэр (Банкны данс дээр тэмдэглэгдсэн нэр).....

.....

1.2 Бусад нэр/Товчилсон нэр:

.....

1.3 Хороо:

1.4 Байршил (гудамж/тоот):.....

.....

1.5 Хохирлын хэлбэр бүртгэлтэй нийцсэн байх #.....

ТӨСЛИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ

2. Та дараа жил хэрэгжиж эхлэх “УБ хотын тогтвортой тээвэр төсөл”-ийн талаар мэдэх үү?

Тийм Үгүй

Хэрэв судалгаанд оролцогч төслийн хэрэгжилтийн талаар ойлголтгүй бол холбогдох товч мэдээллийг өгнө үү.

ӨРХИЙН ХОХИРЛЫН ХЭЛБЭР

3. Танай өрхөд ямар хэлбэрийн хохирол үүсэх вэ?

- Бизнес,
- Хөрөнгө (хашаа болон бусад);
- Барилга байшин (оршин суудаг болон эзгүй байшин)
- Орлого (дэлгүүр ажиллуулагч г.м)
- Газар (Тодорхой дүрсэлнэ үү)

Бусад (Тодорхой дүрсэлнэ үү)

ХҮН АМ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ

Өрхийн байдал					
	Эрх зүйн чадамж	Оршин суугч	Аюулгүйн бүсээс 10 метрийн зайд түр оршин суугч (хууль бусаар)	Зөрчилтэй (хувийн газар дээрх байгууламж болон 10 метрийн доторх)	Бусад
3.1					

3.2 Хэрэв түр оршин суугч болон түрээслэгч бол үндсэн өмчлөгчийн овог нэр, хаягийг бичнэ үү.

3.3 Өрхийн гишүүдийн тоо (нэг дээвэр доор амьдарч буй):.....

	Өрхийн гишүүдийн нэрс	Хүйс	Нас	Боловсрол (6 наснаас дээших хүмүүсийн)	Эдийн засгийн идэвх	Өрхийн тэргүүлэгч тэй ямар хамааралт ай вэ?	Гэрлэлтийн байдал
3.4							
3.5							
3.6							
3.7							
3.8							
3.9							
3.10							

Код: Хүйс: 1= Эр, 2= Эм

Боловсрол: 1= Бичиг үсэгтэй, бага сургууль төгссөгүй

2= Бүрэн бус дунд (1-9 анги төгссөн)

3= Бүрэн дунд (10-12 анги төгссөн)

4= Бүрэн дундаас дээш боловсрол (Сертификатын түвшин, түүнтэй дүйцэхүйц)

5= Бакалавр болон түүнээс дээш

6= Бичиг үсэг үл мэдэгч

Гэрлэлтийн байдал: 1=Гэрлэсэн

2=Гэрлээгүй

Эдийн засгийн идэвх: 1=Төрийн байгууллагад ажилладаг, 2=Хувийн хэвшилд ажилладаг, 3=Бизнес

эрхэлдэг, 4=Мал аж ахуй эрхэлдэг, 5=Оюутан, 6=Ажил хийдэггүй, 7=Бусад бол түүнийгээ дурдана уу.

ӨРХИЙН ОРЛОГО

4. Төсөл хэрэгжих нь танай орлогод нөлөөлөх үү?

Тийм:(учир нь)

Үгүй:.....(учир нь)

Өрхийн орлогын эх үүсвэр

4.1	Орлогын гол эх үүсвэр		1 Ажилтан (дэлгүүрийн ажилтан г.м)	6 Конторын ажилтан
4.2	Орлогын нэмэлт эх үүсвэр		2 Төрийн байгууллагын ажилтан	7 ХАА-н салбарт ажиллагч
			3 Бизнес/ Дэлгүүрийн эзэн	8 Тэтгэвэрт/Шилжүүлэг хүлээн авагч
			4 Түрээслэгч	9 Бусад (тодорхой бичнэ үү)
			5 Биеийн хүчний ажил	

Өрхийн нэг сарын орлого

	Орлогын эх үүсвэр	Өрхийн нэг сарын орлого тус бүр монгол төгрөгөөр
4.3	Үндсэн	
4.5	Нэмэлт	
4.6	Нийт эх үүсвэр	

Нэг сарын дундаж орлого

	Өрхийн гишүүд	Өрхийн нэг сарын дундаж орлого монгол төгрөгөөр
4.7	Нөхөр	
4.8	Эхнэр	
4.9	Бусад гишүүд	
4.10	Нийт (гэр бүлийн бүх гишүүд)	

ӨРХИЙН ЗАРЛАГА

Өрхийн зарлага

	Зарлагын төрлүүд	Жилийн зарлага монгол төгрөгөөр	Сарын зарлага монгол төгрөгөөр
5.1	Хоол хүнс		
5.2	Хувцас		
5.3	Сургуулийн төлбөр, ном, бичиг хэрэг г.м		
5.4	Эм тариа/эмч/эмнэлгийн үзлэг		
5.6	Тээвэр, харилцаа холбоо г.м		
5.7	Тэмдэглэлт өдрүүд		

5.8	Бусад		
5.9	Нийт зардал		

Анхаарах зүйл: Хэрэв зарлага нь орлогоосоо хамаагүй өндөр байвал шалтгааныг тайлбарлана уу.

ТУСЛАМЖ АВАХ ТАЛААРХ САНАЛ БОДОЛ

6.1	Орон гэрээ шилжүүлэн суурьшуулах газар бий юу?		1 Суурьших газар бий 2 Суурьших газаргүй 3 Суурьших газар олоход дэмжлэг хэрэгтэй байна
6.2	Орон гэрээ\өмчөө өөр газар шилжүүлэн суурьшуулахад дэмжлэг хэрэгтэй юу?		1 Нүүхэд дэмжлэг хэрэгтэй 2 Нүүхэд дэмжлэг хэрэггүй
6.3	Барилгын ажил эхлэхээс өмнө төслийн зүгээс туслах талаар та ямар бодолтой байна вэ?		Дэмжлэг хэрэггүй Дэмжлэг хэрэгтэй (тодорхой дүрслэх)

6.4 Танд төслийн талаар санал бодол бий юу? (Жагсаан бичнэ үү?)

6.5 Анхаарах асуудлууд:

Судалгаа авсан хүний гарын үсэг/тамга тэмдэг



**УЛААНБААТАР ХОТЫН ТОГТВОРТОЙ АВТО ЗАМ, ТЭЭВЭР ТӨСӨЛ
ХОХИРЛЫН БҮРТГЭЛИЙН ХҮСНЭГТ**



Огноо:

--	--	--	--	--	--

Хүснэгтийн дугаар:

--	--	--	--	--	--	--	--

1. ЭЗЭМШИГЧИЙН ТАЛААРХ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

**Хэрэв эзэмшигч тодорхойгүй бол хүснэгтэд бусад мэдээллийг дэлгэрэнгүй бичээрэй. Хэрэв улсын мэдлийн дэд бүтэц бий бол асуулт 6-д хариулна уу. Асуулгыг барилга байшин|өмч эзэмшигч тус бүрээр бөглөнө үү. (Бизнес эзэмшигч тус бүр нэг асуулга бөглөнө.)*

1.1 Эзэмшигчийн нэр\компани (Банкны данс дээр тэмдэглэгдсэн нэр):.....
.....

1.2 Бусад нэр/товч нэр:

1.3 Хороо:

1.4 Байршил (гудамж/тоот):.....
.....

Байгууламж

2. Барилгын ажил байшин барилгад нөлөөлөх үү? Тийм Үгүй

Төслийн үйл ажиллагааны нөлөөнд автах барилга, байгууламжийг жагсаан бичнэ үү?

No	Барилга байгууламжийн төрөл	Материалын хэлбэр	M2	Давхрын тоо	Барьсан жил	Байгууламжийн хэдэн хувьд нөлөөлөх	Тэмдэглэл
2.1							
2.2							
2.3							
2.4							
2.5							

Байгууламжийн төрөл: бизнесийн киоск/дэлгүүр, амьдардаг байшин, агуулах, олон нийтийн зориулалтын байр; бусад (тодорхой дүрслэн бичнэ үү)

Төслийн бүтээн байгуулалтад шууд өртөх өмч хөрөнгө байна уу?

3. Төслийн бүтээн байгуулалтад өртөх өмч хөрөнгө бий юу? Тийм Үгүй

Дд	Өмч хөрөнгийн хэлбэр	м2	т	Дд	Ашигласан материал	Насжилт	Тэмдэглээ
3.1							
3.2							
3.3							
3.4							
3.5							
3.6							

Өмч хөрөнгийн хэлбэр: хашаа, тоглоомын тоног төхөөрөмж, дээвэр, худаг, усны контайнер,бусад (тодорхой дүрслэнэ үү)

БИЗНЕСИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

4. Та дэлгүүр эсвэл бизнесийн зориулалтын барилгатай юу? Тийм Үгүй

- 4.1 Өөрөө эзэмшдэг, Хамтран, Түрээсэлдэг, Компанийн эзэмшлийн
- 4.2 Танд эзэмшигчийн баталгаа бий юу? Тийм Үгүй (зөвхөн өмч хөрөнгө бий)
- 4.3 Өмчлөлийн бичиг баримтын хэлбэр:
- 4.4 Энэ байршилд хэдэн жил бизнесээ эрхэлж байна вэ?
- 4.5 Хөрөнгийн өнөөгийн үнэлгээ монгол төгрөгөөр:
- 4.6 Бизнесийн тооцоологдсон өртөг\ дэлгүүр монгол төгрөгөөр:

5. БИЗНЕСИЙН МЭДЭЭЛЭЛ

	Бизнесийн төрөл	Бизнесийн татварын байдал		Ажиллаж буй хүмүүсийн тоо		Сарын ашиг	Өдрийн ашиг	Тэмдэглэл
		Бүртгүүлсэн	Бүртгүүлээгүй ч татвар төлдөг	Тогтмол	Улирлын			
5.1								
5.2								
5.3								
5.4								

5.5 Хэрэв таны дэлгүүр төслийн үйл ажиллагааны нөлөөнд автвал танд орлогын өөр эх үүсвэр бий юу?

5.6 Танд орлогын бусад эх үүсвэр бий юу?

5.7 Танай гэр бүл бусад эх үүсвэрээс хэдэн төгрөгийн орлого олдог вэ? (хувь хэмжээ)?

6. БУСАД ДЭД БҮТЭЦ

Төслийн бүтээн байгуулалтад өртөх бусад дэд бүтэц бий юу? Төслөөс хамаарахаас бусад

	Дэд бүтэц	Тоо/ Нэгж	Талбай / урт	Материалын төрөл	Тооцолсон үнэ	Төрийн өмчийн
6.1						
6.2						
6.3						
6.4						
6.5						
6.6						

Дэд бүтэц: Сургууль, цахилгааны шон, төрийн байгууллага, улсын мэдлийн хашаа, бусад (тодорхойлон бичнэ үү)

Судалгаа авсан хүний тэмдэглэл:

Өмч хөрөнгө\ байгууламж эзэмшигчийн гарын үсэг:

Судалгаа авсан хүний нэр:

Судалгаа авсан хүний гарын үсэг

ФОТО ЗУРАГ ХАВСАРГАХ

(Эзэмшигч өмч хөрөнгө, барилга байгууламжийн урд зогсоод зургаа авхуулна.)

Тийм Үгүй

Арга хэрэгсэл 2: Эрхийн матриц

Монгол Улсын хууль тогтоомж, Дэлхийн банкны бодлогын зөрүүтэй байдлыг арилгахын тулд энэхүү Нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээнд эрхийн заалтуудыг боловсруулан тусгасан бөгөөд энэ нь Монгол Улсын хууль тогтоомж, Дэлхийн банкны шаардлагыг нэгтгэсэн бөгөөд зөрүүтэй тохиолдолд Дэлхийн банкны бодлогын шаардлагыг мөрдөн ажиллана. Төслийн хүрээнд боловсруулагдсан нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөнд нийцүүлэн энэхүү эрхийн матриц шинэчлэгдэж байна.

НШБХ-ний оролцогч талуудын эрхийн матриц

Хохирлын хэлбэр	Эрх бүхий тал	Эрх
Дэлгүүрийн барилга байшин (барилга байгууламжаа бүрмөсөн алдах)	Барилга байгууламж эзэмшигч	<ul style="list-style-type: none"> Барилга байгууламжийг орлуулах өртөг Шилжилтийн болон дахин суурьших тэтгэмж Өөр байрлалд дэлгүүр олоход нь дэмжлэг үзүүлэх
Тодорхой барилга байгууламж (барилга байгууламжаа бүрмөсөн алдах)	Барилга байгууламж эзэмшигч	<ul style="list-style-type: none"> Барилга байгууламжийг орлуулах нөхөн төлбөр Материалаа авах эрх Тээврийн нөхөн олговор
Барилга байгууламжийн хувилбар	Газар өмчлөгч, эзэмшигч, хууль ёсны оршин суугч	Хохирол амсах барилга байгууламжийн нөхөн төлбөр, барилга байгууламжийн үлдсэн хэсгийг сэргээн босгох ажлыг гэрээний үндсэн дээр элэгдэл хорогдлын хэмжээг суутгалгүйгээр зах зээлийн ханшаар төлнө.
Газар (бүр мөсөн алдах)	Газар ашиглагч\ эзэмшигч	<ul style="list-style-type: none"> Газрын өртгийг орлуулах Шилжих болон дахин суурьших төлбөр, үүнд нүүх зардал, энэ шилжилтийн хугацаанд /3-6 сар/ олж болох орлогын дэмжлэг Боломжтой бол өөр газар олоход нь дэмжлэг үзүүлэх
Бизнес	Түр хугацааны нөлөө үзүүлж буй байгууллагууд	Хохиролтой тэнцэх хэмжээний мөнгөний нөхөн олговор, өөрөөр хэлбэл үйл ажиллагаа түр зогсох хугацааны татвар/ бусад хүчин төгөлдөр баримт бичигт үндэслэх эсвэл боломжгүй бол төслийн бүс нутагт ажиллаж буй орон нутгийн бизнес эрхлэгчдийн дундаж цэвэр орлогыг үндэслэн олгох нөхөн олговор.
	Байнгын нөлөө үзүүлж буй байгууллагууд	Хохиролтой тэнцэх хэмжээний мөнгөний нөхөн олговор, өөрөөр хэлбэл үйл ажиллагаа түр зогсох хугацааны татвар/ бусад хүчин төгөлдөр баримт бичигт үндэслэх эсвэл боломжгүй бол төслийн бүс нутагт ажиллаж буй орон нутгийн бизнес эрхлэгчдийн дундаж цэвэр орлогыг үндэслэн олгох нөхөн олговор
	Нөлөөнд өртсөн байнгын түрээслэгч	<ul style="list-style-type: none"> Түрээслэх байсан хугацааны болон түрээсийн төлбөрийг нөхөн олгох, Түрээсээ шилжүүлэх тэтгэмж /3 сарын орлогын дэмжлэг гэх мэт/
Албан хаагч, ажилтнууд	Нөлөөнд өртсөн дэлгүүрийн халагдсан бүх ажилтнууд	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 сарын хугацаанд алдсантай дүйцэх хэмжээг орлогын тэтгэмж
	Нөлөөнд өртсөн бизнесийн	1-ээс доошгүй жил ажилласан ажилтан/албан хаагчдын 2 сарын цалин хөлсийг, бусад ажилтнуудад 1

Хохирлын хэлбэр	Эрх бүхий тал	Эрх
	халагдсан бүх түр зуурын ажилтнууд	сарын цалин хөлстэй дүйцэхүйц хэмжээний нөхөн олговор олгоно;
Эмзэг бүлгийн өрх	Тооллогын үед тодорхойлогдсон хөрөнгө эзэмших эрхгүй, эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй, өрхийн тэргүүн нь хөгжлийн бэрхшээлтэй, ядуу зэрэг эмзэг бүлгийн өрх	<ul style="list-style-type: none"> • Эмзэг бүлгийн өрхийн тэтгэмж, сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний байна. • Дахин суурьших, амьжиргаагаа дахин эхлүүлэх шаардлагатай зөвлөх үйлчилгээ, дэмжлэг
Түр хугацаагаар оршин суугч	Эзэмшигч, ашиглагч, газрын гэрчилгээгүй оршин суугч	<ul style="list-style-type: none"> • Коридорын ойролцоох газар дээрх хашаа, барилгын ажлыг буцааж эздэд нь шилжүүлэх зэрэг түр зуурын нөлөөлөлд өртсөн байгууллагуудтай тохиролцсоны үндсэн дээр бэлэн мөнгөөр нөхөн олгоно. • Нөлөөлөлд өртсөн аж ахуйн нэгжүүд газар болон оршин суух газраа үргэлжлүүлэн ашиглах боломжтой болно. • Барилгын ажлын гүйцэтгэгч компаниуд хашаагаа нүүлгэж, ажил дууссаны дараа газар, хашаагаа сэргээн засна.

Арга хэрэгсэл 3: Төслийн мэдээллийн товхимолын агуулга

Бүрэлдэхүүн хэсэг 1.1-д заасны дагуу нүүлгэн шилжүүлэх ажлыг эхлүүлж төслийн анхны мэдээллийн бюллетенийг англи, монгол хэлээр хэвлэн гаргана. Үүнийг олон нийтэд чиглэсэн энгийн, ойлгомжтой үг хэллэг ашиглан бичнэ. Бюллетеныг дараах агуулгаар шинэчлэнэ. Үүнд: (i) Нүүлгэн шилжүүлэх Нүүлгэн шилжүүлэх бодлогын төслийн ил тод байдлыг хангах, (ii) Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний төслийг эцэслэн олон нийтийн хүртээл болгох, (iii) төслийн эцсийн хяналт-шинжилгээний үр дүнг танилцуулах зэрэг болно.

Төсөл хэрэгжүүлэх явц, зам, нисэх онгоцны буудлын байгууламжийн үйл ажиллагаа, тэдгээрт хэвийн нэвтрэхтэй холбоотой үүссэн хязгаарлалтын талаар олон нийтэд мэдээлэх зорилгоор шаардлагатай бол бусад хугацаанд бюллетенийг хэвлэн гаргана.

Төслийн мэдээллийн бюллетений агуулгад нүүлгэн шилжүүлэх төлөвлөлтийн үе шатны дараах мэдээлэл багтана. Үүнд:

- Төслийн тодорхойлолт, Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд
- Төслийн үндэслэл, хүлээгдэж буй үр дүн
- Байгаль орчин, нийгэм эдийн засгийн үр нөлөө, сөрөг, эерэг үр дагавар
- Сөрөг нөлөөллийн нөхөн төлбөр
- Хамрагдах шалгуур-дахин суурьших иргэд, үр нөлөө
- Эрх авах үйл ажиллагааны эхний хугацаа
- Үр нөлөөний илрэх хэлбэр, тэдгээрийн тодорхойлолт
- Төлөвлөсөн зөвлөлдөх уулзалтуудын шинж байдал
- Төслийн сөрөг нөлөөнд автсан иргэнийг бүртгэх мэдээлэл
- Төлөвлөж буй фокус бүлгийн уулзалтын мэдээлэл
- Дараа дараагийн санал болгож буй үйл явцын шинж байдал
- Төлөвлөж буй өргөдөл, гомдол барагдуулах системийн тайлбар
- Тохиромжтой бол газрын зураг, үзүүлэх материал

Дахин суурьшлын бодлогын анхан шатны зөвлөлдөх уулзалт, өргөдөл, гомдол барагдуулах болон хяналт-шинжилгээний үйл явц зэрэг нь дараа хэвлэгдэн гарах бюллетений агуулгад тусгагдана.

Арга хэрэгсэл 4. Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний агуулга

- Төслийн тодорхойлолт
- Нүүлгэн шилжүүлэх зорилго
- Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын судалгаа
- Эрх зүйн хүрээ

- Институцийн үзэл баримтлал. Шалгуур үзүүлэлт
- Хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр
- Хэрэгжүүлэх хугацаа
- Өртөг, төсөв
- Өргөдөл, гомдол барагдуулах механизм
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ

ХАВСРАЛТ 2. Хөдөлмөрийн харилцааг зохицуулах журам

Хөдөлмөрийн харилцааг зохицуулах журам нь Монгол улсын холбогдох хууль тогтоомжууд болон Дэлхийн банкны байгаль орчны нийгмийн стандарт 2-т заасан заалтуудын тойм бөгөөд Улаанбаатар хотын тогтвортой автозам тээвэр (УБТАТ) төслийн бүрэлдэхүүн хэсгүүдэд хөдөлмөртэй холбоотой асуудлууд эрсдэлүүдийг төсөл хэрэгжүүлэх үед хэрхэн удирдаж зохион байгуулахыг заасан байдаг.

Төслийн үеийн хөдөлмөр харилцаа

Төсөл нь 2 үе шаттайгаар хэрэгжих ба эхний үе шатны үйл ажиллагаануудыг засгийн газрын хамтрагч байгууллагуудын хэрэгжилтийн бэлэн байдал болон дүн шинжилгээнүүдийн бэлэн байдал зэрэгт үндэслэн сонгоно. Эхний үе шатны явцад хэрэгжүүлсэн үйл ажиллагаануудаас үндэслэж бий болсон зөвлөмжүүд ололт амжилтууд нь төслийн 2 дугаар үе шатанд хэрэгжих үйл ажиллагаануудыг нарийвчлан тодорхойлдог. УБТАТ нь дараах 4 бүрэлдэхүүн хэсэгтэй:

- Бүрэлдэхүүн хэсэг 1: Цогц коридорууд
- Бүрэлдэхүүн хэсэг 2: Тогтвортой нийтийн тээврийн систем
- Бүрэлдэхүүн хэсэг 3: Зам, тээврийн төлөвлөлт ба менежментийн үр дүнтэй институцууд
- Бүрэлдэхүүн хэсэг 4: Болзошгүй, онцгой байдлын үеэр авах хариу арга хэмжээ

Төслийн үйл ажиллагаанд гурван төрлийн хөдөлмөрийн гэрээг хийх шаардлага гардаг. (i) Шууд ажилчид-Зээлдэгчийн харьяаны ажилчид, төслийн удирдлагын албаны ажилтнууд үүнд шууд оролцдог; (ii) Гурав дахь этгээдээр дамжуулсан гэрээт ажилчид, коридорыг хийж буй бүтээн байгуулалтын компанийн бүтээн байгуулалтын ажилчид болон техникийн мэргэжилтнүүд үүнд хамаарна; (iii) техникийн тусламж ба барилга байгуулалтын менежментэд оролцож буй гадаадын техникийн мэргэжилтнүүд. Тухайн газрын оршин суугчдаас ажилтан элсүүлж авах нь төсөлд хамаагүй ба мөн цагаач ажилчдыг оролцуулахыг урьдчилан тооцоогүй тул энэ нь төсөлд хамааралгүй бөгөөд коридорын ажилд орон нутагт ажиллаж байсан хөдөлмөрийн хүчийг оролцуулна. Төсөл хэрэгжүүлэх явцад дараах төрлийн болон тодорхой тооны ажилчдыг ажиллуулах тухай дор дурдсан байна. Цөөн тоон аюулгүй ажиллагааны ажилчдыг мөн ажиллуулна.

Бүрэлдэхүүн хэсэг 1.1-д шууд гэрээт ажилчид тухайн улсын болон шаардлагатай тохиолдолд өндөр үр чадвар бүхий гадаадын мэргэжилтэн хийж гүйцэтгэнэ. 1) тухайн газрын бэлтгэл ажлыг хангах ажилчид ба техникчид, бүтээн байгуулалтын компаниар дамжуулан оролцогчид зэрэг 50-100 ажилчныг оролцуулна гэсэн хүлээлт тооцоо байна. Төслийн удирдлагын албаны үндэсний техникийн мэргэжилтнүүд (ойролцоогоор 10 ажилтан) тэдгээрээс гадна олон улсын техникийн мэргэжилтнүүд, байгаль орчинтой холбоотой мэргэжилтнүүд нь зөвлөх үйлчилгээний компаниудаар дамжин оролцоно (гэрээт ажилчид) эдгээр нь ойролцоогоор 5-10 ажилчин байна. Төслийг хэрэгжих явцад эдгээр дэд төслүүдэд оролцох шууд ажилчид, гэрээт ажилчид, болон анхдагч материал нийлүүлэх ажилчдын тоо

нь тодорхой болоогүй байгаа хэдий ч багцаалсан тооцооллоор 50-150 ажилчид байх бөгөөд эдгээрт төслийн удирдлагын албаны ажилтнууд техникийн зөвлөхүүд зэргүүд нь бүтээн байгуулалтын үе шатуудын явцуудад багтан оролцох юм.

Бүрэлдэхүүн хэсэг 3-ын зорилго нь Улаанбаатар хотын захиргаанд хотын авто зам, тээврийн хөгжлийн уялдаа холбоо бүхий хэтийн зорилгот цогц стратеги бүхий тогтвортой уян хатан байгууллагын тогтолцоог хөгжүүлэхэд туслахад оршино. Энэ бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагаануудад Улаанбаатар хотын дэд бүтцийн төлөвлөлт, менежмент, үйлчилгээний хангамжид шинэ хандлага стратегийг нэвтрүүлнэ. Энэ бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэхдээ олон улсын болон үндэсний хэмжээний техникийн мэргэжилтнүүд (бие даасан зөвлөхүүд)-ийг ажиллуулах бөгөөд тэдгээр нь тухайн бүс нутгийн хүмүүс байна (гэрээт ажилчид). Энэ тухайлсан бүрэлдэхүүн хэсгийг төслийн туршид хэрэгжүүлэх явцад эдгээр гэрээт ажилчдын нарийвчилсан тоо нь тодорхойгүй байгаа бөгөөд энэ тоо нь хэлбэлзэх ба 5-10 техникийн мэргэжилтнүүд нэг цаг хугацаанд ажиллах магадгүй болно.

Төслийн ажилчдын тоо ба шинж чанар

1. Шууд /direct/ ажилчид

Шууд ажилчид гэдэгт зээлдэгчийн ажилчид эсхүл зээлдэгчтэй хамаатай ажилчид (төслийг дэмжигчид, төслийг хэрэгжүүлэгч агентлагууд) зэрэг төсөлтэй шууд холбоотой ажилладаг хүмүүс хамрагдана.

Энэ төслийн хувьд зээлдэгч нь төслийн удирдлагын албанд зориулж ажиллах хүчнийг хөлслөн ажиллуулна. Төслийн удирдлагын албаны шууд ажилчид нь Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас төсөлд зориулан бүтэн цагаар ажиллахаар томилогдсон эрэгтэй ба эмэгтэй ажилчид байх болно. Эдгээр ажилчид нь засгийн газрын холбогдох газрууд агентлагуудтай хөдөлмөрийн харилцаанд орж төслийг удирдан зохион байгуулж ажиллана. Улаанбаатар хотын захирагчийн тушаалаар төслийн удирдлагын албаны захирлыг томилно. Төслийн удирдлагын албаны ажилтнууд нь зохион байгуулагчид, мэргэжилтнүүд, зөвлөхүүд зэрэг санал болгож буй УБТАТ төслийг удирдан зохион байгуулах зорилготойгоор хөлслөгдсөн хүмүүс байна. Эдгээр ажилчид нь 18 аас дээш насны хүмүүс байна.

2. Гэрээт ажилчид

Гэрээт ажилчид нь байрлалаас үл хамааран төслийн гол үйл ажиллагаатай холбоотой гуравдагч талтай гэрээ хийсэн тэдэнд хамаатай хүмүүс байна. Гуравдагч тал гэдэгт шууд гэрээт, дэд гэрээт, брокерууд, төлөөлөгчид, зуучлагчид орно. Төслийн гол үйл ажиллагаа гэдэг нь тухайлсан төслийн үйл ажиллагааны хамгийн чухал процессууд, үйлчилгээнүүд, үйлдвэрлэлүүд зэрэг орох бөгөөд эдгээргүйгээр төсөл үргэлжлэх боломжгүй юм.

Энэ төслийн хувьд гэрээт ажилчдыг дараах байдлаар тодорхойлсон болно: ойролцоогоор 50-100 бүтээн байгуулалтын ажилчдыг бүрэлдэхүүн хэсэг 1-ийг хэрэгжүүлэхэд оролцуулна гэж урьдчилан төлөвлөж байна. Бүтээн байгуулалтын ажилд орон нутгийн хувийн хэвшлийн чадвар туршлагаас хамаарч олон улсын өрсөлдөөнт тендерийг зарлах магадлалтай. Энэ

тохиолдолд цөөн тооны олон улсын техникийн мэргэжилтнүүд ба ажилчид бүрэлдэхүүн хэсэг 1 ба 3-ын бүтээн байгуулалт эхлэхээс өмнө болон бүтээн байгуулалтын эхний шатуудад оролцож болно. Гэрээт ажилчдыг сонгон авах ажлыг тендер шалгаруулалтад үндэслэн авна. Бүтээн байгуулалтын ажилчдын менежментийн хэрэгцээг сонгон шалгаруулалтын процесс дахь сонгон шалгаруулалтад оролцогчдын хөдөлмөрийн менежментийн системийн үнэлгээнд заасны дагуу хангана. Бүтээн байгуулалтын баг нь ахлах инженерээр 2 жил ажилласан ажлын туршлагатай нэг ахлах инженертэй байх бөгөөд тэр нь тухайн салбарынхаа мэргэжилтэн төдийгүй тусгай лицензтэй байх ёстой, ажлын байрны эрүүл мэнд аюулгүй ажиллагааны мэргэжилтэн нь ажлын байрны эрүүл мэнд аюулгүй ажиллагааны сертификаттай байх ба ажлын байрны эрүүл мэнд аюулгүй ажиллагааны чиглэлээр дор хаяж 2 жилийн ажлын туршлагатай байх ёстой. Эдгээр хүмүүс нь нийгмийн даатгалын дэвтрийнхээ сүүлийн 6 сарын тэмдэглэгээг хавсаргаж тогтвор суурьшилтай ажиллаж байснаа батлах ёстой.

Төслийн удирдлагын алба нь Байгаль орчин аялал жуулчлалын яамны байгаль орчинд нөлөөлөх байдлын мэргэжлийн эрхтэй байгаль орчны зөвлөх үйлчилгээний байгууллагуудаас эрэгтэй ба эмэгтэй ажилтныг багтаа авч, ажиллуулах ёстой. Энэ нь тухайн бүс нутагт байдаг олон улсын болон үндэсний техникийн мэргэжилтнүүдээс бүрдэх ёстой. Эдгээрт байгаль орчин, нийгэм, санхүү эдийн засаг, худалдан авалтын мэргэжилтнүүд орох бөгөөд тэд техникийн тусламж үйлчилгээгээр хангана. 5-10 техникийн мэргэжилтнүүд байна гэж урьдчилан тооцоолж байгаа бөгөөд бодит тоо нь тодорхойгүй байна. Төслийн энэ тусгай бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэх явцад хэдэн тооны гэрээт ажилчид байх нь тодорхой биш байгаа бөгөөд магадгүй 5-10 техникийн мэргэжилтнүүд ажиллана гэж үзэж байна.

3. Анхдагч материал нийлүүлэгч ажилчид

Анхдагч материал нийлүүлэгч ажилчдад зээлдэгчийн нийлүүлэгчид ордог. “Анхдагч нийлүүлэгчид” гэж төслийн гол үйл ажиллагаанд зайлшгүй хэрэгцээтэй бараа материалыг байнга хангаж байдаг хүмүүсийг хэлнэ. Анхдагч материал нийлүүлэгч ажилчдын тодорхой тоо мэдэгдээгүй байгаа бөгөөд магадгүй 10-20 ажилчид/техникийн мэргэжилтнүүдийн хооронд хэлбэлзэнэ.

Эмзэг/зорилтот бүлгийн ажилчид:

Энэ төсөлд ямар төрлийн эмзэг ажилчдыг хамруулах нь тодорхойгүй байдаг хэдий ч энэ ангиллын ажилчдын хамгааллын асуудлыг Монгол улсын хөдөлмөрийн хууль журмууд БОНХ БОНС2 удирдамжийн дагуу сонгох болно. Төсөлд хүүхдүүдийг хөлсөлж ажиллуулахгүй, хөдөлмөрийн хууль (1999, 109 дүгээр зүйлийг харах)-д хамгийн бага нас 16 гэж заасан байдгийг анхаарч үзэх хэрэгтэй ба 18 нас хүрээгүй бол хүнд зүйлийг өргүүлэхийг хориглодог байна. Хөдөлмөрийн хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг янз бүрийн хэлбэрээр хамгаалсан байдаг. Монгол улсын статистикийн үзүүлэлтээр 2006 онд ажиллах хүчинд эмэгтэйчүүдийн эзлэх хэмжээ 64.8 хувь байсан бол 2018 онд 53.4 хувь болж буурсан байна. Эдийн засгийн хямрал нь эмэгтэй ажилчдад ялангуяа хот суурин газарт байгаа эмэгтэй ажиллах хүчинд тухайлбал нийслэл хотод (44.8) хөдөө орон нунтгийн (60.5) эмэгтэйчүүдтэй

харьцуулахад илүү нөлөөлж байгааг энэ үзүүлэлт 2018 оны байдлаар илтгэж байна (АХБ, 2018). Монгол улс нь хүйсийн тэгш байдлыг дэмжсэн хууль (2011)-тай бөгөөд энэ хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр сүүлийн үед илүү анхаарч ажиллаж байна. Энэ хууль нь ялгаварлан гадуурхалгүй тэгш эрх, бусад ерөнхий ойлголтуудыг түгээн дэлгэрүүлэхийг дэмжиж, засгийн газрын зүгээс хүйсийн тэгш байдлыг дэмжихийг шаарддаг. Энэ төсөлд ажиллаж байгаа хүн бүр ёс зүйн дүрэм дээр гарын үсэг зурна, хүйсээс хамаарсан эмзэг байдал, хүйсийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг ба хүчирхийллийн элементүүдийн талаар танилцуулга сургалтуудыг хамрагдсан байна.

Хамгааллын ажилчид. Зээлдэгч нь (бүтээн байгууллын гэрээт этгээд) бүтээн байгуулалтын явцад цөөн тооны хамгааллын ажилчид (цагдаа эсвэл гэрээт хамгааллын алба)-аар төслийн бүтээн байгуулалтын талбайг хамгаалуулна гэдгийг урьдчилан тооцоолсон. Тендерийн материалуудад бүх ажилчдын болон хамгааллын ажилчдын дагаж мөрдөх ёс зүйн дүрмийг багтаасан байх болно.

Хөдөлмөрийн болзошгүй эрсдэлийг үнэлэх

Төслийн үйл ажиллагаа

Шууд ажилчид

Төслийн удирдлагын албаны ажилчид нь төслийн удирдлага зохион байгуулалт, худалдан авалт ба бараа, ажиллах хүч үйлчилгээний гэрээний менежментийг хариуцаж ажиллан, төслийн аудит зардлын боловсруулалт зэрэг санхүүгийн менежментийг хариуцаж, олон нийттэй харьцах ажил, Дэлхийн банкны шаардлагын дагуу байгаль орчин ба нийгмийн аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлэх, үе шатны тайлангуудыг бэлтгэх, хяналт үнэлгээг хэрэгжүүлж дэлхийн банканд хүргүүлэх, гомдлыг хянан шийдвэрлэх механизмыг хэрэгжүүлэх ажлыг хариуцна. Шууд ажилчдын хөдөлмөрийн боломжит эрсдэл бага байдаг хэдий ч дараах эрсдэлүүд гарч ирдэг. Үүнд:

(i) Албан ёсны ажлын цагийг дагаж мөрдөхгүй байх, (ii) Ажилд авахдаа ялгаварлан гадуурхах ба үндэсний хууль тогтоомжийг зөрчин эрэгтэй ба эмэгтэй хүмүүсийн ижил ажилд ижил хэмжээний төлбөр төлөхгүй байх

Гэрээт ажилчид

Төслийн техникийн тусламжтай холбоотой ажилчид техникийн саналуудын судалгаа хийх, үнэлгээ хийх, төслийн байгаль орчин нийгмийн нөлөөллийн эрсдэлийг үнэлнэ. Техникийн тусламжийн зорилго төсөл хэрэгжилтийн үеийн техникийн удирдамжаар хангадаг байхад мониторингийн ажилчид төслийн менежментийн хяналт үнэлгээг хариуцдаг байна.

Бүтээн байгуулалтын ажилчид нь бүтээн байгуулалтын талбай дээр төслийн бүтээн байгуулалтыг хийж гүйцэтгэдэг. Аюулгүй ажиллагааны эрсдэлүүдэд бэртэж гэмтэх явдал ордог.

Төслийн нарийн мэргэшсэн бүтээн байгуулалтын багт ахлах инженерүүд, цахилгааны инженерүүд, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтнүүд, техникчид, бүтээн байгуулалтын ажилчид зэрэг ойролцоогоор 50-100 хүн байдаг. Ажлын байрны төвлөрсөн менежмент болон ёс зүйн дүрмийг боловсруулж дагаж мөрдүүлэхийн тулд дүрмээ харагдахуйц газар байрлуулж тавьдаг бөгөөд үүнд согтууруулах ундаа, мансууруулах бодисыг хориглох зохих хууль журмыг хатуу дагаж мөрдөхийг сануулах зэргүүд ордог.

Хэрвээ бүтээн байгуулалтын нэгжүүд нь холбогдох хууль журмуудыг хатуу хэрэгжүүлэхгүй, хөдөлмөрийн гэрээн дээр гарын үсэг зурахгүй байвал бүтээн байгуулалтын ажилчдын эрх ашгийг хамгаалж баталгаа өгөх, ажилчдын цалинг цагт нь тавих эсэхэд баталгаа өгөх боломжгүй болно.

Бүтээн байгуулалтын үйл ажиллагаа явагдаж байх үед орон зайн хувьд хязгаарлагдмал газарт ажиллаж байхдаа бэртэж гэмтэх, багаж техникийг засварлаж байхдаа мөн бэртэж гэмтэх боломжтой.

Гэрээт ажилчдад дараах эрсдэлүүд гарах магадлалтай:

- Албан ёсны ажлын гэрээ байхгүй,
- Албан ёсны ажлын цагийг даган мөрдөхгүй байх,
- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт болон албадан хөдөлмөр эрхлэлтийн талаарх хөдөлмөрийн тухай үндэсний хуулийг зөрчих,
- Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ижил тэнцүү хөдөлмөр эрхлэхэд ижил тэнцүү цалин хөлс олгогдохгүй байх,
- Ажилд авах, болон ажиллуулахдаа Ялгаварлан гадуурхах тухай үндэсний хуулийг зөрчих,
- Хүртээмжтэй хөдөлмөрийн өргөдөл, гомдол барагдуулах механизм байхгүй байх,
- Хөдөлмөрийн өргөдөл, гомдол барагдуулах механизмийн талаарх мэдлэг дутмаг,
- Хөдөлмөрийн өргөдөл, гомдол барагдуулах механизмийн дагуу үйл ажиллагаа явуулахгүй байдал
- Ажлын байрны эрүүл мэнд аюулгүй байдлын талаар зохих арга хэмжээ аваагүйгээс ноцтой аваар осол, гэмтэл гарах,
- ЖСХ-ийн талаарх мэдлэг ойлголт, урьдчилан сэргийлэх байдал дутмаг,
- COVID 19 холбоотой асуудлууд,
- Төслийн дээр нь байнгын мэргэшсэн Ажлын байрны эрүүл мэнд аюулгүй ажиллагааны мэргэжилтэн байхгүй.

Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн тойм

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль (1999), Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011), 2015 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль зэрэг хуулиуд нь Монгол Улсын ажилчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор батлагдсан.

Цалин ба нийгмийн хамгаалал

1. Цалингийн хуваарилалтыг хөдөлмөрлөснийхөө хэрээр цалингаа авах, гүйцэтгэлийн үр дүнд үндэслэх зарчмыг дагах шаардлагатай. Цалингийн түвшин нь эдийн засгийн өсөлтийг дагаж аажмаар нэмэгдэх ёстой. Засгийн газар макро эдийн засгийн зохицуулалтын хэрэгжүүлж нийт цалингийн хэмжээг зохицуулна.
2. Монгол улсын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2009 оны байдлаар сард 320,000.0 /118 америк доллар/ төгрөг байсан бөгөөд 2020 онд сарын 420,000.0 /155 америк доллар / төгрөг байхаар төлөвлөж байсан. Ажилчдад төлөх цалингийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага байх ёсгүй.
3. Ажилчдад цалинг сар бүр тухайн ажилтанд өөрт нь мөнгөн хэлбэрээр өгөх бөгөөд шалтгаангүйгээр өр болгож, эсвэл бусад хэлбэрээр суутгал авах ёсгүй.
4. Ажилчдад ажил олгогч нь хууль ёсны амлалт, гэрлэлт, оршуулга зэрэг бусад хууль үйл ажиллагааны үеэр ч цалинг тооцож өгөх ёстой

Ажлын хугацаа, амралт, бүх нийтийн амралт

1. Монгол улсын Хөдөлмөрийн хуулийн 5 дугаар бүлэгт зааснаар ердийн ажлын өдрийн үргэлжлэх хугацаа нь 8 цагаас илүүгүй байх, 7 хоногийн ажлын цаг нь 40 цагаас илүүгүй байх ба ажлын дараалсан 2 өдрийн хоорондох тасралтгүй амралтын хугацаа нь 12 цаг ба түүнээс доошгүй хугацаатай байх ёстой.
2. Ажил олгогч нь хөдөлмөрийн квот хөдөлмөрийн стандартыг засгийн газраас тогтоосон ажлын цагийн системийн дагуу тодорхойлно.
3. Ажил олгогч нь хуулийн дагуу наадам /7 дугаар сарын 11,12,13/, хүүхдийн баяр /6 дугаар сарын 1/ бусад албан ёсны баяр ёслолын үеэр ажилчид амарч байх ёстой асуудлыг зохицуулна.
4. Монгол улсын хөдөлмөрийн хуулийн дагуу /5 дугаар бүлгийн 77 дугаар зүйл /ажилтан нь ажил, үйлдвэрлэлийн онцлогоос шалтгаалан бямба ням гарагт амралтгүйгээр ажилласан бол 7 хоногийн дараалсан өөр 2 өдөр амарна.

Тэгш эрх

1. Ажилчдыг үндэс угсаа, арьсны өнгө, хүйс шашны итгэл үнэмшлээр ялгаварлахгүйгээр ажиллуулна.
2. Хамтын гэрээ хэлэлцээрт эрэгтэй эмэгтэй хүмүүст тэдний мэргэжлийн болон гэр бүлийн үүрэг хариуцлага, хүүхдээ тээх, асран халамжлах үүрэг хариуцлагыг харгалзан үзэх, эрүүл мэнддээ анхаарал тавих, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах

зэрэгт нь хөдөлмөрийн тэнцүү нөхцөлийг бий болгож, ижил цалин урамшуулал олгох зэргийг багтаана.

3. Хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн харилцаанд хүйсээр ялгаварлан, гадуурхахыг хориглоно. Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол ажилтныг хүйс, жирэмслэлт, хүүхэд асрах үүрэг, гэр бүлийн байдал зэргээр давуу эрх эдлүүлэх, эрхийг нь хязгаарлах, ажлаас халах зэргийг хориглоно.
4. Албадан хөдөлмөр эрхлэлтийн аливаа хэлбэрийг хатуу хориглоно.
5. Ажил олгогч нь хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөдөлмөрийн харилцаанд хүйсээр ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх, ажлын байран дахь хүйсийн тэгш байдлыг хангах чиглэлээр дараах үүрэг хүлээнэ:
 - 5.1. Хүйсийн тэгш байдлыг дэмжихэд чиглэгдсэн төлөвлөгөө болон хөтөлбөрт үндэслэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж, хэрэгжилт, үр дүнгийн талаар ажилтнуудад тайлагнана.
 - 5.2. Ажилд авах зарлалд аль нэг хүйсийг илүү үзэж байгаагаа тодорхой илэрхийлэх, эсхүл далд санаагаар илэрхийлэхийг Монгол улсын Хөдөлмөрийн хуульд заасан тусгай нөхцөлөөс бусад тохиолдолд /6 дугаар бүлэг, 7 дугаар бүлэг/ хориглоно.
 - 5.3. Тухайн байгууллага эсвэл тэр байгууллагын нэгжид хүйсийн тэнцвэрийг хангах зорилгоор дутуу төлөөлөлтэй хүйсийн хүнийг ажилд авна.
 - 5.4. Адил хөдөлмөр эрхлэлтэд ижил цалин олгох, хөдөлмөрийн тэнцүү нөхцөлийг бүрдүүлэх зэрэг хуулийн заалтууд хэрэгжиж байгаа эсэхэд хяналт үнэлгээ хийж, зөрчил илэрвэл арга хэмжээ авна.
 - 5.5. Тушаал дэвшүүлэх, мэргэжлийн сургалтад хамруулах, үр чадварыг сайжруулах, эрэгтэй эмэгтэй ажилчдын цалин нэмэгдүүлэх зэргийг хүний нөөцийн жагсаалтад үндэслэн гүйцэтгэнэ.
 - 5.6. Ажлын байрны сул орон тоо болон мэргэжлийн сургалт, давтан сургалтад хамрагдах боломж нөхцөлийн талаар бүх ажилчдад цаг алдалгүй мэдээлнэ.
 - 5.7. Бүтцийн өөрчлөлтөөс болоод ажилчдын гуравны нэгийг халах тохиолдолд халсан ажилчдын хүйсийн харьцаа нь ажилласан жилийн хугацаанаас үл хамааран нийт ажилчдын тоотой шууд хамааралтай байна.
6. Ажил олгогч нь байгууллагыг татан буулгах, Хөдөлмөрийн хуулийн 40.1.4, 40.1.5-д зааснаас бусад тохиолдолд жирэмсэн эмэгтэй, 3-аас доош насны хүүхэдтэй ээжийг ажлаас халахыг хориглоно.
7. Ажил олгогч нь ажлын байрыг бэлгийн дарамтгүй байлгах, урьдчилан сэргийлэх, ийм төрлийн дарамтыг тэг байлгахын тулд дараах арга хэмжээг авна.

- 7.1. Байгууллагын дотоод журамд ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гомдлыг барагдуулах хэм хэмжээг тусгах,
- 7.2. Бэлгийн дарамт үгүй ажлын орчныг бий болгохын тулд сургалт ба давтан сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж, үүний үр нөлөөллийг ил тодоор тайлагнадаг болгох,
8. Иргэнийг ажилд авахдаа, хөдөлмөрийн харилцааны явцад, ажил үүргийн онцлог шаардлагаас шалтгаалан ажил олгогч нь ажилтны эрх болон эрх чөлөөг хязгаарлаж байгаа бол түүнийг хийх болсон үндэслэлээ нотлох хэрэгтэй.
9. Иргэнийг ажилд авах үедээ тухайн ажлын онцлогтой холбоотой эсвэл хийж гүйцэтгэх үүрэгтэй холбоотой биш бол хувийн амьдрал, хувийн үзэл бодол, гэрлэлтийн байдал, улс төрийн намын харьяалал, шашин шүтлэгийн итгэл үнэмшил, эсвэл жирэмсэн эсэхийг асуухыг хориглоно.

Хөдөлмөрийн гэрээ

1. Хөдөлмөрийн гэрээнд дараах үндсэн нөхцөлийг зөвшөөрнө.
 - a. Хөдөлмөр эрхлэлтийн албан тушаалын төрөл, нэр,
 - b. Хөдөлмөрийн гэрээний хугацаа,
 - c. Үндсэн цалингийн хэмжээ ба тухайн албан тушаалын цалин,
 - d. Ажиллах нөхцөл
2. Талууд өмнөх хэсэгт заасан шаардлагатай заалтаас гадна бусад заалтыг тохиролцож болно.
3. Хөдөлмөрийн гэрээ нь гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
4. Хөдөлмөрийн гэрээ нь хугацаатай буюу хугацаагүй байна.
5. Хөдөлмөрийн гэрээний хугацааг талууд гүйцэтгэх ажил, үүргийн онцлогийг үндэслэн тогтооно.
6. Хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусаж, талууд гэрээг цуцлах санал гаргаагүй ажилтан ажлаа үргэлжлүүлэн гүйцэтгэж байгаа тохиолдолд хөдөлмөрийн гэрээнд тусгасан анхны нөхцөлүүд, болон гэрээний хугацаа сунгагдсан гэж үзнэ.
7. Ажил олгогч нь ажилтантай хөдөлмөрийн гэрээг бичгээр үйлдэж, тухайн хөдөлмөрийн гэрээний нэг хувийг ажилтанд өгөх ёстой. Байнгын ажлын байранд хөдөлмөрийн гэрээнээс бусад гэрээ байгуулахыг хориглоно.
8. Хэрвээ ажил олгогч нэг ажлын байран дээр хэд хэдэн ажилтныг ажиллуулж байгаа бол ажилтан тус бүртээ гэрээ байгуулна.
9. Хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулаагүй нөхцөлд ажил олгогч нь ажилтныг ажил үүргээ гүйцэтгэхийг шаардах эрхгүй.

10. Гамшгийн эрсдэлийг бууруулах, хор уршгийг арилгах зэрэг зайлшгүй шаардлага гарсан болон урьдчилан мэдэх боломжгүй бодит нөхцөл байдал бий болсон тохиолдолд ажил олгогч нь ажилтныг хөдөлмөрийн гэрээнд заагаагүй өөр ажилд 45 хүртэл хоногийн хугацаагаар шилжүүлж болно.

11. Ажилтан ажил үүргээ биелүүлээгүй дараах тохиолдолд ажил болон албан тушаалаа хэвээр хадгална:

- a. Хэрэв ажилтан төрийн байгууллын томилогдсон үүргийг 3 сараас илүүгүй хугацаанд гүйцэтгэж байгаа бол,
- b. Хэрэв ажилтан ердийн амралтын өдрүүдэд байсан бол,
- c. Хэрэв ажилтан эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж, хандивлагчийн үүргийг гүйцэтгэж байгаа, эсвэл захиргааны зөвшөөрлөөр чөлөө авсан бол, эсхүл эмчийн бичигтэйгээр чөлөө авсан бол,
- d. Хэрэв ажилтан жирэмсэн, жирэмсний амралт, хүүхдээ өсгөж буй амралттай байгаа бол,
- e. Ажилтан нь хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах, хууль ёсны дагуу зохион байгуулалттай ажил хаялт хийх үеэр хэлэлцүүлэг, хэлэлцээрт оролцож байгаа бол,
- f. Цэрэг татлагын хорооноос армид элсэх тушаал авсан ажилтныг армид алба хааж эхлэх хүртэл,
- g. Хуульд болон хамтын ба хөдөлмөрийн гэрээнд заасан бусад тохиолдолд,
- h. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хамгаалалтын арга хэмжээнд хамрагдсан бол,

12. Хөдөлмөрийн гэрээг дараах үндэслэлээр цуцална:

- a. Хэрэв талууд харилцан зөвшөөрсөн бол,
- b. Хэрэв ажил олгогч эсвэл ажилтан иргэн нас барсан бол,
- c. Хэрэв хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусаж гэрээг цаашид үргэлжлүүлэхгүй гэж шийдсэн бол,
- d. Хуульд заасан эрх бүхий байгууллагаас шаардсан бол,
- e. Ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтныг өмнөх ажил, албан тушаалд эргүүлэн томилсон бол,
- f. Хэрэв ажилтан армид дуудагдсан бол,
- g. Хэрэв ажилтанд ял оногдуулсан шүүхийн шийдвэр гарсан мөн гэмт хэргийн улмаас хөдөлмөрийн үүргээ гүйцэтгэхэд нь саад болж буй бол,
- h. Хөдөлмөрийн гэрээг ажил олгогч болон ажилтны санаачилгаар цуцалсан бол

13. Ажлаас халах өөр ажилд шилжүүлэх

- a. Ажил олгогч нь ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцлахдаа шинэ ажилтанд ажил хүлээлгэн өгөх хугацааг тогтоож, уг хугацааг ажлаас халах тухай шийдвэрт заана,
- b. Ажилтан ажлаа хүлээлгэн өгсөн сүүлчийн өдрийг ажлаас халагдсан өдөр гэж тооцно,
- c. Ажил олгогч нь ажлаас халагдсан ажилтанд ажлаас халах тухай шийдвэр, нийгмийн даатгалын дэвтэр зэргийг, хэрэв хуульд заасан бол ажлаас халагдсаны тэтгэмжийг ажлаас халах өдөрт нь өгөх үүрэгтэй,
- d. Ажил олгогч нь тухайн ажилтны хүсэлтийн дагуу ажил мэргэжил, мэргэшил, мэргэшсэн байдал, албан тушаал, цалин хөлсний талаар тодорхойлолт гаргаж өгөх үүрэгтэй.

Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал

Хөдөлмөрийн үндэсний хуулиудын тойм

Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2015 оны нэмэлт, өөрчлөлт) нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар төрөөс баримтлах бодлого, зарчмуудыг тодорхойлж, удирдлага, хяналтын тогтолцоотой холбоотой харилцааг зохицуулдаг.

1. Өргөх, хүргэх, тээвэрлэх машин механизмд тавигдах шаардлага

- a. Өргөх, хүргэх, тээвэрлэх машин механизм нь техникийн шаардлагад нийцсэн байх ёстой.
- b. Өргөх, хүргэх, тээвэрлэх машин механизмыг мэргэжлийн байгууллагаар баталгаажуулж, ашиглахыг зөвшөөрч гэрчилгээжүүлсэн байх ёстой.
- v. Өргөх, хүргэх, тээвэрлэх техник хэрэгслийн засвар, үйлчилгээ, тохируулга нь ажлыг техникийн баримт бичигт заасан хугацаанд, эсхүл эдгээр машин механизмын туршилт, тохируулга, гэрчилгээжүүлэлтийг эрх бүхий байгууллагаас батлагдсан хугацаанд хийх ёстой.

2. Даралтат контейнер, сувагт тавигдах шаардлага

- a. Даралтат контейнер, хоолой, сувгийг холбогдох журмын дагуу шалгаж, тохируулж, гэрчилгээжүүлсэн байх ёстой бөгөөд техникийн шаардлага хангасан, ашиглахыг зөвшөөрсөн байх ёстой;
- b. Даралтат контейнер, суваг нь бэлэн журам, ашиглалтын заавартай байх ёстой ба урт хугацаанд зогсоох, засвар үйлчилгээ хийх боломжтой байх,
- v. Даралтат контейнер, суваг нь ялгагдах тэмдэг, логотой байх ёстой бөгөөд аваар ослоос урьдчилан сэргийлэх дохиолол, хамгаалалтын хэрэгслээр тоноглогдсон байх ёстой.

4. Хортой, аюултай химийн бодис, тэсрэх төхөөрөмж, цацраг идэвхт ба биологийн идэвхт бодисуудад тавигдах шаардлага

а. Ажил олгогч нь ажилчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаа болон химийн хорт, аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг идэвхт, биологийн идэвхт бодис болон тэдгээрийн нөлөөллөөс урьдчилан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

б. Ажил олгогч нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хэрэглэж буй химийн хорт болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэрч дэлбэрэх хэрэгсэл, цацраг идэвхт, биологийн идэвхт бодисын талаар бүртгэл хөтөлж, эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу хөдөлмөрийн хяналтын байгууллага, бусад холбогдох мэргэжлийн байгууллагад мэдээлэх ёстой.

в. Хортой, аюултай химийн бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг идэвхт, биологийн идэвхт бодисуудтай харьцаж байгаа хүн нь эдгээр бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэдлэгтэй байх ба дадлагажсан байх ёстой.

г. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд химийн хорт болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг идэвхт, биологийн идэвхт бодис ашиглах, зарцуулахад тавигдах бусад шаардлагыг холбогдох хуулиар зохицуулна.

д. Химийн хорт болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг идэвхт, биологийн идэвхт бодис ашиглахтай холбоотой гарсан осол, хурц хордлогыг үйлдвэрлэлийн осол гэж үзэн шалгаж, бүртгэнэ.

4. Ажилчдыг тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах

а. Ажил олгогч нь ажилчдыг тэдний ажиллах нөхцөл, ажлын гүйцэтгэлийн шинж чанарт тохирсон тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах үүрэгтэй.

б. Тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг түрших, худалдан авах, хадгалах, цэвэрлэх, засах, ариутгал хийхтэй холбогдсон зардлыг ажил олгогч хариуцна.

в. Ажил олгогч нь тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн нэр, төрөл, ашиглалтын хугацааны талаарх жагсаалтыг баталж, хадгална.

г. Ажил олгогч нь тусгай хувцас, хамгаалах хэрэгслийнхээ чанарын талаар мэргэжлийн байгууллагуудаас дүгнэлт гаргуулна. Олон улсын стандартад нийцсэн, чанарын баталгаатай тусгай хувцас, хамгаалалтын тоног төхөөрөмж үйлдвэрлэх асуудал нь энэхүү заалтад хамаарахгүй.

5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, мэргэжлийн дадлагажилтын сургалт

а. Ажилтай иргэн, ажилтан нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн

талаарх богино хугацааны сургалтад хамрагдаж, мэдлэг, боловсрол эзэмших, дадлагажих шаардлагатай;

б. Өөр ажлын байранд шилжиж байгаа иргэд, ажилтнуудад зориулсан сургалт;

в. Хортой нөхцөл, үйлдвэрлэлийн аюултай нөлөөлөлтэй болон түүнтэй ижил төстэй нөхцөл байдалтай ажлын байранд ажилладаг иргэд, ажилтнуудад зориулсан сургалт.

г. Ажил олгогч нь нийт ажилчдад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар жилд 2-оос доошгүй удаа сургалт явуулж, тэднээс шалгалт авсан байх.

6. Иргэд, ажилчдын хөдөлмөрийн таатай нөхцөлөөр хангагдах эрх, үүрэг

а. Ажилтай иргэн, ажилтан дараах нийтлэх эрх эдэлнэ.

- I. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ажлын байранд ажиллах;
- II. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний эрүүл мэндийн даатгалд хамрагдах;
- III. Ажлын байрны нөхцөл байдал, эрүүл мэнд, үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн учирч болзошгүй эрсдэлийн талаар мэдээлэл авах;
- IV. Ажлын явцад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны журам зөрчигдсөн эсвэл хүний амь нас, эрүүл мэндэд аюул учирч болзошгүй тодорхой нөхцөл байдал үүссэн тохиолдолд ажил үүргээ гүйцэтгэхээс түдгэлзэж, энэ талаар ажил олгогчид мэдэгдэнэ;
- V. Ажлын байрны нөхцөл байдал, эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй эрсдэл, үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн талаар мэдээлэл авах;

б. Ажилтай иргэн, ажилчин дараах нийтлэг үүрэг хүлээнэ.

- I. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт, дүрэм журам, технологийг дагаж мөрдөх;
- II. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх сургалтад хамрагдах, хэрэв хуульд заасан бол шалгалт өгч, аюулгүй ажиллагааны зааварчилгаа авах;
- III. Ажил гүйцэтгэх явцад хүний амь нас, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй тодорхой нөхцөл байдал үүссэн тохиолдолд аюулгүй ажиллагааны дүрэм, журамд заасан арга хэмжээг цаг тухайд нь авах;
- IV. Өөрийнхөө эрүүл мэндээ хамгаалахын тулд эмчийн үзлэгт орох;
- V. Тусгай хувцас, хамгаалалтын хэрэгслийг зориулалтын дагуу ашиглах;
- VI. Албан үүргээ эрсдэлгүй, осол авааргүй гүйцэтгэх техник, арга зүй, мэргэжлийн ур чадвар эзэмших, осол, гэмтэл, цочмог хордлогоос

урьдчилан сэргийлэх, аюул, ослын үед анхны тусламж үзүүлэх чадвар эзэмших;

- VII. Өөртөө болон бусдад аюул, эрсдэл учруулахгүй байх;
- VIII. Ажил олгогчоос тогтоосон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн хууль, тогтоомжийн дагуу ажлаа гүйцэтгэх.

Ажлын байрны эрүүл мэнд ба аюулгүй байдлын арга хэмжээ

Төслийн удирдлагын алба болон үнэлгээний хороо нь өөрийнхөө ажилчдын ажлын байрны эрүүл мэнд аюулгүй байдлыг удирдаж зохион байгуулах чадамжтай эрх бүхий этгээдийг сонгох ёстой. Үүнээс гадна ТМО нь ажлын байрны эрсдэлийг аюулыг учруулах зүйлүүдийг урьдчилан тодорхойлох ажилчдад учрах эрсдэлийг үнэлэх, аюул заналаас сэргийлэх, хяналтын механизмыг ашиглахад чиглэгдсэн эрсдэлийг идэвхтэй хянах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Монгол Улсын ажлын байрны эрүүл мэнд ба аюулгүй байдлын хуулийн дагуу инженер техникийн ажилчид 2 жид 1 удаа шалгалт өгч тэнцсэн байх шаардлагатай байдаг. Гүйцэтгэгч байгууллагын ажлын байрны эрүүл мэнд ба аюулгүй ажиллагааны ажилчин нь дор хаяж энэ чиглэлээр 2 жил ажилласан туршлагатай байх ёстой. Үүнээс гадна ТМО нь ажилчид болон гүйцэтгэгч байгууллагуудтай ажлын байрны эрүүл ахуй аюул ажиллагааны сургалтуудыг тогтмол явуулах ёстой. Ажлын байрны эрүүл ахуй аюулгүй ажиллагааны талаар өглөө бүр ажилчдад танилцуулж АБЭААА –ын талаар ажилчид сонссон гэж гарын үсэг зуруулах ёстой. Хэрвээ тэд энэ бичиг баримтад гарын үсэг зураагүй бол ажлаа эхлэх, хийхийг зөвшөөрөхгүй. Ажлын хэсгийн гаргасанчлан боломжит гүйцэтгэгч нарыг энэ журмыг дагуулж мөрдүүлэх ёстой.

ТМО нь гадаад яаралтай тусламжийн төлөвлөгөө түүний арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэх ёстой. Үйлдвэрлэлийн авар ослоос сэргийлэхийн тулд ажилчдад тусгай ажлын хувцас болох аюулгүйн дуулга малгай, ган хоншоортой гутал зэрэг аюулгүй байдлыг ханасан хувцсыг бүтээн байгуулалтын талбар дээр өмсүүлэх ёстой. Үүнээс гадна ариун цэврийн байгууламж, хувцас солих өрөө зэргээр хангаж сүү, цагаан идээ витамин зэргийг нэмэлтээр өгөх ёстой. ТМО нь ажилчдын гэрээлэгчдийн бусад холбогдох этгээдийн саналыг тогтмол идэвхтэйгээр сонсож аюулгүй ажиллагааг байнга хянаж шалгах хэрэгтэй

Цахилгаан хэрэгслүүд ба цахилгаанаар ажилладаг багаж техник хэрэгслийг цахилгаан хэрэгслийн аюулгүй ажиллагааны журмын дагуу хамгаалж, зохих төхөөрөмжүүдийг суурилуулсан байх ёстой. Түр зуурын хуйран ба зам барилгын үйл ажиллагааны асуудлууд (ус, ариун цэврийн төхөөрөмж, хаягдал гадагшлуулах төхөөрөмж).....

Төслийн хүн ихтэй газруудад болон төслийн аюултай газруудад анхааруулах тэмдгүүдийг харагдахуйц цэгүүдэд байрлуулна. Бүтээн байгуулалтын үйл ажиллагаа явагдаж байх үед аюулгүй байдлыг хангасан холбогдох арга хэмжээг авч байх ёстой. Эмнэлгийн анхны тусламжийн хайрцаг, гал сөнөөх төхөөрөмж, цэвэр ус зэргийг төслийн талбар дээр байрлуулж, тавьсан байх ёстой.

Хөдөлмөрийн хариуцлага ба үүрэг

Улаанбаатар хотын захирагчийн алба Төслийн удирдлагын алба ба хэрэгжүүлэгч этгээдүүд төслийг үр дүнтэй удирдаж, хэрэгжүүлэхийн тулд төслийн үйл ажиллагааг үр дүнтэй байлгах баталгаа өгөхийн тулд дараах үүрэг хариуцлагыг дагаж мөрдөнө.

Үүрэг, Хариуцлага	Шууд ажилчид	Гэрээт ажилчид
Гэрээлэгч, туслан гүйцэтгэгчийн менежмент	ТУА (төслийн зохицуулагч)	ТУА
Удирдлагын ажилчид	НЗДТГ	Гэрээлэгчид (талбайн менежер)
Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал	ТУА, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар	Гүйцэтгэгчид (туслан гүйцэтгэгчидтэй хийх зохицуулалтыг багтаасан)
Сургалт	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар	ТУА, Гүйцэтгэгчид
Давж заалдах	НЗДТГ	ТУА
Мониторинг	НЗДТГ	ТУА

Гүйцэтгэгчийн менежмент

Гүйцэтгэгч нь дараах журмыг дагаж мөрдөнө.

1. Бүтээн байгуулалтын явцад ажлын байрны эрүүл мэнд аюулгүй ажиллагааны мэргэжилтэн нь хөдөлмөрийн менежментийн журмыг дагаж мөрдөн хөдөлмөрийн менежментийн журам болон ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны дүрмийг дагуулж мөрдүүлнэ. Ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны мэргэжилтэнд тавигдах шаардлагыг тендерийн материал болон гэрээний материалд оруулж өгсөн байна.
2. Үйл ажиллагаа эхлэхээс өмнө гүйцэтгэгч нь Төслийн удирдлагын албанд төслийн хэрэгжилтийг тайлагнаж байх тусгай хүнийг томилсон байна.
3. Туслан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах үед ерөнхий гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэгчийг удирдан ажиллана, туслан гүйцэтгэгчийн аюулгүй байдал эрүүл мэнд байгаль орчны хамгааллын ажлуудыг ерөнхий гүйцэтгэгчийн төслийн менежер нь хариуцаж байхын тулд төслийн менежерийн хариуцлагын тогтолцоог боловсруулна, хөдөлмөрийн менежментийн шаардлагын дагуу дотоод хяналт, тайлагналт удирдлагын механизмыг боловсруулан ажиллана.
4. Төслийн үйл ажиллагаа болон төслийн бүтээн байгуулалт эхлэхээс өмнө ёс зүйн дүрэм журмын боловсруулан согтууруулах ундаа, мансууруулах бодисыг хориглох, тохирох зан байдлын талаар дагаж мөрдөх, холбогдох хууль журмуудыг дагаж мөрдөх талаар дурдаж өгнө. Ажилтан болгон нь ёс зүйн дүрэм журмаа ойлгосон зөвшөөрсөн байх ёстой. Ёс зүйн дүрэм журмыг олон хүн цугладаг газар байрлуулах шаардлагатай.

Ёс зүйн дүрэм, журмууд нь дараах зүйлүүдийг багтаах ёстой:

- Бүх ажилчид, гүйцэтгэгчид Монгол Улсын хууль, журмыг дагаж мөрдөнө.
- төслийн талбарт хууль бус зүйл, зэвсэг, галт зэвсэг болон бусад аюултай зүйлийг байлгахыг хуулиар хориглоно
- Хэрүүл, зодоон хийхийг хориглоно.
- Мөрийтэй тоглоом тоглохыг хориглоно
- Ажлын цагаар хар тамхи, мансууруулах бодис хэрэглэх болон бусад холбогдох үйл ажиллагааг хориглоно.
- Зэрлэг ан амьтдыг мах хэрэглэхийг хориглоно
- Гэрийн тэжээвэр амьтан байлгахыг зөвшөөрөөгүй
- Хөрш оршин суугчдад саад болохгүй байх
- Хамгаалалтын малгай, дүрэмт хувцас өмсөх зэрэг ажлын байрны эрүүл ахуй аюулгүй ажиллагааны стандартыг дагаж мөрдөнө
- Аль ч зэрэглэлийн ажилчид, эрэгтэй эмэгтэй хүмүүс, ажилтай хамааралтай хэн нэгэн хүн, оршин суугчдын төлөөлөл зэрэг хүмүүсийн хооронд доромжилсон дээрэлхсэн, гүтгэсэн ямар нэгэн үйлдлийг гаргуулахаас зайлсхийхийн тулд дотоодын болон гадаадын компаниудын хооронд ажлын байрны бие биеэ хүндэтгэсэн байдлыг бий болгох
- Ажлын цаг, мэдэгдэл өгөх, огцрохтой холбоотой компанийн дүрмийг баримтлах
- Хамтран ажиллагч эсвэл ойр орчмын оршин суугчид, эрэгтэй эмэгтэй аль ч хүмүүсийг ямар нэгэн ялгаварлан гадуурхах зүйлийг тэвчих
- Компанийн ажлын байрны эрүүл ахуй аюулгүй ажиллагааны дүрмийг дагаж мөрдөх

Компани доторх ёс зүйгүй авирлах байдлын тодорхойлолт ба бодлогыг анхааруулах, сануулга өгөх журмын хамтаар тайлбарласан байна.

Гүйцэтгэгч нь ажилчдадаа төслийн ажлын байрны ёс зүйн дүрмийг мөн бэлгийн замын халдварт өвчин, ажлын байрны бэлгийн дарамт, бэлгийн мөлжлөг ба бурангуй үйлдэл, ЖСХ, Ковид 19 зэргийн талаар чиг баримжаа олгосон мэдээллүүдийг болон сургалтуудыг өгөх үүрэг хариуцлагыг хүлээсэн байх ёстой.

ТМО, төслийн гүйцэтгэгч нар нь төсөл хэрэгжиж буй бүх хугацаанд өдөр тутмын удирдлагаар хангаж, төслийн явц болон ахицын талаар хяналт тавьж, мэдээлэн хөдөлмөрийн менежментийн гүйцэтгэлийн байдал, ажлын байрны эрүүл мэнд аюулгүй байдлын талаарх хяналт, сургалтуудын хэрэгжилт зэргийг нэгтгэн дүгнэж, төслийн удирдагч ба эзэмшигч, төслийн менежментийг хариуцагч талуудад товлосон цаг хугацаанд тайлагнаж байна.

Шууд ажилчид

Шууд ажилчид нь холбогдох яам тамгын газруудтай болон засгийн газрын агентлагуудтай хөдөлмөрийн харилцаанд орж, төслийн удирдлага болон менежментийн үйл ажиллагаанд голдуу оролцоно.

Хөдөлмөрийн гомдлыг барагдуулах

Дэлхийн банкны Байгаль орчин нийгмийн стандарт 2-ын хүрээнд ажил хөдөлмөртэй холбоотой гомдол болон гомдол барагдуулах механизм байдаг хэдий ч төслийн гомдол барагдуулах журам гэж байдаг. Ийм гомдол барагдуулах механизмыг ажлын байран дээрх санаа зовоож буй асуудлуудыг дэвшүүлэн гаргаж ирэхийн тулд шууд ажилчид ба гүйцэтгэх ажилчидад зориулан боловсруулдаг. Эдгээр ажилчдыг ажилд орох үед нь гомдол барагдуулах механизмын талаар мэдээлэл өгч хариу арга хэмжээ авахаас тэднийг хамгаалах арга хэмжээ авна. Төслийн эдгээр ажилчдад гомдол гаргах механизмын талаар олж мэдэхэд хялбар болгоно.

Гомдлын механизм нь хууль тогтоомжийн дагуу эсвэл одоо байгаа арбитрын журмаар дамжуулан авах боломжтой бусад шүүхийн болон захиргааны арга хэрэгслийг ашиглахад саад болохгүй, эсвэл хамтын гэрээгээр хангаж өгсөн гомдлын механизмыг орлохгүй. Төсөлтэй холбоотой хөдөлмөрийн гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэх зорилгоор дараах гомдлыг барагдуулах журмыг боловсруулна. Бүтээн байгуулах ажил эхлэхээс өмнө гомдол барагдуулах хороог байгуулна. Төслийн аливаа нэг ажилчид гомдол барагдуулах хороонд гомдлоо и-мэйлээр, утсаар, бичгээр гаргана. Ажилчдыг ажилд авах үед гомдол барагдуулах хороо болон гомдол хүлээн авах имэйл хаягийг ажилчдад танилцуулна.

Ажилчдын гомдол барагдуулах хороо: Үүнд: (i) НЗДТГ, (ii) Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам; (iii) барилгын үндсэн гүйцэтгэгчийн төлөөлөгч, (iv) ТУА дахь гомдол гаргах асуудал хариуцсан ажилтан; (v) ажилчдын төлөөлөгчид / үйлдвэрчний эвлэл, (vi) Нийслэлийн засаг даргын тамгын газрын төлөөлөгчид. Гомдол гаргах хороонд ирсэн өргөдөл гомдлыг ажлын 7 хоногт багтаан хянана.

Хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж нь гомдлын бүртгэлийн маягт болон гомдлын бүртгэлийн дэвтрийг гаргах ёстой. Тэд мөн гомдол гаргагчдад бүртгэлийн маягтыг бөглөхөд нь туслах ёстой. Гомдол гаргагчдад хэзээ хариу өгөх ёстойг мэдэгдэх шаардлагатай юм.

Гомдлыг барагдуулах хороо нь бүтээн байгуулалтын явцад ажлын даалгаварт заасны дагуу тодорхой хугацаанд уулзаж гомдлыг дүгнэн эвлэрүүлж тохиролцуулахын тулд маргаанд оролцоно. Гомдол барагдуулах дээрх механизмыг ажлын зарчимд томъёолж оролцогч талуудад (ажилчид ба ажил олгогчдод) эвлэрүүлэн зохицуулах зарчмаар ажилтай холбоотой гомдлыг шийдвэрлэж байх болно. Хэрвээ гомдол барагдуулах хороо нь гомдлыг шийдвэрлэж чадахгүйд хүрвэл хүснэгтэд заасны дагуу зохицуулалтын зарчмыг ашиглахыг зөвлөнө.

Гомдол барагдуулах хороог хөдөлмөрийн хууль, дүрэм, журмууд болон Дэлхийн банкны БОНХ (БОНС2, хөдөлмөр ба ажлын нөхцөл) хөдөлмөрийн менежменттэй холбоотой

асуудлууд (ажлын байрны техник тоног төхөөрөмж, үр өгөөж, бусад эрхүүд) зэргүүдэд сургана.

Хүснэгт 10. Хөдөлмөртэй холбоотой гомдол барагдуулах зохицуулгын механизм

Сэдэв	Журам	Гомдлыг барагдуулах
Жендэрийн ялгаварлан гадуурхалт	Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011),	Төрийн албаны зөвлөл нь төрийн албан дахь жендэрийн ялгаварлан гадуурхалтын талаархи гомдлыг барагдуулах үйл ажиллагаанд хяналт тавидаг (21-р зүйл) 23 дугаар зүйл, Энэ хуулийн 14 дүгээр зүйлээс бусад зүйл, заалтыг зөрчсөн нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст гомдол гаргах үндэслэл болно
Үндэслэлгүй ажлаас халах, нөхөн төлбөр, гэрээ, шийтгэл,	Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль (1999), 128 дугаар зүйл	Хөдөлмөрийн харилцааны маргааныг шүүхээр хянан шийдвэрлэнэ.
Бусад хөдөлмөрийн маргаан	Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль (1999), 126 дугаар зүйл	Хөдөлмөрийн маргаан таслах комисс нь Монгол Улсын 1999 оны Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу шүүх хянан шийдвэрлэхээр зааснаас бусад маргааныг хянан шийдвэрлэнэ (126 дугаар зүйл).

ХАВСРАЛТ 3. Талуудын оролцоог хангах төлөвлөгөө

1. Удиртгал

Улаанбаатар хотын Тогтвортой авто зам, тээврийн төсөл (цаашид “төсөл” гэх)-ийн Талуудын оролцооны төлөвлөгөө (ТОХТ)-ний төслийг 2021 оны 3 дугаар сард боловсруулан, баримт бичгийн төслийг Улаанбаатар хотын Захиргааны вэб хуудснаа тавьсан.

Дэлхийн банк (цаашид “Банк” гэх) тус төслийг хэрэгжүүлэхэд Олон улсын хөгжлийн холбооноос зээлийн 100 сая ам долларын санхүүжилтыг Монгол Улсын Сангийн яаманд олгохоор төлөвлөж байна. Төслийн хэрэгжүүлэгч байгууллага Улаанбаатар хотын Захиргаа; хэрэгжүүлэгч байгууллагууд НАЗХГ, ЗХУТ, НТҮГ (цаашид “хэрэгжүүлэгч байгууллагууд” гэх) юм.

Энэхүү Талуудын оролцооны хангах төлөвлөгөө (ТОХТ)-г төслийн оролцогч талуудын дунд зохион байгуулсан сургалт семинаруудаар дамжуулан, мэдээлэл хүргэх, хэлэлцэх аргуудыг гомдол санал хүлээн авч шийдвэрлэх механизмын аргатай хослуулан боловсруулав.

“Оролцогч тал” гэж (а) төслийн нөлөөлөлд өртөж байгаа эсвэл өртөж болох иргэд ба бүлгүүд (хамтад нь “төслийн нөлөөлөлд өртөх талууд” гэх); (б) төслийн үйл ажиллагааг сонирхогч тал (“бусад сонирхогч талууд” гэх)-ууд гэсэн үндсэн хоёр хэсэгт хуваан үзэж байгаа болно.

Талуудын оролцоо нь төслийн амьдралын мөчлөгийн туршид өргөн хүрээтэй үйл явц байх бөгөөд үүний гол зорилго төслийн байгаль орчин, нийгмийн эрсдлийн удирдлагыг амжилттай хэрэгжүүлэх хүчтэй, үр дүнтэй, хариу үйлдэл бүхий харилцаа холбоог хөгжүүлэхэд чиглэж байгаа болно. Талуудын оролцоог төслийн бүр эхний үе шатаас эхлэн хангах нь хамгийн үр дүнтэй арга зам байхын зэрэгцээ төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг үнэлэх, удирдах хяналт шинжилгээ хийж төслийн эхэн үед шийдвэр гаргах үйл явцын салшгүй нэг хэсэг байна.

2. Зорилго цар хүрээ

Талуудын хамтын ажиллагааг Дэлхийн Банкны БОНХ, Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн стандарт (БОНС) 10-т тодорхойлсон үндсэн зорилгууд:

- Оролцогч талуудыг тодорхойлох, нөлөөлөлд өртөх талуудтай харилцаа холбоог тогтоож, үр дүнтэй системтэй харилцах.
- Төслийн оролцогч талуудын сонирхол болон оролцооны түвшинг үнэлэн тодорхойлж төслийн зураг төсөл болон байгаль орчин, нийгмийн хамгаалалттай холбоотой талуудын саналыг тусгах.
- Төсөл хэрэгжих бүх үе шатанд нөлөөлөлд өртсөн талуудтай үр дүнтэй, хүртээмжтэй, бүх талуудын оролцоог хангаж холбогдож байх.
- Төслийн үйл ажиллагаа болон түүний байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн тухай мэдээллийг оролцогч талуудад цаг тухайд нь ойлгомжтой, хүртээмжтэй зохих журмын дагаа хүргэж ил тод байдлыг хангах.

- Нөлөөлөлд өртсөн талуудад санал, хүсэлт, гомдол гаргах нөхцөл нь хүртээмжтэй арга хэрэгсэл боломжийг олгох, төсөл хэрэгжүүлэгчид санал гомдолд хариу өгч, зохицуулах.

3. Төслийн тодорхойлолт танилцуулга

Бүрэлдэхүүн хэсгүүд	Үйл ажиллагаанууд
<p>Бүрэлдэхүүн хэсэг 1. Гудамж замын цогц коридор</p> <p><i>(тооцоолж буй нийт өртөг: 90 сая америк доллар, ОУСБХБ-ны зээл: 81 сая америк доллар)</i></p>	<p>1.1. Гудамж замын коридорын дэд бүтцийн тусгайлсан хөрөнгө оруулалт</p> <ul style="list-style-type: none"> • I төрөл: коридор шинэчлэл ба өөрчлөн зохион байгуулалт • II төрөл: коридор сайжруулалт <p>1.2 Ухаалаг тээврийн систем (ITS)</p> <p>1.3 Ухаалаг авто зогсоолын удирдлагын систем</p>
<p>Бүрэлдэхүүн хэсэг 2. Нийтийн тээврийн тогтвортой систем</p> <p><i>(тооцоолж буй нийт өртөг:20 сая америк доллар, ОУСБХБ-ны зээл:10 сая америк доллар)</i></p>	<p>2.1: Коридорт зориулсан хөрөнгө оруулалтууд</p> <ul style="list-style-type: none"> • Сонгогдсон коридоруудад автобус эгнээ байгуулах • Төслийн коридоруудын дагуу автобусны буудлуудыг сайжруулах ба үүнд сайн дурын дэлгүүрүүдэд гэр бүлд зориулсан дотор хүлээлгийн орчинг турших орно <p>2.2: Хотын хэмжээний хөрөнгө оруулалтууд</p> <ul style="list-style-type: none"> • Нийтийн тээврийн удирдлагын системүүдийн шинэчлэл • Эрэлтэд суурилсан тээврийн үйлчилгээ нэвтрүүлэлт
<p>Бүрэлдэхүүн хэсэг 3. Зам, тээврийн төлөвлөлт, менежментийн үр дүнтэй институциуд</p> <p><i>(тооцоолж буй нийт өртөг: 10 сая америк доллар, ОУСБХБ-ны зээл: 9 сая америк доллар, Буцалтгүй тусламжийн сан: 0.45 сая америк доллар)</i></p>	<p>3.1. Стратегийн судалгаанууд: (а) алсын хараа, стратеги; (б) замын дэд бүтцийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, менежмент; (в) авто замын аюулгүй байдал; (г) нийтийн тээвэр</p> <p>3.2 Чадавх бэхжүүлэх ба хэрэгжилтийн дэмжлэг</p> <ul style="list-style-type: none"> • Төслийн менежмент болон хэрэгжилтийн дэмжлэг • ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах • Семинар, сургалт, хурал, танилцах аялал

<p>Бүрэлдэхүүн хэсэг 4: Болзошгүй, онцгой байдлын хариу арга хэмжээ (CERC) <i>(нийт өртөг: 0 америк доллар)</i></p>	<p>Энэхүү тэг өртөгтэй бүрэлдэхүүн хэсэг нь онцгой хямрал гэж хүлээн зөвшөөрөгдсөн онцгой байдлын үед түргэн хариу арга хэмжээ авахад зориулагдсан бөгөөд Улаанбаатараас шаардлагатай тохиолдолд яаралтай тусламж үзүүлэх, сэргээн босгох ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор төслийн санхүүжилтийг дахин хуваарилуулах хүсэлтийг Дэлхийн банкинд гаргах суваг, боломжийг олгоно.</p>
--	---

БОНМХ-ны нэгдүгээр бүлэгт төслийн дэлгэрэнгүй тодорхойлолт орсон.

4. Эрхзүйн шаардлага

ДБ-ны “Байгаль орчин, нийгмийн стандарт 10”-г дагаж мөрдөхөөс гадна 2015 онд батлагдсан “Хот байгуулалтын” тухай хуулийн 17, 18 дугаар зүйлийн дараах заалт заалтыг дагаж мөрдөнө. Үүнд:

- Хот төлөвлөлтийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоотой төлөвлөлтийн зарчмыг тусгаж ажиллана.
- Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, хотын захирагчийн ажлын алба нь энэ хуулийн хүрээнд гаргасан аливаа шийдвэрийн талаар тухай бүр олон нийтэд мэдээлнэ.
- Хэрэглээний тасалдлыг оршин суугчид болон аж ахуйн нэгжүүдэд 24 цагийн өмнө мэдээлэх шаардлагатай.

2012 онд батлагдсан “Байгалд орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 5, 8 дугаар зүйлд дараахыг тусгасан. Үүнд:

- Хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа хөтөлбөр, төлөвлөгөөнд стратегийн үнэлгээ хийх талаарх мэдээллийг нийтэд мэдээлж, төрийн захиргааны төв байгууллага өөрийн цахим хуудсанд байрлуулах бөгөөд хэвлэмэл хувилбартай танилцах боломжийг бүрдүүлнэ.
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх зөвлөх орон нутгийн удирдлага, орон нутгийн иргэдтэй оршин сууж буй газар нутагт үзүүлэх нөлөөний талаар зөвлөлдөн санал авах бөгөөд олон нийтээс санал ирүүлэх хугацаа нь ажлын 30-аас дээшгүй өдөр байх бөгөөд амаар болон бичгээр санал авна.
- Байгалд орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хурлын тэмдэглэл, орон нутгийн удирдлагын санал, нөлөөнд автах орон нутгийн иргэдтэй зөвшилцсөн байдал зэргийг тусгасан байна.

5. Үнэлгээний өмнө төслийн бэлтгэл ажлын хүрээнд талуудтай хийсэн уулзалт, хэлэлцүүлэг

Оролцогч талууд	Сэдэв	Хэзээ болох	Хэлэлцүүлэг
-----------------	-------	-------------	-------------

Төслийн гүйцэтгэгч, хэрэгжүүлэгч байгууллагууд	БОНХ-ний үйл явц ба зохион байгуулалтын талаарх хэлэлцүүлэг	2021оны 3 сарын 11	НЗДТГ-ын холбогдох харьяа байгууллагуудад мэдээлэл өгсөн
Хот төлөвлөлт ба газрын асуудал эрхэлсэн газар	Нүүлгэн шилжүүлэлт	2021оны 3 сарын 15	Нүүлгэн шилжүүлэлтийн журам ба төслийн хүрээн хийгдэх зохицуулалт
Монгол улс: УБ хотын үйлчилгээ, гэр хорооллын хөгжилд оруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр, АХБ-ны санхүүжилттэй төсөл	Бүтэц зохион байгуулалт, Байгаль орчин, нийгмийн асуудал	2021оны 3 сарын 16	Бүтэц зохион байгуулалт, Байгаль орчин, нийгмийн холбогдож журам Чадавх бэхжүүлэх
Төслийн гүйцэтгэгч, хэрэгжүүлэгч байгууллагууд	БОНХ-ний үнэлгээ	2021оны 3 сарын 25	ТББ-ын төлөөлөл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгардаг гол асуудлууд болон боломжит засаж сайжруулах аргуудыг тодотгосон

6. Оролцогч талуудын тодорхойлолт, дүн шинжилгээ

Төслийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх явцад талуудтай хамтран, асуудлыг зөвшилцөн хэлэлцэхэд юун түрүүнд төсөлд оролцон, гишүүдийнхээ эрх ашиг сонирхлыг илэрхийлэн, эрх ашиг сонирхолд нөлөөлж чадах, нийт гишүүдээр албан ёсоор итгэмжлэгдэн сонгогдсон холбогдох бүлгүүдийн төлөөллийг тогтоох шаардлага гардаг. Нутгийн иргэдийн төлөөлөл нь төслийн үйл ажиллагааг орон нутагт оновчтой хэрэгжүүлэхэд тустай, чухал санааг хуваалцан, төсөлтэй холбоотой мэдээ мэдээллийг орон нутагт түгээн дэлгэрүүлэх, төслийг түүний зорилтот бүлэгтэй холбож, тэдний хоорондын сүлжээг бүрдүүлэхэд гол үүрэгтэй ажилладаг. Оролцогч талуудын төлөөллийг баталгаажуулах (жишээ нь: төлөөлж буй иргэдээр албан ёсоор сонгогдон, тэдний эрх ашиг сонирхлыг бүрэн илэрхийлж чадахыг баталгаажуулсан үйл явц) нь оролцогч талын хувьд иргэд олон нийттэй холбоо харилцаа тогтоох чухал ажил хэвээр үлдэнэ. Иргэд олон нийтийн жинхэнэ төлөөлөл мөн эсхийг тухайн бүлгийн гишүүдээс санамсаргүйгээр түүвэрлэн албан бусаар уулзаж ярилцан баталгаажуулж, тэдний эрх ашиг сонирхлыг хэн хамгийн үр дүнтэй илэрхийлж, төлөөлж чадахыг тэдний санал бодлыг үндэслэн тогтоож болно. КОВИД-19 цар тахлын өнөөгийн нөхцөлд олон нийтийн арга хэмжээг хязгаарлаж эсвэл хориглож буй байгаа болохоор төслийн нөлөөлөлд өртөх хүмүүст хүрч ажиллахад төрөл бүрийн орчин бүхий хувь хүнд илүү чиглэн талуудыг тодорхойлно гэсэн үг болно.

Хүснэгт 11 Оролцогч талууд

Оролцогч талууд	Төслийн хэрэгжилтэд гүйцэтгэх үүрэг	Сонирхол	Нөлөө
Дэлхийн Банк	Төслийг санхүүжүүлнэ.	Өндөр	Өндөр
	Төслийн зорилгыг биелэлтэд хяналт тавина.		
Зам тээврийн хөгжлийн яам	Төслийн удирдах зөвлөлөөр дамжуулан төслийг хэрэгжүүлэх ерөнхий чиглэлээр хангах	Дунд	Өндөр
Байгаль орчин, аялал жуулчлалын яам/ Нийслэлийн байгаль орчны газар	Байгаль орчин, аялал жуулчлалын яам/Нийслэлийн байгаль орчны газар нь байгаль орчны зөвшөөрөл олгох, өөрсдийн шийдвэрт тулгуурлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Дунд	Дунд
Сангийн яам	Сангийн яамны сайдын 4 дүгээр тушаалаар батлагдсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын биелэлтийг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх.	Дунд	Өндөр
	Төслийн удирдах зөвлөлөөр дамжуулан төслийн хэрэгжилтийг үндсэн чиглэлээр хангах.		
НЗДТГ	Гүйцэтгэх болон хэрэгжүүлэгч агентлаг. Төслийн удирдлагын албыг томилох болон төслийн төлөвлөлт, удирдлага, зохицуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг хариуцана.	Өндөр	Өндөр
Нийслэлийн авто замын хөгжлийн газар	Төслийг хэрэгжүүлэгч байгууллага	Өндөр	Өндөр
	Төслийн хэрэгжилтэд оролцох		
Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын газар	Төслийг хэрэгжүүлэгч байгууллага	Өндөр	Өндөр
Тээврийн цагдаа	Төслийг хэрэгжүүлэгч байгууллага	Өндөр	Өндөр

Нийтийн тээврийн үйлчилгээний газар	Төслийг хэрэгжүүлэгч байгууллага	Өндөр	Өндөр
Хот байгуулалт хөгжлийн газар	Дэмжлэг, зөвшөөрөл	Дунд	Дунд
Улаанбаатар хотын Хот төлөвлөлт, архитектур, дизайны институт	Дэмжлэг	Дунд	Дунд
Нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын алба	Хамаарал бүхий дүүргийн газар зохион байгуулалтын албадууд газар өмчлөлийн гэрчилгээ, газрын сертификат, газар ашиглах гэрээ, кадастрын зураг гаргах зэрэг зөвшөөрөл олгох. Төслийн удирдлагын албыг Нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.	Дунд	Өндөр
МХЕГ	Бүтээн байгуулалтын явцад тогтмол давтамжтай хяналт тавих	Дунд	Өндөр
Дүүрэг хороо	Дэмжлэг	Өндөр	Дунд
Төслийн удирдах хороо	Нийслэлийн засаг даргын тамгын газар (НЗДТГ) мөн Сангийн яам удирдах чиг үүрэгтэй. Зам Тээврийн Яам, болон бусад талууд тодорхойлогдоогүй байгаа тул удирдах зөвлөл нь СЯ-ны сайдын 4 дүгээр тушаалаар батлагдсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын дагуу дагуу төслийн хэрэгжилтэд ерөнхий чиглэлээр хангана.	Өндөр	Өндөр
Төслийн удирдах алба	Төслийн хэрэгжилтийг бүхэлд нь хариуцна.	Өндөр	Өндөр
Гэрээт гүйцэтгэгч	Төслийн хамтрагч	Өндөр	Өндөр
	Төслийн хэрэгжилтэд оролцох		
Зөвлөх	Төслийн хамтрагч	Дунд	Дунд
	Төслийн хэрэгжилтэд оролцох		

Судалгааны байгууллага	Төслийн хамтрагч	Өндөр	Бага
	Төслийн хэрэгжилтэд оролцох		
Иргэний нийгмийн байгууллага	Төслийн хамтрагч	Өндөр	Бага
	Төслийн хэрэгжилтэд оролцох		
ТББ	Төслийн хамтрагч	Өндөр	Бага
	Төслийн хэрэгжилтэд оролцох		
Төслийн нөлөөлөлд өртсөн улсын байгууллагууд	Төслийн хэрэгжилтэд оролцох	Өндөр/Нөлөөлөлд өртсөн	Бага
Төслийн нөлөөлөлд өртсөн хувийн хэвшил	Төслийн хэрэгжилтэд оролцох	Өндөр/Нөлөөлөлд өртсөн	Бага
Төслийн нөлөөлөлд өртсөн Иргэд	Төслийн хэрэгжилтэд оролцох	Өндөр/Нөлөөлөлд өртсөн	Бага
Төслийн нөлөөлөлд өртсөн Эмзэг бүлэг	Төслийн хэрэгжилтэд оролцох	Өндөр/Нөлөөлөлд өртсөн	Бага
Зам хэрэглэгч	Төслийн хэрэгжилтэд оролцох	Өндөр/Нөлөөлөлд өртсөн	Бага


7. Аргачлал

Сайн шилдэг практик арга ажиллагааны аргачлалаас суралцаж, нэвтрүүлэхдээ төсөл талуудын оролцооны дараах зарчмуудыг дагаж мөрдөнө. Үүнд:

- *Нээлттэй, амьдралын мөчлөгөөр хандах хандлага:* төслийн олон нийтийн уулзалт хэлэлцүүлгийг төслийн амьдралын мөчлөгийн хэмжээнд гадны ба хөндлөнгийн оролцоо, арга зам хайлт, албадлага эсвэл сүрдүүлгээс ангид нээлттэй хэлбэрээр явуулна;
- *Мэдээлэл хуваалцан, санал бодлыг солилцох байдлаар оролцоог хангах:* төслийн бүх оролцогч талд мэдээллийг боломжит хэлбэрээр өргөн хүрээгээр хүргэж; талуудын санал бодол, асуудлыг хүлээн авч, дүн шинжилгээ хийх боломжуудыг бүрдүүлж ажиллана;

- *Хүртээмжтэй ба мэдрэмжтэй байдал.* оролцогч талуудыг тодорхойлох үйл явц нь илүү сайн, үр дүнтэй мэдээлэл, холбоо харилцаа тогтоохыг дэмжихэд гол чиглэнэ. Төслийн оролцооны үйл явц хүртээмжтэй, өргөн хүрээг хамарсан байна. Төсөл оролцогч бүрийг зөвлөх, хэлэлцэх үйл явцад байнга оролцож байхыг дэмжин ажиллана. Оролцогч талуудад мэдээллийг тэгш хүртэх, авах боломжийг олгоно. Оролцооны аргуудыг сонгохдоо талуудын хэрэгцээг мэдэрч ажиллахыг гол зарчим болгоно. Нийгмийн эмзэг бүлгүүд ялангуяа өндөр настан, үндэстний цөөнхийн бүлгүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд онцгой анхаарал хандуулна.
- *Уян хатан байх:* хэрэв нөхцөл байдлаас үүдэн зайнаас харилцах шаардлага оролцооны уламжлалт хэлбэрүүдийг мөрдөхөд саад учруулах бол, аргачлалд интернет ба цахим орчны төрөл бүрийн хэлбэрийг оруулан оролцооны бусад хэлбэрүүдийг нэвтрүүлнэ.

Талуудын оролцоог хангах төрөл бүрийн арга хэрэгсэл байдаг. Тэдгээр аргачлалын нэг нь сонирхогч талуудын хэрэгцээг хангах ирээдүйн тогтвортой хувилбаруудыг тодорхойлоход чиглэсэн буцаан харах аргачлал юм. (Quist, 2006) Буцаан харах аргачлал нь засгийн газар, компаниуд, олон нийтийн ашиг сонирхлын бүлгүүд, мэдлэгийн байгууллагууд гэх мэт янз бүрийн бүлгүүдийн оролцогч, талуудыг өргөн хүрээнд хамруулж, асуудлыг тодорхойлж, шийдэл, нөхцлийг эрэлхийлж, хуваалцсан хөгжүүлэлтийг нэгтгэх боломжийг олгодог.



Зураг 8 Эргэн харах аргачлал болон талуудын оролцоог хангах жишээ

Үр дүнтэй, нөхцөл байдалд тохирсон оролцоог хангах зорилгоор төлөвлөж буй төслүүдийн оролцогч талуудыг дараах цөм ангилалд хувааж болно. Үүнд:

- *Нөлөөлөлд өртөх талууд:* төслийн шууд нөлөө (бодит эсвэл боломжит)-нд өртөх ба/эсвэл төсөлтэй холбоотой хийгдэх өөрчлөлтөнд хамгийн их өртөх гэж тодорхойлогдсон ба нөлөөлөл болон тэдгээрийн үр дагаварыг тодорхойлох болон нөлөөллийг бууруулах ба менежментийн арга хэмжээний талаар шийдвэр гаргахад оролцох хэрэгтэй гэж үзсэн төслийн нөлөөллийн бүсэд амьдардаг иргэд, бүлэг ба бусад этгээд орж болно;
- *Бусад сонирхогч талууд:* төслийн шууд нөлөөлөлд өртөхгүй ч төсөл тэдний эрх ашиг сонирхолд нөлөөлж байна гэж үзэж эсвэл ойлгож байгаа ба/эсвэл тэдний эрх ашиг сонирхолд ба төсөл, түүний хэрэгжилтэнд ямар нэг байдлаар нөлөөлж болох гэж үзсэн хувь хүмүүс/бүлэг/ этгээд орж болно.
- *Эмзэг бүлгүүд:* төсөлтэй холбоотой хэлэлцүүлэг, шийдвэр гаргах үйл явцад төлөөллийг тэгш хангахад бусад бүлгүүдтэй харьцуулахад эмзэг гэж тогтоогдсон, төсөл (үүд)-ээс харилцан адилгүй хэмжээгээр нөлөө үзүүлэх эсвэл цаашид эмзэг бүлэгт орж болох хүмүүс орж болно.

Төслийн нөлөөлөлд өртөх талуудад нүтгийн иргэд, олон нийтийн бүлэг нөхөрлөлийн гишүүд болон төслийн шууд нөлөөнд өртөж болох бусад талууд орно. Энд ялангуяа дараах хувь хүмүүс, бүлгүүд орно. Үүнд:

- Бүх зам хэрэглэгчид
- Ойр орчин амьдарч буй бүх насны иргэд
- Аж ахуй нэгж
- Эмзэг бүлгийн иргэд

Бусад сонирхогч талууд: Төслийн оролцогч талуудад шууд нөлөөлөлд өртсөн олон нийтийн бүлгээс бусад талууд орно.

- Бусад үйл ажиллагаа эрхлэгчид, үйлчилгээ үзүүлж буй байгууллага болон ханган нийлүүлэгчид
- Мэдээллийн эх үүсвэр, сангууд. Жишээ нь: судалгааны институт, олон улсын болон үндэсний зөвлөхүүд
- Бусад дотоод болон гадаадын байгууллагууд
- Хэвлэл мэдээллийн байгууллагууд
- Олон нийт
- Бүх шийдвэр гаргах түвшиний байгууллагууд (Бүлэг 7)

Эмзэг ба амьжиргааны түвшин доогуур иргэд ба тэдний бүлэг

Энд төслийн нөлөөллийг ойлгон, асуудлаа илэрхийлэх чадвар сул, амьжиргааны түвшин доогуур ба эмзэг бүлгийн иргэд ба бүлгүүдийн төслийн нөлөөлөл өртөх байдал харилцан адилгүй гэж үзэн, амьжиргааны түвшин доогуур ба эмзэг бүлгийн иргэд ба бүлгүүдэд

ялангуяа халдварт өвчин, эмчилгээний талаар мэдээлэл сурталчилгаа, оролцоог хангахад тэдний эмзэг байдал, санаа зовж буй асуудал, соёлын эмзэг байдлыг авч үзэн, тэдний дунд төслийн үйл ажиллагаа болон үр өгөөжийн талаар бүрэн гүйцэт ойлголт бий болгоход гол анхаарлаа хандуулах нь чухал болно. Эмзэг байдал хүний гарал үүсэл, гендер, нас, эрүүл мэнд ба эдийн засгийн нөхцөл байдал, санхүүгийн баталгаагүй байдал, иргэдийн дунд дорой сул гэж үзэгдэх (жишээ нь: цөөнхи эсвэл ялгаварлан гадуурхагддаг), бусад иргэд эсвэл байгалийн нөөц зэргээс хамааралтай байдлаас үүдэлтэй байж болно. Эмзэг бүлэг, иргэдийн оролцоог хангахад ихэнхидээ тэдэнд чиглэсэн тусгай арга хэмжээ авч, төсөлтэй холбоотой шийдвэр гаргахад тэдний оролцоог идэвхижүүлж тусласнаар тэдний ойлголт, мэдлэг, оролцоо төслийн бусад талуудтай адил тэнцүү болж чадна.

Төслийн хүрээнд эмзэг буюу ядуу бүлгүүдэд дараах бүлгүүд орж (гэхдээ эдгээрээр хязгаарлахгүй) болно. Үүнд:

- Хүүхдүүд
- Өсвөр үеийнхэн
- Эмэгтэйчүүд
- Өндөр настай иргэд
- Ядуу иргэд
- Дундаас доогуур орлоготой өрх болон ганц бие өрх толгойлсон эцэг/эх
- Албан ёсны бүртгэлгүй түр оршин суугчид (хөдөөнөөс хотод шилжилт хөдөлгөөн) мөн газар өмчлөөгүй иргэд
- Нийгмийн цөөнх бүлгийн өрхүүд
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
- Шууд орч гарц шаардлагатай төслийн талбайд байрлах жижиг дунд аж ахуй нэгжүүд

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо

ХБИ оролцоог ханган харилцах арга зам харилцан адилгүй байх бөгөөд дараах жишээ хэлбэрээр ойлголцож болно. Үүнд:

- Сонсголын бэрхшээлтэй хүмүүст тохионы хэлээр харилцаж, уулзалт хэлэлцүүлгээр юуны талаар ярилцаж байгааг ойлгуулах.
- Сонсголын аппарат, туслах хэрэгсэлтэй хүмүүст нийтийн уулзалт хэлэлцүүлгийн үед тод сонсох арга хэмжээг авах.
- Суралцах чадвар хязгаарлагдмал хүмүүст гол асуудлыг ойлгох боломжтой болгож баримт бичгүүдийг амархан унших (энгийн хялбаршуулсан) хувилбар гаргах.
- Оюун ухаан хөгжлийн асуудалтай хүмүүст уулзалт ярилцлагын үеэр айдастай тулгарах асуудлаа даван туулахад туслах зорилгоор уулзалтаас өмнө урьдчилан

уулзаж ярилцах. Айдасаа давж гарахад туслах нь нийгэмд гадуурхагдсан хүмүүсийг нийгмийн харилцаанд оруулахад туслана.

- Тэргэнцэртэй хөдөлгөөн хязгаарлагдмал хүмүүст барилга байгууламжид орох хаалганд зориулалтын налуу эсвэл тэгш зам, шатны оронд цахилгаан шатаар орох боломж олгож, барилгын дотор орчинд хөдлөх хангалттай орон зайтай байхаас гадна тэдэнд зориулсан ариун цэврийн байгууламжтай байна.

8. Талуудын оролцоо

Улсын онцгой комисс (УОК)-оос КОВИД-19 цар тахлыг тархалтыг хумих арга хэмжээ үр дүнтэй хэрэгжих хүртэл гамшгаас хамаагаалах зорилгоор бүх нийтийн бэлэн байдлыг хэд хэдэн удаа зарлах шийдвэр гаргасан (УОК, 2021).

КОВИД-19 цар тахал халдварын өндөр эрсдэлтэй харгалзан халдвар ба/буюу тархалтаас урьдчилан сэргийлэх арга барилыг олон нийтийн уулзалт хэлэлцүүлэгт дагаж мөрдөнө. КОВИД-19 цар тахлын өнөөгийн нөхцөлд мэдээлэл, харилцааны сувгуудыг сонгохдоо дараах зүйлийг авч үзнэ. Үүнд:

- Олон нийтийн уулзалт, сонсгол, сургалт семинар зэрэг нийтийг хамарсан арга хэмжээ, цугларалт (үндэсний хэмжээний хязгаарлалт, журам, зөвлөмжийг даган)-аас зайлсхийх;
- Хэрэв уулзалт ярилцлагыг цөөн тооны хүмүүст явуулахыг зөвшөөрөх бол фокус бүлгийн уулзалт цөөн тооны хүмүүсийн дунд уулзалт хийх. Хэрэв үүнийг зөвшөөрөхгүй бол онлайн ба цахим орчны уулзалт ярилцлага зэрэг боломжит бүх хэлбэрийг ашиглах;
- Мэдээлэл, харилцаа холбооны хэрэгслийг төрөлжүүлэх ба олон болгож, нийгмийн цахим харилцааны орчин, онлайн сувгуудад гол түшиглэх, боломжтой бол оролцогч талуудын төрөл, ангилалд үндэслэн зорилгод нийцүүлэн тусгайлан гаргасан онлайн платформ, бүлгүүдийг бий болгох;
- Оролцогч талууд онлайн харилцах боломжгүй эсвэл тэдгээрийг төдийлөн их ашигладаггүй бол мэдээлэл, харилцаа холбооны уламжлалт сувгууд (телевиз, сонин, радио, утасны тусгай дугаар ба шугам, шуудан)-ыг ашиглах. Уламжлалт сувгууд нь талуудад мэдээ мэдээлэл хүргэх дамжуулж, тэдний санал бодол, зөвлөгөөг авах, хуваалцахад илүү үр дүнтэй байж болно;
- Төслийн нөлөөнд өртөж буй хүмүүс эсвэл төслийн үр шим хүртэгчдийн шууд оролцоо нэн чухал үед цахим шуудангаар мессеж хүргэх, шуудан илгээмж, онлайн платформ болон мэдээлэл өгөх оператор бүхий утасны тусгай шугам зэрэг боломжит хэлбэрүүдийг хослуулан нөлөөлөлд өртөж буй өрх бүртэй шууд харилцах сувгуудыг тодорхойлно;
- Оролцоог хангах боломжит сувгуудыг нэгбүрчлэн тодорхойлж, талуудын санал бодол, зөвлөгөөг хэрхэн авахыг тодорхой зааж өгсөн байх нь чухал.

Мэдээллийг ил тод болгох ерөнхий стратеги

Оролцогч талууд	Эрх ашиг сонирхол	Харилцах арга, хэлбэр	Төслийн үе шат			Хариуцах
			Өмнө	Барих	Ашиглалт	
Бүх талууд	Төслийн мэдээллийг хүргэх	Бүх оролцогч бүлгүүдтэй тогтмол уулзалт хийх, эмзэг бүлэгт анхаарлаа хандуулах; Зарлал, захидал, вэбсайт				НЗДТГ, ТУА, дүүрэг хороо, иргэдийн бүлэглэл
Бүх талууд	Дэд төслийн зураг төслийн шаардлагууд	Бүх оролцогч бүлгүүдтэй тогтмол уулзалт хийх, эмзэг бүлэгт анхаарлаа хандуулах; Зарлал, захидал, вэбсайт				НЗДТГ, ТУА, дүүрэг хороо, иргэдийн бүлэглэл
Сангийн яам	Зөвшөөрөл олгох	Албан бичиг уулзалтууд				НЗДТГ, ТУА
Нийтийн аж ахуй, хот төлөвлөлтийн удирдлагууд	Засвар үйлчилгээний хуваарьтай ажлуудыг уяалдуулах, зөвшөөрөл	Албан бичиг уулзалтууд				НЗДТГ, ТУА
Дүүрэг хороодын засаг дарга	Дэмжлэг хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах	Албан бичиг уулзалтууд				НЗДТГ, ТУА
БОАЖЯ	Зөвшөөрөл авах, хяналт шалгалт	Албан бичиг, БОННУ БОМТ				НЗДТГ, ТУА
МХЕГ	Зөвшөөрөл авах, хяналт шалгалт	Уулзалтууд				НЗДТГ, ТУА, Хэрэгжүүлэгч байгууллага
Зам дагуу байрлах хувийн хэвшил	Дэмжлэг	Уулзалтууд				НЗДТГ, ТУА, Хэрэгжүүлэгч байгууллага

Хорооны иргэд	Замын хөдөлгөөны саатал	Олон нийтийн уулзалт, Зам засварын ажлын зарын самбар, оршин суугчдад илгээсэн захидал, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн платформ, вэбсайт, телевиз, радио, сонин, Нийслэлийн захиргааны байгууллагын вэбсайт (www.ulaanabaatar.mn)				НЗДТГ, ТУА, Хэрэгжүүлэгч байгууллага
ШУА-ийн Археологийн хүрээлэн (ШУА)	Археологийн эд зүйлсийн барилга байгууламжтай холбоотой тохиолдлын олдворууд	Албан бичиг уулзалтууд				ТУА, Хэрэгжүүлэгч байгууллага
Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яам (БСШУЯ)	Археологийн эд зүйлсийн барилга байгууламжтай холбоотой тохиолдлын олдворууд	Уулзалтад мэдээлэх, төслийн ажилд урих албан бичиг				ТУА, Хэрэгжүүлэгч байгууллага
ТББ	Зураг төсөл, асуудлыг тодорхойлох, мэдлэгийн эх үүсвэр, Сургалт	Бүх оролцогч бүлгүүдтэй тогтмол уулзалт хийх, эмзэг бүлэгт анхаарлаа хандуулах; Зарлал, захидал, вэбсайт				ТУА, Хэрэгжүүлэгч байгууллага
Хэвлэл мэдээлэл	Төслийн мэдээллийг хүргэх	Хэвлэл мэдээлэл				НЗДТГ, ТУА, Хэрэгжүүлэгч байгууллага
Донор болон олон улсын байгууллагууд	Төслийн байршил	Төслийн мэдээ, цахим хүүдас, хэвлэл мэдээлэл, уулзалтууд				ТУА, Хэрэгжүүлэгч байгууллага

9. Хяналт шинжилгээ (мониторинг) ба тайлан

ТУА-ны хамгааллын ажилтан (байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд) ТОХТ-ний дагуу талуудын оролцоог хангах ажлыг хариуцан явуулж, талуудтай тогтоосон харилцаа холбоо, тэдний оролцооны сувгуудын ажиллагааг үргэлжлүүлнэ. Ялангуяа ТУА төслийн байгаль орчин, нийгмийн асуудлаар оролцогч талуудын санал бодлыг авч, Байгаль орчин, нийгмийн асуудлаар авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийг хангана.

Хэлэлцэх, мэдээллийг ил тод болгох үйл ажиллагааны хэрэгжилт, явцыг ДБ-нд хүргүүлэх төслийн хагас жилийн төлөвлөгөөнд тусган, тайлагнасан байна. Гүйцэтгэлийн гол индикаторуудад ТУА тогтмол хяналт шинжилгээ хийх бөгөөд дараах үзүүлэлтүүд орсон байна. Үүнд:

- Тухайн тайлант хугацаа (жишээ нь: сар, улирал, жил)-нд зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэг болон бусад олон нийтийг хамарсан хэлэлцүүлэг/форум;
- Олон нийтийг хамруулсан үйл ажиллагааны давтамж;
- Тухайн тайлант хугацаа (жишээ нь: сар, улирал, жил)-нд иргэд олон нийтээс хүлээн авсан өргөдөл, гомдлын тоо ба тогтоосон хугацаанд шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо;
- Иргэд олон нийтээс хүлээн авсан өргөдөл, гомдлыг төрөл;
- Үндэсний хэмжээний хэвлэлд гарсан/хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсан материалын тоо.

10. Талуудын оролцооны үйл ажиллагааны нөөц ба үүрэг хариуцлага

Төслийн удирдлагын алба (ТУА)-г Улаанбаатар хотын Захиргаанд байгуулж, төслийн Захирал удирдан ажиллана. Улаанбаатар хотын Захиргаа төслийн бэлтгэл ажил, хяналт удирдлага, хяналт шинжилгээ ба үнэлгээг оруулан төслийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангана. Төслийн хүрээнд төлөвлөсөн талуудын оролцоог хангах үйл ажиллагааны санхүүжилтийг ТУА-нд олгосон байна.

ТУА-ны бүрэлдэхүүнд энэхүү Талуудын оролцооны төлөвлөгөөний үйл ажиллагааг хариуцан ажиллах хамгааллын мэргэжилтнүүд орсон байна. Төслийн бэлтгэл ажлын энэ шатанд холбогдох асуулт, тодруулгыг НЗДТГ-т хүргүүлж болно.

Улаанбаатар хотын Захиргаа нь энэхүү төлөвлөгөөний хэрэгжилттэй холбон явуулах шаардлагатай сургалтуудыг явуулах бөгөөд сургалтуудад ажил үүргийнхээ дагуу иргэд олон нийттэй харилцах, хамтран ажиллах ажилтнууд болон удирдах багийн бүрэлдэхүүн хамрагдсан байна. Түүнчлэн төслийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, барагдуулах механизмын хүрээнд талуудын өргөдөл, гомдлын асуудлаар ажиллах мэргэжилтнүүдэд мэргэжлийн ба техникийн сургалтуудыг зохион байгуулна. Төслийн ажилтнууд мөн хөдөлмөрийн удирдлагын журмын дагуу ажил хөдөлмөр эрхлэлттэй холбоотой өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбоотой зааварчилгааг авсан байна.

11. Санал гомдол барагдуулах механизм

Өргөдөл, гомдол барагдуулах механизм нь хүрээлэн буй орчинтой холбоотой өргөдөл, гомдол, төслийн хэрэгжилтийн сөрөг нөлөөнд өртөж болзошгүй хүмүүс/орон нутагт тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн хандлагыг бий болгоход чиглэнэ.

Төслийн удирдлагын албаны инженерийн ажилтнууд төслийн бүх үе шатанд өргөдөл, гомдлыг хянан үзэх, бүртгэх, жижиг асуудлуудыг газар дээр нь шийдвэрлэх, өргөдөл, гомдлыг анхаарах, оролцогч талуудад хариу өгөх зорилгоор өргөдөл, гомдол барагдуулах механизмыг хэрэгжүүлэх санаачилгыг гарган төслийн удирдлагын алба нь өргөдөл, гомдол барагдуулах механизмыг хэрэгжүүлэх явц, дарааллыг боловсруулна.


Төсөл хэрэгжих явцад өргөдөл, гомдол барагдуулах механизмын талаар олон нийттэй зөвлөлдөн монгол хэлээр оролцогч талуудын дунд мэдээлэл тараана. Өргөдөл, гомдлыг дараах дөрвөн үе шатаар шийдвэрлэнэ.

Нэгдүгээр үе шат: Орон нутгийн түвшинд өргөдөл, гомдлыг шийдвэрлэх. Өргөдөл, гомдол барагдуулах механизмын систем нь төслийн сөрөг нөлөөнд өртөж болзошгүй талуудаас (орон нутгийн оршин суугчид, аж ахуйн нэгжийн төлөөлөгчид, гэрээлэгчдийн ажилтнууд гэх мэт) ирүүлсэн гомдол, саналыг хэд хэдэн хувилбараас хамгийн боломжит арга замыг сонгох байдлаар шийдвэрлэх боломжийг олгоно. Төслийн сөрөг нөлөөнд өртсөн хүний санал, гомдлыг НЗДТГ-ын дотоод цахим төв серверт шууд бүртгэх бөгөөд энэ нь хариу өгөх системтэй холбогддог. Өргөдөл, гомдлын бүртгэлд санал/ өргөдөл гомдлын асуудал, төслийн сөрөг нөлөөнд өртсөн хүний нэр, холбоо барих хаяг, өргөдөл, гомдол хүлээн авсан огноо зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг оруулна.

Хоёрдугаар үе шат: НЗДТГ-аас гаргасан шийдвэр, өргөдөл, гомдлын шаардлагын боломжтой эсхийг үнэлнэ. Хүлээн авсан өргөдөл, гомдлыг төслийн удирдлагын алба холбогдох ажилтнуудад эсвэл НЗДТГ-ын холбогдох хэлтэс / хэлтэс / нэгжид хуваарилна. Төслийн удирдлагын алба нь асуудлыг шалгаж, шийдвэрлэх арга хэмжээг авна. Үүнд ажил гүйцэтгэгчийн үйл ажиллагааны алдааг залруулах арга хэмжээ багтана. Гэрээлэгч өргөдөл, гомдол барагдуулсан шийдэл, түүний үр дүнг төслийн удирдлагын албанд уламжилж, ДБ-д мэдэгдэх ёстой. Өргөдөл, гомдлын төрөл, ярвигтай байдлаас шалтгаалан төслийн удирдлагын алба/НЗДТГ нь тухайн өргөдөл, гомдлыг хүлээн авснаас хойш 1-30 өдрийн дотор асуудлыг шийдвэрлэнэ.


Гуравдугаар үе шат: Өргөдөл, гомдлыг төслийн удирдлагын алба, удирдах зөвлөл шийдвэрлэнэ. Гуравдугаар үе шатанд НЗДТГ, төслийн удирдлагын алба нь асуудлыг судалж 10 хоногийн дотор олон талын оролцогчдын дунд уулзалт зохион байгуулж, түүнээс хойш 10 хоногийн дотор асуудлыг шийдвэрлэнэ.

Дөрөвдүгээр үе шат: Дээд байгууллагын тогтоол. Хэрэв өргөдөл, гомдлыг барагдуулаагүй бол төслийн сөрөг нөлөөнд өртсөн тал шүүхэд хууль ёсны дагуу хандах, эсвэл ДБ-ны Өргөдөл, гомдлыг барагдуулах үйлчилгээнд хандах боломжтой.



Зураг 9. Төслийн санал болгож буй өргөдөл, гомдол барагдуулах механизм

НЗДТГ-ын өргөдөл гомдлыг барагдуулах систем нь Нийслэлийн засаг даргын А/1086 тоот журмаар зохицуулагдана. Бүх агентлаг, НЗДТГ-ын төслүүд өргөдөл, гомдлын нэгдсэн систем (Зураг 1-д үзүүлэв) хэрэгжүүлэхийг шаарддаг. УБТАТ төсөл өргөдөл, гомдол барагдуулах өнөөгийн системд тулгуурлан үр дүнтэй менежмент хийж байна. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага төслийн бүх үе шатанд төслийн сөрөг нөлөөнд өртөж болзошгүй хүмүүс болон/бусад сонирхогч талуудтай илүү сайн хамтран ажиллах зорилгоор төслийн удирдлагын алба (ТУА) өргөдөл, гомдол барагдуулах журмыг илүү боловсронгуй болгож болно.



Зураг 10. Төслийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх менежмент нь НЗДТГ-ын ухаалаг GRM системтэй уялдсан байдал

Одоогоор ашиглаж байгаа мэдээлэл, харилцааны сувгууд

1. Засгийн газрын иргэд олон нийттэй харилцаж, санал хүсэлт хүлээн авах 1111 төв,

Засгийн газрын ордны өмнө байрладаг тус төвд иргэд биеэр очиж эсвэл утсаар харилцаж болно.

Ерөнхийлөгчийн тамгын газар, УИХ-ын тамгын газар, ЗГХЭГ, төрийн агентлагууд тус төв болон утсаар дамжуулан бүх холбогдох мэдээллийг хүлээн авдаг. Тус бүр мэдээллийг хүлээн авч, холбогдох байгууллагад хүргэж, санал хүсэлт шийдэгдсэн асуудлаар ажилладаг ажилтантай. Иргэдэд хариу өгөх, санал хүсэлт, гомдлыг хүлээн авснаас хойш 30 өдөрт багтаан шийддэг.

Мэдээллийг бүртгэн 11-11.mn вэб хуудаст байрлуулдаг.

2. Вэб хуудас

а) Улаанбаатар хотын Захиргаа

Захиргааны албан ёсны вэб хуудас www.ulaanbaatar.mn -т “санал хүсэлт, гомдол” гэсэн товч байдаг. Тухайн товч дээр дарахад хотын портал е-үйлчилгээтэй шууд холбогдоно. Энд иргэд бүртгүүлэн, мэдээллээ үлдээж болно. Ажилтан мэдээллийг хүлээн авч, холбогдох газруудад хүргэдэг. Холбогдох ажилтан санал хүсэлт, гомдлыг хүлээн аваад, тухайн тогтоосон хугацаа

(ихэвчлэн 30 өдөр)-нд багтаан асуудлыг шийдэн холбогдох иргэнд хариу өгөх ёстой байдаг.

б) Ерөнхийлөгчийн тамгын газар

Тамгын газрын албан ёсны вэб хуудас www.president.mn-т иргэд/байгууллагууд зөвхөн өөрсдийн саналаа үлдээх боломжтой хэсэг байна. Ажилтан саналуудыг хүлээн авч, холбогдох газруудад хүргүүлдэг.

Иргэд маягтыг бөглөхдөө овог нэр, иргэний үнэмлэхний дугаар, хаяг, утасны дугаараа оруулах ёстой.

в) www.manaikhoroo.mn

Нийслэлийн Засаг даргын тамгын газар “Манай хороо” вэб хуудсыг иргэд, төрийн ажилтнуудад зориулан ажиллуулдаг. Тус вэб хуудаст иргэд Улаанбаатар хотын захиргааны байгууллага, албан тушаалтнуудад гомдол саналаа хүргэж, шийдвэрлүүлэх хэсэг орсон байна.

Энэ нь иргэдэд хотын захиргааны байгууллага, албан тушаалтнуудад гомдол саналаа түргэн шуурхай хүргүүлж, шийдвэрлүүлэх боломжийг олгоно.

Холбогдох байгууллага шийдвэр гаргасны дарааа гомдол санал гаргасан иргэдэд хариултыг утсаар өгнө.

3. Албан бичиг (байгууллага) ба бичгээр гаргах гомдол, хүсэлт (иргэн)

Энэ нь иргэн эсвэл аж ахуйн нэгж, этгээдэд гомдол, санал, хүсэлт эсвэл санал бодлоо холбогдох төрийн байгууллагуудад бичгээр хүргүүлэх боломж олгодог. Албан бичгийн хүлээн аваад ажилтан гүйцэтгэх шатны ажилтнууд (захиралд) мэдээлнэ.

*Гомдол эсвэл хүсэлтийн аль ч хэлбэрт хамаарах дүрэм журам нь Монгол Улсын “Төрийн албаны ажилтан эсвэл Төрийн байгууллагад иргэн эсвэл аж ахуйн нэгж ба этгээдээс ирүүлсэн гомдол ба санал хүсэлтийг шийдвэрлэх” тухай хуультай нийцсэн байна.

4. Улаанбаатар хотын Захирагчийн алба 1800-1200 утсаар иргэд олон нийтийн санал хүсэлтийг хүлээн авдаг.

Иргэд Дүнжингарав төвд байрлах тус төвд биеэр очиж эсвэл утсаар холбогдож болно.

Хотын Захирагчийн алба болон Засаг даргын тамгын газар тус төв болон түүний утсаар дамжуулан мэдээллийг хүлээн авдаг. Энд утасны дуудлага авч мэдээлэл хүлээн авч холбогдох газруудад хүргүүлж, шийдэх үйл явцын асуудлаар ажилладаг 8 ажилтантай. Санал хүсэлт, гомдлыг хүлээн аваад шийдэж, иргэдэд хариу өгөх хугацаа 30 өдөр байна.

5. Мобайл аппликэйшн

а) “Check My Service”

Хотын Засаг даргын тамгын газар, Ардчилалын боловсролын төв хамтран “Check My Service” мобайл аппликэйшнийг иргэдэд зориулан шинээр нэвтрүүлээд байна.

Энд иргэд хотын захиргааны байгууллага, албан тушаалтанд иргэдээс гомдол санал хүлээн авч шийдэхээс гадна 2018 оны 1 дүгээр сарын 31-нд иргэд байгууллагуудын үйл ажиллагааг үнэлсэн байна.

Иргэд аппликэйшнийг ашиглахдаа " Check My Service"-г гар утсандаа суулгаж, хувийн мэдээллээ UB1200.mn-д бүртгүүлнэ. Холбогдох байгууллага шийдвэр гаргасны дараа гомдол саналтай холбоотой хариултыг холбогдох хүнд утсаар өгнө.

б) Smart UB

Улаанбаатар хотын Захиргааны албан ёсны ухаалаг утсанд хэрэглэх аппликэйшн. Иргэд гар утсандаа "SmartUB"-г суулган, хувийн мэдээллээ UB1200.mn вэб хуудаст бүртгүүлнэ. Холбогдох байгууллага шийдвэр гаргасны дараа гомдол саналтай холбоотой хариултыг холбогдох хүнд утсаар өгнө. Гэхдээ 2019 оноос хойш "гомдол санал" хэсэг ажиллахгүй болсон.

в) E-Police

Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн иргэдэд тэдний мэдээллээр дамжин торгууль оногдуулдаг. Хүмүүс замын хөдөлгөөний зөрчлөө холбогдох ажилтанд е-цагдаа аппликэйшнээр дамжуулан мэдээлж чадна.

Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний хяналтын төв, Тээврийн бодлогын газрын боловсруулсан энэ аппликэйшний гол зорилго замын хөдөлгөөний зөрчлийг бууруулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, аюулаас урьдчилан сэргийлэхэд чиглэдэг. Үүнийг ашиглахын тулд иргэд гар утсандаа "E-Police" аппликэйшнийг суулгах хэрэгтэй.

г) E-Mongolia

"E-Mongolia" нь төрийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад нэг дороос түргэн шуурхай хүргэх цахим платформ юм. Нийт 592 төрлийн үйлчилгээ хүргэхээр төлөвлөснөөс 180 үйлчилгээг тус платформ хүргэж байгаа бөгөөд тэдгээрийн нэг нь иргэд, компани, байгууллагууд замын нэвтрэх зөвшөөрөл авах хүсэлтээ гаргах юм.

Санал гомдлын хуудас

Нөлөөлөлд өртсөн хүний мэдээлэл

Он сар өдөр

Нэр

Утас

Хүйс:

Таны санал хүсэлт, шийдвэрлүүлэх гомдол юу вэ?

Хэрэв та СГБ хуудсыг биечлэн хүргэх хүсэлтэй бол дараах хаягт хүргэнэ үү

Холбогдох утас (ТУН/Дэд төсөл СГБ хүний нэр/Гүйцэтгэгч байгууллагын утас)

Цахим хаяг (ТУН/Дэд төсөл СГБ хүний нэр/Гүйцэтгэгч байгууллагын утас)

ТУН хаяг

Санал өгсөн танд баярлалаа!

Нөлөөлөлд өрсөн иргэнд өгөх баримт:

202.... /он//сар//өдөр/ таны санал хүсэлт гомдлыг дараах ажилтан хүлээн авав.

...../албан тушаал/...../нэр/.

ХАВСРАЛТ 4. Дэд төслийн Байгаль орчин, нийгмийн тандалт, эрсдлийн үнэлгээ

Дараах хүснэгтийг байгаль орчин, нийгмийн хамгааллын мэргэжилтнүүдийн дэмжлэгтэйгээр төсөл хэрэгжүүлэгчид бөглөж ТУА-т хянуулан зөвшөөрөл авна. Тэдгээр байгаль орчин, нийгмийн тандалтын хүснэгтийг архив, хяналтын зорилгоор бүртгэж хадгална.

Дэд төслийн нэр:

Төрөл (тэмдэглэх): Төрөл I корридор засвар, үйлчилгээ / Төрөл II корридорыг шинэчлэх / ТТ1 / ТТ2 / ТТ3 / бусад, тодорхойлж бичнэ үү:

Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын нэр:

Асуулт	Т	Ү	Тайлбар/Санал болгосон үйл ажиллагаа
А. БОН-ийн хасагдах үйл ажиллагааны жагсаалт (БОН-ийн эрсдэл өндөртэй үйл ажиллагааг оруулахгүйгээр)			
1. Уг үйл ажиллагаа нь хуулиар хамгаалагдсан дархан цаазат газар, байгалийн нэн чухал амьдрах орчин, байгалийн үзэсгэлэнт газар, соёлын өвд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэх үү?			Хэрэв тийм бол дэмжигдэхгүй
2. Уг үйл ажиллагаа нь экосистем ба биологийн олон янз байдалд, мөн агаарын чанар, хордсон хөрс, шороог хангалттай хаалт, нөхөн сэргээлтгүйгээр зайлуулах зэргээр орон нутгийн хүрээлэн буй орчин болон экосистемийг ноцтой доройтолд оруулах үү?			Хэрэв тийм бол дэмжигдэхгүй
3. Уг үйл ажиллагаа нь олон нийт, эмзэг болон ядуу бүлгийн иргэд, эмэгтэйчүүдийн ашиг сонирхлыг үл ойшоож, хайхрамжгүй хандахаар үү?			Хэрэв тийм бол дэмжигдэхгүй
4. Уг үйл ажиллагаа нь албадан хөдөлмөр эрхлэх, эсхүл хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, ялгаварлан гадуурхалт, бэлгийн мөлжлөг, дарамт, бэлгийн хүчирхийлэл, эсхүл жендэрийн ялгааг нэмэгдүүлэхтэй холбоотой юу?			Хэрэв тийм бол дэмжигдэхгүй
5. Уг үйл ажиллагаа нь үндэстний цөөнхийн эзэмшлийн газарт сөрөг нөлөө үзүүлэх үү? Эсхүл нүүлгэн шилжүүлэлт хийх шаардлагатай бөгөөд үүнд үнэ төлбөргүйгээр, урьдчилж мэдэгдсэн зөвшөөрөл авах боломжгүй юу?			Хэрэв тийм бол дэмжигдэхгүй
6. Уг олж тогтоосон үйл ажиллагаа ОУСК-			Хэрэв тийм бол дэмжигдэхгүй

Асуулт	Т	Ү	Тайлбар/Санал болгосон үйл ажиллагаа
<p>ын (www.ifc.org) хасагдах үйл ажиллагааны жагсаалтад орсон бөгөөд тухайлбал, дараахи үйл ажиллагаа үүнд хамаарна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хүлээн авагч орны хууль тогтоомж, дүрэм журам, олон улсын конвенц, хэлэлцээрийн дагуу хууль бус гэж үзсэн, эсхүл олон улсын хоригт хамрагдсан аливаа бүтээгдэхүүн, үйл ажиллагаанд хамаатай үйлдвэрлэл, худалдаа. • Зэр зэвсэг, сумны үйлдвэрлэл, эсхүл худалдаа. • Согтууруулах ундааны үйлдвэрлэл, эсхүл худалдаа. • Тамхины үйлдвэрлэл, эсхүл худалдаа. • Мөрийтэй тогтлоом, казино, түүнтэй адилтгах аж ахуйн үйл ажиллагаа. • Цацраг идэвхт бодисын үйлдвэрлэл, эсхүл худалдаа. Энэ нь зөвшөөрөгдсөн эмнэлгийн тоног төхөөрөмж, чанарын хяналтын (хэмжих) тоног төхөөрөмж худалдан авахад хамаарахгүй. • Ойролцоох гол (Туул) дахь хууль бус загас агнуур, жишээлбэл, ProDrift тороор загасчлах эсвэл тэсэлгээний аргаар загасчлах үйл ажиллагаа. 			
<p>В. Байгаль орчин, нийгмийн эрсдлийн зэрэглэл ба ангилал</p>			
<p>7. Төслийн үйл ажиллагаа нь БОН-ийн ноцтой нөлөөлөл (жишээлбэл, байгалийн амьдрах орчинд нөлөөлөх нөлөөлөл, эсхүл бага хэмжээний LAR-тай холбоотой) үзүүлэх үү?</p>			<p>Хэрэв тийм бол уг дэд төслийн БОН-ийн эрсдэлийг “Бодитой” гэж үзэх бөгөөд БОН-ийн холбогдолтой баримт бичгийг (БОННУ, БОНМТ, НШУАТ, ХХЗЖ гэх мэт) Банкны БОНХ-ний дагуу зохих ёсоор бүрдүүлэх шаардлагатай.</p>
<p>8. Төслийн үйл ажиллагаа нь зөвхөн хүн амын болон/эсхүл байгаль орчинд үзүүлэх хамгийн бага буюу үл ялиг сөрөг эрсдэл буюу нөлөөллийг агуулж байгаа юу?</p>			<p>Хэрэв тийм бол, энэхүү дэд төслийн БОН-ийн эрсдлийг “Бага” гэж үзэх бөгөөд Талуудын оролцоог хангах төлөвлөгөөнөөс өөр БОН-ийн холбогдолтой баримт бичиг шаардагдахгүй.</p>
<p>9. Төслийн үйл ажиллагааны БОН-ийн эрсдэл нь Асуулт 7 ба 8-д тодорхойлосоны хооронд байна уу?</p>			<p>Хэрэв тийм бол, энэхүү дэд төслийн БОН-ийн эрсдлийг “Дунд зэргийн” гэж үзэх бөгөөд БОН-ийн холбогдолтой баримт бичгийг (БОННУ, БОНМТ, НШУАТ, ХХЗЖ гэх мэт) Банкны БОНХ-ний дагуу зохих ёсоор бүрдүүлэх шаардлагатай.</p>
<p>10. Хэрэв, төслийн үйл ажиллагаа Техникийн</p>			

Асуулт	Т	Ү	Тайлбар/Санал болгосон үйл ажиллагаа
туслалцаа 1 (ТТ1)-д хамааралтай бол, дараахь асуултуудад хариулна уу?			
10.1 ТТ-нд хамааралтай үйл ажиллагаа нь тодорхой биет хөрөнгө оруулалтын нарийвчилсан зураг төсөл эсхүл түүнтэй адилтгах техникийн баримт бичгийг санхүүжүүлэхээр төлөвлөж байгаа юу?			Хэрэв тийм бол, БОННУ, БОНМТ, НШУАТ, ХХЗЖ зэрэг, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй БОН-ийн холбогдолтой баримт бичгийг ТТ-ны үр дүнгийн нэг хэсэг хэлбэрээр Банкны БОНХ-ний дагуу бүрдүүлэх шаардлагатай.
10.2 ТТ-нд хамаарах үйл ажиллагааны төлөвлөгөө нь бодитой хөрөнгө оруулалтын ТЭЗҮ, эсхүл түүнтэй адилтгах бусад техникийн баримт бичгийг санхүүжүүлэхээр төлөвлөж байгаа юу?			Хэрэв тийм бол, БОН-ийн холбогдолтой асуудлыг Ажлын удирдамж буюу Ажлын даалгаварт тусгаж, улмаар, ТТ-ны хүрээнд хүлээлгэн өгөх ажлын нэг хэсэг болгон оруулна. Жишээлбэл, төслийн БОН-ийн эрсдэл, нөлөөлөл болон БОНХ-нд заасан шаардлагын дагуу эрсдэл, нөлөөллийг бууруулах арга хэмжээнд дүн шинжилгээ хийх тухай тусгайлсан бүлгийг СТБ-ын тайланд оруулах хэрэгтэй.
11. Дэд төсөл нь аливаа тодорхой заасан 'Холбогдох байгууламжууд'-ыг өөртөө багтаасан уу? ("Холбогдох байгууламж" гэж төслийн нэг хэсэг болгон санхүүжилт хийгдээгүй, Банкнаас: (а) Төсөлтэй шууд ба их хамааралтай; (б) Төсөлтэй нэгэн зэрэг хэрэгжүүлсэн эсхүл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн; (в) Төсөлд зориулж баригдсан бөгөөд төсөлд шаардлагатай) гэж үзсэн байгууламж, эсхүл үйл ажиллагааг хэлнэ.			Хэрэв тийм бол, дэд төсөлд тавигдах БОН-ийн шаардлагууд 'Холбогдох байгууламжууд'-д мөн адил хамаарна.
12. Энэхүү БОН-ийн сэрэмжлэх шүүлтүүр хийхээс өмнө (ихэнхдээ, сүүлийн хоёр жилд) төслийн үйл ажиллагааны улмаас газар чөлөөлөх, газар ашиглахад хязгаарлалт хийх тохиолдол гарч байсан уу?			Хэрэв тийм бол, нүүлгэн шилжүүлэлтийн шалган нягтлах ажлыг БОНС 5-ын дагуу хийх шаардлагатай.
13. Төслийн үйл ажиллагаа ТТ 2-т хамаарах уу?			Хэрэв тийм бол, холбогдох БОН-ийн эрсдэлийг харгалзан үзэх талаар Ажлын даалгаварт тусгаж, ийм судалгаа хийхээс өмнө Банкинд хянуулахаар өгөх ёстой бөгөөд стратеги, төлөвлөгөө, зохицуулалтын асуудлыг боловсруулахтай холбоотой аливаа дэд төслийн хувьд хүлээлгэн өгөх ТТ-ны хүрээнд багтах ажил нь санал болгож буй нөлөөллийг бууруулах стратеги болон БОН-ийн нийт нөлөөлөлд хийсэн урьдчилсан дүн

Асуулт	Т	Ү	Тайлбар/Санал болгосон үйл ажиллагаа
			шинжилгээг өөртөө багтаасан байх шаардлагатай.
14. Төслийн үйл ажиллагаа ТТ 3-т хамаарах уу?			Хэрэв тийм бол, БОН-ийн нэмэлт баримт бичиг бэлтгэх шаардлагагүй. Гэхдээ, ийм үйл ажиллагааг явуулахаас өмнө холбогдох Ажлын даалгаврыг бэлтгэх үедээ ТОХТ болон тодорхой үйл ажиллагаанд үндэслэн талуудын (эмзэг бүлгийг оролцуулан) хангалттай бөгөөд үр дүнтэй оролцоог хангах талаар авч үзэх шаардлагатай.
15. Төслийн үйл ажиллагаа нь I төрлийн гудамж, замын коридорын засвар, үйлчилгээнд хамааралтай юу (холбогдох дэд бүтцийн байгууламжуудыг оруулаад)?			Хэрэв тийм бол, Хэрэгжүүлэгч байгууллагууд болон тэдгээрийн гэрээт ажил гүйцэтгэгчид Байгаль орчин, нийгмийн менежментийн жишиг төлөвлөгөө (БОНМТ, БОНМСХ-ний хавсралт 5), замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө (ЗХМТ, БОНМСХ-ний хавсралт 7), аюулгүй байдлын Ёс зүйн дүрмийг (БОНМСХ-ний хавсралт 8) гэрээгээр хүлээсэн үүргийн нэг хэсэг хэлбэрээр хэрэгжүүлэх шаардлагатай.
<p>Нэгдсэн дүгнэлт (зохистой гэснийг тэмдэглэнэ үү?):</p> <p>1. Санал болгож буй үйл ажиллагааг (зохистой/зохисгүй) БОНМСХ-ний БОН-ийн хасагдах жагсаалтад үндэслэн төслийн санхүүжилтэд хамруулна.</p> <p>2. Санал болгож буй дэд төсөл нь БОН-ийн (Бодитой/Дунд зэргийн/Бага) эрсдэлтэй.</p> <p>3. Санал болгож буй дэд төслийг боловсруулах явцад дараахи БОН-ийн баримт бичгийг бэлтгэнэ. Үүнд:</p> <p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>Бөглөсөн (Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төлөөлөл): _____; Хянасан (ТХА-ны төлөөлөл/БОН-ийн мэргэжилтэн): _____</p>			

ХАВСРАЛТ 5. Дэд төслийн байгаль орчин нийгмийн менежментийн төлөвлөгөө (Дэд-төслийн БОНМТ)

Зүйл	Үзүүлж болох нөлөө ба асуудал	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ ба/эсвэл хамгааллын арга хэмжээ	Хариуцах тал	
			Хэрэгжүүлэх	Хяналт тавих

А. Барилгын ажлын өмнөх үе шат

Нарийвчилсан төлөвлөлтийн үе шат	Байгаль орчны менежментийн бэлэн байдал	<ul style="list-style-type: none"> - Шаардлагатай үед энэ дэд төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж шинэчлэн, нарийвчилан авч үзнэ. - Энэхүү шинэчилсэн дэд төлөвлөгөөний шаардлагууд тендер болон гэрээний баримт бичгүүдэд тусгагдагдсан байна. - Дэд төсөл гүйцэтгэгч БОНМХ, БОНННУ, Ерөнхий БОННУ, дэлгэрэнгүй БОННУ, БОМ-ийн дэд төлөвлөгөөнийн шаардлагуудыг хангасан БҮ-г боловсруулсан байна. - Төслийн БОНМХ -нд орсон Өргөдөл, гомдол барагдуулах механизм (ӨГБМ)-д заасны дагуу ТХН нь ӨГБМ-ын ерөнхий үүргийг хүлээн ажиллана; ӨГБМ-ын сургалтыг гэрээгээр ажил гүйцэтгэгчид, ТХН, дэд төслийн нөлөөллийн үнэлгээ, ӨГБМ хариуцсан ажилтан нарт явуулна; өргөдөл, гомдол хүлээж авах утас, факсны дугаар, оффис ба цахим шуудангийн хаяг нөхөн сэргээлт ба барилгын талбайн хэмжээнд тавигдсан байна. - Нутгийн оршин суугчид, оролцогч гол талуудад мэдээллийг цаг тухайд нь өгч, холбогдох асуудлыг хэлэлцдэг байна. 	ТУА, дэд төслийн нөлөөллийн үнэлгээний ажилтан	НЗДТГ ба ДБ-ны групп
---	---	--	--	----------------------

В. Барилгын ажлын үе шат

Зүйл	Үзүүлж болох нөлөө ба асуудал	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ ба/ эсвэл хамгааллын арга хэмжээ	Хариуцах тал	
			Хэрэгжүүлэх	Хяналт тавих
Байрзүй ба хөрс	Газрын элэгдэл, карьер, хог хаягдал	<p>Хөрс хамгааллын сайн практик арга ажиллагаа (үйл ажиллагааны холбогдох хэсгүүдэд)-г хэрэгжүүлэх, үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хөрс, ургамал, мод чулуу зайлуулах талбайн хэмжээг багасгах; - Элэгдлээс хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх замаар хөрс шорооны зайлуулалт хийгдсэн газруудад налуугийн тогтвортой байдлыг хадгалах; - Ойролцоох гол усны эх үүсвэрээс үүсч болох үер усны урсацаас хамгаалсан түр тусгаарлах далан эсвэл бусад ус зайлуулах боломжит орчныг бүрдүүлэх; - Барилгын материал зөөх карьерууд хүн амын суурьшил, гол усан орчин, хатсан гол усны сайр ба гольдрол болон бусад чухал газруудаас зайтай байх; - Хог хаягдал материал (хэрэв гарах бол)-ыг орон нутгийн удирдлагуудтай зөвлөнтөгтоосон цэгт зайлуулах; - Ашиглалт явуулж дууссны дараа карьер болон хог хаягдлын цэгүүдийг тэгшилж, гадаргын усаар зөөгдөхөөс сэргийлэх, орчны хэвийн харагдах байдлыг хангана. 	Дэд төсөл гүйцэтгэгч	
Орчны агаар	Нөхөн сэргээлт ба барилгын ажлын явцад үүсэх тоос, машин механизмаас ялгарах бохирдуулагч хийнүүд	<p>Ажлын талбайн эмх цэгц, зохицуулалтын сайн практик арга ажиллагаатай байх, үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Овоолгуудаас үүсэх тоос бууруулах арга хэмжээ авах, шаардлагатай бол материалыг хучих бүтээх, хэрэв бусад арга 	Дэд төсөл гүйцэтгэгч	Гүйцэтгэгч

Зүйл	Үзүүлж болох нөлөө ба асуудал	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ ба/ эсвэл хамгааллын арга хэмжээ	Хариуцах тал	
			Хэрэгжүүлэх	Хяналт тавих
	(SO ₂ , CO, NO _x гм)	<p>төдийлөн тохирохгүй бол усаар шүршиж орчны тоосжилтыг бууруулах арга хэмжээ авах;</p> <ul style="list-style-type: none"> – Овоолгууд нөлөөлөлд өртөх мэдрэмтгий хэсгүүд (хэрэв хамаарах бол)-ийн салхины доод хэсэгт байрласан байх; – Нөхөн сэргээлт ба барилгын талбайн менежмент: хэрэв мониторингоор тоос ойр орчны оршин суугчдад нөлөөлж байгаа нь тогтоосон бол нөхөн сэргээлт, барилгын талбай, материал буулгаж, ачих газруудад ус шүршиж тоосны тархалтыг бууруулах; – Барилгын материалын тээвэр: шороо, элс, хайрга зөөдөг машинууд бризент ба бусад тохирох материал бүхий бүтээлэгтэй байх; барилгын машин, механизмууд тоос, бохирдуулагч бодис ялгаруулалтыг багасгах үүднээс стандартын өндөр түвшинд засвар үйлчилгээ хийгдсэн байх; – Үйлдвэрлэгч цехүүд: бетон зуурмаг үйлдвэрлэлийн цех ойролцоох хүн амын суурьшлаас хамгийн наад зах нь 500 м-ийн зайтай, салхины доод талд байрласан байна. 		
Гадаргын ба гүний ус	Барилгын ба ахуйн хаягдал ус	<p>Хаягдал усны сайн практик ажиллагааг хэрэгжүүлэх, үүнд:</p> <ul style="list-style-type: none"> – Нөхөн сэргээлт, барилгын ажлын явцад ус зайлуулах түр суваг байгуулж, тухай ажлын талбайнууд үер усанд автагдахаас сэргийлнэ. – Нөхөн сэргээлт ба барилгын талбай ундны усны найдвартай 	Дэд төсөл гүйцэтгэгч	Гүйцэтгэгч

Зүйл	Үзүүлж болох нөлөө ба асуудал	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ ба/ эсвэл хамгааллын арга хэмжээ	Хариуцах тал	
			Хэрэгжүүлэх	Хяналт тавих
		эх үүсвэр, ариун цэврийн түр байгууламжтай байна.		
Үер ус	Үер уснаас үүдэлтэй хохирол	– Хур тунадас ихтэй үед ажиллахаас зайлсхийх.	Дэд төсөл гүйцэтгэгч	Гүйцэтгэгч
Хог хаягдал	Хог хаягдлын менежмент, нөөц ашиглалт	<p>Хог хаягдлын сайн практик арга ажиллагаа, хог хаягдал бууруулах шатлал (нөөцийг оновчтой ашиглаж, хог хаягдлаас сэргийлэх, зайлсхийх, бууруулах, багасгах) арга ажиллагааг нэвтрүүлсэн байх, үүнд:</p> <ul style="list-style-type: none"> – Юуны өмнө эх үүсвэр дээр гарах хог хаягдлаас сэргийлнэ. Хог хаягдлаас сэргийлэхэд худалдан авалт хийх арга замууд гол үүрэгтэй, тухайлбал: аль болох бага савалгаатай материалуудыг худалдан авахыг чухалчилж болно. Ухаж гаргасан хөрсийг дүүргэлтэнд эргүүлэн ашиглана. Хог хаягдлыг багасгах нь хоёр дахь зохистой хувилбар байна. Хог хаягдал бага гаргахад талбай дээр материалын хадгалалт хамгаалалт, ажлын төлөвлөлтийг маш сайн хийх замаар үр дүнтэй менежмент явуулна гэсэн үг юм. Эргүүлэн эсвэл дахин боловсруулж ашиглах хог хаягдлыг зайлуулахын өмнө авч үзэн, хэрэв дахин боловсруулах материалын зах зээл байгаа бол тухайн хаягдал материалуудыг ангилан тус тусад хадгалах арга хэмжээ авдаг байна. Дахин боловсруулах ба эргүүлэн ашиглах боломжгүй хог хаягдлыг орон нутгийн удирдлагаас зөвшөөрсөн цэгт зайлуулдаг байна. – Хадгалалт, хамгаалалт: ажилчдын суурингийн хог хаягдлыг 	Дэд төсөл гүйцэтгэгч	Гүйцэтгэгч

Зүйл	Үзүүлж болох нөлөө ба асуудал	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ ба/ эсвэл хамгааллын арга хэмжээ	Хариуцах тал	
			Хэрэгжүүлэх	Хяналт тавих
		<p>зориулалтын саванд хадгалан батлагдсан хогийн цэгт хүргэдэг байна.</p> <p>– Ерөнхий менежмент: ямар ч үед хог хаягдал шатаахыг хориглоно.</p>		
	Аюултай ба хортой материал	<p>Хог хаягдлын сайн практик арга ажиллагааг хэрэгжүүлэх, үүнд:</p> <ul style="list-style-type: none"> – Түлш, нефть, химийн бодис ба бусад аюултай материал хадгалах сав байгууламжийг далантай, шингэн нэвтрэхгүй гадаргуутай хамгаалалт бүхий талбайд ус зайлуулах байгууламж, гол усны орчин болон бусад нөлөөлөлд өртөж болох хэсгүүдээс хамгийн багадаа 300 м-ийн зайтай байрлуулсан байна. – Аюултай материал хадгалах байгууламж нь шингэн үл нэвтрэх гадаргуу дээр байрлан, хадгалах хүчин чадал хамгийн багадаа 110% байна. – Ямар нэр, төрлийн химийн ба аюултай материал байгааг мэдээлэн, анхааруулах үүднээс агуулахын талбайг тэмдэгжүүлсэн байна. – Химийн ба аюултай бодис асгарах алдагдах үед авах арга хэмжээний журам (аюултай материал хадгалах байгууламжид шингээгч бодис бэлэн байлгах)-ыг боловсруулж, асгарсан ба алдагдсан тохиолдолд нэн даруй цэвэрлэх арга хэмжээ авна. – Аюултай материал нийлүүлэгчид тухайн бодис материалын хаягдал гарсан үед Монгол эсвэл бүс нутгийн өөр орон дахь тусгай зөвшөөрөл бүхий байгууламжид дахин боловсруулалтанд оруулахаар тээвэрлэн хүргэх үүрэгтэй байна. Аюултай хог хаягдлын экспортыг БОАЖЯ хянуулж, батлуулан, экспортлоход шаардлагатай бүх тусгай 	Дэд төсөл гүйцэтгэгч ба ханган нийлүүлэгчид	Гүйцэтгэгч

Зүйл	Үзүүлж болох нөлөө ба асуудал	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ ба/ эсвэл хамгааллын арга хэмжээ	Хариуцах тал	
			Хэрэгжүүлэх	Хяналт тавих
		<p>зөвшөөрлийг авсан байна.</p> <ul style="list-style-type: none"> – Машин, тоног төхөөрөмж бүрт шаардлагатай засвар үйлчилгээ, түлш шатахууныг орон нутгийн засварын газар эсвэл адил үйлчилгээ бүхий бусад байгууламжаас нийлүүлдэг байна. Машин механизмыг гадаргын усанд ба ойр угаах эсвэл засварлахыг хориглоно. 		
Нийгэм-эдийн засгийн нөөц	Замын хөдөлгөөнд үзүүлэх нөлөөлөл	<p>Зам, тээврийн үйл ажиллагааны сайн практик арга ажиллагаатай байх, үүнд:</p> <ul style="list-style-type: none"> – Зам, тээврийн удирдах газартай зөвлөлдөн зам тээвэр, материал хүргэлтийн хуваарь чиглэл гаргах; – Барилгын ажлын замын хөдөлгөөнд гарсан аливаа хохиролыг дэд төсөл гүйцэтгэгч тал арилгах үүрэгтэй байна; – Барилгын материал эсвэл хог хаягдал тээвэрлэж буй машин нөлөөлөлд өртөх мэдрэмтгий хэсгээр эсвэл ойр явахдаа хурдаа сааруулж явдаг байна. 	Дэд төсөл гүйцэтгэгч	Гүйцэтгэгч
	Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй (ХАБЭ)	<p>ХАБЭ-н сайн практик арга ажиллагааг ажилтны ХАБЭ-н аргачлалын дагуу хэрэгжүүлж мөрддөг байх, үүнд:</p> <ul style="list-style-type: none"> – Монгол улсын ХЭБА-н холбогдох дүрэм журмыг хатуу чанд дагаж мөрдөн ажиллах; – Ажилтан бүр хамгаалалтын малгай, хамгаалалтын ба/ буюу галд тэсвэртэй хувцас, газардуулга, халуун шугам ба тусгаарлалтгүй хэсэгтэй харьцахад ашиглах багаж хэрэгсэл, хамгаалалт бүхий бээлий ба нүдний шил, унахаас хамгаалах хамгаалалтын бүс ба өндөрт авирах ба ажиллахад шаардлагатай бусад хамгаалалтын хэрэгсэл, чихний хамгаалалт зэрэг хувь хүний хамгаалах хэрэгсэл (XXX)-ээр 	Дэд төсөл гүйцэтгэгч	Гүйцэтгэгч

Зүйл	Үзүүлж болох нөлөө ба асуудал	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ ба/ эсвэл хамгааллын арга хэмжээ	Хариуцах тал	
			Хэрэгжүүлэх	Хяналт тавих
		<p>бүрэн хангагдсан байна. ХХХ-үүдийг шаардлагатай үед тухай бүр засварлаж, сольдог байх;</p> <ul style="list-style-type: none"> – Өндөрт гүйцэтгэдэг ажлыг гэрэл муутай өдрийн цагаар, манантай, хүчтэй салхитай үед хийхийг хориглоно. – Нөхөн сэргээлт ба барилгын талбай ундны усны найдвартай эх үүсвэр, ариун цэврийн түр байгууламжтай байна; – Гэрээгээр ажил гүйцэтгэгчид КОВИД-19 цар тахалтай холбоотой төр засгийн зүгээс мөрдөж буй дүрэм журам буюу цаашид шинэчлэгдэн мөрдөгдөх олон улсын сайн практик арга ажиллагаатай нийцүүлэн эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа (ЭААА)-ны төлөвлөгөөтэй байна. ЭААА-ны төлөвлөгөөг орон нутгийн эрүүл мэндийн улсын байцаагчид, эмнэлгийн ажилтнууд эсвэл эрүүл мэндийн бусад холбогдох мэргэжилтнүүдтэй зөвлөн гаргасан байх. Төлөвлөгөөнд КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх тухайлбал нөхөн сэргээлт ба барилгын ажлын талбай, кэмпийн халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээ, газар дээр биеийн халуун шалгах, хүн хоорондын зай барих, амны хаалт, гар ариутгагч, гар угаах цэг зэрэг ХХХ-тэй байх, цар тахлын халдвар илэрсэн үед авах арга хэмжээг тусгасан байна. – Барилгын ажил эхлэхийн өмнө болон тогтмол (жишээ нь сар бүр) ажилчдад халдварт өвчин (БЗХӨ/ДОХ)-өөс урьдчилан сэргийлэхийг оруулан ЭААА-ны холбогдох бүх асуудлаар сургалт явуулдаг байна. <p>Онцгой нөхцөл байдлын үед авах арга хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> – Онцгой үед авах арга хэмжээний журам боловсруулсан байх, энд орон нутгийн ба бүсийн онцгой байдлын газартай харьцах журам, эрчим хүч салгах, гал түймэртэй тэмцэх журам, гал түймэртэй тэмцэх багаж хэрэгслийн хангамж, галын эсрэг авах 		

Зүйл	Үзүүлж болох нөлөө ба асуудал	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ ба/ эсвэл хамгааллын арга хэмжээ	Хариуцах тал	
			Хэрэгжүүлэх	Хяналт тавих
		<p>арга хэмжээ ба бүртгэл хөтлөх талаар ажилчдад зориулсан сургалтыг оруулсан байх.</p> <ul style="list-style-type: none"> – Эмнэлэг эрүүл мэндтэй холбоотой авах арга хэмжээ нь ажилчид болон иргэд (төслийн үйл ажиллагаатай холбоотой нөлөөлөлд өртсөн үед)-ийн аль алиныг хамарсан байх. Энд орон нутгийн ба бүсийн яаралтай тусламжийн үйлчилгээ үзүүлэгчидтэй харилцах журам, газар дээр үзүүлэх анхны тусаламжийн хэрэгсэл, хамгийн ойрын түргэн тусламж, эмнэлгийн байгууллагатай холбогдох мэдээлэл, газар дээр үүссэн нөхцөлд анхны тусламж үзүүлэх талаар ажилчдад зориулсан сургалт, орон нутгийн ба бүсийн эрүүл мэндийн төвд бэртэж гэмтсэн ажилтны талаар мэдээлэх эсвэл хүргэх болон бүртгэл хөтлөх журам орсон байна. Нөхөн сэргээлт ба барилгын талбайд наад зах нь нэг ажилтныг анхны тусламж үзүүлэхэд бэлтгэж, бэлэн байлгана. – Онцгой нөхцөл байдалд авах арга хэмжээний асуудлаар ажилчдад сургалт явуулсан байна. 		
	Дуу чимээний нөлөө	<p>Дуу чимээг бууруулах арга хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> – Дуу чимээ багатай тоног төхөөрөмж сонгох. – Мотор, компрессийн дуу чимээ багасгагч, чихэвч, дуу чимээ багасгагч, баригч тоног хэрэгсэл, цацрагийн дуу чимээ, дуу багасгагч ба сарниулагчдыг суулгах, – Тоног төхөөрөмж ажиллуулах эсвэл ажиллагаа ялангуяа хөдөлгөөнт эх үүсвэрүүдийг хүмүүсийн амьдардаг газруудад ажиллах цагийг хязгаарлана. 	Дэд төсөл гүйцэтгэгч	Гүйцэтгэгч
	Иргэд олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд учирч болох	<p>Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө</p> <p>Жендерт суурилсан хүчирхийлэлийг бууруулах арга хэмжээ</p>	Дэд төсөл гүйцэтгэгч	Гүйцэтгэгч

Зүйл	Үзүүлж болох нөлөө ба асуудал	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ ба/ эсвэл хамгааллын арга хэмжээ	Хариуцах тал	
			Хэрэгжүүлэх	Хяналт тавих
эрсдэл	Бэлгийн мөлжлөг ба хүчирхийлэлийг бууруулах арга хэмжээ Иргэд олон ниитийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны сайн практик арга ажиллагаа, энд дараах зүйл орох:	<ul style="list-style-type: none"> - Нутгийн иргэд, олон нийтэд нөхөн сэргээлтийн ба барилгын талбай, тэдгээрийн ойр орчмын аюулгүй байдлын талаар мэдлэг мэдээлэл хүргэх, хамгааллын хашаа, анхааруулах тэмдэг, мэдээллийг Монгол хэлээр ялангуяа эмзэг бүлгийн хүмүүст ойлгомжтой энгийн хэлбэрээр өгсөн байх. - Эрсдлийн үнэлгээгээр тодорхойлон талбайн хяналтын ажилтан (шөнийн харуулыг оруулан) нөхөн сэргээлтийн ба барилгын талбайд гадны хүмүүс орохоос сэргийлэх. - Нөхөн сэргээлтийн ба барилгын талбайд гадны хүн орохгүй байх сануулга бүхий тэмдэг тэмдэглэгээг нийтэд ил тод харагдах байдлаар байрлуулж, тэдгээр талбайд гадны хүн ороорхоос сэргийлнэ. 		
Соёлын биет өв	Хэрэв соёлын биет өв илэрсэн үед:	<ul style="list-style-type: none"> - Нөхөн сэргээлт ба барилгын үйл ажиллагааг нэн даруй зогсооно; - Соёлын биет өвийг сүйтгэх, гэмтээх, гадаргууг гэмтээх эсвэл нуухыг Монгол улсын дүрэм журмын дагуу хатуу хориглоно; - Соёлын өвийн хороонд даруй мэдээлж, зөвөлгөө авна; 	Дэд төсөл гүйцэтгэгч	Гүйцэтгэгч, орон нутгийн соёлын өвийн хороо

Зүйл	Үзүүлж болох нөлөө ба асуудал	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ ба/ эсвэл хамгааллын арга хэмжээ	Хариуцах тал	
			Хэрэгжүүлэх	Хяналт тавих
		<ul style="list-style-type: none"> – Нөхөн сэргээлт ба барилгын үйл ажиллагааг зөвхөн нарийвчилсан судалгаа шинжилгээ хийсний дараа болон Соёлын өвийн хорооны зөвшөөрөлтэйгээр эхлүүлнэ. 		

ХАВСРАЛТ 6. Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын удирдамж (БОНМТ)

1. Ерөнхий хэсэг

- БОНМТ Дэлхийн Банкны Байгаль Орчин ба Нийгмийн Хүрээ (БОНХ¹⁵), Байгаль орчин, Эрүүл Мэнд ба Аюулгүй ажиллагааны Удирдамж, Монгол Улсын холбогдох хууль журмуудад үндэслэгдэх ёстой.
- БОНМТ нь захиалагч байгууллагын байгаль орчин ба нийгмийн мэргэжилтнүүдийн хамтран боловсруулсан байгаль орчин ба нийгмийн асуудлуудыг хоёуланг нь хамарсан хамтын бичиг баримт юм.
- БОНМТ нь ТОХТ-ын хавсралт ба Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөөнд (ТОХТ) хэсэг болно. ТОХТ-ийн дагуу оролцогч талууд, ялангуяа оролцогч талууд шууд нөлөөлөлд өртөж, шууд ашиг сонирхлыг татан оролцуулах ёстой бөгөөд гэрээний үр дүнг БОНМТ-ийн бэлтгэл ажлыг хангахад ашиглах ёстой;
- Тодорхой байрлал, төслийн үйл ажиллагаа, байгууламжийн уялдаа холбоо нь тодорхой бус байвал Байгаль Орчин Нийгмийн Хүрээг боловсруулан эдгээр ажлуудын байгаль орчин, нийгмийн бичиг баримтыг бэлтгэх удирдамж болгон ашиглах ёстой.

2. Тусгай шаардлагууд

БОНМТ нь Байгаль Орчны Үйд ажиллагаатай холбоотой дүрэм, мэдрэмтгий рецепторуудын тухайн газарт үзүүлэх нөлөөллийг бууруулах болон УБТАТ төсөлд зориулсан үзлэг шалгалтуудын тойм зэргийг багтаасан байна.

Үүнээс гадна Монгол Улсын холбогдох байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны болон хүйсийн тэгш эрх, эмзэг байдлын зэрэг нийгмийн хууль журмуудыг Байгаль орчин Нийгмийн Хүрээний холбогдох Байгаль орчин Нийгмийн стандартуудтай тулгаж харьцуулан дүн шинжилгээ хийж ямар нэгэн Монгол Улсын хууль журмууд орхигдсон байгаа эсэхийг шалгаж бичиг баримтуудыг сайжруулна.

БОНМТ нь дараах тусгай агуулгуудыг багтаасан байна:

Бүлэг/хэсэг	Агуулга	Тодорхойлолт
Бүлэг 1	Төслийн тодорхойлолт	1. Төслийн үндэслэл, агуулга 2. Төслийн биет болон биет бус (техникийн тусламж) үйл ажиллагаа болон төслийн бүх үйл ажиллагааг тодорхойлон бичих,

¹⁵ EHSGs нь Дэлхийн банкны хүлээн зөвшөөрсөн гүйцэтгэлийн түвшингүүд ба арга хэмжээнүүдийг багтаасан байдаг бөгөөд ерөнхийдөө байгаа технологи, боломжийн өтрөгөөр, шинэ тоног төхөөрөмжийн тусламтайгаар гүйцэтгэх боломжтой.

		3. Чимээ, чичирхийлэл, агаар, гадаргын ус, цаг агаар, нийгэм, хүйсийн харьцаа, орон нутаг дахь халдварын дэгдэлт зэрэг байгаль орчин, нийгмийн суурь үнэлгээг бичнэ.
Бүлэг 2	Байгаль орчин ба нийгмийн үнэлгээ	
2.1	Байгаль орчин, нийгмийн эрсдэл ба нөлөөллийг судлах, үнэлэх	<ol style="list-style-type: none"> 1. Бүтээн байгуулалтын болон үйл ажиллагааны үе шатууд дахь байгаль орчин нийгмийн боломжит нөлөөллийг биет ба биет бус үйл ажиллагаануудад дүн шинжилгээ хийх замаар илрүүлэх 2. Үнэлгээний хамрах хүрээ, үнэлгээний зэрэг, үнэлэх арга (загварчлал) -ын хувьд цаашид үнэлэгдэх байгаль орчин, нийгмийн нөлөөллийг хамрах хүрээ; 3. Аливаа чухал асуудлын хувьд ТОХТ нь оролцогч талуудыг тодорхойлоход туслах зорилгоор ашиглагдах ёстой.
2.2	Хууль ба журмууд	<ol style="list-style-type: none"> 1. Монгол Улсын холбогдох хууль журмуудыг тодорхойлон бичиж, гол агуулгыг товчлон танилцуулга бэлтгэх 2. Энэ төслийн байгаль орчин нийгмийн үнэлгээнд зориулсан холбогдох аливаа техникийн удирдлагыг тодорхойлно.
2.3	Холбогдох стандартууд	<ol style="list-style-type: none"> 1. Үнэлгээнд ашиглагдах Монгол улсын холбогдох байгаль орчин, нийгмийн стандартуудыг олж илрүүлэх¹⁶. 2. Монгол Улсын стандартуудыг Байгаль Орчин, Эрүүл Мэнд Аюулгүй Ажиллагааны удирдамж дахь стандартуудтай харьцуулж, нарийн тулгаж үзнэ.
2.4	Байгаль Орчин, Нийгмийн Боломжит Нөлөөллийн Үнэлгээ	<ol style="list-style-type: none"> 1. Байгаль орчны менежментийн шатлалыг хуулиар хамгаалагдсан соёлын өв¹⁷, эсхүл аливаа соёлын өв, зэрлэг амьтны чухал амьдрах орчин, эсхүл аливаа амьдрах орчноос

¹⁶ Хэрэв тодорхой төслийн нөхцөл байдлаас хамааран тухайн төслийн байгаль орчны үнэлгээний нэг хэсэгт хатуу чанга арга хэмжээг авах шаардлага гарсан бол санал болгож буй орлуулах аливаа арга хэмжээг сайтар тайлбарлан бичсэн байх шаардлагатай. Энэ тайлбараар үйл ажиллагаа нь хүний эрүүл мэнд болон байгаль орчныг хэрхэн хамгаалахыг үзүүлэх ёстой.

¹⁷ 27, Хуудас 19, ESF

		<p>зайлсхийхийн тулд, мэдрэмтгий рецепторуудыг багасгахын тулд эсхүл зайлсхийхийн тулд ашиглана.</p> <p>2. Байгаль орчин, нийгмийн дүн шинжилгээний товч бөгөөд тодорхой дүгнэлтийг гаргана, хэрэв онц ноцтой нөлөөлөл, нөлөөллийг багасгах боломжтой зөвшөөрч болохуйц нөлөөлөл зэргийг тодорхойлно.</p> <p>3. Нийгмийн нөлөөллийн үнэлгээний дүгнэлтийг шууд авч бичнэ.</p>
2.5	Хяналт шалгалтын тойм	<p>1. Энэ төслийг хууль ёсны статусыг үнэлнэ.</p> <p>2. Монгол Улсын системийн хүрээнд дэд төслийн үйл ажиллагаа нь байгаль орчны үзүүлэлтүүдийг хангаж буйг үнэлнэ.</p> <p>3. Товч бөгөөд тодорхой дүгнэлтүүдийг гаргаж, санал болгож буй хувилбаруудыг гаргах</p>
Бүлэг 3	Байгууллагын зохион байгуулалт	<p>1. Төлөвлөлт бүтээн байгуулалт ба үйл ажиллагааны үе шатуудын байгаль орчин нийгмийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллагын зохион байгуулалтыг товч бөгөөд тодорхой гаргах</p> <p>2. Нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд, сургалт ба тайлагналын хэрэгжилт, удирдлага, хяналт, зохион байгуулалтын үүрэг хариуцлагын талаарх мэдээллийг хангах</p> <p>3. Байгууллагуудын чадамжид дүн шинжилгээ хийж, хэрэгцээ шаардлагатай байгаа сургалтуудыг тодорхойлох</p>
Бүлэг 4	Нөлөөллийг бууруулах	<p>1. Байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг төрөл болгоноор бууруулах арга хэмжээнүүд, техникийг дэлгэрэнгүй тодорхойлон бичих</p> <p>2. Жишиг. Сахилгын дүрэм жишээг тусдаа хүснэгт ашиглан тодорхойлон бичих</p>

		<ol style="list-style-type: none"> 3. Тухайн төслийн талбайд үзүүлж буй нөлөөллийг бууруулах талаар тодорхойлох 4. Асгаралтын менежментийн төлөвлөгөө, элэгдлийн менежментийн төлөвлөгөө, Хөдөлмөрийн эрүүл ахуйн аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах. 5. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ тус бүрийг хэрэгжүүлэх, удирдах, хянах, байгууллагуудын хариуцсан ажлуудын жагсаалтыг гаргана. 6. Авч хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтыг гаргах 7. Нийгмийн нөлөөллийн үнэлгээнд санал болгосон үйл ажиллагаа арга хэмжээг жагсааж бичих 8. Үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулахад хэрэгтэй байгаа сургалт, улс орны системийг сайжруулах үйл ажиллагааны жагсаалт
Бүлэг 5	Мониторинг	<ol style="list-style-type: none"> 1. Мониторингийн төрөл, ба арга зүйг холбогдох стандартуудын хамт техникийн дэлгэрэнгүйг гаргах 2. Мониторингийн зүйл анги төрлүүд, жишээлбэл, PM 10, PM 2,5 ба TSP зэрэг агаарын бохирдлын төрлүүд 3. Бүтээн байгуулалтын болон үйл ажиллагааны үе шатууд дахь мониторингийн төлөвлөгөө, мониторинг хийх хугацаа, давтамж, мониторинг хийх байгууллагуудын шаардлагыг боловсруулж гаргах 4. Төслийн мониторингийн төлөвлөгөөний жагсаалт гаргах, энэ төлөвлөгөөг дэд төсөлд хэрэгжүүлнэ гэдгийг тодотгож, үр дүнг нь БОНМТ-ний хэрэгжилтийн тайланд¹⁸. тусган оруулах шаардлагатай
Бүлэг 6	Чадавхыг сайжруулах сургалт	<ol style="list-style-type: none"> 1. Бүлэг 3-т тодорхойлсон байгууллагуудыг чадавхжуулах

¹⁸ Төслийн хэрэгжилтийн үе шатанд БОНМТ-ний хэрэгжилтийн тайланг Дэлхийн банканд жил бүр эсхүл жилд хоёр удаа хүргүүлэх ёстой.

		<p>сургалтуудыг тэдний чадавхыг үнэлсний үндсэн дээр боловсруулах</p> <p>2. Багаж, техник тоног төхөөрөмж худалдан авах эрэлтийг тодорхойлох</p> <p>3. Сургалтаар хангах байгууллагуудад тавигдах шаардлага, мэргэжлийн үр чадварыг тодорхойлох</p>
Бүлэг 7	Өртгийн тооцоо гаргах	<p>1. Байгууллагын чадавхыг сайжруулах, сургалт зохион байгуулах, мониторинг хийх, тайлагнах, нөлөөллийг бууруулах (ус, цацах, чимээ шуугиан бууруулах, хашаа барих) үйл ажиллагаа тус бүрээр өртгийг бодож гаргах</p> <p>2. Капитал өртөг, дахин давтагдсан өртөг, санхүүжилт/хөрөнгө оруулалтын эх үүсвэр зэргийн жагсаалтыг гаргах. Төслийн нийт өртгийг харуулсан хүснэгтэд эдгээрийг нэгтгэн оруулах</p>
Бүлэг 8	Гомдол барагдуулах механизм	<p>1. Журмууд, ажилчид, нөөцийн¹⁹ талаарх олон нийтийн гомдлыг барагдуулах механизмыг тодорхойлох</p> <p>2. БОНС2-н хүрээнд GRM –г тодорхойлох</p>
Бүлэг 9	Файлуудыг хадгалж, тайлагнах	<p>1. Файлыг хадгалах ажилтан ба журмыг тодорхойлох</p> <p>2. Дэлхийн банканд болон бусад талуудад тайлагнах системийг тодорхойлох</p>
Хавсралт	Хавсралт 1	Фото зургууд гарын үсэг уулзалтын тэмдэглэлүүд зэргээс бүрдсэн SEP-н хэрэгжилт
	Хавсралт 3 Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө	<p>1. Төслийн үйл ажиллагаа ба материалын тээвэрлэлтэд зориулж замын хөдөлгөөнийг зохицуулах, хөнгөвчлөх арга хэмжээг боловсруулах</p> <p>2. Жолооч нар болон оршин суугчдад зориулсан замын хөдөлгөөний аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулах</p> <p>3. Сургууль, эмнэлэг, цэцэрлэгүүдэд зориулсан тусгай арга хэмжээг боловсруулах</p>
	Хавсралт 4 Хөдөлмөрийн	

¹⁹ Энэ GRM нь БОНС 10-н хүрээнд боловсрогдсон;

	менежментийн журам ²⁰	
--	-------------------------------------	--

²⁰ Хөдөлмөрийн менежментийн журмыг хавсралтаар өгсөн загварын дагуу боловсруулна.

ХАВСРАЛТ 7: Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө боловсруулах болон түр зохицуулалтын ерөнхий удирдамж

Төсөлд зориулсан замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөөний удирдамжуудыг төслийн бүтээн байгуулалтын явцад бүтээн байгуулалтын талбарт болон оршин суугчдын ойр орчимд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор бүтээн байгуулалтын талбарын Замын Хөдөлгөөний Менежментийн Төлөвлөгөөг боловсруулахад нь зориулж бэлтгэн боловсруулдаг байна. Эдгээр удирдамжууд нь Улаанбаатар хотын орон нутгийн хэрэгцээ шаардлагууд, Дэлхийн Банкны Байгаль орчин, аюулгүй ажиллагааны удирдамжууд, ДБ-ны Замын аюулгүй байдлын талаарх сайн туршлагын тэмдэглэл, Байгаль орчин, нийгмийн хүрээний (i) Бүтээн байгуулалтын талбарын Аюулгүй ажлын байр, (ii) Бүтээн байгуулалтын талбарын Аюулгүй Тээврийн хэрэгсэл, (iii) Аюулгүй жолооч ба жолоочтой холбоотой туршлага, (iv) Зам тээврийн аюулгүй байдал, (v) Гэнэтийн олсын бэлэн байдал ба хариу арга хэмжээ зэрэг бичиг баримтуудад үндэслэгдэж боловсрогдох ёстой

I. Зорилго

Энэ удирдамж нь төслийн шинэ замуудын бүтээн байгуулалт, засварын ажил, замыг шинэчлэх ажлуудын үед тухайн газрын оршин суугчдад, ялангуяа явган зорчигчид, дугуйгаар замын хөдөлгөөнд оролцогчид, бараа материал ханган нийлүүлэлтийг ажилчид, бүтээн байгуулалтын ажилчид, тээврийн хэрэгслийн жолооч нарт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг бий болгох зорилготой.

II. Бүтээн байгуулалтын талбарын Замын Хөдөлгөөний Менежментийн Төлөвлөгөөг боловсруулах

Сонгогдсон гүйцэтгэгч нь ЗХМТ-ний анхны хувилбарыг боловсруулан тендерийн материалын нэг хэсэг болгон хавсаргана. Энэ нь мөн БОНМТ-ны нэг хэсэг нь болно. Ажил эхлэхээс өмнө шинэчилсэн ЗХМТ-г дүүргийн холбогдох байгууллагаар батлуулж, РМУ д хүргүүлнэ. Үүнийг ажилчдад тогтмол танилцуулж байна. Тухайн талбарын Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө нь дараах зүйлсийг багтаана:

- a. Ажилчдын ажлын талбар дээрх аюулгүй байдал ба жирийн иргэдийг нэвтрүүлэн өнгөрөөх эсхүл ажлын талбарын ойролцоо газраар өнгөрүүлэх аюулгүй байдал.
- b. Замын хөдөлгөөний менежментийн ерөнхий стратеги нь ажлын янз бүрийн шатуудад замын хөдөлгөөнийг зохион байгуулах арга зүйг багтаана.
- c. Барилгын тээврийн хуваарь, нөөцийн материал, ажлын хог хаягдлыг зохицуулах зэрэг ажлууд болон бусад ажил тус бүрд зориулсан түр зуурын замын хөдөлгөөний менежментийн зохицуулалт.
- d. Ажлын үе шат бүрд хэрэгцээтэй байгаа замын хянагчдын тоо, зохион байгуулалт,
- e. Яаралтай тусламжийн гарц-ажилчид болон яаралтай тусламжийн тээврийн хэрэгсэл, олсын үед орж, гарах боломжтой байх, ойролцоох дэлгүүрүүд эсхүл сургууль зэрэг рүү гарах гарц,

- f. Шаардлагатай үед ашиглах тойруу зам эсхүл өөр замуудын ашиглалт,
- g. Хэт том оврын тээврийн хэрэгслүүдийн хангамж,
- h. Явган зорчигч, дугуйчид ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан аюулгүй гарцны хангамж
- i. Хангамж ба нийтийн тээврийн хэрэгсэлд нөлөөлөх нөлөөлөл (ж нь: автобусыг хоцроох, зорчигчдыг автобусанд суух талбай руу явахад нь хязгаарлах, төмөр замын гарц орчимд бөглөрөл үүсэх зэргийг багасгах) боломжтой бол нийтийн тээврийн хэрэгслийг нэн тэргүүнд тавих,
- j. Зэргэлдээх үл хөдлөх хөрөнгө рүү нэвтрэх, орох, гаргах боломжийг хангах,
- k. Ажлыг хийж гүйцэтгэх хугацаа ба үргэлжлэх хугацаа (ж нь: өдөр ба шөнийн үйл ажиллагаа)
- l. Ажлын бус цагуудад эсхүл ажилчид талбар дээрээ байхгүй үеийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний менежментийн зохицуулалт
- m. Тээврийн хэрэгслүүд ажлын талбар дээр олшрох үед цувааны мөргөлдөөний эрсдэлийг хянах, зохицуулах
- n. Ослын үеийн хариу арга хэмжээний журам ба холбоо барих мэдээлэл
- o. Ослын үед явагдах арга хэмжээ-ерсдэлийг бууруулахын тулд тээврийн хэрэгслийн хөдөлгөөний менежмент ослын үндсэн шалтгааны дүн шинжилгээ, дахин осол гарахаас сэргийлэх арга хэмжээ.
- p. Харилцаа холбооны зохион байгуулалт

III. Зам Тээврийн Хөдөлгөөний Менежментийн Төлөвлөгөөнд багтах арга хэмжээнүүд

a. Ерөнхий арга хэмжээ

- Эмнэлэг, сургууль, цэцэрлэг болон бусад олон нийтийн үйл ажиллагаа явагддаг замын хөдөлгөөний осол гарах эрсдэлтэй газруудад болон огтлолцсон зам дээр, хөдөлгөөн ихтэй газруудад анхааруулга тэмдэг, шөнийн гэрлийг босгож өгнө.
- Мэдрэмтгий рецепторууд болох шугам хоолойн бүтээн байгуулалтын талбар, оршин суугчдын талбай руу тээврийн хэрэгсэл орох газрууд эсхүл оршин суугчдын замын хөдөлгөөнтэй газруудад анхааруулах тэмдэг, хурдны хязгаарын тэмдэг зэргийг байрлуулж өгнө. Мөн бүтэн цагаар замын хөдөлгөөнд хяналт тавин ажиллах хүмүүсийг томилно.
- Аюулын гарц түүний орчмыг үргэлж чөлөөтэй байлгана. Харанхуй нөхцөлд гарцуудыг чөлөөтэй харах боломжийг бүрдүүлнэ. Ямар ч цагт олон хүнийг нүүлгэн гаргах шаардлага гарах үед аваарын гарцын тоо болон багтаамж нь хангалттай байх ёстой ба ямар ч ажлын талбарт дор хаяж хоёр гарц байх ёстой.
- Бүтээн байгуулалтын талбар луу тээврийн хэрэгслүүд орохтой холбоотой асуудлуудыг зохицуулж байхын тулд бүтээн байгуулалтын явцад замын хөдөлгөөний хэлтсээс холбоо барих хүн тогтмол байх ёстой.

- Замын хөдөлгөөний тэмдгүүд бусад дэд бүтцийг бүтээн байгуулалтын ажлын бүтээн байгуулалтын талбарт харагдахуйц тодорхой газруудад босгосон байх төдийгүй орох гарах үндсэн хаалга, огтлолцсон замууд, түр зуурын замууд зэргүүд дээр байрлуулж өгнө; эдгээр тэмдгүүдийг засаж сэлбэх тусгай хүнийг томилно. Бүтээн байгуулалтын үе шатууд дахь замын хөдөлгөөний шаардлагууд нь тогтвортой байх ёстой бөгөөд Улаанбаатар хотын журмуудтай нийцэж байх ёстой.

в. Оршин суугчдын ойролцоох бүтээн байгуулалтын үйл ажиллагааны зохицуулалтын арга хэмжээ

- Замын хөдөлгөөнд нөлөө үзүүлж саад болох зүйлүүдийг холдуулсан байх ёстой. Замын хажуу талын явган хүнд зориулсан замуудыг холбогдох журмуудын дагуу чөлөөтэй байлгах ёстой.
- Хаалттай байгаа бүтээн байгуулалтын хэсэг рүү орохоор завдаж буй тээврийн хэрэгслүүдийг тойруулан гаргахын тулд огтлолцсон замууд дээр харагдахуйц тэмдгүүдийг босгоно; замын хөдөлгөөний тэмдэг замын хөдөлгөөнийг журамласан бусад дэд бүтцүүдийг бүтээн байгуулалтын талбарт байрлуулж өгнө.
- Замын хөдөлгөөний зохицуулагчыг замын цагдаагийн байгууллагатай гэрээ хийсний үндсэн дээр бүтэн цагаар ажиллуулна.
- Бүтээн байгуулалтын үйл явцад замын хөдөлгөөний хэлтэст зориулан тусгай хүнийг томилон ажиллуулна.
- Бүтээн байгуулалтаас үүдэн бий болох тоосжилтоос замын гадаргууг цэвэрлэж, цэгцтэй байлгана.
- Замын хөдөлгөөний менежментийг хангах тусгай бүрэлдэхүүн болгож замын хөдөлгөөний зохион байгуулалтын оффисыг байгуулна.
- Улсын стандартын дагуу замын тэмдэглэгээнүүдийг босгож замын уулзварууд дээр зам дагуу болон замыг тойруулсан хашаануудыг босгоно.
- Замын эгнээнүүд дээр ямар нэгэн материалыг овоолохгүй.
- Бүтээн байгуулалтын үе шатанд ямар нэгэн тусгай нөхцөл байдал бүхий арга хэмжээ болбол замын цагдаагийн зөвшөөрөлгүйгээр замын хөдөлгөөний өөрчлөлтийг хийх ёсгүй.
- Төслийн хэрэгжилтэд оролцож байгаа тээврийн хэрэгслийн жолооч нарт болон бусад хүмүүст аюулгүй ажиллагааны сургалтыг хийхэд анхаарч ажиллана.
- Жолооч нарын аюулгүй ажиллагааг хангуулна.
- Жолоодлогын үр чадварыг сайжруулж, жолооч нарт лиценз олгоно.
- Жолооч нарыг хэт ядраахгүйн тулд ээлжтэйгээр ажиллуулж, явах хугацааг нь тодорхойлно.
- Осол гарах эрсдэлийг бууруулахын тулд аюултай замаар явахаас зайлсхийж, өдөрт хэдэн удаа тээвэрлэлт хийх тоог тогтооно.

- Жолооч нарын явсан зайг хянаж, том машинуудад зориулсан хурдны хязгаарын төхөөрөмжүүдийг ашиглана.
- Тээврийн хэрэгслүүдийг тогтмол хугацаанд үзлэг шалгалт хийж засварлан, эд ангиудын эвдрэлээс үүдэх болзошгүй ослыг багасгахын тулд үйлдвэрлэгчийн баталгаатай эд ангиудыг ашиглах.
- Бүтээн байгуулалтын тээврийн хэрэгслүүд нь явган зорчигчдтой аль болох харилцаанд орохгүй байхаар зохицуулах.
- Орон нутгийн иргэд холбогдох хариуцлагатай байгууллагуудтай сургуулийн орчимд эсхүл хүүхдүүд явдаг газруудын замын аюулгүй байдлыг сайжруулах болон харагдах байдал, тэмдгүүдийг сайжруулахын тулд хамтран ажиллана. Орон нутгийн ард иргэдтэй явган зорчигчийн аюулгүй байдал (жишээ нь: сургуулийн боловсролын кампанит ажил), замын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханахын тулд хамтран ажиллана.
- Осол гарсан тохиолдолд холбогдох анхны тусламжаар хангахын тулд осолд хариу үйлдэл үзүүлэгч нараас удирдамж авна.
- Тээвэрлэх зайг аль болох багасгахын тулд ойрхон байгаа материалуудыг ашиглана. Гадны тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг аль болох багасгахын тулд төслийн талбартай ойрхон байгаа ажилчдын хуаран дахь холбогдох дэд бүтэц, ажилчдын автобус зэргийг ашиглах.

с. Үйлдвэрлэлийн тээврийн хэрэгслийг жолоодох ба төслийн талбарын замын хөдөлгөөн

Туршлага муутай үйлдвэрлэлийн тээврийн хэрэгслийн жолооч нар эсхүл сурталтанд бага хамрагдсан жолооч нар бусад тээврийн хэрэгсэлтэй, явган зорчигчидтой, багаж тоног төхөөрөмжтэй харьцахдаа осол гаргах эрсдэл өндөр байдаг. Үйлдвэрлэлийн тээврийн хэрэгсэл, бараа материалыг зөөвөрлөдөг тээврийн хэрэгсэл, хувийн тээврийн хэрэгслүүд нь төслийн талбар дээр осол гаргах магадлалтай байдаг. Үйлдвэрлэлийн тээврийн хэрэгслийг жолоодох болон төслийн талбар дээрх замын хөдөлгөөний аюулгүй байдалд дараах зүйлсийг анхаарах шаардлагатай:

- Бараа бүтээгдэхүүнүүдийг түр хадгалах, зөөвөрлөх бусад үйл ажиллагаануудыг аюулгүй хийж гүйцэтгэхэд ажилтан бүрд тодорхой хэмжээний орон зай хэрэгтэй байдаг.
- Өргөх, ачих, буулгах зориулалттай тусгай машинуудын аюулгүйгээр өргөх, буулгах ачааны хязгаар тавих зэргээр тусгай зорилготой тээврийн хэрэгслүүдийн аюулгүй ажиллагааг хангахын тулд эдгээр үйлдвэрлэлийн тээврийн хэрэгслийн жолооч нарт сургалт явуулж, лицензжүүлэх.
- Жолооч нарыг эмнэлгийн шинжилгээнд хамруулах.
- Хөдөлж байгаа техник, тоног төхөөрөмжийн ар талын харагдац хязгаартай үед сонсогдохуйц дохиолол дуугарч байхаар тоноглогдсон байх.
- Замын хөдөлгөөний чиглэл хэв маягийн хяналт, үйл ажиллагаа явуулах дүрэм журам (жишээ нь доор байрлалд байгаа сэрээтэй өргөх, буулгах, ачих машиныг үйл ажиллагаа явуулахыг нь хориглох), тээврийн хэрэгслийн үзлэгт тавигдах

шаардлагууд, төслийн талбар дээрх хурдны хязгаар, тээврийн хэрэгслийн урсгал чиглэлийг тодорхойлох.

- Бараа материал хүргэж өгдөг болон хувийн тээврийн хэрэгслүүдийг хязгаарлахын тулд явах маршрут, байрлах, зогсох газрыг зааж өгч шаардлагатай бол нэг эргэлтэд давуу эрх олгоно.

d. Замын хөдөлгөөний гол тэмдэг, байгууламж

- Бүтээн байгуулалтын талбар нь зорчих хэсгээс 2 мм-ээс дээш зузаантай цайр төмрийн атираат хавтангаар хийсэн 1.8 метрээс намгүй хашаагаар тусгаарлагдах ёстой. Бүтээн байгуулалтын аюулгүй ажиллагааны тухай уриалгуудыг хотын барилга байгууламжуудад босгох хэрэгтэй бөгөөд бүтээн байгуулалтын талбарт гаднын хүнийг оруулахгүй байх шаардлагатай.
- Бүтээн байгуулалтын талбар дээр байгаа тэмдэг тэмдэглэгээнүүд мэдэгдэхүйц байх шаардлагатай. Замын тэмдэглэгээнүүд бүтээн байгуулалтын талбарын урд болон ард талд тодорхой зайд байрлуулагдсан байх бөгөөд "үүгээр тойрч гарна", "урд талд бүтээн байгуулалтын талбар байгаа" "хурдаа хас" гэх зэрэг тэмдэглэгээнүүдийг тавьсан байна. Шөнийн цагаар гэрэлтүүлгээр хангасан байна.
- Бүтээн байгуулалтын талбарын орох гарах хэсэгт тодорхой тэмдэглэгээнүүдийг байрлуулах ба замын бүтээн байгуулалтын машин механизм, ачаа ачсан машинууд, бүтээн байгуулалтын бус тээврийн хэрэгсэл зэргүүд хоорондоо осол гаргах, түгжрээ үүсэх зэргийг бууруулахын тулд тусгай ажилтныг томилон ажиллуулна.
- Түр зуурын замын хөдөлгөөний удирдамжийн тэмдэглэгээнүүд ба хориглосон тэмдэглэгээнүүдийг уулзварууд дээр болон замын хөдөлгөөний менежментийн байгууллагуудтай хамтран гаргасан түр зуурын зам дээр байрлуулж, түр зуурын замын замын хөдөлгөөний менежментийг хангахын тулд замын хөдөлгөөний менежментийн байгууллагад тусламж үзүүлнэ.

IV. Яаралтай тусламжийн бэлэн байдал ба хариу арга хэмжээний төлөвлөгөө

Яаралтай тусламжийн бэлэн байдал ба хариу арга хэмжээний төлөвлөгөөг бүтээн байгуулалтын явцын замын хөдөлгөөний эрсдэлд үндэслэн боловсруулна. Үүнд дараах зүйлүүдийг багтаана:

- Гүйцэтгэгч нь бүхий л дотоод гадаад дэмжигч байгууллага болон хүмүүсийн нэр, албан тушаал, хаяг, холбоо барих мэдээлэл (утас, и мэйл)-ийн жагсаалтыг гаргана. Энэ жагсаалтыг жил бүр шинэчилнэ. Яаралтай тусламжийн бэлэн байдал ба гүйцэтгэлийн төлөвлөгөөг шалгаж шинэчлэн, уян хатан байдлаар өөрчилж, тоног төхөөрөмж тус бүр, хүн тус бүр, дэд бүтэц тус бүрд тохируулж шалгаж, шинэчилнэ.
- Аваар ослын үед яаралтай тусламжийг зохих ёсоор хангахын тулд яаралтай тусламжийн ажилтан удирдаж ажиллана.

- Тээврийн хэрэгслийн хяналтын арга хэмжээнд явган зорчигч ба тээврийн хэрэгслүүдэд аюулын талаар, замын тэмдэглэгээ болон дохиочдоор дамжуулан анхааруулга сануулга өгч байхыг багтаана.
- Яаралтай тусламжийн шаардлагатай ажиллагааг богино хугацаанд хийж гүйцэтгэх хэрэгтэй.
- Гүйцэтгэгч ослыг тайлагнах механизмыг боловсруулж, яаралтай тусламж үзүүлж дууссаны дараа тайланг явуулж байх.

Яаралтай тусламжид хариу арга хэмжээ авах чадавхыг сайжруулахын тулд ажилчдад зориулж холбогдох журмыг зааж сурган, сургуулилт хийдэг байх шаардлагатай.

Замын хөдөлгөөний түр зохицуулалт (ЗХТЗ)-ын хамрах хүрээ

Замын хөдөлгөөний түр зохицуулалт (ЗХТЗ) гэдэг нь авто зам, замын байгууламжийн ажил явагдах үед иргэдийг хамгаалах, зам барилгын ажлын үзүүлэх нөлөөллийг багасгах цогц арга хэмжээнд хэрэглэгддэг нэр томъёо юм. Авто зам, замын байгууламжийн барилгын ажил нь замын сүлжээг сайжруулах, өргөтгөх, Ухаалаг тээврийн системийн (УТС) тоног төхөөрөмжийг гудамжинд суурилуулах ажлаас бүрдэнэ. Эдгээр авто зам, замын байгууламжийн ажил нь гол төлөв, авто зам, замын байгууламжийн ажил явагдаж байх үед замд нэвтрэх, замын ажлын хажуугаар аюулгүй гарч өнгөрөх шаардлагатай тээврийн хэрэгсэл болон явган хүнд зам нээлттэй байх үед хийгдэх шаардлагатай байдаг.

ЗХТЗ-ын арга хэмжээг дараахи ажлыг хийж гүйцэтгэх үед авах шаардлагатай болдог. Үүнд:

- Сувагжуулалт хийх, суваг шуудуу татах, замын хөдөлгөөний хяналт, дохиоллын системд шаардагдах шон ба гүүр босгох, мөн камер, солигддог зурвасан тэмдэг (ХЗТ) суурилуулахад шаардлагатай гүүрэн байгууламж зэрэг Ухаалаг тээврийн систем (УТС)-ийн тоног төхөөрөмж суурилуулах үед;
- Гудамж замын коридорт завсар үйлчилгээ хийх, шинэчлэх;
- Төмөр замтай хөндлөн огтлолцох зам, трамвай, эсхүл хөнгөн төмөр замын транзит (ХТЗТ) замын ажил хийх үед;
- Авто зам болон явган хүний зам зэрэг бусад гудамж, замыг шинээр барьж байгуулах ажил хийж буй үед.

ЗХТЗ-ын гол зорилго нь зорчих хэсэг болон явган хүний замыг ухах, барилга, байгууламжид нэвтрэх боломжийг хаах зэрэг гудамж, замын ажлын үеэр замын хөдөлгөөнд оролцогчдын, ялангуяа ийм ажлын үед дутуу анхаарч болзошгүй явган зоригчийн аюулгүй байдлыг хангахад оршино. Аюулгүй байдлыг хангах явдал гол зорилго, гэхдээ, энэ зорилго болон зам, замын байгууламжийн ажлын талбайн эргэн тойронд явах аюултай шийдвэр гаргахад хүргэж болзошгүй байрлалаас уртассан, тааламжтай бус байдлаар өөр чиглэл бий болгох хоёрын хоорондын тэнцвэрийг барих явдал чухал.

Замын хөдөлгөөний түр зохицуулалтын төлөвлөгөө (ЗХТЗТ)

Замын хөдөлгөөний түр зохицуулалтын төлөвлөгөө (ЗХТЗТ) нь зам барилгын ажлын нөлөөллийг багасгахад чиглэсэн замын хөдөлгөөнд оролцогчдын аюулгүй байдлыг хангах

олон арга хэмжээнээс бүрддэг. Ерөнхийдөө, ЗХТЗТ нь Ажлын талбайн төлөвлөгөө, Тухайн газар нутгийг хамарсан төлөвлөгөө, Стратегийн маршрут буюу чиглэлийг хамарсан өргөн цар хүрээтэй төлөвлөгөө гэсэн шатлалтай байдаг.

ЗХТЗТ нь замын саатал болон тойруу замыг багасгах, замд аюулгүй нэвтрэх боломжоор хангах, төмөр замын хөрөнгө, барилга байгууламж зэрэг авто замын болон бусад хөрөнгийг хамгаалах зорилго агуулна. ЗХТЗТ нь хүнд даацын ачааны автомашины дарааллыг зохицуулах, барилгын талбай, хогийн цэг, карьер, тоног төхөөрөмж, материал хадгалах талбай хооронд явах ачааны автомашины чиглэлийг зохицуулах замаар замын ажлын талбай руу орох, болон талбайгаас гарах замын хөдөлгөөнд зохицуулалт хийх, авто замын сүлжээ болон түүний орчимд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцлийг бүрдүүлнэ.

ЗХТЗТ нь:

- Тухайн газрын төлөвлөгөө нь хангалттай хэмжээнд тухайн газрын төлөвлөгөө байж чадахгүй, стратеги төлөвлөгөө нь хангалттай хэмжээнд стратеги төлөвлөгөө биш байж болзошгүй тул стандартчилагдсан суурь төлөвлөгөө ашиглана.
- Ачааны автомашины тоог нэг цагт, эсхүл нэг өдөрт гэсэн байдлаар тооцоолсон өгөгдөлтэй байна.
- Ачааны автомашин байрлуулах газрыг төлөвлөгөөнд тусган үзүүлнэ.
- Хөдөлгүүргүй тээврийн хэрэгсэл (ХТХ) - явган зорчигч, дугуйтай хүн, тэргэнцэр, амьтан-хөллөсөн тээврийн хэрэгслийн хэрэгцээг зохих ёсоор хангаж, хамгаалах асуудлыг дүрслэн харуулна.

Ачааны автомашин болон бусад зам барилгын ажилд ашиглах тээврийн хэрэгслүүд, жишээлбэл, ухагч, өргөгч цамхаг буюу кран хэвийн хэмжээтэй байна гэж таамаглаж байна. Хэт их өргөн, урт, эсхүл өндөр ачаатай хэвийн бус ачаа ачсан ачааны автомашинд зориулсан тусгай нөхцөл шаардлагатай бол ийм хэрэгцээг хангах нь зүйтэй бөгөөд үүнийг ЗХТЗТ-нд тусгах шаардлагатай. ЗХТЗТ-г боловсруулах, хэрэгжилтийг хангах байгууллагын талаарх институцийн зохицуулалтыг тусгана. Ихэнхдээ, энэ нь дээрээс доош чиглэсэн удирдлагын арга байх хэдий ч, урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдлын үеийн шаардлагыг хангахын тулд тухайн тохиолдолд нийцүүлэн уян хатан байх орон зай бүхий байвал зохилтой. Дараахи нийтлэг институцийн зохицуулалт байж болно. Үүнд:

a. Гол гэрээлэгч нь ЗХТЗТ-г дараахь байдлаар бэлтгэнэ:

- (1) Гудамж, замын коридорын бүх чиглэл, эсхүл чиглэлийн тодорхой хэсгийг сайжруулах; (2) ажлын талбай нэг бүрээр; (3) сувагжуулалт хийх, суваг шуудуу ухахад нэвтрэх боломж; (4) бусад явган хүний / тээврийн хэрэгслийн гарц, үүний дотор төмөр замын гарц; (5) ачааны автомашины хогийн цэг, карьерууд, тоног төхөөрөмж, материал хадгалах агуулахууд руу явах, буцаж ирэх зориулалтын чиглэл;
- b. Ачааны автомашины ачааны хэмжээний урьдчилсан тооцоолол зэрэг асуудлаарх санал хүсэлтээ дотоодын гэрээлэгчид өгнө;

- c. Зам, тээврийн агентлаг/Замын хөдөлгөөний удирдлагын төв/Замын цагдаа ЗХТЗТ-г хянаж үзэн дэлгэрэнгүй мэдээлэл гаргаж өгөх ба ажлын талбайг тодорхойлно;
- d. УБ хотын захирагч/Нийслэлийн Засаг дарга/Холбогдох газар, хэлтсүүд зөвшөөрлөө өгнө;
- e. Гэрээлэгч мэдээлэл авч, ЗХТЗТ-г хэрэгжүүлнэ.

Ачааны автомашин түрээсэлж, ачааны автомашины жолооч ажилд авах асуудлыг судалж үзэх хэрэгтэй. Дэлхий даяар тохиолддогчлон, ачааны автомашинууд нь ихэвчлэн хэн нэгний өмчлөлд, эсхүл жижиг түрээслэгчийн жижиг автопаркын нэг хэсэг байдаг. Ийм тохиолдолд, гэрээлэгч нь энэхүү олон тооны ачааны автомашин, ачааны тэрэгний жолооч нарыг үр дүнтэй удирдан зохион байгуулах шаардлагатай болно. Ачааны автомашины менежментийг байршил тогтоох систем (GPS), Радио давтамж илрүүлэгч (RFID) эсхүл гар утасны програм ашиглан сайжруулж болно. Хотын захиргааны зүгээс жолооч нарт зориулсан замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаархи мэдээллийн багцыг боловсруулж, бүх ачааны автомашины болон зам барилгын ажилд ажиллах жолооч нарт тарааж өгөх боломжтой.

Замын цагдаа зэрэг замын хөдөлгөөний албан хаагчдыг дайчлан ажиллуулах асуудлыг судалж үзэх хэрэгтэй. Эдгээр албан хаагчид нь ЗХТЗТ-ний зам, замын байгууламжийн ажлын талбай дахь ажлын хэрэгжилтэд хяналт тавьж, 24/7 горимоор замын хөдөлгөөн болон оршин суугчдад шууд чиглэл өгч, тэдний асуултанд хариулах боломжтой.

Суралцахуйн өв уламжлал: Их Британид хэрэгжсэн Crossrail төсөл зэрэг бусад томоохон зам барилгын төслүүдийн нэгэн адил энэхүү төслийг танилцуулах, суралцаж болох өв уламжлал болсон материалыг цахимаар татаж авч байршуулах замаар суралцахуйн архиваар хангах боломжтой²¹.

ЗХТЗ-ын зарчмууд

Их Британийн Лондон хот нь бусад томоохон хотуудын нэгэн адил өөрийн авто замын сүлжээнд хамаардаг авто замд олон тооны тогтмол замын ажлыг удирдан зохион байгуулах ёстой байдаг. Жишээлбэл, 2017/2018 онд Лондон хотод 355,000 зам, замын байгууламжийн талбайг хамарсан газар доорхи инженерийн шугам сүлжээний шинэчлэлт, засвар үйлчилгээ хийх, гудамж, замын харагдах байдалд өөрчлөлт оруулах, шинээр зам тавих, төмөр замын зэрэг томоохон бүтээн байгуулалт хийх шаардлагатай байв. Хотын тээврийн агентлаг болох Лондон хотын тээвэр (TfL) нь бусад хотууд авч үзэн хэрэглэх боломжтой ЗХТЗ-ын арга хэмжээг тодорхойлсон²².

Эдгээр ЗХТЗ-ын арга хэмжээ нь дараахи зарчмуудыг баримтлах нь зүйтэй гэж үзсэн. Үүнд:

²¹ <https://learninglegacy.crossrail.co.uk/learning-legacy-themes/authorisation-and-consents/traffic-and-highways-consents/> 2021 3-р сарын 3-ны өдөр нэвтэрсэн.

²² Лондон хотын тээвэр (TfL)/Лондон хотын Засаг дарга, Замын хөдөлгөөний түр зохицуулалтын гарын авлага: *Замын ажлын үед хүмүүсийн аюулгүй байдлыг хангах нь*, Лондон хот, 2020.

- Иргэдийн зорчих, ялангуяа автобусанд суух, алхах, дугуй унахад саад учруулж болохгүй;
- Аюулгүй байдлыг хангасан байх – эдгээр нь практикт хэрэглэх боломж болон эрсдэлийг бууруулах мэдрэмж хоорондын тэнцвэрт байдлыг хангах замаар сүлбэлдэх эрсдэлийг бууруулах шаардлагатай;
- Замын хөдөлгөөнд оролцогчдод зориулсан чиглэлийн өөрчлөлт нь эвтэйхэн, дөхөмтэй, өдрийн аль ч цагт ашиглахад аюулгүй байдлыг хангасан байх нөхцлийг бүрдүүлэх;
- Хүн бүрт хүртээмжтэй, эвтэйхнээр нэвтрэх боломжийг олгох; саад бэрхшээл, өөр чиглэлд шилжих нь тэднийг эвгүй, эрсдэлтэй эсхүл бие бялдрын хувьд илүү ихийг шаардсан сонголт хийхэд хүрэх хүмүүсийн хэрэгцээг тэргүүн ээлжинд авч үзэх;
- Хүмүүст учруулах саадыг хамгийн бага байлгахын тулд хөдөлгөөний боломж олгох бодит арга замыг санал болгосон, хэрэглэхэд тохиромжтой байх;
- Тодорхой тэмдэглэгээтэй, ойлгомжтой байх, бүхий л хэрэглэгчдэд хялбархан ойлгогддог, хоёрдмол утгагүй байх ёстой.

ЗХТЗ-ын шатлал

Ерөнхийдөө, ЗХТЗ нь дараахи шатлалаас бүрддэг. Үүнд: Ажлын талбайн төлөвлөгөө, Тухайн газар нутгийг хамарсан төлөвлөгөө, Стратегийн маршрут буюу чиглэлийг хамарсан өргөн цар хүрээтэй төлөвлөгөө. Замын хөдөлгөөний түр зохицуулалтын төлөвлөгөө нь (ЗХТЗТ) саатал, ачааллыг багасгах, ажилчдын аюулгүй нэвтрэх боломжийг хангах, явган зорчигч болон бусад замын хөдөлгөөнд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, зам болон бусад эд хөрөнгийг хамгаалах зорилго агуулна.

Ажлын талбайн төлөвлөгөө: Эдгээр нь ажлын талбай тус бүрт тохируулсан нарийвчилсан төлөвлөгөө бөгөөд явган зорчигч болон тээврийн хэрэгсэлд зориулсан хамгаалалтын тоног төхөөрөмж болон тэмдгийг зөв байрлуулахад чиглэгддэг. Зураг 1-т хаалттай явган хүний зам барихад зориулсан Их Британийн Лондон хотын төлөвлөгөөний сайн жишээг үзүүлэв. Зураг 2-т налуу зам, хаалт зэрэг ЗХТЗ-ын төхөөрөмжийн дэлгэрэнгүй мэдээллийг харуулсан бол, Зураг 3-т Их Британийн Эдинбург хотын сайн хийгдсэн ЗХТЗ-ыг харууллаа.

Зураг 11. Явган хүний хажуугийн замыг хаах төлөвлөгөөний жишээ, Лондон хот



Их Британы Лондон хотын жишээ: Түр явган зам, шар өнгөтэй замын төхөөрөмжийг түр зохицуулалтад байршуулах

Зураг 12. Түр зохицуулалтын тоног хэрэгсэл, замын төлөвлөгөө



Kerb ramps help maintain accessibility for people who are disabled, or pushchair users



Pedestrian barrier has a tapping rail at its base for visually impaired people to follow with a walking cane

Traffic barrier without a tapping rail can be deployed in areas away from pedestrian routes

Pedestrian barrier with low-profile feet can reduce obstructive widths and tripping hazards

Их Британы Лондон хотын жишээ: Түр явган зам, шар өнгөтэй замын төхөөрөмж нь тэргэнцэртэй иргэд, хүүхдийн түрдэг тэрэгтэй болон бусад иргэдэд зориулан байршуулах


Их Британы Лондон хотын жишээ: Автомашин, явган зорчигчдод зориулсан бага насны хүүхэд, харааны бэрхшээлтэй иргэдийг хамгаалсан түр хаалт

Зураг 13. Түр зохицуулалтын жишээ, Их Британи, Эдинбург хотⁱ




Тухайн газар нутгийг хамарсан төлөвлөгөө: Эдгээр төлөвлөгөө нь зам барилгын ажлын тухайн газар нутагт үзүүлэх нөлөөллийг судалж, тээврийн хэрэгслийн явах замын чиглэлийг өөрчлөх шаардлагад анхаарлаа төвлөрүүлдэг. Зураг 4-т тухайн газар нутгийн зам хаагдах чиглэлийг өөрчлөхөд ашиглах нийтлэг үлгэрчилсэн загварыг харуулав. Иргэд замын сүлжээнд оруулсан түр зуурын өөрчлөлтийгн талаар мэдэж байхын тулд ийм төлөвлөгөөг тухайн газар нутагт гудамжинд болон цахим орчинд байршуулсан байх ёстой.

Зураг 14. Замын хаах, чиглэл өөрчилсөн жишээⁱⁱ



Стратегийн чиглэлийг хамарсан өргөн цар хүрээтэй төлөвлөгөө: ЗХТЗ нь хүнд даацын ачааны автомашины дарааллыг зохицуулах, барилгын талбай болон хогийн цэг хооронд явах ачааны автомашины чиглэлийг зохицуулах замаар замын ажлын талбай руу орох, болон талбайгаас гарах замын хөдөлгөөнд зохицуулалт хийх асуудлыг шийддэг. ЗХТЗ-ын арга хэмжээ нь зам барилгын ажил хийх цаг хугцаа болон дараалал нь авто замын сүлжээ болон түүний орчимд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцлийг бүрдүүлдэг.

Зураг 15. Ачааны машины чиглэлийн жишээⁱⁱⁱ



ХАВСРАЛТ 8: Жишиг Сахилгын дүрэм

Жендэрт суурилсан хүчирхийлэл болон хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх

Бүхий л шатны менежерүүд буюу удирдах ажилтнууд ЖСХ болон ХСХ-ээс урьдчилан сэргийлэх, үүнд анхаарал хандуулах талаарх компанийн итгэл үнэмшлийг баталгаажуулах асуудлаар тодорхой үүрэг хүлээдэг. Энэ нь удирдах ажилтнууд ЖСХ болон ХЭХ-ээс урьдчилан сэргийлэх орчныг бүрдүүлж, хэвшүүлэх үүрэгтэй гэсэн үг юм. Удирдах ажилтнууд Компаний Сахилгын дүрмийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж, сурталчлан таниулах шаардлагатай. Энэ утгаараа, удирдах ажилтнууд нь Удирдах ажилтны Сахилгын дүрмийг мөрдөж ажиллах ба Ажилтны сахилгын дүрэмд гарын үсэг зурна. Энэ нь тэдгээрт үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд тус дөхөм үзүүлэх, ажлын байр болон тухайн орон нутгийн түвшинд ЖСХ-гүй, ХЭХ-гүй орчныг бүрдүүлж, хэвшүүлэхэд чиглэсэн системийг дэмжиж, хөгжүүлэх үүрэг хүлээлгэдэг. Эдгээр үүрэгт дараахь, гэхдээ эдгээрээр хязгаарлагдахгүй зүйлс орно. Үүнд:

Хэрэгжилт

1. Компанийн болон Ажилтны сахилгын дүрэм дээд зэргийн үр дүнтэй байх нөхцлийг хангах:
 - Ажилчдын хотхон, оффис болон ажлын байрны нийтийн зориулалттай хэсэгт Компаний болон Ажилтны сахилгын дүрмийг нүдэнд тусахуйцаар байршуулсан байна. Ийм газрын жишээнээс дурдвал, хүлээлгийн хэсэг, амрах болон лобби үйл ажиллагаанд зориулсан хэсэг, хоолны газар, эрүүл мэндийн клиник байж болно.
 - Компаний байршуулсан болон түгээсэн Ажилтнуудын болон Компаний Сахилгын дүрмийг ажлын талбайн бүсэд ашиглахаар тооцон Монгол, Англи хэл дээр болон бусад гадаадын ажилтнуудад зориулан тэдгээрийн үндэсний хэл рүү хөрвүүлэн байршуулна.
2. Компанийн болон Ажилтны сахилгын дүрмийг нийт ажилтнуудад амаар болон бичгээр тайлбарлаж өгнө. Ингэхдээ:
 - Ажлаа шууд тайлагнадаг нийт ажилтнууд Сахилгын дүрмийг уншиж танилцсан бөгөөд хүлээн зөвшөөрч байгаагаа баталгаажуулж 'Ажилтны сахилгын дүрэм'-д гарын үсэг зурсан байна.
 - Ажилтнуудын нэрсийн жагсаалт болон гарын үсэг бүхий Ажилтнуудын сахилгын дүрмийн хуулбарыг Барилгын ажлын Ерөнхий гэрээлэгч болон захиалагч талд хүргүүлнэ.
 - Сургалтанд хамрагдаж, ажилтнуудыг доор дурдсанчлан үүнд оролцсон байх нөхцлийг бүрдүүлнэ:
 - Ажилтнууд гомдол барагдуулах механизмыг (ГБМ) сайтар мэддэг бөгөөд үүнийг ашиглан ЖСХ эсхүл ХЭХ-ийн тохиолдлын талаар нэрээ нууцлан мэдээлэх боломжтой байх нөхцөл бүрдүүлнэ.

- Ажилтнуудын ЖСХ эсхүл ХЭХ-ийн талаархи мэдлэгийг дээшлүүлэх, ажилтнууд нь ажил эрхэлж буй компани болон ажил эрхэлж буй улс орны өмнө хүлээсэн үүрэг хариуцлага болон нууцлалыг чандлан сахина гэдгийг тус тус онцлоод ГБМ-аар дамжуулан сэжигтэй эсхүл бодитойгоор үйлдэгдсэн ЖСХ эсхүл ХЭХ-ийн талаар мэдээлдэг байх явдлыг баталгаажуулна.
 - Холбогдох хууль тогтоомжийн дагуу болон өөрийн эрх мэдлийн хүрээнд бэлгийн мөлжлөг үйлдэгч, дарамт учруулагчдыг ажилд авах, эргүүлэн ажилд авах, шилжүүлж ажиллуулахаас сэрэмжилнэ. Нийт ажилтнуудын тухай ерөнхий болон эрүүгийн хэргийн талаарх лавлагаа авдаг байх явдлыг баталгаажуулна.
3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчтэй хийх эсхүл түүнтэй адилтгах гэрээнд оролцохдоо эдгээр гэрээ дараахь нөхцлийг хангасан байх шаардлагыг биелүүлнэ. Үүнд:
- ЖСХ болон ХЭХ-тэй холбоотой Сахилгын дүрмийг гэрээнд хавсаргана.
 - Гэрээ байгуулсан аж ахуйн нэгж, хувь хүмүүс, тэдгээрийн ажилтнууд, сайн дурын ажилтнуудаас Ажилтны сахилгын дүрмийг дагаж мөрдөхийг шаардсан талаарх зохих үг хэллэгийг гэрээнд тусгана.
 - Эдгээр аж ахуйн нэгж, хувь хүмүүс ЖСХ болон ХЭХ-ээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй, тэдгээрт холбогдох гомдлыг шалгаагүй, эсвэл ЖСХ эсхүл ХЭХ үйлдэгдсэн үед үүнийг залруулах арга хэмжээ аваагүй тохиолдолд энэ нь Ажилтны сахилгын дүрэмд заасны дагуу хариуцлага хүлээлгэх үндэслэл болно гэдгийг ойлгомжтойгоор мэдэгсэн байна.
 - Үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх стратегийн хүрээнд дотоод мэдрэмжтэй байх чадвар бий болгох санаачлага гарган, түгээхэд нь Ерөнхий гүйцэтгэгчид дэмжлэг үзүүлж, нөөцөөр хангана.
4. Аливаа ЖСХ болон ХЭХ-тэй холбоотой тохиолдлыг баталгаажуулсан цагдаагийн байгууллагын ажиллагааны талаар захиалагч болон Дэлхийн банкинд нэн даруй тайлагнана.

Сургалт

- Бүхий л удирдах ажилтнууд ЖСХ болон ХЭХ-тэй холбоотой Сахилгын дүрмийг дагаж мөрдөх үүрэг, хариуцлагаа сайтар ухамсарласан байх үүднээс газар дээрх ажил эхлэхээс өмнө удирдах ажилтны чиглүүлэх сургалтанд хамрагдах шаардлагатай.
- Энэхүү сургалт нь нийт ажилтнуудад зориулж хийх чиглүүлэх сургалтаас тусдаа байх бөгөөд ЖСХ болон ХЭХ-ийн асуудлыг авч үзсэн Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж эхлэхэд удирдах ажилтнуудын эзэмшсэн байвал зохих мэдлэг, ойлголттой, техникийн дэмжлэгтэй болоход нь туслах болно.
- Ажилтнууд газар дээрх ажил эхлэхээс өмнө энэхүү зайлшгүй шаардлагатай ЖСХ болон ХЭХ-ийн тухай чиглүүлэх сургалтанд хамрагдахад нь зориулж ажлын цагаар уг сургалтанд оролцох цаг гаргаж өгөх хэрэгтэй.
- Зам, барилгын ажлын үеэр ЖСХ болон ХЭХ-ийн эрсдэл нэмэгдэхтэй тэмцэхийн тулд нийт ажилтнуудыг сар тутам заавал давтан сургах сургалтанд хамруулна.

- Удирдах ажилтнууд төслийн ажилтнуудад зориулан сар тутам зохион байгуулагдах сургалтанд өөрсдөө хамрагдах ба үүнийг зохион байгуулахад туслалцаа үзүүлэх шаардлагатай. Сургалтыг нээх болон сургалтыг үнэлэх үйл ажиллагааг өөрийн биеэр танилцуулах шаардлагатай.
- Сургалтын үйл ажиллагаанд үнэлгээ өгөхийн тулд сэтгэл ханамжийн санал асуулгыг бөглүүлж авах ба сургалтын үр нөлөөг дээшлүүлэх талаар зөвлөгөө өгнө.

Хариу арга хэмжээ

Удирдах ажилтнууд нь Барилгын ажлын Ерөнхий гэрээлэгчийн зүгээс Үйл ажиллагааны эцэслэгдсэн төлөвлөгөөний нэг хэсэг хэлбэрээр боловсруулах ЖСХ болон ХЭХ-ийн талаарх зарга мэдүүлэх журам болон хариу үйлдлийн протоколд саналаа өгөх шаардлагатай.

Удирдах ажилтнууд нь ЖСХ болон ХЭХ-ийн тохиолдлыг мэдээлсэн бүх ажилтны нууцлалыг хадгалах зорилгоор, компаний баталсан Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлнэ. (хүн, эсхүл эд хөрөнгийг ноцтой хохирлоос хамгаалахын тулд, эсхүл хууль тогтоомжид заасны дагуу нууцлалыг задруулах шаардлагагүй тохиолдолд).

Хэрэв удирдах ажилтан өөрт нь ажлаа шууд тайлагнадаг ажилтны аль нэг нь, эсхүл нэг ажлын талбай дээр ажиллаж буй өөр гүйцэтгэгчийн ажилтантай холбоотой ЖСХ эсхүл ХЭХ-ийн аливаа хэлбэрийн талаар анхаарал татсан асуудал гарсан, эсхүл сэжиглэж байгаа тохиолдолд, тухайн хэргийн талаар ГБМ ашиглан мэдээлэх шаардлагатай.

Хариуцлагын арга хэмжээ авах тухай шийдвэр гарсаны дараа холбогдох удирдах ажилтан (арга хэмжээ авах) уг шийдвэр гарсан өдрөөс хойш хамгийн ихдээ 14 хоногт багтаан уг арга хэмжээ үр дүнтэй хэрэгжих асуудлыг биечлэн хариуцна.

Ийм үйлдлийн талаар мэдээлээгүй буюу дүрмийн заалтыг дагаж мөрдөөгүй удирдах ажилтнуудад оногдуулах сахилгын шийтгэлийг компаний Гүйцэтгэх захирал, ажил эрхэлсэн захирал, эсхүл түүнтэй адилтгах хамгийн дээд албан тушаалын удирдах ажилтнаар батлуулж болно. Эдгээр арга хэмжээнд дараахь зүйлс орно.

1. Албан бус сануулга өгөх.
2. Албан ёсны сануулга өгөх.
3. Нэмэлт сургалтанд хамруулах.
4. Нэг хүртэлх 7 хоногийн цалингаар торгох.
5. Хамгийн багадаа 1 сар (цалингүй), дээд тал нь 6 сараар хөдөлмөр эрхлэлтийг түдгэлзүүлэх.
6. Хөдөлмөр эрхлэлтийн гэрээг цуцлах.

Эцэст нь, ажлын талбайд үйлдэгдсэн ЖСХ болон ХЭХ-ийн тохиолдол гарсан үед компаний удирдах ажилтнууд эсхүл Гүйцэтгэх захирлын зүгээс үр дүнтэй хариу арга хэмжээ үзүүлээгүй тохиолдолд энэ нь эрх бүхий байгууллагуудаас хууль ёсны арга хэмжээ авах үндэслэл болж болзошгүй.

Иймд, миний бие өмнө дурдсан Удирдах ажилтны сахилгын дүрмийг уншиж танилцсанаа хүлээн зөвшөөрч, түүнд заасан стандартуудыг дагаж мөрдөхийг зөвшөөрч, ЖСХ болон ХЭХ-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үүрэг, хариуцлагаа ухамсарлаж байна. Энэхүү Удирдах ажилтны сахилгын дүрэмд нийцэхгүй аливаа үйлдэл гаргасан эсхүл энэхүү Удирдах ажилтны сахилгын дүрэмд заасан арга хэмжээ аваагүй тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулж болзошгүйг гэдгийг би ойлгож байна.

Гарын үсэг: Овог нэр: Албан тушаал:

Огноо:

Ажилтны сахилгын дүрэм

Жендэрт суурилсан хүчирхийлэл ба Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх Миний бие, _____, Жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ) болон Хүүхдийн эсрэг хүчирхийллээс (ХЭХ) урьдчилан сэргийлэх нь чухал гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Компани нь ЖСХ эсхүл ХЭХ-ийн үйлдлийг ноцтой зөрчил гаргасан үйлдэлд тооцдог тул хариуцлагын шийтгэл, торгууль оногдуулах эсхүл хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл болно гэж үздэг. Ажлын талбай, ажлын талбайн орчин тойрон, ажилтнуудын хотхонд ЖСХ эсхүл ХЭХ-ийн бүх хэлбэрийг хүлээн зөвшөөрөхгүй. Шаардлагатай тохиолдолд, ЖСХ, эсхүл ХЭХ үйлдсэн хүмүүсийг хэрэгт татаж болно.

Төсөл дээр ажиллаж байхдаа дараахь зүйлийг хийх болно гэдгийг би хүлээн зөвшөөрч байна. Үүнд:

- Цагдаагийн тодорхойлолт авахыг зөвшөөрөх.
- Эмэгтэйчүүд, хүүхдүүд (18-аас доош насны хүмүүс) болон эрэгтэйчүүдэд арьс өнгө, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс угсаа, нийгмийн гарал, өмч хөрөнгө, хөгжлийн бэрхшээл, төрсөн газар болон бусад байдлаас үл хамааран хүндэтгэлтэй хандах.
- Эмэгтэйчүүд, хүүхдүүд, эрэгтэйчүүдэд тохиромжгүй, танхайрсан, хүчирхийлсэн, бэлгийн дүр хүсэл өдөөсөн, дорд үзсэн зан авир гаргахгүй, соёлын хувьд зохисгүй үг хэллэг хэрэглэхгүй.
- Хүүхэдтэй бэлгийн харьцаанд орох, эсхүл бөөцийлөх, дижитал мэдээллийн хэрэгслээр дамжуулан холбоо барих зэрэг үйл ажиллагаанд оролцохгүй. Хүүхдийн настай холбоотой алдаатай итгэл үнэмшил нь хамгаалалт биш юм. Хүүхдийн зөвшөөрөл нь бас өмгөөлөл, эсхүл шалтаг биш юм.
- Хариу тус нэхсэн бэлгийн харьцаанд орохгүй байх - тухайлбал бэлгийн харьцаанаас хамааралтай амлалт өгөх эсхүл тааламжтай хандах, эсхүл бусад хэлбэрээр гутаан доромжилсон, дорд үзсэн, мөлжлөгийн зан үйл гаргахгүй.

- Харьцаанд оролцогч талуудын бүрэн зөвшөөрөлгүйгээр эргэн тойрны хамтран ажиллагчтай бэлгийн харьцаанд орохгүй.
- **Зөвшөөрөл** гэдэг нь хувь хүний ямар нэгэн зүйлийг хийх хүсэл зориг, сайн дурын хүсэл эрмэлзэл, хүлээн авах эсвэл тохиролцоонд үндэслэгдсэн мэдээлэлтэй сонголт гэж тодорхойлогддог. Хамт ажиллагчтайгаа бэлгийн харьцаанд орохын тулд бодит ашиг тус (мөнгөн эсхүл мөнгөн бус) хүртээхээр амлах замаар хүлээн зөвшөөрүүлсэн, эсхүл тохиролцоо хийгдсэн тохиолдолд, ийм бэлгийн үйл ажиллагааг энэхүү дүрмийн хүрээнд "зөвшилцөөгүй" гэж үзнэ.
- Ажил олгогчийнхоо шаардсанаар ХДХВ/ДОХ, ЖСХ, ХЭХ-тэй холбоотой сургалтанд хамрагдаж, идэвхтэй оролцоно.
- Манай компанид ажилладаг эсэхээс үл хамааран хамт ажиллагсдын сэжигтэй эсхүл бодит ЖСХ эсхүл ХЭХ үйлдэгдсэн тохиолдол, эсхүл энэхүү сахилгын дүрмийг зөрчсөн тохиолдын талаар ГБМ-аар дамжуулан эсхүл удирдах ажилтандаа тайлагнана.

18 нас хүрээгүй хүүхдүүдийн тухайд:

- Боломжтой тохиолдолд, хүүхдүүдийн ойролцоо ажиллахдаа өөр хэн нэгэн насанд хүрсэн хүн тэнд хамт ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.
- Гэр бүлийнхэнтэйгээ холбоогүй, хараа хяналтгүй хүүхдүүдийг хэрэв тэд шууд гэмтэх, бие махбодийн хувьд аюулд орохооргүй тохиолдолд гэртээ урихгүй.
- Шаардлагагүй бол хараа хяналтгүй хүүхдүүдийн ойролцоо унтахгүй байх, ийм тохиолдол гарахаар бол би удирдагчийнхаа зөвшөөрлийг авч, боломжтой бол өөр насанд хүрэгчийг хамт байлцуулна.
- Аливаа компьютер, гар утас, эсхүл видео болон дижитал камерыг зохих ёсоор нь ашиглаж, хүүхдийг мөлжих, дарамтлах, эсхүл аливаа аргаар хүүхдийг садар самуунд хэзээ ч ашиглахгүй (доорх "Хүүхдийн зургийг ажилтай холбоотой зорилгоор ашиглах" гэдгийг үзнэ үү).
- Хүүхдүүдэд бие махбодийн шийтгэл оногдуулах замаар хүмүүжүүлэхийг цээрлэнэ.
- Хүүхдүүдийн нас, хөгжлийн үе шатыг харгалзан тэдний сурч боловсрох, амралт чөлөөт цагаа өнгөрөөхөд нь саад учруулдаг, эсвэл бэртэл гэмтэл авах эрсдлийг дагуулдаг гэр орны эсхүл бусад ажил хөдөлмөрт хөлсөлж ажиллуулахыг цээрлэнэ.
- Тухайн орон нутагт мөрдөгддөг холбогдох бүхий л хууль тогтоомж, түүний дотор хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн тухай тусгасан Хөдөлмөрийн тухай хуулийг дагаж мөрдөнө.

Ажилтай холбоотой зорилгоор хүүхдийн зургийг ашиглах

Ажилтай холбоотой хүүхдийн гэрэл зураг авах, бичлэг хийхдээ би дараахь зүйлийг анхаарах ёстой. Үүнд:

- Хүүхдийн гэрэл зургийг авах, бичлэг хийхээс өмнө тухайн газар нутгийн уламжлал, эсхүл хувийн дүр төрхийг хуулбарлахад тавигдах хязгаарлалтыг үнэлж, дүгнэн дагаж мөрдөхийг хичээнэ.

- Хүүхдийн гэрэл зургийг авах, бичлэг хийхээс өмнө хүүхэд, түүний эцэг эх, асран хамгаалагчаас мэдээлэл бүхий зөвшөөрөл авна. Энэ хүрээнд би гэрэл зураг эсхүл хийсэн бичлэгийг хэрхэн ашиглах талаар тайлбарлах ёстой.
- Гэрэл зураг, кино, видео, болон DVD-н дэх хүүхдүүдийг эмзэг, хүлцэнгүй байдалтайгаар бус харин нэр төртэй, хүндэтгэлтэй байдлаар үзүүлсэн байх нөхцлийг бүрдүүлнэ. Хүүхдүүд тохиромжтой хувцасласан байх ёстой бөгөөд бэлгийн дур хүслийг өдөөж болохуйц биш байх ёстой.
- Зураг нь тухайн нөхцөл байдал, баримт мэдээг цэх шулуунаар илэрхийлсэн байх явдлыг баталгаажуулна.
- Зургийг цахим хэлбэрээр илгээхдээ файлын шошгонд хүүхдийг танигдуулах мэдээллийг илчлэхгүй байх явдлыг баталгаажуулна.

Шийтгэл

Хэрэв, миний бие Ажилтны сахилгын дүрмийг зөрчвөл надад ажил олгогч нь дараахь байдлаар сахилгын шийтгэл оногдуулна гэдгийг би ухамсарлаж байгаа болно. Үүнд:

- Албан бус сануулга өгөх.
- Албан ёсны сануулга өгөх.
- Нэмэлт сургалтанд хамруулах.
- Нэг хүртэлх 7 хоногийн цалингаар торгох.
- Хамгийн багадаа 1 сар (цалингүй), дээд тал нь 6 сараар хөдөлмөр эрхлэлтийг түдгэлзүүлэх.
- Хөдөлмөр эрхлэлтийн гэрээг цуцлах.
- Үндэслэлтэй бол цагдаад мэдэгдэх.

ЖСХ эсхүл ХЭХ гэж ойлгож болохуйц, эсхүл энэхүү Ажилтны сахилгын дүрмийг зөрчсөн үйлдэл, зан авираас зайлсхийх нь миний үүрэг гэдгийг би ойлгож байна. Иймд, миний бие өмнө дурдсан Ажилтны сахилгын дүрмийг уншиж танилцсанаа хүлээн зөвшөөрч, түүнд заасан стандартуудыг дагаж мөрдөхийг зөвшөөрч, ЖСХ болон ХЭХ-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үүрэг, хариуцлагаа ухамсарлаж байна. Үүнтэй нийцэхгүй аливаа үйлдэл нь заналхийлэл, хүч хэрэглэх эсхүл бусад хэлбэрээр албадлага хийх, хулгайлах, залилан мэхлэх, хууран мэхлэх, хуурамч мэдээлэл ашиглах зэргээр ашиглагдана гэдгийг би ойлгож байна. НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн дагуу Дэлхийн банк нь сахилгын дүрмийг нэвтрүүлсэн улс орны үндэсний хууль тогтоомжид 18-аас доош нас заасан тохиолдолд ч зөвшөөрөл өгөх боломжгүй гэж үздэг. Хүүхдийн нас, хүүхдийн зөвшөөрөлтэй холбоотой эндүү ташаа итгэл үнэмшил нь хамгаалалт биш юм.

Ажилтны сахилгын дүрэм, эсхүл энэхүү Ажилтны сахилгын дүрэмд заасан арга хэмжээг аваагүй тохиолдолд, энэ нь надад сахилгын шийтгэл оногдуулах, миний эрхэлж буй ажил, хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж болзошгүй.

Гарын үсэг:

Овог нэр:

Албан тушаал:

Огноо:
